

Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах удирдамж

Protection from threats & attacks
by State & non-State actors

DEFENDERS AT
SPECIFIC RISK

ENABLING LEGAL ENVIRONMENT

Хүний эрхийг
хамгаалагчдыг хамгаалах
удирдамж

ЕАБХАБ (Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага)-ын
Ардчилсан институт, хүний эрхийн газраас эрхлэн хэвлүүлэв.
Польш улс, Варшав хот 00-251, Мёдова гудамж 10
www.osce.org/odihr

© ЕАБХАБ/АИХЭГ 2020

Бүх эрхийг хуулиар хамгаалсан. Зохиогчийн эрхийг эзэмшигч ЕАБХАБ/АИХЭГ-аас зөвшөөрөл авсан тохиолдолд уг бүтээлийг чөлөөтэй ашиглаж, боловсролын болон арилжааны бус зорилгоор хувилан хэрэглэж болно.

ISBN 978-83-66089-97-6

Эх бэлтгэгч: Нона Ройтер

Хавтасны зургийг: Агнешка Рембовска

Польш улсын Centrum Poligrafii хэвлэлийн газар хэвлэв.

Гарчиг

Товчилсон үгийн жагсаалт	v
ОРШИЛ	vii
ТАНИЛЦУУЛГА	ix
Хэсэг А: Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах удирдамж	1
I. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧДЫГ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ЗАРЧИМ	3
II. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧДЫН БИЕТ ХАЛДАШГҮЙ БАЙДАЛ, ЭРХ ЧӨЛӨӨ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА НЭР ТӨР	5
A. Заналхийлэл, халдлага болон бусад хүчирхийллээс хамгаалах	5
Б. Хууль эрх зүйн дарамт, гэмт хэрэгт тооцох, дур зоргоор баривчлах, албадан саатуулахаас хамгаалах	7
В. Доромжлол, гадуурхалтай тэмцэх нь.	10
III. ХҮНИЙ ЭРХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АЮУЛГҮЙ, ТААТАЙ ОРЧИН	12
Г. Үзэл бодлоо илэрхийлэх, мэдээллийн эрх чөлөө	12
Д. Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө	15
Е. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, ТББ байгуулах, элсэх, идэвхтэй оролцох эрх	18
Ё. Олон нийтийн бодлогын үйл ажиллагаанд оролцох эрх.	21
Ж. Чөлөөтэй зорчих эрх ба хилийн дотор болон хил дамнасан хүний эрхийн ажил	21
З. Хувийн амьдралыг хүндэтгэх эрх	23
И. Олон улсын байгууллагатай холбоо тогтоох, харилцах эрх	25
IV. УДИРДАМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	26
Хэсэг В: Төрөлжсөн тайлан	31
I. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧДЫГ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ЗАРЧИМ	41
II. Хүний эрхийг хамгаалагчдын бие махбодын халдашгүй байдал, эрх чөлөө, аюулгүй байдал, нэр төр.	56
A. Заналхийлэл, халдлага, бусад зүй бус үйлдлээс хамгаалах.	56
Б. Хуулийн дарамт, гэмт хэрэгт тооцох, хууль бус дур зоргоор баривчлах, цагдан хорихоос хамгаалах нь	69
В. Доромжлол, гадуурхалтай тэмцэх нь.	80

III. ХҮНИЙ ЭРХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АЮУЛГҮЙ, ТААТАЙ ОРЧИН	87
Г. Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээллийн эрх чөлөө.	87
Д. Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө	100
Е. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, ТББ байгуулах, тэдгээрт элсэх, идэвхтэй оролцох эрх	113
Ё. Бодлогын үйл ажиллагаанд оролцох олон нийтийн эрх	128
Ж. Чөлөөтэй зорчих эрх ба хилийн дотор болон хил дамнасан хүний эрхийн ажил	133
З. Хувийн амьдралыг хүндэтгэх эрх	141
И. Олон улсын байгууллагатай холбоо тогтоох, харилцах эрх	153
IV. УДИРДАМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	160
ХАВСРАЛТ: Сонгосон лавлах материал, эх сурвалжууд	175
1. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧДЫГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙ ТУСГАЙ БАРИМТ БИЧИГ, СТАНДАРТУУД.	176
2. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧДЫГ ХАМГААЛАХ АСУУДЛЫГ ТУСГАСАН ЕРӨНХИЙ ХҮНИЙ ЭРХИЙН СТАНДАРТУУД	178
3. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧДЫГ ХАМГААЛАХ ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БҮС НУТГИЙН МЕХАНИЗМУУД	180

Товчилсон үгийн жагсаалт

ХЭАК	Хүний эрхийн америкийн конвенц
ЭЯГБХУК	Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах конвенц
ЭШЭК	Эрүүдэн шүүлт болон бусад хэлбэрийн хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжилсон харьцаа буюу шийтгэлийн эсрэг конвенц (Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц)
ХЭК	Хүүхдийн эрхийн конвенц
ХБИЭК	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн конвенц
ХЭУЭЧК	Хүний эрх, үндсэн эрх чөлөөний конвенц (Европын хүний эрхийн конвенц)
ЕХЭШ	Европын хүний эрхийн шүүх
ЕХ	Европын холбоо
ЕЗҮЦХСК	Европын зөвлөлийн үндэсний цөөнхүүдийг хамгаалах суурь конвенц
АДХЭХ	Америк дундын хүний эрхийн хороо
ИУТЭОУП	Иргэний ба улс төрийн эрхийн олон улсын пакт
АӨЯГБХУОУХ	Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын хэлцэл
ЭЗНСЭОУХ	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын хэлцэл
ЛГБТИ	Лесби, Гэй, Бисекс, Трансжендер, Интерсекс
ТББ	Төрийн бус байгууллага
ҮХЭИ	Хүний эрхийг хамгаалах үндэсний институт
АИХЭГ	Ардчилсан институт, хүний эрхийн газар
ЭШЭНП	Эрүүдэн шүүлт болон бусад хэлбэрийн хэрцгий, хүнлэг бус буюу хүний нэр төрийг доромжилсон харьцаа ба шийтгэлийн эсрэг конвенц (Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц)-ын Нэмэлт Протокол
ЕАБХАБ	Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага
ЕЗПА	Европын холбооны парламентын ассамблей
ХЭТТ	Хүний эрхийн түгээмэл тунхаглал
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБЕА	Нэгдсэн үндэстний байгууллагын Ерөнхий ассамблей

ОРШИЛ

ЕАБХАБ-ын төр, засгийн газрын тэргүүнүүд 20 жилийн өмнө “Шинэ эринд шударга хамтын ажиллагааны төлөө” хэмээн хүний эрх, аливаа үндсэн эрх чөлөө, эрх зүйт ёс, ардчилсан институтууд нь энх тайван, аюулгүй байдлын суурь мөн болохыг дахин баталгаажуулж 1994 оны Будапештын баримт бичгийг хэрэгжүүлж эхэлсэн билээ. Улмаар тэд хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах хэрэгцээ шаардлага буйг цохон тэмдэглэсэн юм.

Энэхүү хэрэгцээ шаардлагыг хүний эрхийг хамгаалагч, иргэний нийгмийн үүрэг чухал гэдгийг хүлээн зөвшөөрсөн 1975 оны Хельсинкийн төгсгөлийн баримт бичиг, 1990 оны ЕАБХАБ-ын хүний аюулгүй байдлын хэмжүүрийн асуудлаарх бага хурлаас гарсан Копенхагены уулзалтын баримт бичиг болон ЕАБХАБ-ын хүний аюулгүй байдлын хэмжүүрийн талаарх үүрэг амлалтуудад нарийн тусгаж тодорхойлсон байдаг. Хүний эрхийг хамгаалагчдыг явуулсан үйл ажиллагааных нь төлөө мөрдөж, мөшгөхийг таслан зогсоогоогүй газарт хүний үндсэн эрх чөлөө, хүний эрхийн баталгаа хангагдах боломжгүй билээ.

Астана хотод 2010 онд зохион байгуулагдсан ЕАБХАБ-ын Чуулга уулзалтын үеэр чуулганд оролцогч улс орнууд хүний эрх, үндсэн эрх чөлөө, ардчилал, эрх зүйт ёсыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд нь иргэний нийгэм, чөлөөт хэвлэл мээлэл чухал үүрэг гүйцэтгэснийг тэмдэглэн хэлсэн (Астанагийн ойн тунхаг, 2010).

Дээрх баримт бичгүүдэд хүний эрхийг хамгаалагчдын баталгааг тунхагласан ч иргэний нийгмийн байгууллагуудын хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд саад учруулдаг, шийдвэрлэгдээгүй асуудал, зарим тохиолдолд нүүр тулдаг ноцтой эрсдэлүүдийг АИХЭГ болон ЕАБХАБ-ын анхааралд тасралтгүй хүргэсээр байгаа билээ. Даблин хотноо 2012 онд зохион байгуулагдсан ЕАБХАБ-ын Гадаад хэргийн сайд нарын хорооны хурлын хүрээнд иргэний нийгмийн байгууллагууд тус бүс нутагт ажиллаж буй хүний эрхийг хамгаалагчдын аюулгүй байдалд туйлаас санаа зовж буйгаа илэрхийлэн хамтарсан тунхаг бичиг гаргасан бөгөөд тэднийг хамгаалах удирдамж гаргахыг ЕАБХАБ-д уриалсан юм.¹ Энэхүү уриалгыг ажил хэрэг болгож АИХЭГ өөрийн төлөөлөх эрхийн хүрээнд энэхүү Удирдамжийг боловсруулсан болно.

Будапештын баримт бичгийг баталснаас хойших хоёр аравны хугацаанд нэлээд ололт амжилт гаргажээ. Гэсэн хэдий ч хүний эрхийг хамгаалагчдад тулгардаг олон бэрхшээлийг шийдээгүй нь тодорхой төдийгүй, нийгмийн өөрчлөлт шинээлэлтэй холбоотойгоор ноцтой шинэ сорилтууд урган гарсаар байна. Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах удирдамж нь Засгийн газрууд

1 “Даблины тунхаглал – Хүний эрхийг хамгаалагчдын аюулгүй байдал: ЕАБХАБ арга хэмжээ авах цаг нь болсон”, 2012 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Зэрэгцээ Иргэний Нийгэм Бага хурлын оролцогчдын баталсан, <http://www.civicsolidarity.org/sites/default/files/dublin_declaration_on_human_rights_defenders_final.pdf>.

болон хүний эрхийг хамгаалагчдын дунд эдгээр сорилтыг амжилттай шийдвэрлэх, шинэ шатны, бодитой хамтын ажиллагааны үндэс суурийг тавьж, ЕАБХАБ-ын харьяа бүс нутагт хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэн үзэх хандлагыг суулгах нийтлэг зорилгодоо хүрэхэд Та бид хүчээ нэгтгэн зүтгэнэ гэдэгт бид итгэж байна.

*Элчин сайд, ЕАБХАБ-ын Ардчилсан институт,
хүний эрхийн газрын захирал Жанез Ленарчич*

ТАНИЛЦУУЛГА

“Олон улсын хамтын ажиллагаанд бодитой, урт хугацааны баттай үндэс суурь болж чадах, хүний эрхийг хамгаалахаар онцгойлон авч үзсэн Хорооны мэдэгдлийг миний бие талархан хүлээн авлаа [...]

Мэдээллийн эрх чөлөө, итгэл үнэмшилтэй байх, хэвлэн нийтлэх, зорчих, оршин суух орноо чөлөөтэй сонгох эрх чөлөөгүйгээр олон улсын итгэлцэл, харилцан ойлголцол, зэвсэг хураалт, олон улсын аюулгүй байдлыг бий болгох боломжгүй гэж би үздэг”.

(Андрей Сахаров, 1975)²

1975 оны Хельсинкийн төгсгөлийн баримт бичигт оролцогч орнууд буюу тухайн үеийн Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны чуулган (ЕАБХАЧ)-аар хүн эрхээ мэдэж, эрхийнхээ төлөө тэмцэх эрх, түүнчлэн хувь хүн хүний эрхийг хамгаалахад бусдаас тусламж эрэх, авах, бусдыг хүний эрх хамгаалахад нь туслах эрхийг тус тус хүлээн зөвшөөрсөн.³ Хувь хүн, бүлгэм, нийгмийн төрөл бүрийн байгууллагын даян дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах эрх, үүргийн тухай Нэгдсэн үндэстний байгууллагын Түгээмэл тунхаглалын агуулга, төслийг боловсруулах ажлын хүрээнд хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах хэрэгцээ байгааг цохон дурдсан (Будапештын баримт бичиг 1994). Иймээс, НҮБ-ын Түгээмэл тунхаглалаар хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийг хамгаалах эрхийг ЕАБХАБ-ын үүрэг амлалтад маш тодорхой тусгаж оруулсан.

Энэхүү хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах удирдамжийг боловсруулахдаа ЕАБХАБ-ын үүрэг амлалт, ЕАБХАБ-ын оролцогч орнуудын дагаж мөрдөхөөр амласан даян дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийн стандартууд дээр үндэслэн боловсруулснаас гадна бусад хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах тухай олон улсын чухал баримт бичгүүд, ялангуяа, НҮБ-ын Түгээмэл тунхаглалтай уялдуулсан. Мөн уг удирдамж нь тусгайлан шинэ стандарт эсвэл хүний эрхийг хамгаалагчдад зориулсан “тусгай” эрх бий болгоогүй. Харин, хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааныхаа улмаас эрсдэлд орсон хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалахад анхаарсан баримт бичгүүдийг эмхэтгэн гаргасан гэж ойлгож болох юм. Түүнчлэн энэ удирдамж нь хүн бүрийн хүний эрхийг тэгш хамгаалах зорилготой билээ.

2 Нобелийн лекц, 1975 оны 12 дугаар сарын 11-ний өдөр.

3 ЕАБХАБ-ын хүний аюулгүй байдлын хэмжүүрийн асуудлаарх бага хурлаас гарсан Копенхагены уулзалтын баримт бичиг, 1990 он.

ЗОРИЛТ БА АРГАЗҮЙ

Энэхүү удирдамжийн заалтуудыг ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн газар (АИХЭГ)-аас хүний эрхийг хамгаалагч нартай урт хугацаанд харилцаж ажилласан туршлага, олон жилийн турш энэ байгууллагын төвлөрч ажилласан гол асуудал болох хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагаагаа явуулдаг бодит нөхцөл байдалд үндэслэн боловсруулсан билээ.⁴ Түүнчлэн АИХЭГ төлөөлөх эрхийнхээ хүрээнд эдгээр удирдамжийг хүний эрхийг хамгаалагчтай холбоотой хүний аюулгүй байдлын хэмжүүрийн талаарх үүрэг амлалтаа биелүүлэхэд нь оролцогч улсуудад дэмжлэг болох зорилгоор гаргав.

АИХЭГ нь ЕАБХАБ-ын оролцогч улсуудыг “Хүний эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн хангах, эрх зүйт ёсыг мөрдөж, ардчиллын зарчмыг баримтлах [...] ардчилсан байгууллагуудыг бий болгох, бэхжүүлэх, хамгаалах, нийгэм даяар хүлээн зөвшөөрөх явдлыг хөхиүлэн дэмжих” үйл ажиллагаа явуулахад дэмжин ажиллах үүрэгтэй (Хельсинкийн баримт бичиг, 1992 он).

Уг удирдамжийг хүний эрхийг хамгаалагч, олон улсын мэргэжилтэн, засгийн газар хоорондын бусад байгууллага, иргэний нийгэм, хүний эрхийн үндэсний байгууллага, ЕАБХАБ-ын оролцогч улсуудын өргөн цар хүрээтэй төлөөллүүдтэй хийсэн уулзалт, зөвлөлдөөний явцад боловсруулсан юм. Мөн 2013 оны 6 дугаар сард зохион байгуулсан оролцогч орнуудын уулзалтын дараа бүс нутаг, улс орнуудад гарч буй гол асуудлуудыг тодорхойлох зорилгоор ЕАБХАБ-ын улсын хүний эрхийг хамгаалагчдыг хамруулсан зөвлөлдөх цуврал бүсчилсэн уулзалтыг АИХЭГ нь 2 сарын хугацаанд зохион байгуулсан.⁵ Түүнчлэн иргэний нийгмийн төлөөлөлд түлхүү хандах зорилгоор АИХЭГ бичгээр санал хүсэлтээ ирүүлэх “Нээлттэй уриалга” гаргаж, бүс нутагтаа зарлан түгээв. Хүний эрхийг хамгаалагч, олон улсын мэргэжилтнээс бүрдсэн 12 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөх баг удирдамжийн анхны төслийг хянаж,

4 Хамаарал бүхий өөр бусад сэдвээрх хэвлэлүүдээс гадна, АИХЭГ хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын талаар хоёр тусгай илтгэл хэвлүүлсэн. Үүнд: “ЕАБХАБ-ын бүс нутаг дахь хүний эрхийн хамгаалагчид: Бидний хамтын итгэл үнэмшил”, 2007 оны 12 дугаар сарын 10-ны өдөр, <<http://www.Osce.org/odihr/29714>>; ба “ЕАБХАБ-ын бүс нутаг дахь хүний эрхийн хамгаалагчид: Бэрхшээлүүд ба шилдэг туршлагауд” 2008 оны 12 дугаар сарын 15-ны өдөр, <<http://www.Osce.org/odihr/35652>>.

5 Дэд бүс нутгийн зөвлөлдөх уулзалтуудад хүний эрхийн төрөл бүрийн асуудалтай өөр өөр орнуудад ажилладаг 110 орчим хүний эрхийн хамгаалагч оролцсон. 2013 онд хоёр уулзалт зохион байгуулсан. Анхны уулзалтад Андорра, Австри, Бельги, Болгар, Канад, Гүрж, Хорват, Кипр, Бүгд Найрамдах Чех, Дани, Эстони, Франц, Финланд, Герман, Грек, Ватиканы ариун сэнтий, Унгар, Исланд, Ирланд, Итали, Латви, Лихтенштайн, Литва, Люксембург, Мальта, Монако, Нидерланд, Норвег, Польш, Португал, Румын, Сан Марино, Словени, Словак, Испани, Швед, Швейцар, Их Британи, АНУ, хоёр дахь уулзалтад Беларус, Молдова, Оросын Холбооны улс, Украины хүний эрхийг хамгаалагчдад оролцсон. Өөр хоёр уулзалтыг 2013 оны 10 дугаар сард зохион байгуулсан. Үүний эхнийхэд Албани, Армени, Азербайжан, Босни-Херцеговин, Гүрж, хуучнаар Югославын Бүгд Найрамдах Македон улс, Монтенегро, Серби, Турк улсын хүний эрхийг хамгаалагчдад, мөн Косово улсын төлөөлөгчид оролцсон. Дөрөв дэх зөвлөлдөх уулзалт Казакстан, Киргизстан, Монгол, Тажикстан, Туркменистан, Узбекистан улсын хүний эрхийг хамгаалагчдын бүрэлдэхүүнтэйгээр болж өнгөрсөн.

боловсруулахад дэмжиж оролцсон. АИХЭГ нь нарийн тодорхой, нэгдсэн баримт бичгийн төсөл боловсруулж гаргахад оролцогч улсуудын үзэл бодол, саналыг тусгах үүднээс 2014 оны 5 дугаар сард зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан юм.

ТАЛАРХАЛ

АИХЭГ нь зөвлөлдөх уулзалтуудад оролцож, үнэлж баршгүй хувь нэмрээ оруулсан байгууллага, хувь хүмүүст талархал илэрхийлье. Үүнд: НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн тусгай илтгэгч, түүний албаны болон арын албаны ажилтнууд зэрэг хүний эрхийг хамгаалагчдын хамгааллыг сайжруулахад хүчин зүтгэж буй олон улсын механизмуудын түнш, мэргэжилтнүүд, Европын хүний эрхийн хороо; Европын холбооны Парламентын йссамблейн Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн тусгай илтгэгч; Европын гадаад хэргийн алба; Америкийн улсууд дундын хүний эрхийн хорооны хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын тайлангийн газар, Хэвлэлийн эрх чөлөөний ЕАБХАБ-ын Төлөөлөгчийн газрын хамт олон багтана. Ялангуяа уг баримт бичгийг боловсруулахад үнэтэй зөвлөгөө, хувь нэмрээ оруулсан ажлын хэсгүүдийн гишүүдэд АИХЭГ-ын зүгээс гүнээ талархаж байна. Түүнчлэн зөвлөж хэлэлцэх бүхий л үйл ажиллагаанд оролцогч улс орнуудын оруулсан хувь нэмрийг дурдахад таатай байна.

Хэсэг А:

Хүний эрхийг хамгаалагчдыг
хамгаалах удирдамж

Хэсэг А:

Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах удирдамж

1. **Хүний эрхийг хамгаалах эрх нь даян дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн эрх:** Энэ нь салшгүй, бие даасан, харилцан шүтэлцээтэй бөгөөд ЕАБХАБ-ын оролцогч орнууд хүндлэх, хамгаалах, өөрийн нутаг дэвсгэр дээрх хүн бүрийн хувьд бүрэн хангах, хууль ёсоор эдлүүлэх үүрэг амлалт авсан түгээмэл хүний эрхүүдээс урган гарсан.
2. **Хүний эрхийг хамгаалагч нар гэж хэн бэ?** Хүний эрхийг хамгаалагч нар нь орон нутгийн, үндэсний, бүсийн, олон улсын түвшинд “ганцаарчлан болон бусадтай эвсэж хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хэрэгжүүлэх явдлыг хөхиүлэн дэмжиж, үүний төлөө эрмэлзэж” ажилладаг.”⁶ Тэд аливаа ялгаварлалгүйгээр бүх хүнд хамаатай хүний эрхийн түгээмэл чанарыг хүлээн зөвшөөрч, хүний эрхийг тайван замаар хамгаалдаг.
3. **Хүний эрхийг хамгаалагч нар ардчилсан нийгэмд амин чухал үүрэг гүйцэтгэдэг:** Олон улсын хүний эрхийн баримт бичгүүдийн хэрэгжилтийг бүрэн дүүрэн хангахын тулд тасралтгүй ахиц дэвшил гарган ажиллахад хүмүүс, бүлэг, байгууллага, институцүүдийн идэвхтэй оролцоо амин чухал. Бусад байгууллагаас гадна, иргэний нийгэм нь хүний эрх, үндсэн эрх чөлөө, ардчилал, эрх зүйт ёс бүрэн хэрэгжих нөхцөлийг хангахад төрийг дэмжин ажилладаг. Үүний нэгэн адил хүний эрхийг хамгаалагч нар ардчилсан нийгэмд чухал, хууль ёсны үүрэг гүйцэтгэдэг. Төрийн эрх бүхий байгууллагууд ардчилсан нийгэмд тайван замаар илэрхийлж байгаа шүүмжлэлт үзэл санааг дэмжих хэрэгтэй бөгөөд хүний эрхийг хамгаалагчдын хууль ёсны, чухал үүргийг олон нийтэд нээлттэйгээр хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.
4. **Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах хэрэгцээ шаардлага:** Хүний эрхийг хамгаалагч нар нь хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулсныхаа төлөө онцгой эрсдэлтэй учирч, ихэвчлэн ноцтой дарамт шахалтын бай болдог. Иймээс, орон нутаг, үндэсний, олон улсын хэмжээнд тусгай, нэмэлт хамгаалалтаар хамгаалуулах шаардлагатай. Хүний эрхийг хамгаалагчдын тодорхой төрлийн бүлгэмүүд нь үйл ажиллагааныхаа онцлог, анхаарч буй асуудал, газарзүйн байршил, үйл ажиллагаа явуулж

6 НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглал, Заалт №1, <http://www.ohchr.org/Documents/Issues/Defenders/Declaration/declaration.pdf>.

буй нөхцөл байдал эсвэл нийгмийн тодорхой бүлэгт харьяалагддагаасаа шалтгаалаад илүү ноцтой эрсдэлтэй тулгардаг.

5. **Төрийн үүрэг хариуцлага:** Хүний эрхийг хамгаалагчдын хамгааллыг нэн тэргүүнд сайжруулж хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах үүргийг төр биелүүлнэ. Төр нь хүний эрхийг хамгаалагчдын хамгаалах тал дээр эерэг ба сөрөг хариуцлагын аль алиныг хүлээнэ. Хүний эрхийг хүндлэх, хамгаалах ёстой гэж заасан олон улсын хуулиар хүлээсэн үүргийнхээ хамт, төр нь дараах хариуцлагыг үүрнэ. Үүнд:
 - а) Хүний эрхийн талаарх үйл ажиллагааны улмаас хүний эрхийг хамгаалагчдын аливаа эрхийг зөрчих үйлдэл гаргахаас татгалзах;
 - б) Хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааных нь улмаас гуравдагч талаас үзүүлэх дарамт шахалтаас хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах, энэ үйл явцыг зохих журмын дагуу шийдвэрлэх;
 - в) Хүний эрхийг хамгаалагчдын эрх, түүний дотор хүний эрхийг хамгаалах бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн санаачилгатай алхмуудыг авч хэрэгжүүлэх зэрэг болно.
6. **Хүний эрхийн үйл ажиллагаа явуулахад аюулгүй, таатай орчин:** Хүний эрхийг хамгаалагчдын нэр төр, бие махбод, сэтгэлзүйн халдашгүй байдал, эрх чөлөө, аюулгүй байдлыг үр дүнтэй хамгаалах нь хүний эрхийг хамгаалагчдын эрхийг хамгаалахурьдач шаардлага юм. Цаашлаад аюулгүй, таатай орчин нь итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх, олон нийтийн бодлогын үйл ажиллагаанд оролцох эрх чөлөө, зорчих эрх чөлөө, хувийн амьдралыг хүндэтгэх эрх, олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн механизм гэх мэт олон улсын байгууллагатай саадгүйгээр харилцаа холбоо үүсгэх эрх чөлөө зэрэг хүний эрхийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай бусад хүний үндсэн эрхийн хэрэгжилтийг шаарддаг.

I. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧДЫГ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

7. **Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах олон улсын шинжийг хүлээн зөвшөөрөх:** Хүний аюулгүй байдлын хэмжүүрийн хүрээнд хүлээсэн үүрэг амлалтууд нь ЕАБХАБ-ын оролцогч улс орнуудын хувьд шууд, хууль ёсны анхаарах асуудал мөн. Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах талаарх үүрэг хариуцлага нь голчлон оролцогч улсын нуруунд ирэх боловч, хүний эрхийг хамгаалагчдын эрхийн зөрчил нь дан ганц дотоод асуудал биш болж хувирна. Иймд оролцогч улс өөрийн болон бусад улсын нутаг дэвсгэр дээр ч хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах хэрэгцээ шаардлага буйг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Тиймээс тухайн улс хүний эрхийг хамгаалагчдыг

хамгаалах асуудлыг дотооддоо болон гадаадад авч үзэх зохистой бодлого, механизм бий болгох шаардлагатай юм.

8. **Төрийн бус талуудын хүлээх хариуцлага:** Төрийн бус талуудын зүгээс хүний эрхийг хамгаалагчдад учруулж буй дарамт, шахалтаас оролцогч улсууд хамгаалах үүрэгтэй. Гэвч төрийн бус талууд ч хүний эрхийг хамгаалагчдын эрхийг хэрэгжүүлэхэд чухал оролцоотой. Төрийн бус талууд өөрсдийн үйл ажиллагаагаа явуулахдаа олон улсын хүний эрхийн хэмжүүрийг хүндэтгэж, хүлээн зөвшөөрөх шаардлагатай. Оролцогч улсууд тэднийг дотоодын хууль, журмыг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх хэрэгтэй.
9. **Тэгш байдал ба үл ялгаварлах:** Хүний эрхийг хамгаалагчдыг үйл ажиллагааных нь төлөө ялгаварлан гадуурхах ёсгүй. Хүний эрхийг хамгаалах эрхийг аливаа ялгаварлалгүйгээр баталгаатай эдлүүлэх ба хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах арга хэмжээнд төрөл бүрийн хэлбэрийн ялгаварлан гадуурхалтай тулгардаг хамгаалагчдын онцгой хэрэгцээг тусгах хэрэгтэй. Хүний эрхийг хамгаалагчдын хамгааллыг бэхжүүлэх бүхий л үйл ажиллагаанд хүйсийн (жендер) болон ялгаатай байдлын мэдрэмж бүхий хандлагыг тусгах нь зүйтэй.
10. **Хууль эрх зүй, захиргаа, институтийн ээлтэй тогтолцоо:** Хүний эрхийг хамгаалагчдыг хууль ёсны үйл ажиллагаагаа явуулахад нь хамгаалдаг, дэмждэг аюулгүй, таатай орчин бүрдүүлэх, бэхжүүлэхэд дотоодын хууль тогтоомж, захиргаа, институтийн тогтолцоо хувь нэмрээ оруулах ёстой. Дотоодын хууль, журам, бодлого, практик нь ЕАБХАБ-ын үүрэг амлалт, хүний эрхийн олон улсын стандартуудад нийцсэн байх нь зөв. Тэдгээр нь гуйвуулж хэрэглэхээс сэргийлэх, хуулийн өмнө хүчинтэй байх үүднээс нарийн тодорхой байх шаардлагатай. Институтийн тогтолцоо нь хууль ёсны ажиллагаа, шударга байдлын үндсэн зарчмуудын баталгаа нь байх ёстой.
11. **Хүний эрхийн үйл ажиллагаатай холбоотойгоор суурь эрхэд тавигдах хязгаарлалтуудын хууль ёсны байдал, шаардлага ба пропорциональ байдал:** Олон улсын хүний эрхийн баримт бичгүүд нь зөвхөн тодорхой эрхүүдэд хязгаарлалт тавихыг зөвшөөрдөг. Тэдгээр хязгаарлалтууд нь зөвхөн хууль ёсны байх бөгөөд тодорхойлсон үндэслэлүүдийн аль нэгийг ашиг сонирхлын үүднээс ардчилсан нийгэмд зайлшгүй шаардлагатай тохиолдолд л зөвшөөрдөг. Түүнчлэн тэдгээр хязгаарлалт нь ялгаварлан гадуурхахыг хориглох гэх мэт үндсэн хүний эрхийн зарчмуудад нийцсэн, пропорциональ байх ёстой. Олон улсын хүний эрхийн механизмууд эдгээр зөвшөөрөгдөхүйц хязгаарлалтуудын цар хүрээг нарийн тодорхойлон тайлбарласан байх ёстойг тусгайлан анхааруулдаг. Хүний эрхийг

хамгаалах эрх нь бусад бүх эрхийг амжилттай хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг тул зөвшөөрөгдөхүйц хязгаарлалтуудын цар хүрээг улам багасгах шалтгаан болдог. Энэ мэт аливаа хязгаарлалтыг бий болгох зайлшгүй шаардлага ба пропорциональ байдлын шалгуурыг хангах босго нь маш өндөр байдаг.

II. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧДЫН БИЕТ ХАЛДАШГҮЙ БАЙДАЛ, ЭРХ ЧӨЛӨӨ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА НЭР ТӨР

A. Заналхийлэл, халдлага болон бусад хүчирхийллээс хамгаалах

12. Төрийн институтууд, албан хаагчид хүний эрхийг хамгаалагчид болон тэдний гэр бүлийн гишүүдийг онилон заналхийлэн сүрдүүлэх, хариу арга хэмжээ авах, эд хөрөнгийг эвдэж сүйтгэх, устгах, бие махбодод нь халдах, эрүүдэн шүүх болон бусад зүй бус байдлаар хандах, амь насыг хохироох, хүчээр сураггүй алга болгох эсвэл бие махбодын болон сэтгэлзүйн хор уршиг учруулах аливаа үйлдэл гаргахаас татгалзах ёстой. Мөн оролцогч улсууд хүний эрхийг хамгаалагчдыг төрийн бус талуудаас ирэх энэ мэт үйлдлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Төрийн эрх барих байгууллагууд ийм төрлийн үйлдлүүдийг олон нийтийн өмнө нээлттэйгээр буруушааж, үл тэвчих бодлого баримтлах нь зүйтэй.

Ял шийтгэлээс зугтах ба үүний эсрэг үр дүнтэй арга хэмжээ авах

13. Энэ мэт аливаа үйлдэлд буруутгагдсан мэдэгдлийг нэн даруй, хараат бусаар бүрэн мөрдөн шалгах ёстой. Цагдаа болон бусад төрийн албан хаагчдын үйлдсэн дарамт шахалттай холбоотой гомдолд хяналтын хараат бус хяналт ба түүнийг шалгаж илрүүлэх үр дүнтэй механизмтай байх, мөн хохирогчид хүний эрхийг хамгаалагч нарт чөлөөтэй хандах эрхтэй байх нь ийм хэргүүдийн хувьд хамгийн чухал хүчин зүйлс юм. Мөн цагдаа болон бусад хууль хүчний байгууллагын алба хаагчийн эсрэг нэхэмжлэл, гомдол гаргагч нь түүнийхээ төлөө ямарваа нэгэн дарамт, шахалтад өртөх ёсгүй.
14. Хүний эрхийг хамгаалагчдын гомдлын мөрөөр нэн даруй, нарийвчилсан, хараат бус, ил тод мөрдөн шалгах ажиллагаа явуулахад саад учруулж буй төрийн албан хаагч эсвэл төрийн бус талын аливаа хууль бус үйлдлийг эрх бүхий байгууллагууд хаацайлах ёсгүй. Мөрдөн шалгах ажиллагаа нь буруутай этгээдийг олж илрүүлэх, шаардлагатай бол шүүхээр шийдвэлрүүлэх чадвартай байж, идэвхтэй ажиллах ёстой. Аливаа шийтгэл нь учруулсан хохирлынхоо хэмжээнд пропорциональ байх хэрэгтэй. Хүний амьд явах эрх, эрүүдэн шүүх болон бусад төрлийн зүй бус харьцааны эсрэг хориглосон хууль тогтоомж, хүний эрхийг ноцтой

зөрчсөн бусад үйлдэлд оногдуулсан “албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласан” ял болон бусад эрүүгийн ялын аль алиныг сахилгын арга хэмжээгээр орлуулж эдлүүлэхгүй.

15. Оролцогч улсууд хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааныхаа хүрээнд хүний эрхийг хамгаалагчдын эсрэг үйлдсэн гэмт хэргийг хүндрүүлсэн нөхцөлөөр яллах тухай дотоодын хууль, тогтоомжиндоо тусгах хэрэгтэй.
16. Оролцогч улсууд гэмт хэргийн тухай хуульд өс хонзонгийн улмаас хүний эрхийг хамгаалагчдын эсрэг үйлдсэн гэмт хэргийг “хамаарлын улмаас” үйлдсэн гэсэн томьёоллоор авч үзэхээр тусгах хэрэгтэй. Хэрвээ хүний эрхийг хамгаалагч шууд харьяалагддаггүй боловч түүнд хамааралтай нийгмийн тодорхой бүлгийн эсрэг үйлдсэн гэмт хэргийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу дээр дурдсан нөхцөлтэй ижил төстэй шийтгэл оногдуулах шаардлагатай.
17. Оролцогч улсууд эрх зүйт ёс болон хараат бус шүүх эрх мэдлийн баталгааг бүрэн хангах ёстой. Хүний эрхийг хамгаалагчдын эсрэг үйлдсэн гэмт хэрэгт халдашгүй байдал бий болгохгүйн тулд шаардлагатай нөхцөлд, хуулийн реформ хийх ба хууль ёсны, хүртээмжтэй, үр нөлөөтэй эрх зүйн зохицуулалтын баталгааг хангаж хохирогч болон түүний гэр бүлийн гишүүдэд учирсан хохирлыг зохистой хэмжээгээр нөхөн төлөх боломжийг оролцогч улсууд бүрдүүлэх нь зөв.
18. Хүний эрхийг хамгаалагч шүүхэд саадгүй хандахад шаардлагатай хууль эрх зүйн болон бусад дэмжлэг үйлчилгээгээр хангаж өгөх хэрэгтэй.

Хамгааллын бодлого, хөтөлбөр, механизмууд

19. Оролцогч улсууд иргэний нийгмийн зөвлөмж, холбогдох олон улсын агентлагуудын техникийн зөвлөгөөг авч, эрсдэлд буй хүний эрхийг хамгаалагчдын аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангах зохих хамгааллын бодлого, хөтөлбөр, механизм боловсруулах хэрэгтэй. Үүнд биет хамгаалалт, түр нүүлгэн байрлуулах болон шаардлагатай бусад хамгаалах арга хэмжээ, дэмжлэг үзүүлэх үйлчилгээ зэрэг багтана.
20. Оролцогч улсууд аливаа хамгааллын хөтөлбөр, бодлого, механизм боловсруулахдаа хүйсийн мэдрэмжтэй хамгааллыг бий болгож, эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдын хэрэгцээ шаардлагыг хангасан хамгаалал, дэмжлэг үзүүлэх аргачлал, чадамжтай байх тал дээр анхаарах шаардлагатай. Хамгааллын хөтөлбөр, бодлого, механизм нь эрх нь зөрчигдсөн хувь хүн, бүлэг этгээдийн хэрэгцээ, шаардлагад тулгуурлан бусад эмзэг бүлэг хүний эрхийг хамгаалагч нарын тусгай хэрэгцээг тусгасан байх ба тэдгээрийг хангах чадвартай байх хэрэгтэй. Мөн шаардлагатай

үед, хүний эрхийг хамгаалагчид, тэдний гэр бүлийн гишүүдийг эрсдэлээс хамгаалах хамгааллын тогтолцоог бий болгох, энэ төрлийн эрсдэлээс сэргийлэх оновчтой арга хэрэгслийг тодорхойлоход оролцуулах нь чухал.

21. Оролцогч улсууд төсөвтөө эрсдэлт нөхцөлд байгаа хүний эрхийг хамгаалагчдад бие махбодын болоод сэтгэл санаандэмжлэг үзүүлэх, хамгаалах, онцгой байдлын тусламж болон бусад дэмжлэг үйлчилгээнд зориулан хангалттай хэмжээний хөрөнгө тусгаж өгөх хэрэгтэй. Мөн ийм төрлийн үйлчилгээ явуулдаг төрийн бус байгууллага (ТББ)-ыг идэвхтэй дэмжих шаардлагатай. Хэрвээ шаардлагатай бол оролцогч улсууд энэ зорилгоор олон улсын хамтын ажиллагаанаас санхүүжилт хүсч болно.
22. Дээр дурдсан арга хэмжээний хүрээнд тухайн нийгэмд хүний эрхийг хамгаалагчдыг олон нийтэд ухуулан таниулах, хандлага бий болгох, зан үйлийг хэвшүүлэх, улмаар тэдний хамгааллыг бэхжүүлэх зорилгоор холбогдох мэргэжлийн бүлгүүд, түүнчлэн хүний эрхийн тухай гүнзгий боловсрол олгоход чиглэсэн сургалт, мэдлэг олгох хөтөлбөрүүдийг багтаах хэрэгтэй.

Б. Хууль эрх зүйн дарамт, гэмт хэрэгт тооцох, дур зоргоор баривчлах, албадан саатуулахаас хамгаалах

23. Хүний эрхийг хамгаалагчдыг үйл ажиллагааных нь төлөө ямарваа нэгэн хууль бус шийтгэл оногдуулах, хуулийн дарамт, шахалт үзүүлж хуулийн болон шүүн таслах ажиллагаа явуулах, эрх мэдлээ урвуулан ашигласан аливаа үйлдэл эсвэл гэмт хэрэгт тооцох, дур зоргоор баривчлах, албадан саатуулах болон бусад төрлийн шийтгэл оногдуулахаас ангид байх ёстой. Хүний эрхийг хамгаалагчдыг албадан саатуулсан эсвэл тэдэнд оногдуулсан аливаа ял шийтгэлийн эсрэг гомдол гаргах, хууль ёсны эсэхэд нэхэмжлэл, гомдол гаргах эрхтэй байх ёстой.

Гэмт хэрэгт тооцох болон хуулийг дур зоргоор, мушгин гуйвуулж хэрэглэх

24. Оролцогч улсууд хүний эрхийг хамгаалагчдад хамааралтай дотоодын хууль эрх зүйн тогтолцоо, өөрсдийн үйл ажиллагааны хууль ёсны байдлыг олон улсын хүний эрхийн стандарттай жишиж хянах шаардлагатай. Мөн үүнийгээ хүний эрхийг хамгаалагч нартай өргөн хүрээнд, үр дүнтэй зөвлөлдөж, энэ талаар олон улсын дэмжлэг туслалцаа авах хэрэгтэй. Олон улсын стандартын дагуу хамгаалагдсан үйл ажиллагааны төлөө шууд болон шууд бус замаар гэмт хэрэгт буруутгаж байгаа хуулийн заалтад нэн даруй нэмэлт, өөрчлөлт оруулах эсхүл хүчингүй болгох нь зөв.

25. Өргөн агуулгатай, салаа утгатай тайлбар бүхий хуулийн заалтууд нь хүний эрхийг хамгаалагчдыг хүний эрхийн үйл ажиллагааных нь төлөө шүүхэд буруугаар ашиглагдаж болзошгүй учир тэдгээрт нэн даруй нэмэлт, өөрчлөлт оруулах эсхүл хүчингүй болгох шаардлагатай. Олон улсын шүүх эрх мэдэл, шүүх таслах ажиллагааны стандартын дагуу хүний шүүхээр эрхээ хамгаалах эрхийг бүрэн хангах ёстой.
26. Хууль эрх мэдэл, шүүн таслах ажиллагааг хүний эрхийг хамгаалагчдын эсрэг хэрэглэж айлган сүрдүүлэх, дарамтлах, мөрдөж хавчих эсвэл хариу арга хэмжээ авах зорилгоор ашиглах ёсгүй. Захиргааны болон хөнгөн зөрчлүүдэд оногдуулсан шийтгэл ямагт пропорциональ байх бөгөөд бие даасан, хараат бус шүүхээр гэм буруутай эсэхийг шийдвэрлүүлэх эрхтэй байх ёстой.
27. Оролцогч улсууд нь хүний эрхийг хамгаалагчдыг хүний эрхийн үйл ажиллагааныхаа төлөө улс төрийн сэдэлтэй мөрдөн шалгах ажиллагаа, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эсвэл хууль, дүрэм журмыг гуйвуулан ашиглах эрсдэлээс сэргийлэхийн тулд шаардлагатай хууль, шүүхийн эрх бүхий байгууллагын бие даасан байдлыг бэхжүүлэх, түүнчлэн хууль сахиулах байгууллагын зохистой үйл ажиллагааг хангах алхмуудыг авч хэрэгжүүлэх шаардлагатай.
28. Хүний эрхийг хамгаалагчдад учирч болзошгүй хуулийн дарамтыг хянах зорилгоор хууль сахиулах болон шүүхийн байгууллагын ажилтнуудын хяналтын тогтолцоог бий болгох нь зөв. Түүнчлэн шүүх эрх мэдэл болон хууль сахиулахын салбарт эрх мэдлээ урвуулан ашиглах эсвэл хээл хахуульд автах бололцоог бүрдүүлж буй тогтолцоо, бүтцийн хийдлийг авч хэлэлцэж, шийдвэрлэх шаардлагатай.
29. Хүний эрхийн зөрчлийг эсэргүүцэж үг хэлсэн, хүний эрхийг хамгаалах аливаа үйл ажиллагаанд оролцсон хууль сахиулах ажилтан, цэргийн алба хаагч, төрийн албан хаагч болон бусад төрийн албаны ажилтнуудыг айлган сүрдүүлэх, дарамт үзүүлэх, сахилгын арга хэмжээ авах эсвэл тэдний ажлын байртай холбоотой бусад дарамж шахалт үүсэхээс хамгаалах ёстой. Ялангуяа шүүх болон сахилгын арга хэмжээ оногдуулах эрх бүхий байгууллага зэвсэгт хүчний алба хаагчийг хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулах эрхээ хэрэгжүүлэх боломжгүйд хүргэх хэмжээний шийтгэлийн арга хэмжээ авч болохгүй. Тагнуулын байгууллага, аюулгүй байдлын бусад салбарын ажилтнуудад хориг, хязгаарлалт тогтоохдоо тэдгээрийн зайлшгүй ба пропорциональ байдалд маш өндөр шаардлага тавих хэрэгтэй.

30. Оролцогч улсууд, хууль болон практикт, шүүхэд нэхэмжлэл гаргасны төлөө зөрчил, ял шийтгүүлэх эсвэл хуулийн дагуу хариуцлага хүлээж буй хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах ёстой. Түүнчлэн шүүх хуралдааны танхимын гадна болон дотор тэдний бие махбод, хувь хүний халдашгүй байдлыг бүрэн хамгаалах ёстой. Хүний эрхийн хүрээнд ажилладаг өмгөөлөгчид хүний эрх хамгаалснаасаа эсвэл хүний эрхийг хамгаалагчдыг өмгөөлснөөсөө хуульчдын гишүүнчлэлээсээ хасагдах, айлган сүрдүүлэлтэй тулгарах эсвэл аливаа хариу арга хэмжээнд өртөх ёсгүй.

Дур зоргоор албадан саатуулах ба албадан саатуулах үеийн нөхцөл

31. Оролцогч улсууд нь хүний эрхийг хамгаалагчдыг хүний эрхийн үйл ажиллагаанд оролцсоных нь төлөө эрх, эрх чөлөөг нь дур зоргоор хязгаарлах ёсгүй. Хүний эрх чөлөөг хязгаарласан аливаа үйлдэл нь хуулийн дагуу бөгөөд хуулиар зөвшөөрөгдсөн байх ба шударга шүүхийн өмнө хууль ёсны эсэхийг тогтоолгох, эс бөгөөс олон улсын стандартуудад нийцсэн байх ёстой.
32. Хүний эрхийг хамгаалагчдыг дур зоргоор албадан саатуулсан бол нэн даруй суллах шаардлагатай. Энэ тохиолдолд оролцогч улсууд нь олон улсын хүний эрхийн механизмаас гаргасан шийдвэр, саналыг бүрэн баримтлах шаардлагатай.
33. Хүний эрхийг хамгаалагчдыг хүний эрхийн үйл ажиллагаа явуулахаас нь татгалзуулах, айлган сүрдүүлэх эсвэл түр хугацаагаар хорих эсвэл албадан саатуулах ёсгүй.
34. Эрх чөлөөгөө хасуулсан хүний эрхийг хамгаалагчдыг ялгаварлан гадуурхахгүйгээр олон улсын стандартын дагуу хандах ёстой. Хүний эрхийг хамгаалагчдын хүний эрхийн үйл ажиллагаа явуулах хүч зоригийг нь няцаах эсвэл түүнийх нь төлөө шийтгэх зорилгоор зөвхөн өөрийг нь ялгаж, тусгайлан арга хэмжээ авахуулах ёсгүй. Тэднийг гадагш харилцаа холбоо тогтоох боломжгүйгээр удаан хугацаагаар албадан саатуулж болохгүй. Тэдгээр хүмүүс өөрийн хүслээр, сонгосон өмгөөлөгчөө сонгох, гэр бүлийн гишүүдээ эргэлтээр авах боломжтой байх ёстой. Албадан саатуулагдсан үед нь хоол, эрүүл мэндийн үйлчилгээгээр хангах шаардлагатай. Шоронгийн хүнд нөхцөлөөс ангид байлгаж, аливаа төрлийн эрүүдэн шүүх, бусад зэрлэг балмад, хүний ёсноос гажууд, гутаан доромжилсон дэглэлтэд өртөхөөс бүрэн хамгаалах ёстой. Эрх бүхий байгууллагууд тэднийг өдөөн хатгаж болзошгүй, дарамт учруулагч аливаа этгээд, бусад албадан саатуулагдсан хүмүүс, хамт хоригдогсдын дарамт шахалтаас хамгаалах арга хэмжээг зохих журмын дагуу авах үүрэгтэй. Эрүүдэн шүүсэн болон бусад төрлийн зүй бус харьцаанд өртсөн тухай бүх гомдлыг нэн даруй, хараат бусаар, үр

дүнтэй мөрдөн шалгаж, шүүх эрх мэдлийн байгууллагад шилжүүлэх хэрэгтэй.

35. Эрх бүхий байгууллагууд албадан саатуулагдах үед эмэгтэй болон бусад хүний эрхийг хамгаалагч нарт тулгарч болзошгүй онцлог эрсдлийг тооцоолж, цагдаагийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдыг хүйсийн онцлогийн тухай сургалтад хамруулж, олон улсын стандартад заасан зохих үйлчилгээнүүдийг үзүүлэх зэргээр тэднийг албадан саатуулагдах үед хүйсийн сэдэлтэй дарамт, зөрчлөөс хамгаалах шаардлагатай.

Шударга шүүх

36. Хүний эрхийг хамгаалагчдад эрүүгийн ял төлөвлөсөн тохиолдолд хүний эрхийг хамгаалагч мэргэшсэн, хараат бус, шударга дагнасан шүүхээр шүүлгэх эрхтэй. Үүнд гэмт хэрэгт буруутгагдсан хүний эрхийг хамгаалагч өөрийн сонгосон өмгөөлөгчөөс бүрдсэн хуулийн төлөөлөлтэй байх, хэрэг хүлээлгэхийн тулд хүчлэх, гэрчийн мэдүүлэг гэх мэт эрүүдэн шүүх, зүй бус аргаар олсон нотлох баримтуудыг хууль ёсны шүүн таслах ажиллагаанд баримтаар татахгүй байх гэх зэрэг багтана. Мөрдөн шалгах болон бусад төрлийн албаны ажилтнуудын зүй бус үйлдэл дээр үндэслэсэн хүний эрхийг хамгаалагчдын эсрэг мэдэгдлийг шүүхэд тэдний эсрэг ашиглах ёстой. Тэдний өмгөөлөгчдийг төрийн албан хаагч болон төрийн бус талын дарамт шахалтаас сайтар хамгаалах хэрэгтэй. Хүний эрхийг хамгаалагчдын үйлчлүүлэгч болон бусдыг шүүхэд тэдний эсрэг мэдүүлэг өгөхийг шахах үйлдэл гаргахаас хамгаалахаас гадна урьдчилан сэргийлэх шаардлагатай. Шүүхээр шүүлгэж буй хүний эрхийг хамгаалагч, өмгөөлөгч нарын хооронд солилцсон мэдээллийн нууцлалыг бүрэн баталгаажуулах ёстой. Мөн төлбөрийн чадваргүй хүний эрхийг хамгаалагч нар шүүхийн өмнө өөрийгөө зохих ёсоор төлөөлүүлэх, тэгш эрх эдлэх боломжоор хангахын тулд ашиглахад бэлэн, түүнд хамрагдах боломжтой эрх зүйн туслалцааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ёстой.

В. Доромжлол, гадуурхалтай тэмцэх нь

37. Төрийн институтууд, албан хаагчид хувь хүнийг харлуулах ажиллагаа, хүний эрхийг хамгаалагч, түүний ажлыг буруугаар ухуулан таниулах, эсвэл гутаан доромжлох үйлдэлд оролцохоос татгалзах хэрэгтэй. Үүнд хүний эрхийг хамгаалагч нарт нэр хоч өгөх, хүний эрхийг хамгаалах ажлыг нь үгүйсгэх, эсвэл ямар нэг байдлаар тэднийг гүтгэн доромжлох зэрэг орно.

38. Оролцогч улсууд нь хүний эрхийг хамгаалагчдыг харлуулах ажиллагаа, доромжлолын эсрэг авах арга хэмжээнүүдийг санаачилж, хэрэгжилтийг хангах хэрэгтэй. Үүнд гуравдагч талын этгээдүүдийн гаргасан үйлдлүүд ч багтана. Төрөөс хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах хэрэгцээ шаардлага, хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааг олон нийтэд нээлттэйгээр хүлээн зөвшөөрч, сурталчлах нь зөв. Мөн хүний эрхийг хамгаалагч хувь хүнийг үнэлж, улмаар нийгэм дэх хүний эрхийн үйл ажиллагааны хууль ёсны байдал, статусыг баталгаажуулах хэрэгтэй.
39. Оролцогч улсууд хүний итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хүндэтгэхийн зэрэгцээ цахим хэлбэрээр болон биет байдлаар үзэн ядсан ухуулга, ялгаварлан гадуурхах явдал, дайсагнал, хүчирхийлэлд турхирах гэх мэт хүний эрхийг хамгаалагчдын эсрэг бусад төрөл хэлбэрийн үл тэвчих хандлагатай тэмцэх бодлого боловсруулж баримтлах хэрэгтэй. Үндэсний, бүс, орон нутгийн гэх мэт бүх түвшний Засгийн газар, төрийн байгууллагууд хүний эрхийг хамгаалагчдын эсрэг сэдэл, эсвэл бодит үйлдэл халдлага гарсан тухай бүрд олон нийтэд нээлттэйгээр мэдээлэлж, эл үйлдлийг буруушаан зэмлэх шаардлагатай. Олон улсын стандартад тодорхойлон заасан үндсэрхэг, арьс өнгөний, эсвэл шашны үзэн ядах үзлийн шинж бүрдсэн аливаа үйлдлийг хуулиар хориглож, ийм үйлдэл гарсан тохиолдолд холбогдох хариуцлагыг оногдуулах ёстой. Эдгээр хууль нь олон улсын хүний эрхийн стандартад бүрэн нийцэх ёстой.
40. Хүний эрхийг хамгаалагчдыг гадуурхалд өртөхөөс зайлсхийхийн тулд олон нийтийн мэтгэлцээнд оролцохоос эхлэн тэдний оролцоог хүчтэй болгох зорилгоор төрийн байгууллагаас хүний эрхийг хамгаалагч нартай санаачилгатай, үр дүнтэй хамтран ажиллах хэрэгтэй. Энэхүү арга хэмжээ нь эрх баригчдын хувьд эмзэг, тэднийг шүүмжилсэн шинжтэй байсан ч төрийн байгууллагууд тэдний хувь нэмрийн ач холбогдол, ажлынх нь нийгэмд хамаатай байдлыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Парисын зарчмуудын⁷ дагуу байгуулж, ажиллуулдаг Үндэсний хүний эрхийн байгууллага (ҮХЭБ-ууд)-ын гүйцэтгэх үүрэг нөлөөг өндөрсгөхөд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй ба Засгийн газраас ҮХЭБ-ын зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлж буй эсэхийг хянадаг зохих механизм боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай. Энэхүү зөвлөх механизмыг ашиглан хүний эрхийг хамгаалагч, төрийн институт хооронд тогтмол яриа өрнүүлэх хэрэгтэй. Энэ механизм нь хүний эрхийн санаа зовоосон асуудлуудыг ухуулан таниулах, нэхэмжлэл гаргах механизмыг хөхиүлэн дэмжих, улс орон дахь хүний эрхийн зөрчилд анхаарлаа хандуулах, хариуцлага тооцох

7 1993 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Тогтоол №48/134, "Хүний эрхийг хамгаалан дэмжих үндэсний институт", НҮБ-ын Б.Б. А/RES/48/134-г үз.

зорилгоор хамтарсан үйл ажиллагаа, ухуулга, хүний эрхийн боловсролын хөтөлбөр зохиож хэрэгжүүлэх үндэс суурь болох ёстой юм.

III. ХҮНИЙ ЭРХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АЮУЛГҮЙ, ТААТАЙ ОРЧИН

41. Оролцогч улсууд хүний эрхийн холбогдолтой аливаа арга хэмжээг хүндэтгэж, хөхиүлэн дэмжиж, зохион байгуулах хэрэгтэй. Мөн хүний эрхийг хамгаалагчдыг хүний эрхийн үйл ажиллагаагаар бие даан, эсвэл бусадтай хамтран, орон нутагтаа эсвэл хилийн чанадад чөлөөтэй, үндэслэлгүй хязгаарлалтаас ангид эрхлэн явуулах боломжоор хангаж аюулгүй, таатай орчин бүрдүүлэх практик арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зөв. Бусад эрх, эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх боломж нь хүний эрхийг хамгаалах гол арга хэрэгсэл юм.

Г. Үзэл бодлоо илэрхийлэх, мэдээллийн эрх чөлөө

42. Оролцогч улсууд итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх тухай эрх зүйн баримт бичгүүдийг эргэн нягталж, олон улсын хүний эрхийн стандартуудад нийцээгүй заалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох шаардлагатай. Үүнд үндэсний аюулгүй байдал, нийтийн хэв журам, нийтийн ёс суртахуун, хүн амын эрүүл мэнд, эрүүл ахуйн журмын эсрэг болон өөр бусад шалтгаанаар үндэслэлгүй хязгаарлалт тогтоох зэрэг олон улсын стандартуудад зөвшөөрдөггүй заалтууд багтана. Зэвсэгт хүчний, эсвэл төрийн албан хаагчийн гэх мэт тодорхой бүлгэм, эсвэл мэргэжилтнүүд итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэхэд тусгай хязгаарлалт тогтоосон хууль журмыг батлахдаа тухайн заалтууд нь заавал хязгаарлалт тогтоох хэрэгцээ шаардлага, пропорциональ байдалд тавьдаг олон улсын өндөр шаардлага стандартуудад нийцсэн эсэхийг нягтлан шалгах нь зөв.
43. Оролцогч улсууд нь хүний эрхийг хамгаалагчдыг шоронд хорих, дуугүй байлгах, сүрдүүлэх зорилгоор эрүүгийн болон холбогдох бусад хууль тогтоомжиндоо дур зоргоор ашиглаж болзошгүй, салаа утгатай үгээр илэрхийлсэн заалтуудыг тухайн хууль тогтоомжоос хасах ёстой. Мөн ялгаварлан гадуурхалт, үл тэвчих байдлын эсрэг ухуулга хийхийг хориглосон, Засгийн газар болон төрийн албан хаагчийг шүүмжилсэн, үл хүндэтгэсэн явдлыг гэмт хэрэгт тооцох, төрийн байгууллага, төрийн бэлгэ тэмдгийг үл хүндэтгэсэн үйлдлийг хориглосон, энэ төрлийн бусад хуулийн заалтууд гэх мэт олон улсын хуульд заасан хүний эрхийг хамгаалагчдын эрхэд хязгаарлалт тогтооход тавигдах хэрэгцээ шаардлага ба пропорциональ байдалд тавьдаг өндөр шаардлагад тусгагдаагүй заалт

бүхий хууль тогтоомжуудыг хүчингүй болгох хэрэгтэй. Шүүмжлэлт үзэл бодлоо тайван замаар илэрхийлж болно гэсэн зарчмыг хүндэтгэн үзэх хэрэгтэй.

44. Үүнтэй адилаар, гүтгэхийг гэмт хэрэгт тооцох тухай хуулийг хүчингүй болгох хэрэгтэй. Гүтгэх болон цахимаар үйлдэгдсэн үүнтэй ижил төстэй зөрчлүүдийг Иргэний хуулиар зохицуулах хэрэгтэй. Амаар, бичгээр болон, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гүтгэх гэх мэт нэр хүнд гутаасан зөрчлүүдэд шоронд хорих гэх мэт эрүүгийн хүнд ял оноохгүй. Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх үйлдлийг зохицуулдаг Иргэний хууль нь хувь хүн болон хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг эрсдэл оруулах, дампууралд хөтлөх, өөртөө үзэл санааны шүүлтүүр тавихад хүргэх үр дагавартай санхүүгийн шийтгэл зэрэг бусад үндэслэлгүй шаардлагуудыг тусгахгүй байх хэрэгтэй.

Нийтийн эрх ашигт хамаатай мэдээлэл авах боломж, шүгэл үлээгчид

45. Оролцогч улсууд нь хүний эрхийг хамгаалагчдыг мэдээлэл түгээснийх нь төлөө үйл ажиллагаагаа явуулах, эсвэл хамгаалуулагч талдаа үйлчилгээгээ хүргэх боломжгүйд хүргэхүйц үр дагавартай үндэслэлгүй хязгаарлалт тогтоож болохгүй.
46. Оролцогч улсууд хүний эрхийг хамгаалагчдын гаргасан болон бусад төрлийн албан ёсны баримт бичгүүдтэй чөлөөтэй, тэгш эрхтэйгээр танилцах боломжоор хангасан мэдээллийн эрх чөлөөний хууль боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгтэй. Мөн нийгэм олон нийтэд ийм хуультай болохыг сурталчлан таниулж, тэдний албан ёсны баримт бичигтэй танилцах эрх, танилцах хүсэлт гаргах тусгай журмын талаар мэдээлэл өгөхөд санаачилгатай арга хэмжээ авах ёстой.
47. Хүний эрхийн зөрчил, гэмт хэргүүдтэй холбоотой олон нийтийн ашиг сонирхол бүхий мэдээлэлтэй танилцах эрхэд хууль бус хязгаарлалт тогтоохоос сэргийлэх хэрэгтэй. Үүний тулд төрийн нууцын тухай тусгасан хууль, журам, практикт дүн шинжилгээ хийж, шаардлагатай бол нэмэлт, өөрчлөлт оруулах ёстой.
48. Оролцогч улсууд төрийн болон хувийн салбар дахь авлига, хээл хахууль, зөрчлийг нийтийн эрх ашгийн төлөө илчилдэг шүгэл үлээгчдийн ач холбогдлыг үнэлэх хэрэгтэй. Мөн шүгэл үлээгчдийн хамгаалах, аюулгүй сонголт хийх боломжоор хангах чадвартай хууль тогтоомж боловсруулж хэрэгжүүлэх хэрэгтэй. Шүгэл үлээгчдийн эсрэг шүүн таслах ажиллагаанд тэдний мэдээлсэн мэдээлэлд дурдагдаж буй нийтийн эрх ашгийн харьцааг зөв тооцоолох хэрэгтэй. Ялангуяа төрийн албан тушаалтан болон төрийн

бус тал хүний эрхийн ноцтой зөрчил гаргасныг мэдээлэхдээ төрийн нууц задалсны төлөө шүгэл үлээгчдийг шүүх, ял шийтгүүлэхээс найдвартай хамгаалах шаардлагатай бөгөөд тухайн нууцыг төрийн нууц гэж үзэж хамгаалах ёсгүй.

49. Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх цахим орчинд ч хүчинтэй. Оролцогч улсууд интернэт, тоон мэдээллийн технологийн хэрэглээнд тэгш эрхийг дэмжиж, тэгш хүртээмжтэй орчинг бий болгох хэрэгтэй. Интернэт харилцаа холбооны талаар гаргасан төрийн аливаа хууль тогтоомж нь итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд мөрддөг олон улсын стандартуудад заасан өндөр шалгууруудыг нэг бүрчлэн дагаж мөрдөх шаардлагатай. Зөвхөн тухайн нийгмийн зөрчилтэй асуудлыг хэлэлцсэн, эсвэл тухайн засгийн газарт шүүмжлэлтэй хандсан гэх шалтгаанаар цахим агуулгыг шүүж дамжуулах, цахим хуудас, гадаад мэдээ, бусад үйлчилгээг хаах эсвэл тэдгээрийг сонгож дамжуулах нь эдгээр стандартуудад үл нийцнэ.
50. Оролцогч улсууд өөрийн улс орны хууль тогтоомжид захирагддаг. Гэвч олон улсад үйл ажиллагаагаа явуулдаг интернэтийн үйлчилгээ үзүүлэгчид болон бусад хувийн компаниуд өөрийнх нь болон бусад оролцогч улсуудын нутаг дэвсгэрт дээрх мэт үндэслэлгүй хязгаарлалтуудыг баримтлахгүй байх тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй. Хувийн цахим хуудас хөтлөгчид (bloggers), нийгмийн цахим сүлжээ хэрэглэгчид эрх баригчдын талаар эмзэг сэдэв бүхий агуулга, хувийн сэтгэгдэл (comment) нийтэлснийхээ төлөө үр дагавар амсахаас хамгаалах шаардлагатай.

Хэвлэлийн эрх чөлөө

51. Хүний эрхийн хамгааллыг сайжруулах талаар шинэ санал, санаачилга дэвшүүлэх, хүний эрхийн талаарх шинэ асуудлуудыг гаргаж ирж хэлэлцэхэд нь туслах олон нийтийн мэтгэлцээнд хүний эрхийн хамгаалагчдыг оролцоход нь хэвлэл мэдээллийн байгууллагууд дэмжих хэрэгтэй. Иймээс оролцогч улсууд хэвлэл мэдээллийн хүний эрхийг хамгаалагчдад нээлттэй байдлыг нэмэгдүүлэх үүднээс хэвлэл мэдээллийн салбараа хүчтэй, олон ургалч болгох тал дээр далайцтай арга хэмжээ авах нь зөв.
52. Оролцогч улсууд хэвлэл мэдээллийн тухай хууль, бодлого, практикаа эргэн харж, эдгээр хууль нь хүний эрхийг хүндэтгэдэг, хүний эрхийн талаар мэдлэгтэй, бие даасан, олон ургалч үзэлтэй, хүний эрхэд ээлтэй, хүний эрхийг илүү нээлттэй ухуулан таниулдаг хэвлэл мэдээллийн орчныг дэмжиж байгаа эсэхийг нягтлах хэрэгтэй. Хэвлэл мэдээллийн салбарын бие

даасан байдлыг бэхжүүлэхдээ сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг хамруулсан бие даасан мэргэжлийн сургалт явуулах нь зүйтэй юм.

53. Эрх баригчдын үзэл бодол, уламжлалт үнэт зүйлд харш байж болзошгүй, нийгэмд зөрчилдөөнтэй асуудлуудыг хөндсөн, авлига, алдаатай удирдлага зохион байгуулалт, хүний эрхийн зөрчлийн талаар мэдээлэх, засгийн газрыг шүүмжлэхээс сэргийлэх, эсвэл үүнийх нь төлөө шийтгэхийн тулд хэвлэл мэдээллийн салбарыг албан болон албан бус байдлаар хянах, мэдээлэлд шууд болон шууд бус байдлаар шүүлтүүр (цензур) тавих эрх үүрэг өөртөө олгохоос оролцогч улсууд татгалзах хэрэгтэй. Мөн төрийн байгууллага, албан хаагчид, хувийн мэдээллийн байгууллагууд, арилжааны байгууллагууд чөлөөтэй мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх боломжийг хангах ёстой. Тэдний итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг нь боогдуулахгүй байх тал дээр анхаарч ажиллах шаардлагатай.
54. Үйл ажиллагааны статус, төрлөөсөө (хэвлэл, радио, телевиз, эсвэл интернэт) үл хамааран сэтгүүлч болгон хүний эрхийг хамгаалагч юм. Хүний эрхийн зөрчил, авлига, эсвэл удирдлагын алдаа юм уу, шүтэл үлээгчдийн ажлын талаар сурвалжилсан сэтгүүлч үүнийхээ төлөө мөрдөн байцаалт, эрүүгийн хэрэгт шүүхээр шийдүүлэх болон бусад төрлийн шахалт хавчлагад өртөх ёсгүй. Эрх мэдлээ буруугаар, эсвэл урвуулан ашигласныг илчилж бичдэг хараат бус эрэн сурвалжлах сэтгүүл зүйн ач холбогдлыг эрх бүхий байгууллагууд үнэлж, хариуцлагатай байдлыг сайжруулах үүднээс тэднийг дэмжих хэрэгтэй. Түүнчлэн сэтгүүлчид аливаа хариу арга хэмжээнд өртөх айдас, хөндлөнгийн саадгүйгээр ажлаа хийх нөхцөлөөр хангах хууль эрх зүйн болон бусад дэмжлэгийг чөлөөтэй авах, сэтгүүлчийг дур зоргоор гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаанд өртүүлэхгүй байх нөхцөлийг хангах ёстой. Ялангуяа сэтгүүлчдийн аюулгүй ажиллагааг хангаж, сэтгүүлч-хүний эрхийг хамгаалагчдыг оролцогч орны болон төрийн бус талын халдлага, бусад төрлийн дайралтаас найдвартай хамгаалуулах нөхцөлийг хангах шаардлагатай. Сэтгүүлч болон бусад хүний эрхийг хамгаалагчдын эсрэг үйлдсэн аливаа гэмт хэргийг нэн даруй, үр дүнтэй, хараат бусаар мөрдөн шалгаж, буруутай этгээдэд шүүхийн өмнө зохих хариуцлагыг хүлээлгэх хэрэгтэй.

Д. Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө

55. Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль тогтоомж, практик нь олон улсын стандартуудад бүрэн нийцсэн байна. Зөвхөн хууль болон олон улсын хүний эрхийн стандартуудаар ардчилсан нийгэмд зайлшгүй гэж үзэж заасан тусгай үндэслэлийдийн хүрээнд л эвлэлдэн

нэгдэх эрх чөлөөнд хязгаарлалт тогтоож болно. Үүний сацуу, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөнд тогтоох хязгаарлалт нь пропорциональ байх ёстой. Холбогдох хууль тогтоомжийн төсөл бичих, хянан хэлэлцэхэд оролцдог эрх бүхий байгууллагууд, мөн хэрэгжүүлэгч талуудад (үндэсний, бүс, орон нутгийн эрх бүхий байгууллагууд, хууль сахиулах, шүүхийн байгууллага гэх мэт) *ЕАБХАБ/АИХЭГ-Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай* Венецийн хорооны удирдамжийг тусгаж ажиллахыг уриалж байна.

56. Хүний эрхийг хамгаалагчдад жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй холбоотой олон улсын стандартуудад зааснаас бусад хязгаарлалтуудыг тогтоох ёсгүй. Эрх баригчдад шүүмжлэлтэй хандсан, эсвэл нийгэмд зөрчилдөөнтэй утга бүхий гэж үзсэн агуулгад тогтоосон хязгаарлалт нь энэ стандартуудад нийцэхгүй. Эвлэлдэн нэгдэхийг бүрмөсөн хориглох явдлыг олон улсын хүний эрхийн стандартуудад тодорхойлсон маш онцгой нөхцөлд л зөвшөөрнө.
57. Эвлэлдэн нэгдэх үйл ажиллагаа зохион байгуулж буй хүний эрхийг хамгаалагчдаас эрх бүхий байгууллагууд аливаа мэдээлэл шаардахыг хориглоно. Зөвхөн жагсаал, цуглааныг төлөвлөх, олон нийтийн хэв журам сахиулах, ард нийтийн аюулгүй ажиллагаа, бусдын эрх, эрх чөлөөг хангах арга хэмжээ авах зорилгоор урьдчилан мэдээлэл авна. Тайван жагсаал, цуглааны арга хэмжээний цаг, байршил, арга хэлбэрээс шалтгаалан хууль ёсны хязгаарлалт тогтоосон бол хүний эрхийг хамгаалагчдыг зорилтот бүлгийнхээ “нүдэнд харагдаж, чихэнд сонсогдохуйц” өөр газар зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн нөхцөлөөр хангах ёстой. Оролцогч улсууд нь хууль бус хязгаарлалтын талаар гаргасан нэхэмжлэлийг шалгах зохих журамтай болох ёстой. Эрх бүхий байгууллагууд жагсаал, цуглаан хийхэд саад хийх, жагсаал, цуглаан зохион байгуулагч нарт жагсаал, цуглаан зохион байгуулах сонирхолгүй болоход хүрэхүйц үндэслэлгүй шаардлага тавихаас татгалзах хэрэгтэй.
58. Аль нэг төрийн эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэхгүйгээр цуглах, жагсах эрх чөлөөний үзлийн дагуу гэнэт цуглаан хийх эрх зүйн орчныг мөн бүрдүүлж болно. Урьдчилан мэдэгдээгүй жагсаал, цуглаанд оролцсон хүний эрхийг хамгаалагч нар нь уг жагсаал, цуглаанд оролцсоныхоо төлөө баривчлуулах, албадан саатуулагдах, эсвэл торгуулах ёсгүй. Жагсаал, цуглаан зохион байгуулахтай холбоотой хууль, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйн төлөө хүлээлгэх торгууль, эсвэл бусад шийтгэлийн хэлбэрүүд нь гаргасан зөрчлийн хүнд, хөнгөнд тохирсон шударга байх ёстой бөгөөд хэрэв ийм биш тохиолдолд тухайн хууль тогтоомжийг хүчингүй болгох ёстой. Жагсаал, цуглаан зохион байгуулагч нь тухайн тэмцлийг

тайван замаар явуулахад чиглэгдсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах гэж хичээсэн л бол ямар ч тохиолдолд хувь оролцогчдын тайван жагсаал, цуглааныг үймүүлсэн хууль бус үйлдлийн төлөө хариуцлага хүлээхгүй. Оролцогч улсууд нь жагсаал, цуглааны эрх чөлөөгөө эдлэх явцдаа захиргааны болон бусад хэлбэрийн зөрчил гаргасан хүний эрхийг хамгаалагч нар хэрэг хянан шийдвэрлэх процессийн хамгаалалт бүрэн авч чадаж буй эсэхийг хянах ёстой.

59. Жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулахдаа хууль сахиулах алба хаагчид тайван жагсаал, цуглаан хийх эрхээ эдэлж буй хүний эрхийг хамгаалагчдад хүч хэрэглэхээс эрс татгалзах ёстой. Онцгой эрсдэлд буй тодорхой бүлэг хүний эрхийг хамгаалагчдын жагсаал, цуглааны хэв журам сахиулж байх үедээ тухайн нөхцөл байдлын онцлогт тохируулан тусгайлан анхаарал хандуулах ёстой. Үүнд: эрсдэлийн үнэлгээ, нэгж тасгуудын зохион байгуулалтын бодлого, эсвэл урьдчилсан сургалт бэлтгэл гэх мэт орно. Хэрвээ цуглаан эмх замбараагүй болохоор нөхцөл байдал үүссэн тохиолдолд цагдаа зөвхөн шаардлагатай үед л тухайн нөхцөл байдалд тохирсон хүч хэрэглэнэ. Хүч хэрэглэхдээ түрэмгий жагсагч, үйл явдлыг сурвалжилж буй сэтгүүлч, тайван жагсагч, хянагчид, эсвэл хажуугаар өнгөрөх хүмүүсийг ялгалгүй хүч хэтрүүлэн хэрэглэхээс эрс татгалзах ёстой. Хууль сахиулах байгууллагын ажилтны гаргасан зохисгүй үйлдэл, хүч хэтрүүлэн хэрэглэсэн гэх мэт зөрчлүүдийг нэн даруй, хараат бусаар мөрдөн шалгаж, зохих этгээдүүдэд тохирох хариуцлагыг хүлээлгэх хэрэгтэй. Хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг жагсаал, цуглааны хэв журам сахиулахдаа хүний эрхийн зарчмуудыг үйл ажиллагаандаа мөрдөх чадвартай байлгахын тулд хангалттай мэдлэг олгохуйц тогтмол сургалтаар хангаж, эдгээр сургалтуудыг шинээр боловсруулах, заахдаа хүний эрхийг хамгаалагчдыг оролцуулах хэрэгтэй.
60. Түүнчлэн, оролцогч улсууд хүний эрх хамгаалагчдыг тайван жагсаал, цуглаан хийх эрхээ ялгаварлалд өртөлгүйгээр эдлэхэд нь саад болох зорилготой гуравдагч талын аливаа үйлдлээс хамгаалах үүрэгтэй билээ. Үүнд, цуглаан болохын өмнө болон болсны дараа зохион байгуулсан, оролцсон хүмүүс заналхийлэл, хүчтэй дайралттай тулгарсан тохиолдолд бие махбодын хамгаалалт үзүүлэх зэрэг орно. Энэ нь Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, арьс өнгөний ялгааг үл тэвчих, ксенофоби (гадаад хүнийг үзэн ядах үзэл), эсвэл ялгаварлан гадуурхах явдлыг эсэргүүцэх жагсаал зэрэг уламжлалт үнэт зүйлсийг шүүмжлэх, эсвэл хэт даврагч улс төрийн үзэл бодлыг эсэргүүцэх зорилготой жагсаал, цуглааны тухайд маш чухал юм.
61. Эрх бүхий байгууллагууд хамгаалалтын хэрэгцээ шаардлага, түүнийг шийдвэрлэх зохих арга хэмжээг тодорхойлохдоо жагсаал, цуглаан

зохион байгуулагч нартай байгын холбоотой ажиллах ёстой. Хүний эрхийг хамгаалагч нар өөрсдөө жагсаал, цуглааныхаа үеэр сахиулах хэв журам, иргэдийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангах үйл ажиллагааныхаа талаар тухайн жагсаал, цуглаан зохион байгуулагчидтай арга хэмжээг зохион байгуулж эхлэхээс өмнө, явцын дунд болон дараа нь сайтар зөвлөлдөх шаардлагатай. Энэ нь жагсаал, цуглаан хийх эрхийг үндэслэлгүй хөндлөнгийн оролцооноос ангид, аюулгүй орчинд чөлөөтэй эдлэх боломжоор хангах ач холбогдолтой.

62. Эрх бүхий байгууллагууд хүний эрхийг хамгаалагчдын жагсаал, цуглааныг ажиглах (мониторинг хийх), мэдээлэх санал санаачилгыг дэмжиж, хэрэгжүүлэх хэрэгтэй. Эдгээр арга хэмжээ нь хариуцлагыг өндөржүүлж, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хамгаалахад чухал хувь нэмэртэй юм. Хүний эрхийг хамгаалагчид ба тэдний байгууллагууд аливаа ардчилсан тогтолцоонд хоточ нохой (watchdog)-н үүрэг гүйцэтгэдэг тул олон нийтийн жагсаал, цуглааныг чөлөөтэй ажиглахыг зөвшөөрөх ёстой. Үүнтэй адилаар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хараат бус байдлаар мэдээлэх нь жагсаал, цуглааныг зохион байгуулагчид болон хууль сахиулах байгууллагын ажилтнуудын хувьд олон нийтийн өмнө хүлээх хариуцлагыг нэмэгдүүлдэг. Тиймээс бие даасан хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн жагсаал, цуглаанд нэвтрэх, мэдээлэх боломжийг хязгаарлах ёсгүй бөгөөд эрх бүхий байгууллагууд тэднийг хамгаалж, зохион байгуулж өгөх ёстой.

Е. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, ТББ байгуулах, элсэх, идэвхтэй оролцох эрх

63. Хүн бүр бусад хамгаалагдсан эрхүүдийнхээ дагуу, мөн хүний эрхийг хамгаалах зорилгоор бүлгэм, холбоод байгуулах, элсэх, оролцох эрхээ аливаа ялгаваргүйгээр чөлөөтэй эдлэх боломжтой байх ёстой. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд тогтоосон аливаа хязгаарлалт нь хууль ёсны тодорхой үндэслэлтэй байх ёстой бөгөөд хүний эрхийн олон улсын стандартад заасан хатуу шаардлагыг бүрэн дагаж мөрдөх ёстой. Тогтоосон аливаа хязгаарлалт нь хүний эрхийн олон улсын стандартад тусгагдсан тодорхой үндэслэлийн аль нэгний эрх ашигт нийцсэн ардчилсан нийгэмд зайлшгүй шинжтэй байх ёстой. Аливаа ийм хязгаарлалт нь пропорциональ байх ёстой.
64. Оролцогч улсууд холбогдох олон улсын хүний эрхийн стандартуудыг тогтмол хангах, тэдгээрт уялдуулах, дагаж мөрдөхийн тулд холбоо, ТББ-ууд байгуулах, тэдгээрт элсэх, идэвхтэй оролцох эрх чөлөө эдлэх эрхтэй холбоотой бүх хууль тогтоомжийг хянаж үзэх хэрэгтэй. Эдгээр хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хэлэлцэх үедээ иргэний нийгэмтэйгээ

зөвлөлдөх хэрэгтэй бөгөөд ийм хууль тогтоомжуудыг хянаж үзэхдээ олон улсын тусламж хүсэхийг зөвлөж байна.

ТББ-ын үйл ажиллагааг зохицуулах хууль, захиргааны журамлал, шаардлагууд

65. Хүний эрхийг хамгаалагч нар үйл ажиллагаа явуулахын тулд бүртгүүлэх, хуулийн этгээд байгуулах үүрэг хүлээлгүйгээр бүлэг, холбоо байгуулах боломжтой байх ёстой. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний эрхийг бүртгүүлсэн эсэхээсээ хамаарахгүйгээр эдлэнэ. Хүний эрхийг хамгаалагчдыг бүлэг, холбоогоо бүртгүүлээгүйн төлөө гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд тооцох ёсгүй. Бүртгэгдээгүй байгууллагын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулсан, түүний дотор санхүүжилттэй холбоотой гэх мэт аливаа зөрчлийг хууль тогтоомжоос нэн даруй хасах хэрэгтэй.
66. Албан ёсны бүртгэл, хуулийн этгээдээр бүртгэх журам нь хүний эрхийг хамгаалагчдад бусадтай хамтран үйл ажиллагаагаа явуулах, тухайлбал, зөвхөн хуулийн этгээдэд олгодог тусламж, бусад дэмжлэгийг авах боломжийг олгох сонголт хэлбэрээр орших ёстой. Хүний эрхийг хамгаалагчдад энэ чиглэлээрх байгууллага, эсвэл бүлэг байгуулахад нь туслах, хууль ёсны үйл ажиллагаа явуулсныхаа төлөө гутаан доромжлуулахаас нь хамгаалах зорилгоор хууль, захиргааны актыг боловсруулах ёстой.
67. ТББ-ыг [өөрөө хүсвэл] албан ёсоор бүртгүүлэх тухай, эсвэл хуулийн этгээдээр бүртгэх тухай хууль тогтоомж, захиргааны журмууд нь тодорхой, энгийн бөгөөд ялгаварлан гадуурхсан шинж агуулаагүй байх шаардлагатай. Тэдгээр хууль, журмаар тухайн байгууллагуудад үйл ажиллагааг нь саатуулах, эсвэл хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд шаардлагатай эх үүсвэрийг хэт их боогдуулсан хууль бус, хүнд дарамт үзүүлэх шаардлага тавих ёсгүй. Мөн захиргааны болон санхүүгийн тайланд тавих шаардлагууд нь үндэслэлтэй, хуульд заасан байх ёстой. ТББ-ын ажлын байр болон, санхүүгийн тайлангийн шалгалтууд нь хууль эрх зүйн тодорхой үндэслэлтэй, шударга, ил тод байх ёстой. Аудитыг хууль тогтоомжоор тусгайлан зохицуулах нь зөв. Эдгээр хууль тогтоомж нь болзошгүй хяналт шалгалтууд, шаардлагатай баримт бичгийг дэлгэрэнгүй жагсаалтаар нарийвчлан тодорхойлж, хяналт шалгалт орохоос өмнө анхааруулах хангалттай хугацаа, хяналт шалгалт үргэлжлэх хамгийн цаад хугацааг тодорхой тусгах ёстой.
68. Эрх бүхий байгууллагууд нь зохих үндэслэл бүхий шаардлагуудын биелэлтэд хяналт тавихдаа ТББ-ын хараат бус байдал, бие даан шийдвэр гаргах чадварыг хүндэтгэнэ. Өөрсдийн дотоод хэрэг, удирдлага, үйл

ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд нь саад болох ёсгүй. Мөн эрх баригчдын зүгээс тэдний дотоод асуудлын нууцлалыг хүндэтгэх хэрэгтэй бөгөөд тандалт, туршуулын болон өөр бусад аргаар хөндлөнгөөс оролцохоос зайлсхийвэл зохино. ТББ-д ажлын байранд биечлэн, хэт нарийвчилсан санхүүгийн хяналт, аудит хийх шаардлагагүй.

69. ТББ-ыг бүртгэх, үйл ажиллагаа явуулахад тавьдаг зохих ёсны шаардлагуудыг хангаагүй бол эрх бүхий, эсвэл бүртгэлийн байгууллага ямагт залруулах боломжоор хангаж, зохих анхааруулга өгч байх хэрэгтэй. Хүний эрхийн байгууллагын гишүүд нь энэ чиглэлээрх захиргааны, эсвэл бусад үндэслэлгүй шаардлагуудыг биелүүлээгүйнхээ төлөө шийтгэл хүлээх ёсгүй. Захиргааны хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх шийтгэл нь пропорциональ байх ёстой.

Санхүүжилт, эх үүсвэр авах боломж

70. Оролцогч улсууд ТББ-ын бие даасан байдалд хөндлөнгөөс нөлөөлөхгүйгээр санхүүжилт хайх, олж авахад нь тусалж, зохион байгуулж өгөх хэрэгтэй. Мөн оролцогч улсууд нь аль болох ТББ-ыг дэмжих хөрөнгийг бүрдүүлж, хандивын хувиар татварын хөнгөлөлт үзүүлэх замаар хувь хүмүүс, эсвэл бизнесийн байгууллагуудыг хүний эрхийн үйл ажиллагаанд татан оролцуулах зэрэг зохих арга хэмжээг авах шаардлагатай. Оролцогч улсууд нь өөрсдийн хүний эрх, хөгжлийн бодлогодоо ТББ-ын санхүүжилтийг тухайн байгууллагын үйл ажиллагаа, хүний эрхийн үйл ажиллагааных нь байршил, зорилгот газарзүйн бүсээр нь ялгаварлаж, алагчлалгүйгээр олгодог байх зарчмыг тусгах шаардлагатай.
71. Шаардлагатай тохиолдолд, ТББ-ыг бие даасан хүний эрхийн үйл ажиллагаа явуулахад хэрэгтэй материаллаг эх үүсвэр олж авахад нь оролцогч улсууд дэмжиж, зохион байгуулж өгөх нь зүйтэй. Түүнчлэн тоног төхөөрөмж, эсхүл бусад эд хөрөнгийг хураах, гэмтээх, устгах гэх мэтчилэн ТББ-ыг эдгээр эх үүсвэрийг ашиглах боломжгүйд хүргэх дур мэдсэн, хууль бус үйлдлээс хамгаалах ёстой. Материаллаг нөөц олж авахад нь ТББ-д саад болох зорилгоор төрийн бус талуудад шахалт үзүүлэх явдал гаргуулахгүй байх арга хэмжээг төрийн бүх байгууллага, албан тушаалтнууд хэрэгжүүлэх шаардлагатай.
72. Түүнчлэн бүх төрийн байгууллага, ажилтнууд ТББ-ын хараат бус байдлыг бүрэн дүүрэн хүндэтгэх ёстой. Төрийн санхүүжилт, эсвэл санхүүгийн болон санхүүгийн бус аргыг ашиглан ТББ-ын өргөн хүрээний хүний эрхийн хөдөлгөөн бусад үйл ажиллагаанд нь нөлөөлөхөөс татгалзах хэрэгтэй. Төрийн санхүүжилтийн тогтолцоо нь хүний эрхийг хамгаалагч,

тэдний ТББ-д эрх тэгш байдлын үндсэн дээр нээлттэй, шударга, хамрагдах боломжийг бүрдүүлэх ёстой.

73. Оролцогч улсууд ТББ-д хүний эрхийн үйл ажиллагаандаа зориулж санхүүжилт хайх, олж авах, ашиглахад зүй бус хязгаарлалт тавих, дотоодын хууль тогтоомж нь санхүүжилтийн эх үүсвэрээс шалтгаалан хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааг гэмт хэрэгт эсвэл хууль бусад тооцох ёсгүй. Оролцогч орнууд нутаг дэвсгэр дээр нь үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд нь бүртгэлтэй, бүртгэлгүй эсэхээс үл хамааран гаднаас санхүүжилт авахдаа үндэслэлгүй хязгаарлалт, шаардлагуудтай тулгарахгүй байх нөхцөлийг хангах шаардлагатай. Мөн мөнгө угаах болон алан хядах ажиллагааг санхүүжүүлэх үйл ажиллагааг устгах зорилгоор санхүүжилт босгох, ТББ-ууд санхүүжилт авахад алагчилсан хязгаарлалт тавих, эсвэл тэдний гүйлгээг хянахаас татгалзах нь зүйтэй. Гаднаас болон дотроос санхүүжилт хайх, хүлээн авах, ашиглахад Засгийн газраас болон эрх бүхий байгууллагаас урьдчилан зөвшөөрөл авах шаардлагагүй.

Ё. Олон нийтийн бодлогын үйл ажиллагаанд оролцох эрх

74. Оролцогч орнууд хүний эрхийг хамгаалагчдынхаа дотоодын болон олон улсын байгууллагуудын оролцоог дэмжих зохих механизм, журмыг бий болгох ёстой. Эдгээр журам, механизм нь нэг удаагийн, эсвэл тогтмол бус уулзалт зөвлөмжөөр хязгаарлагдах ёсгүй. Харин бодлого, хууль батлах, хууль, тогтоомжийн төсөл боловсруулахын өмнөх үйл ажиллагаа зэрэг олон нийтийн шийдвэр гаргах үйл явцад идэвхтэй оролцох бололцоог бүрдүүлэх үүднээс тогтмол, тасралтгүй, институтчилэгдсэн, нээлттэй яриа хэлэлцээ бий болгох ёстой.
75. Оролцооны механизм, журмууд нь олныг хамарсан, хүний эрхийг хамгаалагчдын олон талт байдлыг тусгасан, мөн тэгш байдалд суурилсан оролцоог хангах ёстойгоос гадна тэдний дундах онцгой хэрэгцээтэй зарим нэгийнх нь эсвэл цөөнхийн нөхцөл байдлыг харгалзаж үзсэн шинжтэй байх ёстой.

Ж. Чөлөөтэй зорчих эрх ба хилийн дотор болон хил дамнансан хүний эрхийн ажил

76. Оролцогч орнууд дотоод болон гадаад дахь хүний эрхийн үйл ажиллагааны ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, хүний эрхийн төлөө тэмцэгчид улс орноосоо явах, эсхүл буцаж нэвтрэх, өөрийн улс орон дотроо хүний эрхийг хамгаалах ажлаар зорчих, эсхүл зорчих зорилго агуулах үед чөлөөтэй зорчих эрх чөлөөтэй холбоотой олон улсын стандартууд, үүрэг амлалтуудыг ягштал биелүүлэх нь зүйтэй.

77. Хүн бүр аливаа улс орныг, түүний дотор эх орноо орхих эрхтэй. Энэхүү эрхэд тавьсан аливаа хязгаарлалт нь хуульд заасан, хүний эрхийн холбогдох олон улсын стандартад тусгасан хууль ёсны зорилгод хүрэхэд зайлшгүй шаардлагатай бөгөөд пропорциональ байх ёстой. Нөгөө талаас хэнийг ч эх орондоо буцаж орох эрхийг дур зоргоор хасах ёсгүй.
78. Зөвхөн хүний эрхийн ажилтай нь холбоотой шалтгаанаар хүний эрхийг хамгаалагчдыг улс орноосоо гарахыг хориглох нь олон улсын стандартад нийцэхгүй. Практик дээр ижил үр дагавар үзүүлэх бусад арга хэмжээ ч мөн адил үл нийцнэ. Өөрсдийнх нь нэр тухайн улс орноос явахыг зөвшөөрөөгүй хүмүүсийн жагсаалтад орсон тохиолдолд тэд ийм жагсаалтын зөв шударгыг шалгуулах эрхтэй ба уг жагсаалтад оруулах хууль ёсны үндэслэл тогтоогдоогүй бол нэрийг нь даруй хасах ёстой.
79. Аливаа улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суудаг хүн бүр тухайн нутаг дэвсгэрийн хил хязгаар дотор чөлөөтэй зорчих эрхтэй. Хүний эрхийг хамгаалагчдад олон улсын хүний эрхийн холбогдох стандартад зааснаас өөрөөр ямар ч хязгаарлалт тавих ёсгүй. Хүний эрхийн үйл ажиллагаагаа үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор тухайн улсын нутаг дэвсгэр, түүний алслагдсан бүс нутагт зорчих хүний эрхийг хамгаалагчдын эрх чөлөөг баталгаатай хангах ёстой. Эдгээрт хүний эрхийн талаас хянах, сурвалжлах зорилгоор бие даасан бүс нутаг, маргаантай нутаг дэвсгэрт нэвтрэх, түүнчлэн хүний эрхийн бусад үйл ажиллагаа явуулах зэрэг нь мөн багтана. Түүнчлэн оролцогч улсууд хүний эрхийн хяналт хийх, мэдээлэл авах зорилгыг хангах үүднээс жагсаал, цуглаан, эсэргүүцлийн жагсаал, хүний эрх чөлөө боогдсон зэрэг хамааралтай газруудад нэвтрэх боломжийг олгох ёстой.
80. Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалагчдыг хөхиүлэн дэмжих хүрээнд хүмүүс хоорондын харилцаа холбоо, зорчих эрх чөлөөний ач холбогдлыг оролцогч улсууд хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Тодруулбал, оролцогч улс орнууд нь бусад оролцогч улсууд хоорондын ТББ-ууд уулзалт, ухуулга болон хүний эрхийн бусад үйл ажиллагаанд оролцох зорилгоор зорчих явдлыг хөхиүлэн дэмжих зорилт тавьж ажиллах хэрэгтэй.
81. Хүний эрхийг хамгаалагчдыг хүний эрхийн үйл ажиллагааны зорилгоор өөр улс руу зорчиход визийн горим, журмууд нь үндэслэлгүйгээр саад тотгор учруулах ёсгүйгээс гадна, тэдгээрийг аль болох хялбаршуулах хэрэгтэй. Хүний эрхийн үйл ажиллагааныхаа төлөө дур зоргоор ял шийтгүүлж, ял эдэлж, баривчлагдаж байсан зэрэг нь хүний эрхийг хамгаалагчдын визийн хүсэлтэд татгалзах шалтгаан болохоос сэргийлэх практик арга хэмжээг оролцогч орнууд авах шаардлагатай. Мөн визийн мэдүүлгийг арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний

болон нийгмийн гарал үүсэл, хөрөнгө чинээ, төрсөн байдал, нас болон бусад байдал зэрэг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүйгээр авч үзэх ёстой.

82. Нэг эсвэл бүлэг оролцогч орон руу нэвтрэхийг хориглосон иргэдийн нэрийн жагсаалтад нэр нь орсноос шалтгаалж тухайн улс руу нэвтрэх эрхгүй болсон хүний эрхийг хамгаалагч нар энэ хоригийн талаар мэдэх, энэ төрлийн хоригууд, хилээр нэвтрэх хоригуудыг холбогдох байгууллага, шүүхэд давж заалдах эрхтэй.
83. Оролцогч орнууд дипломат төлөөлөгчийн газруудаараа дамжуулан амь нас, эрүүл мэндэд нь ноцтой эрсдэл учирч буй хүний эрхийг хамгаалагчдыг шаардлагатай тохиолдолд аюулгүй орчинд түр шилжүүлэх, мөн яаралтай виз олгох замаар дэмжих ёстой. Олон улсын хууль тогтоомжоор хүлээсэн үүргийнхээ дагуу оролцогч орнууд хүний эрхийн төлөө хийсэн ажлаасаа болж хавчлагаас айн улсаа орхих тохиолдолд хүний эрхийг хамгаалагчдад олон улсын урт хугацааны хамгаалалт үзүүлэх шаардлагатай. Амьд явах эрх нь зөрчигдөх, эрүүдэн шүүх, бусад хэлбэрийн зүй бус харьцаа, эсвэл хүний эрхийн бусад ноцтой зөрчилд өртөх эрсдэлтэй улс оронд тухайн хүнийг эрүүлэн өгөхгүй байх талаар олон улсын хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ эдгээр улсууд бүрэн биелүүлэх ёстой.
84. Өөр оролцогч орны нутаг дэвсгэр рүү зорчиж буй хүний эрхийг хамгаалагч нар нь тэнцвэртэй бус, эсвэл хүний эрхийг зөрчсөн хилийн шалгалтад өртөх ёсгүй. Үүний нэгэн адил, бие махбодод зохисгүйгээр халдсан, нэр төрийг нь үл хүндэтгэсэн, эсвэл дур зоргын үзлэгт өртөх ёсгүй. Цаашилбал хил нэвтрэх үед хүний эрхийг хамгаалагчдын авч яваа хүний эрхийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, түүний дотор хувийн мэдээлэл буюу өгөгдөл, хэвлэл, ухуулах хуудас, гарын авлага гэх мэт мэдээллийн материалыг дур мэдэн хурааж үл болно.

3. Хувийн амьдралыг хүндэтгэх эрх

85. Оролцогч орнууд цахим харилцаа холбоо гэх мэтчилэн хүний эрхийг хамгаалагчдын хувийн нууц, гэр бүлийн амьдрал, орон байр, захидал харилцаанд хууль бусаар болон дур зоргоор хөндлөнгөөс оролцохоос зайлсхийх, хууль тогтоомжийн болон бусад арга замаар бусад этгээдийн ийм халдлага, нөлөөллөөс хамгаалах үүрэгтэй. Хувийн нууц, хувийн амьдрал, гэр бүл, орон байр, захидал харилцааг хөндсөн аливаа хөндлөнгийн оролцоог хуульд заасан байх ёстойгоос гадна, хүний эрхийн олон улсын стандартын дагуу хууль ёсны зорилгодоо хүрэхийн тулд тэдгээр нь зайлшгүй бөгөөд тэнцвэртэй байх ёстой.

86. Түүнчлэн, оролцогч улс өөрсдийнх нь хууль тогтоомжид захирагддаг боловч, олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг хувийн компаниудад хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагаанд нөлөөлөхөд зориулан программ хангамж, тандалтын технологи, үйлчилгээ үзүүлэх замаар бусад оролцогч улсуудын нутаг дэвсгэрт хөндлөнгийн оролцооны хууль бус үйл ажиллагаа явуулах ёсгүй болохыг тодорхой ойлгуулж, үүнийг баталгаажуулах дорвитой алхмуудыг авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Тус улсууд мөн цахим харилцаа холбооны аюулгүй байдлыг сайжруулах мэдлэг, чадавхыг бий болгоход хүний эрхийг хамгаалагчдын гаргаж буй хүчин чармайлтыг дэмжиж ажиллах ёстой.
87. Хүний эрхийг хамгаалагчийн хувийн амьдралд хууль бусаар буюу дур зоргоор хөндлөнгөөс оролцож олж авсан мэдээлэл буюу өгөгдлийг тухайн хүний эсрэг үүсгэсэн аливаа шүүхээр хэрэг хянан хэлэлцэх ажиллагаанд ашиглах ёсгүй. Эрх бүхий байгууллагууд хууль ёсны дагуу олж авсан ч, тухайн мэдээлэл буюу өгөгдөл, баримтуудыг хүлээн авах, боловсруулах, ашиглах хууль ёсны зөвшөөрөлгүй аливаа этгээдэд дамжуулахгүй байх үүрэгтэй. Ялангуяа ийм мэдээлэл буюу өгөгдлийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон бусад хүмүүст хүний эрхийг хамгаалагчдын нэр хүндийг олон нийтийн өмнө харлуулах зорилгоор ашиглуулахгүйн тулд нэвтрэх, ашиглах боломжийг олгохгүй байх талаар үр дүнтэй арга хэмжээ авах хэрэгтэй. Хэрэв хууль ёсоор олж авсан бол ийм мэдээлэл буюу өгөгдлийг зөвхөн шаардлагатай хугацаагаар хадгалж, дараа нь устгах ёстой.
88. Хүний эрхийг хамгаалагч нар ажлын онцлогоосоо шалтгаалан хувийн амьдралд нь үндэслэлгүйгээр хөндлөнгөөс оролцохоос хамгаалуулах онцгой хэрэгцээтэй. Мөн хүний эрхийн үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулахын тулд эх сурвалжаа нууцлах, үйлчлүүлэгчдийнхээ хувийн нууцыг хүндэтгэх шаардлагатайг хүлээн зөвшөөрөх ёстой. Бие махбодын болон бусад халдлагад өртөх өндөр эрсдэлтэй хувь хүмүүстэй хамтран ажилладаг хүний эрхийг хамгаалагчдын хувьд эх сурвалж, үйлчлүүлэгчдийн хувийн мэдээллийг зохих ёсоор хамгаалах нь нэн чухал. Энэ нь тэдгээр хүмүүсийг мэдээлэл өгөх, тусламж хүсэхэд хангалттай аюулгүй нөхцөлд байгааг нь баталгаажуулж өгч буй явдал юм.
89. Оролцогч орнууд хүний эрхийг хамгаалагчдын зарим тодорхой бүлэг, тэр дундаа эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдын хувийн амьдралтай холбоотой онцлог хамгаалалтын хэрэгцээ буйг хүлээн зөвшөөрөх ёстой.

И. Олон улсын байгууллагатай холбоо тогтоох, харилцах эрх

90. Хүний эрхийг хамгаалагч нар олон улсын байгууллагууд, түүний дотор хүний эрх зөрчигдсөнтэй холбоотой мэдээллийг хүлээн авах, авч хэлэлцэх чадамж бүхий олон улсын болон бүс нутгийн байгууллагуудтай саадгүй харилцаа холбоо тогтоох эрхээ эдлэх бололцоогоор хангагдах ёстой. Мөн хүний эрхийг хамгаалагч нар, тэдний гэр бүл, хамтрагчдыг олон улсын байгууллагатай хамтран ажиллаж байгаа эсвэл хамтран ажилласан, хамтран ажиллахыг хүссэнийхээ төлөө аливаа хариу сөрөг арга хэмжээнд өртөхөөс хамгаалах ёстой. Энэ мэт хариу арга хэмжээтэй холбоотой бүх хэргийг төрийн албан тушаалтан, эсвэл бусад этгээд үйлдсэн эсэхээс үл хамааран цаг алдалгүй, нарийвчлан, бие даан шалгах ёстой бөгөөд тэд хамтран ажилласныхаа төлөө ямар ч хариуцлага хүлээх ёсгүй. Хохирогчид болон тэдний ар гэр хамгаалуулах үр дүнтэй арга замуудыг сонгох боломжтой байж, зохих нөхөн төлбөр авах ёстой.
91. Оролцогч орнууд хүний эрхийг хамгаалагчдын ЕАБХАБ-ын байгууллагууд, НҮБ ба түүний төлөөлөгчид, хүний эрхийн чиглэлээр ажилладаг байгууллага, Европын Зөвлөлийн байгууллагууд ба Хүний Эрхийн Америкийн Улсууд Дундын Хороо (ХЭАУДХ), олон улсын шүүхүүд, дагнасан шүүхүүд, болон бусад олон улсын болон бүс нутгийн түвшин дэх хүний эрхийн аливаа байгууллагад мэдээлэл өгөх, шүүхүүдэд нэхэмжлэл гаргах, уулзах эрхэд саад хийж, үгүйсгэж болзошгүй аливаа үйлдэл, хууль тогтоомжоор халхавчилсан арга хэмжээ авахаасаа зайлсхийх хэрэгтэй. Түүнчлэн хүний эрхийг хамгаалагчдыг эдгээр улсад айлчлахдаа олон улсын төлөөлөгчидтэй уулзахад нь саад болох ёсгүй.
92. Оролцогч орнууд өөрийн улсын хүний эрхийн хамгааллыг сайжруулах зорилгоор хүний эрхийн ба олон улсын байгууллагууд хоорондын харилцааг дэмжих ёстой. Тухайлбал, хүний эрхийн олон улсын байгууллага, хүний эрхийн холбогдох баримт бичгүүд, зөвлөмж, шийдвэр, шүүхийн практикийн талаар тухайн улсын орон нутгийн хэлээр мэдээллийг идэвхтэй түгээх зэргээр санаачилгатай алхмуудыг авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Эдгээр улс нь хүний эрхийн хяналтын байгууллага болон бусад байгууллагад тайлан гаргахдаа тогтмол хүний эрхийг хамгаалагчидтай байнга зөвлөлдөж, тэдний хяналт, оролцоог зохих байдлаар хангах шаардлагатай. Мөн НҮБ, түүний төлөөлөгчид, хүний эрхийн чиглэлээр ажилладаг байгууллага, түүний дотор НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн тусгай илтгэгчээс ирсэн тухайн улсад албан томилолтоор ажиллах хүсэлтийг зөвшөөрөх ёстой. Мөн тэд ийм айлчлал, түүнчлэн, Европын Зөвлөл ба АДХЭХ зэрэг бүс нутгийн байгууллагуудын өөрийн орон дахь томилолтыг шударга

зарчмаар дэмжиж, хүний эрхийг хамгаалагчдад томилолтынхоо үеэр эдгээр байгууллага, газруудтай хувийн уулзалт хийх, нууц мэдээллийг хуваалцах боломж олгох ёстой. Цаашилбал, оролцогч улсууд АИХЭГ болон ЕАБХАБ-ын бусад байгууллагуудаас томилолтоор ажиллах болон бусад хяналт шалгалтын үйл ажиллагааг хөхиүлэн дэмжвэл зохино.

IV. УДИРДАМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үндэсний хэрэгжилт

93. Хүний эрхийг хамгаалагчдын эрх ашгийг хамгаалахын тулд оролцогч улсуудыг, иргэний нийгэмтэй зөвшилцөн, хүний эрхийг хамгаалагчдад нөлөөлж буй хууль тогтоомж, тэдгээрийн практик хэрэглээний суурь үнэлгээг хийхийг зөвлөж байна. Хүний эрхийг хамгаалагчдын ажлыг хүндрүүлж, саад учруулж буй аливаа хууль тогтоомж, журмуудыг хүчингүй болгох, өөрчлөх шаардлагатай бөгөөд өөрсдийн практик хэрэглээг ч тэдгээрт тохируулан өөрчлөх хэрэгтэй.
94. Оролцогч улсууд бие даасан ҮХЭИ-ийн үүрэг, тэдгээрийн төлөөлөх эрхийг Парисын зарчимд нийцүүлэн бэхжүүлэх, хувь хүний нэхэмжлэл хүлээн авах чадамж олгох талаар анхаарч үзэх хэрэгтэй. Энэ нөхцөл хараахан бүрэлдээгүй тохиолдолд оролцогч орнууд хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдалд системтэйгээр, бодитой хяналт тавьж, тогтмол тайлагнах, хүний эрхийн ажлынхаа улмаас хохирсон хохирлыг нөхөн төлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор ҮХЭИ-д тусгайлан төлөөлөх эрх олгож, хөрөнгө хүчээр хангах ёстой. Тэд хүний эрхийг хамгаалагчдыг ҮХЭИ-тэй холбогдох, харилцах, эсвэл бусад байдлаар холбогдох эрхийг ямар нэг байдлаар хязгаарлах ёсгүй. Улс орнууд хараат бус ҮХЭИ-ийн гишүүд, ажилтнуудыг бусад бүх хүний эрхийг хамгаалагчдын адил хууль бус шахалт дарамт, зүй бус үйлдлүүдээс бүрэн хамгаалах ёстойг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.
95. Шаардлагатай тохиолдолд, оролцогч орнууд хүний эрхийг хамгаалагчдын оролцоотойгоор институт хоорондын зохицуулах байгууллагуудыг байгуулах, томилох, хүний эрхийг хамгаалагчдын хамгаалалтыг сайжруулах стратеги боловсруулж хэрэгжүүлэх, аюулгүй, ээлтэй орчныг бүрдүүлэх, бэхжүүлэх асуудлыг авч үзэх хэрэгтэй. Институт хоорондын зохицуулах байгууллага шаардлагатай эсэхийг хүний эрхийг хамгаалагч нартай зөвлөлдөх нь чухал. Эдгээр байгууллагуудад эрсдэлт нөхцөл байдалд буй хүний эрхийг хамгаалагчдын бие махбодын аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хамгааллыг нэмэгдүүлэхийн тулд зохих хамгаалах хөтөлбөр, бодлого, механизмыг боловсруулж, хэрэгжүүлэх үүрэг хүлээлгэх хэрэгтэй.

96. Оролцогч улс орнуудад энэхүү удирдамжийг бусад холбогдох олон улсын стандартын хамтаар тухайн улсын хэл дээр орчуулан, шүүх засаглал, зэвсэгт хүчин болон шашны үзэл санааны манлайлагчид, багш нар, сурган хүмүүжүүлэгчид, эрүүл мэндийн мэргэжилтнүүд, сэтгүүлчид, бусад мэргэжлийн бүлгэмүүд, иргэний нийгмийн байгууллагууд болон бусад хамааралтай талуудад түгээхийг зөвлөж байна. Хувийн бизнес, улс төрийн болон нийгмийн бүлгүүд гэх мэт төрийн бус талуудыг үйл ажиллагаагаа удирдан явуулахдаа уг удирдамжийг дагаж мөрдөхийг уриалах хэрэгтэй. Зохих эргэн хяналт, хэрэгжилтийг хангахын тулд уг удирдамжийн талаар холбогдох төрийн албан хаагч нар, мэргэжлийн бүлгэмүүд, бусад талуудад сургалт явуулахад АИХЭГ-тай хамтран ажиллах хэрэгтэй.

Бусад ЕАБХАБ-ын оролцогч улсууд болон гуравдагч орнууд дахь хүний эрхийг хамгаалагчдын хамгаалал

97. Оролцогч улсууд нь ЕАБХАБ-ын гишүүн орнууд, ЕАБХАБ-ын бүсээс гадуурх бусад орнууд дахь хүний эрхийг хамгаалагч нар, тэдний ажил үйлсийг дэмжих механизм байгуулах, үндэсний удирдамж боловсруулахыг зөвлөж байна. Ийм үндэсний удирдамжид ЕАБХАБ-ын оролцогч улсууд болон гуравдагч орнуудад болзошгүй эрсдэлт нөхцөлд байгаа хүний эрхийг хамгаалагчдад түргэн шуурхай үйлчлэх механизмыг тусгах ёстой.

98. Дипломат төлөөлөгчийн газраараа дамжуулан оролцогч орнууд хүний эрхийг хамгаалагч, ялангуяа халдлага, дарамт шахалт, мөрдөлт мөшгөлт, дур зоргоор албадан саатуулагдах эрсдэлд өртөж болзошгүй хүмүүсийг дэмжих алхмыг улс орны хэмжээнд авах хэрэгтэй. Тухайлбал, хүний эрхийг хамгаалагчидтай уулзах, албадан саатуулагдаж буй хүмүүстэй уулзах, шүүх хуралдаанд оролцох, олон нийтийн мэдэгдэл гаргах, шаардлагатай тохиолдолд холбогдох улсын эрх баригчдад хөндлөнгөөс анхааруулах захидал илгээх зэрэг дипломат корпусын гишүүдийн үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих хэрэгтэй.

99. Оролцогч улсууд хүний эрхийг хамгаалагчдын эсрэг заналхийлэл, дайралт, дур зоргоор баривчлах болон бусад хүний эрхийн ноцтой зөрчлийн тохиолдлыг авч хэлэлцэх шаардлагатай. Тухайлбал, тухайн засгийн газартай засгийн газар хоорондын дээд түвшний уулзалтуудаар, эсвэл олон улсын форум дээр уриалах замаар, шаардлагатай бол, холбогдох улсын итгэмжлэгдсэн дипломат төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулах гэх мэт боломжит арга замаар шийдэх нь зөв.

100. Шаардлагатай тохиолдолд, оролцогч улсууд холбогдох улсад суугаа дипломат төлөөлөгчийн газруудаараа дамжуулан, эсвэл өөр зохих боломжит аргаар хүний эрхийг хамгаалагчдад эрсдэлд учирсан улсаа

нэн даруй орхих боломж олгож яаралтай виз олгон, мөн нүүн шилжихэд нь дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Хамгаалалтын үр дүнтэй арга хэмжээнд хүний эрхийг хамгаалагчдын ар гэрийнхэнд учрах эрсдэлийг тусгасан байх хэрэгтэй ба шаардлагатай бол тэдэнд үйлчлэх шаардлагатай. Хэрэв өөр улс руу гарсан бол тухайн хүний эрхийг хамгаалагчийн гэр бүлийн гишүүдийг ч мөн найдвартай хамгаалалтаар хангах ёстой.

Олон улсын хамтын ажиллагаа ба хүний эрхийн механизм

101. Оролцогч улсууд нь хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах олон улсын болон бүс нутгийн стандарт, механизмыг боловсруулж, бэхжүүлэхийн тулд ЕАБХАБ болон бусад олон улсын форумуудын хүрээнд хамтран ажиллах ёстой. Үүнд, хангалттай нөөц ба бусад улс төрийн дэмжлэг бүхий олон улсын институтууд, механизмаар хангах зэрэг багтана. Ингэхдээ олон улсын байгууллагууд болон янз бүрийн түвшний хүний эрхийн механизмуудтай харилцан тогтмол, уялдаа холбоотой ажиллах ёстой.
102. Оролцогч улсууд хамгааллын талаарх үндэсний хууль тогтоомжийн цоорхой, практик дахь алдаа дутагдлыг илрүүлэх, түүнчлэн, хүний эрхийг хамгаалагчдын хамгааллыг бэхжүүлэх боломжтой сайжруулалтыг тодорхойлох зорилгын хүрээнд шударга зарчимд тулгуурлан олон улсын түвшинд хамтын хяналт явуулж, энэ тал дээр бусад оролцогч улсын шилдэг туршлагаас суралцах хэрэгтэй.
103. Оролцогч улсууд нь НҮБ, түүний төлөөлөгчид, Америкийн Улсууд Дундын Байгууллагыг оролцуулаад, хүний эрхийн чиглэлээр ажилладаг олон улсын байгууллагууд болон Европын Зөвлөлийн байгууллагууд, ЕАБХАБ-ын байгууллагууд, хүний эрхийн олон улсын механизмуудтай хамтран ажиллах хэрэгтэй. Эдгээр улс нь өөр бусад хүчин чармайлтын сацуу дээр дурдсан байгууллага, механизмаас хүссэн бүх мэдээллийг үнэн зөвөөр өгч, албаны харилцаа холбоог үндэслэлгүй саатуулалгүйгээр харну өгөх замаар хамтран ажиллах хэрэгтэй. Мөн ЕАБХАБ-ын байгууллагууд болон хүний эрхийн олон улсын механизмын гаргасан бүх зөвлөмжийг цаг алдалгүй хэрэгжүүлэхэд зохих хяналт шалгалт хийж, олон улсын болон бүс нутгийн шүүхийн шийдвэрийг бүрэн дагаж мөрдөх ёстой.
104. АИХЭГ-ыг төлөөлөх эрхийнхээ дагуу холбогдох хэрэгжилтийн асуудлаар ЕАБХАБ-ын Байнгын зөвлөлд мэдээлэл өгөх, хэрэгжилтийг жил бүр хянан үзэх материалыг бүрдүүлэх боломжтой болгохын тулд оролцогч улсуудыг АИХЭГ-ыг ЕАБХАБ/АИХЭГ-ын *Хүний эрхийг хамгаалагчдын хамгааллын удирдамжийг* хэрэгжүүлэхэд авч буй алхмуудынхаа талаарх мэдээллээр хангахыг зөвлөж байна. ЕАБХАБ-ын байгууллагуудтай хамтран ажиллах, удирдамжийн хэрэгжилтийг тасралтгүй хянах үүргийнхээ хүрээнд

оролцогч улсууд хүний эрхийг хамгаалагчидтай холбоотой хүний аюулгүй байдлын хэмжүүрийн талаарх үүрэг амлалтаа биелүүлэх, шаардлагатай бол, АИХЭГ-аас тусламж хүсэх хэрэгтэй. Тэд өөрсдийн нутаг дэвсгэр дэх АИХЭГ-ын үйл ажиллагаа болон бусад хэлбэрийн тусламжид нээлттэй хандаж, дэмжих хэрэгтэй бөгөөд тус байгууллагыг төлөөлөх эрхээ хэрэгжүүлэхэд идэвхтэй дэмжлэг үзүүлэх ёстой.

ЕАБХАБ

105. ЕАБХАБ-ын гүйцэтгэх удирдлага, байгууллагууд, төлөөллийн газрууд нь тус тусын төлөөлөх эрхийнхээ хүрээнд ЕАБХАБ/АИХЭГ-ын удирдамжид заасан эрх, зарчмуудыг бүрэн хэрэгжүүлэхэд хүчин зүтгэж, туслалцаа үзүүлэх хэрэгтэй.

Хэсэг В:
Төрөлжсөн тайлан

Хэсэг В: Төрөлжсөн тайлан

“Оролцогч улсууд хүний эрх, үндсэн эрх чөлөөний нийтлэг ач холбогдлыг хүлээн зөвшөөрдөг [...]”. “Тэд хувь хүний энэ талаарх өөрийн эрх, үүргийг мэдэж, хэрэгжүүлэх эрхийг баталгаажуулж байна.” Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурлын тунхаглал (Хельсинки 1975) (Европын аюулгүй байдалтай холбоотой асуултууд: 1. (а) Оролцогч улс хоорондын харилцааг удирдан чиглүүлэх зарчмуудын тунхаглал (VII зарчим).

“(11) Түүнчлэн оролцогч улсууд нь хүний эрх, үндсэн эрх чөлөө зөрчигдсөн явдал гарсан тохиолдолд ашиглах хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалахад бусдаас тусламж эрэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалж буй бусдад туслах хувь хүний эрх [...] зэрэг үр дүнтэй залруулах арга хэмжээг боловсруулж бэлдэхээ мэдэгдсэн.” ЕАБХАБ-ын хүний аюулгүй байдлын хэмжүүрийн талаарх бага хурлын Копенхагены уулзалтын баримт бичиг (Копенхаген 1990).

“18. Оролцогч улсууд [...] хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах шаардлагатай байгааг онцолж, НҮБ-ын зорилтын хүрээнд, бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах ‘хувь хүмүүс, бүлгэмүүд, нийгмийн байгууллагуудын эрх, үүргийн’ тунхаглалын төслийг боловсруулж, батлуулахыг хүлээж байна.” Будапештын баримт бичиг: Шинэ эрин дэх жинхэнэ түншлэлийн төлөө (Төрийн ба засгийн газрын тэргүүн нарын дээд хэмжээний уулзалт) (Будапешт 1994) (Шийдвэр: VIII. Хүний аюулгүй байдлын хэмжүүр).

Хүний эрхийг хамгаалах эрх нь бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрх

1. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалд⁸ заасан хүний эрхийг хамгаалах эрх нь ЕАБХАБ-ын хүлээсэн үүрэг амлалтууд, олон улсын хүний эрхийн гэрээ болон бусад баримт бичгүүдэд заасан хүний үндсэн эрхэд бүрэн суурилсан бөгөөд үүнээс урган гарсан.
2. 1975 оны Хельсинкийн төгсгөлийн баримт бичигт зааснаар оролцогч улсууд хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх, иргэний, улс төр, эдийн засаг, нийгэм, соёл болон бусад эрх, эрх чөлөөний бодит хэрэгжилтийг хөхиүлэн дэмжих, удирдан чиглүүлэх үүрэгтэй. Мөн эдгээр улс нь өөр бусад

8 “Бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах ‘Хувь хүн, Бүлгэм, Нийгмийн байгууллагын эрх, үүргийн тунхаглал’ (цаашид “НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглал” гэх) нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн бүгд санал нэгтгэйгээр баталсан 1998 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн A/RES/53/144 тоот тогтоол.

гэрээ хэлэлцээрүүдээс гадна, Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИУТЭОУП) болон Олон улсын эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хэлцэл (ЭЗНСЭОУХ)-ээс бүрдсэн Хүний эрхийн олон улсын пакт зэрэг энэ салбар дахь олон улсын тунхаглал, гэрээ хэлэлцээрт заасан үүргээ бүрэн биелүүлэх үүрэг хүлээсэн юм.⁹

3. Энэхүү удирдамжууд нь тодорхой бүлэгт зориулсан шинэ стандартыг тогтоогоогүй ч, хүний эрхийг хамгаалах эрхийг хэрэгжүүлэх удирдамж болсон улсын байгууллагын хүний эрхийн баримт бичгүүд болон ЕАБХАБ-ын үүрэг амлалтуудад тусгагдсан эрхүүдийг дахин баталгаажуулж өгсөн. Мөн оролцогч улсуудад хүний эрхийг хамгаалагчдын эдлэх ёстой эрхийг хүндэтгэх, хамгаалах, биелүүлэх үүргээ дагаж мөрдөх боломж бүрдүүлж өгөх, хүний эрхийг хамгаалагчдад хүний эрхийг хамгаалах эрхийг нь чөлөөтэй эдлүүлэхэд чиглэсэн арга хэмжээний талаар удирдамж өгөх зорилготой юм.

Хүний эрхийг хамгаалагч нар гэж хэн бэ?

4. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалын 1 дүгээр заалтаар “Хүн бүр хувь хүн болон бусадтай хамтран үндэсний болон олон улсын түвшинд хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах эрхтэй.” гэдгийг дахин баталж байна. Түүнчлэн НҮБ-ын Ерөнхий ассамблей, Хүний эрхийн зөвлөлийн аль аль нь орон нутгийн, үндэсний, бүс нутгийн, олон улсын түвшинд хүний эрхийг хамгаалагч нар чухал үүрэгтэйг дахин бататгасан.¹⁰
5. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалд заасны дагуу “хүний эрхийг хамгаалагч” гэдэг нэр томъёог ажил мэргэжил, эсвэл бусад

9 Европ дахь Аюулгүй байдал ба хамтын ажиллагааны бага хурлыг Хельсинки 1975 он, “Европ дахь аюулгүй байдалтай холбоотой асуудлууд, 1. (а) Оролцогч улс хоорондын харилцааг удирдан чиглүүлэх зарчмуудын тунхаглал”, зарчим VII-г үз. Ватиканы Ариун Сэнтийгээс бусад ЕАБХАБ-ын оролцогч бүх улс ИУТЭОУП-ыг соёрхон баталж, Андорра, Ватиканы Ариун Сэнтий, АНУ-аас бусад бараг бүх улс ЭЗНСЭОУХ-д гарын үсэг зуржээ. Мөн оролцогч бүх улс Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын хэлцэл (АӨЯГБХУОУХ) ба Эрүүдэн Шүүлт болон бусад хэлбэрийн хэрцгий, хүнлэг бус буюу доромжилсон харьцаа ба шийтгэлийн эсрэг конвенц (ЭШЭК) -д нэгдсэн. Тэдний ихэнх нь Эмэгтэйчүүдийг Ялгаварлан Гадуурхах Бүх Хэлбэрийг Устгах Конвенц (ЭЯГБХУК), Хүүхдийн эрхийн конвенц (ХЭК), Хөгжлийн Бэрхшээлтэй иргэдийн эрхийн конвенц (ХБИЭК) зэрэг хүний эрхийн бусад хэд хэдэн гол олон улсын гэрээг соёрхон баталжээ. Түүнчлэн, Европын Зөвлөлийн гишүүн бөгөөд оролцогч 47 улс Хүний эрх, үндсэн эрх чөлөөний конвенц (ХЭҮЭЧК)-ыг дагаж мөрддөг. Хүний Эрхийн америкийн конвенц (ХЭАК)-д гарын үсэг зурсан оролцогч улсууд уг олон улсын гэрээний зорилго, зорилгыг зөрчихөөс зайсхийх үүрэгтэй.

10 НҮБЕА-н Тогтоол, “Бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах ‘Хувь хүн, Бүлгэм, Нийгмийн байгууллагын эрх, үүргийн тунхаглал’: хүний эрхийг хамгаалагчдын хамгаалал”, НҮБ-ын Б.Б. А/RES/68/181, 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан, ерөнхий зүйл. 6; НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн Тогтоол “Хүний эрхийг хамгаалагчдын хамгаалал”, НҮБ-ын Б.Б. А/HRC/RES/22/6, 2013 оны 3 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан, ерөнхий зүйл. 8-г тус тус үз.

байдлаасаа үл хамааран бие даан, эсвэл бусадтай хамтран хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үйл ажиллагаа явуулдаг аливаа хүн гэж ойлгоно.

6. Хүний эрхийг хамгаалагчдыг тодорхойлдог гол шинж бол хэн бэ гэдэг нь биш, тэдний хийдэг зүйл, баримталдаг зарчим юм. Зарим хүний эрхийг хамгаалагч нар хүний бүх эрхийг хамгаалахын төлөө ажилладаг. Эмэгтэйчүүдийн эрх, үндэстэн ястан, шашин шүтлэг, хэлний цөөнхөд харьяалагддаг хүмүүсийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, зэвсэгт хүчин, хууль сахиулагчдын эрх, түүнчлэн иргэний болон улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн чиглэлээрх хүний эрхийн тодорхой асуудлууд гэх мэт тухайлсан хүний эрхийн асуудлууд, эсвэл тодорхой бүлгийн хүний эрх зэрэг чиглэлээр ажилладаг хүний эрхийг хамгаалагчид ч бий. Зарим нь хүний эрхийг хамгаалах олон улсын норматив тогтолцоог боловсруулж мөрдөхөд төвлөрч ажиллаж байхад, нөгөө хэсэг нь хохирогчдод үйлчилгээ үзүүлэх, эсвэл эрхээ эдлэхийг шаардаж буй хувь хүмүүсийг чадавхжуулахад анхаардаг. Мөн зарим нь ухуулга сурталчилгаа, олон нийтийн кампанит ажилд илүү их оролцож; бусад нь хүчирхийллийг хянах, мэдээлэх, илрүүлэх ажил хийдэг. Олон хүний эрхийг хамгаалагч хил дамнан ажилладаг бөгөөд зарим нь дэлхийн хэмжээнд хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааг сайжруулах зорилготой байдаг бол мөн нөгөө хэсэг нь тодорхой улс, эсвэл бүс нутагт төвлөрдөг.¹¹
7. Хүний эрхийг ухамсарлаж, хэрэгжүүлэхийг эрмэлзэж буй хэн бүхэн мэргэжил, нас, бусад байдал болон хүний эрхийн үйл ажиллагааг дангаараа, эсвэл бусадтай хамтран, эсвэл албан бус бүлэг, төрийн байгууллага (ТББ)-д нэгдэн, сайн дураараа, эсвэл мэргэжлийн түвшинд ажилладаг эсэхээсээ үл хамааран бүгд хүний эрхийг хамгаалагч юм. Нэмж дурдахад хуульчид, үйлдвэрчний эвлэлийн ажилтнууд, хүний эрхийн үндэсний байгууллагуудын ажилтнууд, сэтгүүлчид, эмнэлгийн мэргэжилтнүүд, төрийн албан хаагчид, оюутнууд зэрэг хүмүүс ч хүний эрхийг хамгаалагч байж болно.
8. Хүний эрхийг хамгаалагчдад тавих цорын ганц шаардлага бол өөрсдийн үйл ажиллагааг тайван замаар явуулж, Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ)-ын дагуу бүх хүний эрхийн нийтлэг байдлыг “угсаа гарал, арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний

11 “Хүний эрхийг хамгаалагч” гэсэн нэр томъёоны тайлбар, түүний үндсэн үйл ажиллагааны дэлгэрэнгүй танилцуулгыг Хүний эрхийн Дээд Комиссарын Газрын “Хүний эрхийг хамгаалагч нар: Хүний эрхийг хамгаалах эрхийг хамгаалах”, баримт бичгийн хуу. №29, 2004 оны 4-р сарын 29-ний өдөр, <http://www.ohchr.org/Documents/Publications/FactSheet29en.pdf> - г үз.

эсвэл нийгмийн гарал, өмч, төрсөн байдал гэх мэт аливаа бусад байдлаар ялгаварлалгүйгээр хүлээн зөвшөөрөх явдал юм.”¹²

9. ЕАБХАБ-ын гишүүн орнууд хүн бүрийн өөрийн эрх, үүргийг мэдэх, хэрэгжүүлэх эрх, түүнчлэн оролцогч улсуудын хооронд найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэхэд шаардлагатай энх тайван, шударга ёс, сайн сайхан байдлыг хүндэтгэн үздэг болоход байгууллага, хүмүүс эерэг үүрэг гүйцэтгэж чадна¹³ гэдгийг баталлаа. Тэд мөн “өөрсдийгөө энэхүү үзэл санааг эрхэмлэдгийг тунхаглаж буй” ТББ-уудыг хүлээн зөвшөөрөхөө амласан.¹⁴
10. Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах үндэсний бодлого, эсвэл стратеги боловсруулахдаа оролцогч улсууд НҮБ-ын тунхаглалд заасан “хүний эрхийг хамгаалагч” гэсэн томъёог хэрэглэх хэрэгтэй.

Хүний эрхийг хамгаалагч нар ардчилсан нийгэмд амин чухал үүрэг гүйцэтгэдэг

11. ЕАБХАБ-ын оролцогч орнууд хүний эрх, үндсэн эрх чөлөө, ардчилал, эрх зүйт ёсыг хүндэтгэх асуудал нь ЕАБХАБ-ын аюулгүй байдлын цогц үзэл баримтлалын цөм гэдгийг дахин баталгаажуулж, хүний эрх, үндсэн эрх чөлөө зөрчигдөх зэрэг аюулгүй байдалд тулгарч буй аюул заналхийлэлтэй тэмцэх үүрэг хүлээсэн болно.¹⁵
12. Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалахыг хичээж буй хүмүүсийн чухал ажлыг олон улсын олон чуулга уулзалтын үеэр сайшаан үзсэн. 1998 онд НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаг бичгийг зөвшилцөж баталснаар НҮБ-ын гишүүн орнууд “хүний эрх, үндсэн эрх чөлөөний аливаа зөрчлийг үр дүнтэй арилгахад хувь нэмэр оруулсан хувь хүн, бүлгэм, нийгэмлэгийн үнэлж баршгүй ажлыг” албан ёсоор хүлээн зөвшөөрсөн билээ.¹⁶ 2013 оны 3 дугаар сард батлагдсан тогтоолдоо НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл нь оролцогч улс орнуудад хүний эрхийг хамгаалагчдын амин чухал, хууль ёсны үүрэг ба шүүмжлэлт байр сууриа тайван байдлаар илэрхийлж болохыг олон нийтэд нээлтэй хүлээн зөвшөөрөхийг зөвлөсөн юм.¹⁷ Мөн

12 Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ), 2 дугаар заалт, <http://www.un.org/en/documents/udhr/index.shtml>.

13 Хельсинки 1975.

14 ЕАБХАБ-ын Хүний аюулгүй байдлын хэмжүүрийн асуудлаарх бага хурлын Москва дахь уулзалтын баримт бичиг, Москва, 1991, 43 дугаар заалт.

15 Станбулын баримт бичиг, “Европын аюулгүй байдлын тухай дүрэм”, Станбул 1999, 19 дүгээр заалт.

16 НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглал, 2 дугаар заалт.

17 НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн 2013 оны 3-р сарын 21-ний өдрийн A/HRC/RES/22/6 тоот тогтоолын 5 ба 11(i) дүгээр заалт.

Хүний эрхийн зөвлөл нь “хүний эрхийг хамгаалагч, түүний дотор эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагааг хүндэтгэж, дэмжиж байх нь хүний эрхийн үр шимийг нийтээр хүртэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ”¹⁸ гэж цохон тэмдэглэсэн. НҮБ-ын оролцогч орнууд хэд хэдэн удаа хувь хүн бүлэг, байгууллагууд нь хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үйл ажиллагааг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг гэдгийг хүлээн зөвшөөрсөн байдаг.¹⁹

13. Дээр дурдсанаас гадна, НҮБ-ын Тусгай илтгэгчийн хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын талаар хийсэн илтгэлд тогтмол дурдагддагаар хүний эрхийг хамгаалах нь аюултай үйл ажиллагаа хэвээр байсаар байна.²⁰

Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах хэрэгцээ шаардлага

14. 2013 оны 12 дугаар сард баталсан тогтоолдоо НҮБ-ын Ерөнхий ассамблей (НҮБЕА) олон улс оронд хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах үйл ажиллагаа эрхэлдэг хүмүүс, байгууллагууд аюул занал, дарамт шахалтад байнга өртөж, эдгээр үйл ажиллагааныхаа үр дагавраар аюулгүй байдал нь алдагдаж буйд гүнээ санаа зовниж байгаагаа дахин илэрхийлэв.²¹ Үнэн хэрэгтээ ЕАБХАБ-ын оролцогч орнууд 1994 онд хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрсөн.²²
15. Явуулж буй үйл ажиллагааныхаа үр дагавраас үүдэн учирч болзошгүй эрсдэлээс болж хүний эрхийг хамгаалагч нар орон нутгийн, үндэсний болон олон улсын түвшинд тусгай, өндөржүүлсэн хамгаалалт шаарддаг. Хүний эрхийг хамгаалагчдын хамгааллыг бэхжүүлэх ажлын эхний алхам болгож, ЕАБХАБ-ын гишүүн орнууд хүний эрхийг хамгаалагчдын чухал үүрэг, тэдний үйл ажиллагааны хууль ёсны байдал ба эдгээр эрсдэлүүд буйг олон нийтэд нээлттэй хүлээн зөвшөөрөх явдал юм.

18 Мөн э.сурв., оршил, 2 дугаар заалт. Мөн ерөнхий зүйлийг үз. 8, 9 нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 66/164 тогтоол дахь хүний эрхийг хамгаалагчдын чухал үүргийг онцолсон, НҮБ-ын Б.б. 2011 оны 12-р сарын 11-ний өдөр батлагдсан A/RES/66/164, 2 дугаар заалт.

19 Жишээлбэл: 1991 оны Москвагийн тогтоолын оршил, Астанагийн ойн тунхаг, Астана 2010, 6 дугаар заалт.

20 Жишээлбэл: НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлд Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн НҮБ-ын Тусгай илтгэгчийн хийсэн тайланг үзнэ үү. A/HRC/25/55, 2013 оны 12-р сарын 23, 57 ба 128 дугаар заалт.

21 НҮБЕА-н эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдын талаарх тогтоолын танилцуулгыг үзнэ үү, 2013 оны 12-р сарын 18-ны өдөр батлагдсан A/RES/68/181 тоот НҮБ-ын Б.б. Мөн НҮБЕА-н 66/164-р тогтоолын ерөнхий зүйл 3 дугаарыг үз.

22 Будапешт 1994.

16. Ажиллаж буй тодорхой асуудлууд, үйл ажиллагаагаа явуулж буй нөхцөл байдал, ажлын шугамаар хамаарагддаг эсвэл харьяалагддаг нийгмээс гадуурхагдсан болон нийгмийн цөөнх болсон бүлгүүдтэй холбоотойгоосоо болж тодорхой бүлгийн хүний эрхийг хамгаалагч нар өндөр эрсдэл хүлээдэг. Тухайн улс дахь хүний эрхийн байдал, тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан учрах эрсдэлийн зэрэг өндөртэй хүний эрхийг хамгаалагчдын тодорхой бүлгүүд гэдэгт дараах хүмүүсийг ойлгож болох ба эл байдал нь үүгээр хязгаарлахгүй. Үүнд:

- Хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүд, өөрөөр хэлбэл, хүний эрхийн хамгааллын үйл ажиллагаанд оролцдог бүх насны эмэгтэйчүүд ба хүйсийн хүчирхийлэл, эхийн эрүүл мэнд зэрэг хүйсийн тэгш байдлын²³ өөр бусад олон асуудал дээр ажиллаж буй эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалахад хүчин зүтгэдэг бүх хүн;
- Рома (Зүүн өмнөд европын цыган үндэстэн), Синти (Баруун болон төв европын цыган үндэстэн), Ирланд хэрмэл ястан, африк гаралтай хүмүүс, дүрвэгсэд, цагаачид, бусад хүмүүс буюу нутгийн уугуул иргэд зэрэг үндэстний, эсвэл угсаатны, шашны болон хэлний цөөнхөд хамаарах, эсвэл тэдний хамгаалагч хүний эрхийг хамгаалагчид;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалагчид, түүний дотор сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалдаг хүмүүс;
- Хүний эрхийг хамгаалагч ЛГБТИ хүмүүс, бэлгийн чиг баримжаа, хүйс, хүйсийн илэрхийлэл, манин байдлаар ялгаварлан гадуурхах, хүчирхийлэхийн эсрэг ажилладаг аливаа хүн;
- Хууль сахиулах байгууллагын ажилтнууд, зэвсэгт хүчний алба хаагчид, шүүгч, хуульчид, төрийн албан тушаалтнууд, төрийн үйлчилгээний ажилтнууд болон төрийн бусад салбарын ажилтнууд, хүний эрхийн нэхэмжлэл хариуцсан мэргэжилтнүүд (омбудсмэн), ХЭҮИ-ийн ажилтнууд, сэтгүүлчид болон бусад хэвлэл мэдээллийн ажилтнууд гэх мэт тодорхой мэргэжлийн бүлгүүдийн гишүүд болох хүний эрхийг хамгаалагчид;

23 2013 оны 12-р сард баталсан, эмэгтэй хүний эрхийг хамгаалагч нар болон хүйсээсээ үл хамааран эмэгтэйчүүдийн эрх, хүйсийн тэгш байдлыг хамгаалдаг хүмүүсийн аль алиныг хамруулж тодорхойлсон НҮБЕА-н тогтоолын дагуу “эмэгтэй хүний эрхийг хамгаалагч” гэсэн нэр томъёог ашигладаг. НҮБЕА-н 68/181 тоот тогтоолын ерөнхий зүйл 6 дугаарыг үз.

- Хүний эрхийн зөрчлийн талаарх мэдээллийг илчилдэг шүтэл үлээгчид, түүнчлэн энэ төрлийн мэдээлэл хүлээж авсан, мэдэж буй, эсвэл түгээсэн хүмүүс;
 - Сонгуулийн нөхцөл байдал дахь иргэний болон улс төрийн эрхийн асуудал, итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх, үйлдвэрчний эвлэлд элсэх, оролцох, шашин шүтэх, цэргийн алба хаахаас зарчмын зөрүүгээр татгалзах зэрэг үндсэн эрх чөлөөг хамгаалах гэх мэт хүний эрхийн тодорхой асуудлууд дээр ажилладаг хүний эрхийг хамгаалагч нар, мөн цэргийн дэглэмийн эсрэг болон энх тайван, аюулгүй байдлыг дэмжих чиглэлээр ажилладаг хүмүүс;
 - Эдийн засаг, нийгэм, соёлын эрх, эрүүл мэнд, байгаль орчин, эсвэл газрын асуудал, компанийн хариуцлагын талаар ажилладаг хүний эрхийг хамгаалагч нар. Ядуу, орон гэргүй, мансууруулах бодис хэрэглэгч, ХДХВ/ДОХ-той зэрэг нийгмээс тусгаарлагдсан болон нийгмийн цөөнх болсон хүмүүс, түүнчлэн хүүхдүүд, хүний наймаанд өртсөн хүмүүс гэх мэт мөлжлөгт өртөж буй хүмүүсийн эрх ашгийг хамгаалдаг хүмүүс;
 - Хөдөө орон нутаг буюу алслагдсан бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг, маргаантай, эсвэл хүлээн зөвшөөрөгдөөгүй газар нутаг, мөн мөргөлдөөний дараах, эсвэл мөргөлдөөн үргэлжилж буй нөхцөл байдал, түүнчлэн хүмүүнлэгийн хямрал, эсвэл онц байдлын үеүдэд, төрөл бүрийн сонгуулийн нөхцөл байдалд ажилладаг хүний эрхийг хамгаалагчид.
17. Оролцогч улсууд тухайн орны нөхцөл байдлаас шалтгаалан тодорхой бүлэг хүний эрхийг хамгаалагч нар онцгой төрлийн эрсдэлд ордог гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Иймээс тэднийг хамгаалах, ажлыг нь дэмжихэд чиглэсэн аливаа арга хэмжээ авахдаа оролцогч орнууд эдгээр бүлгүүдийн онцлог хэрэгцээг тухайлан авч үзэх хэрэгтэй.

Төрийн үүрэг хариуцлагын мөн чанар

18. ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүргийнхээ хүрээнд, өөрсдийн соёрхон баталсан олон улсын хүний эрхийн гэрээнүүд, олон улсын хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргийнхээ дагуу улс орнууд хүний эрхүүдийг хүндэтгэх, түүнчлэн тэдгээр эрхүүдийг хангах эерэг ба сөрөг үүрэгтэй байдаг.
19. ИУТЭОУП-д тусгасан эерэг ба сөрөг үүргүүдийн хүрээнд, НҮБ-ын Хүний эрхийн хорооноос НҮБ-ын оролцогч орнуудыг уг Пактад хүлээн зөвшөөрөгдсөн эрх зөрчигдөхөөс зайлсхийхийн сацуу, үүнээс урьдчилан сэргийлэх, шийтгэх, мөрдөн шалгах, эсвэл хувь хүн, бусад этгээдүүдийн

үйлдлээс учирсан хохирлыг барагдуулах зорилгоор зохих арга хэмжээ авахыг ИУТЭОУП шаарддаг гэдгийг мэдэгдсэн. Мөн эдгээр улсаас ИУТЭОУП-ын дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд хууль тогтоомж, шүүх, захиргааны, боловсролын болон бусад холбогдох арга хэмжээг авахыг шаарддаг.²⁴

20. Хүний эрхүүдийг хүндэтгэх, хамгаалах, биелүүлэх үүрэг нь хүний эрхийг хамгаалдаг хүмүүсийн эрхийн тухайд ч нэгэн адил хамаарна. Энэ нь оролцогч орнууд хүний эрхийг хамгаалагчдын эрхийг зөрчих үйлдлээс тагталзахаас гадна хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах чиглэлээр зохих арга хэмжээ авахын зэрэгцээ хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах, түүнчлэн хүний эрхийг хамгаалагчдад чөлөөтэй, хариу арга хэмжээнд орох, бусад хор хөнөөл учрахаас айхгүйгээр хүний эрхийн үйл ажиллагаагаа явуулах боломж олгохуйц аюулгүй, ээлтэй орчныг бүрдүүлэхэд чиглэсэн санаачилгатай, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах ёстой гэсэн үг юм. Мөн хувь хүн, бүлгүүдийн зүгээс эрх баригчид болон ард иргэдтэйгээ харилцах явцдаа хүний эрхийг хамгаалахад үүнийг нь хэвийн үзэгдэл гэж хүлээн авдаг болгохын тулд оролцогч улсууд өөрсдийн нийгэмд хүний эрхийн соёлыг хөхиүлэн дэмжих боловсрол олгосон идэвхтэй алхмуудыг хэрэгжүүлэх нь зүйтэй юм.
21. Хүний эрхийг, тэр тусмаа хүний эрхийг хамгаалагчдын эрхийг (хүний эрхийг хамгаалах эрх зэрэг) хүндэтгэх, хамгаалах, хангах үүрэг гэрээний улс бүрд бүхэлд нь хамаатай. Тухайлбал, НҮБ-ын Хүний эрхийн хорооноос “Пактаар хүлээсэн үүргүүд нь [...] оролцогч улсуудын доторх засаг, засаглалын нэгж салбар бүрд нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ. Бүх төрлийн засаглал (гүйцэтгэх, хууль тогтоох болон шүүх) мөн үндэсний, бүс нутгийн, эсвэл орон нутгийн гэх мэт аль ч түвшний засгийн газрын салбар байгууллага нь гэрээний улсын үүрэг хариуцлагыг хүлээх байр суурьтайгаар оролцоно” гэж мэдэгдсэн. Үүнээс үзэхэд засгийн газрын бүх түвшний салбар байгууллага хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах үүрэгтэй. Тухайлбал, засгийн газрын өөр нэг салбар байгууллага, эсвэл нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны улмаас зөрчил гарсан гэж үзвэл гэрээний улс хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.²⁵ Улмаар төрийн албан тушаалтан, эсвэл байгууллагын албан ёсны статусгүй

24 НҮБ-ын Хүний Эрхийн Хороо, ерөнхий тайлбар №31, “Гэрээний улсуудад оногдуулсан эрх зүйн ерөнхий үүргийн мөн чанар”, НҮБ-ын Б.6. ССР/С/21/Rev.1/Add.13, 2004 оны 5-р сарын 26, 6-8 дугаар заалт.

25 Мөн эх сурв. 6-8 дугаар заалтыг тус тус үз. Энэ агуулгын хүрээнд, улс орнуудын ИУТЭОУП-аар хүлээсэн үүрэг амлалтыг Хүний Эрхийн Хорооноос тайлбарласны дагуу улс орнуудын энд дурдсан үүргүүд нь хилийн чанадад, жишээлбэл: тухайн улсын үйл ажиллагаа явуулж буй гаднын нутаг дэвсгэрт ч хүчин төгөлдөр хэвээр байна гэдгийг тэмдэглэн хэлэх нь зүйтэй. Ерөнхий тайлбар №31-ийг үз. 10 дугаар заалт.

хувь хүмүүс, бүлгүүдийн үйлдсэн буруутай үйлдлүүдэд олон улсын хууль тогтоомжид зааснаар төр өөрөө хүний эрхийг хамгаалагчдын эрхийг зөрчсөн буруутайд тооцогдох ба эдгээр хувь хүн, байгууллага нь де-факто төрийн төлөөлөл байсан ч ялгаагүй юм. Ийм хүмүүс, эсвэл бүлгүүд тодорхой удирдамжийн дагуу, улсаас зарласан зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд (Төрийн бус талын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шийтгэл оногдуулах тухай төрийн үүргийг доороос үз.) хамаарна.²⁶

Хүний эрхийн үйл ажиллагаа явуулахад аюулгүй, таатай орчин

22. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс “[...] хүний эрхийг хамгаалагчдыг аливаа саад тотгор, аюулаас ангид ажиллах боломжтой аюулгүй, таатай орчныг бүрдүүлэхийг”²⁷ уриалсны хариуд ЕАБХАБ-ын оролцогч орнууд “үр дүнтэй ардчилсан институтууд, шударга шүүхийн процесс, эрхзүйг ёсны засаглалын хамгаалалтын дор хүн бүхэн хүний эрх, үндсэн эрх чөлөөгөө бүрэн эдлэх боломжтой байх орчин нөхцөлийг тус тусын бүс нутагт дэмжин цогцлуулах” үүрэг амлалт өгсөн. Үүнд нийгэм дэх бүхий л хувь хүн, бүлэг тайван замаар мэтгэлцэх, ашиг сонирхлоо илэрхийлэхэд аюулгүй орчин, институтуудтэй байх нь нэгэн адил хамаарна.²⁸
23. Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын талаар НҮБ-ын Тусгай илтгэгчийн үзэж буйгаар аюулгүй, таатай орчинд дараах зүйлсийг багтаасан болно. Үүнд: хууль эрхзүй, институт болон засаг захиргааны

26 Прокурор В.Душко Тадич, “Хуучин Югославын нутаг дэвсгэрт 1991 оноос хойш үйлдэгдсэн олон улсын хүмүүнлэгийн тухай хууль тогтоомжийн ноцтой зөрчлийн нэхэмжлэлийн хариуцагч этгээдүүдийн хэргийг шүүхээр хянан хэлэлцсэн Олон улсын дагнасан шүүхийн Давж заалдах шатны шүүхийн дүгнэлт” -ийг үз. Югослав, Нэхэмжлэлийн дугаар IT-94-1-A. 1999 оны 7-р сарын 15-ны өдөр. Зохион байгуулалттай болон шаталсан зохион байгуулалттай цэргийн бүлгүүдийн хувьд “ерөнхий удирдлага дор” нь ажиллаж байгаа тохиолдолд тухайн бүлгийн үйлдсэн үйлдлүүдэд оролцогч улс хариуцлага хүлээнэ. Ерөнхий удирдлага дор гэдэг нь “оролцогч улс нь тухайн бүлгийг санхүүжилт, сургалт, тоног төхөөрөмжөөр хангах, эсвэл үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэхээс гадна, тухайн цэргийн бүлгийн цэргийн ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, төлөвлөхөд үүрэг оролцоотой байвал гэсэн үг. Бүлэг, эсвэл түүний гишүүдийн хийсэн үйлдлийг эдгээр үйл ажиллагааг хянадаг оролцогч Улсын аливаа тусгай зааврыг үл харгалзан төрийн байгууллагуудын үйлдэл гэж үзэж болно.” Мөн эх сурв. 137 дугаар заалтыг үз.

27 НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн A/HRC/RES/22/6 тогтоолын 2 дугаар заалтыг үз. Үүний нэгэн адил Европын Зөвлөлийн Сайд нарын Хороо Европын Зөвлөлийн гишүүн орнуудыг “Хувь хүн, бүлэг, холбоодод үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулах нөхцөл бүрдүүлэх замаар хүний эрхийг хамгаалагчдын ажилд таатай орчин бүрдүүлэх, [...] хүний эрх, үндсэн эрх чөлөөг дэмжиж, хамгаалахыг эрмэлзэхийг [...]” уриалсан. Сайд нарын Хорооны 2008 оны 2-р сарын 6-ны өдөр баталсан “Хүний эрхийг хамгаалагчдын эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагааг нь хөхиүлэн дэмжих талаар Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны тунхаглал”, 2 дугаар заалтыг <https://wcd.coe.int/ViewDoc.jsp?id=1245887&Site=CM-аас> үз.

28 Сайд нарын Хорооны арван нэгдүгээр уулзалтын баримт бичиг, “Хорин нэгдүгээр зууны аюулгүй байдал, тогтвортой байдалд тулгарч буй аюул заналыг шийдвэрлэх ЕАБХАБ-ын стратеги”-г үз. Маастрихт 2003, 36 дугаар заалт.

ээлтэй орчин; шударга ёсыг хүртэх боломж, хамгаалагчдын эсрэг зөрчил гаргагсад ял шийтгэх хүлээх тогтолцоотой, хүчирхэг, бие даасан хүний эрхийн үндэсний байгууллага, эмэгтэй хамгаалагчдад тусгайлан чиглэсэн бодлого, хөтөлбөрүүд; эрсдэлд буй бүлгүүдэд онцгой анхаарал хандуулсан үр дүнтэй хамгааллын бодлого, механизмууд, хүний эрхийг хамгаалагчдын ажлыг хүндэтгэж, дэмждэг төрийн бус талууд, олон улсын хүний эрхийн байгууллагуудад аюулгүй, нээлттэй хандах арга зам, хүчтэй, чадамгай, олон талт байдалтай хүний эрхийг хамгаалагч зэрэг багтана.²⁹

24. Ийм орчин нь хүний эрхийг хамгаалагчдын бие махбодын болон сэтгэл зүйн халдашгүй байдал, эрх, эрх чөлөө, аюулгүй байдал, нэр төрийг найдвартай хамгаалах, мөн хүний эрхийг хамгаалах эрхээ бүрэн эдлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг төрөл бүрийн бусад үндсэн хүний эрхийг хэрэгжүүлэхийг шаарддаг.
25. Хэдийгээр энэ хоёр чиглэл хоёулаа хоорондоо нарийн холбоотой боловч, уг удирдамж нь хүний эрхийг хамгаалагчдын аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа, дараа нь аюулгүй, таатай орчныг бүрдүүлэх бусад хүчин зүйлд тус тусад нь төвлөрч авч үзсэн болно.

I. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧДЫГ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

Хүний эрхийг хамгаалагчдын эрх ашгийг хамгаалах олон улсын хэм хэмжээг хүлээн зөвшөөрөх нь

26. Оролцогч улс орнууд “Хүний эрх, эрх чөлөөний тухайд, хүний эрх, үндсэн эрх чөлөө, ардчилал, эрх зүйт ёстой холбоотой асуудлууд нь олон улсын дэг журмын тулгуур багануудын нэг учраас олон улсын анхаарлын төвд байдаг” гэж удаа дараа цохон тэмдэглэсэн.³⁰ Ялангуяа тэд “ЕАБХАБ-ын хүний аюулгүй байдлын хэмжүүрийн чиглэлээр хүлээсэн үүрэг амлалтууд нь бүх оролцогч улс орны шууд болон хууль ёсоор анхаарал хандуулах асуудлууд бөгөөд холбогдох улс орны дан ганц дотоод хэрэгт хамаарахгүй” гэдгийг тууштай мэдэгдсэн.³¹
27. Үүний нэгэн адил Хүний эрхийн хорооноос ИУТЭОУП-аар хүлээсэн үүргүүдийн тухайд “бусад гэрээний улсын хүлээсэн үүргээ биелүүлэх

29 Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн тусгай илтгэгчийн тайлан, A/HRC/25/55, 2013 оны 12-р сарын 23, 61 дүгээр заалт.

30 Москва 1991, оршил.

31 Мөн эх сурв. Лисбонь баримт бичиг, Төр болон Засгийн газрын тэргүүн нарын уулзалт, “Хорин нэгдүгээр зууны Европын аюулгүй байдлын нийтлэг, цогц загварын тунхаглал”, Лисбон, 1996 он, 5 дугаар заалт; Европын аюулгүй байдлын тухай дүрэм, “Бидний нийтлэг үндсэн зарчим, Станбул 1999, 7 дугаар заалт; Астана 2010, 3 ба 6 дугаар заалтыг мөн тус тус үз.

байдал гэрээний улс бүрийн хууль ёсны эрх ашгийг хөндөнө. Энэ нь “хүний үндсэн эрхэд хамаарах дүрэм журам” нь erga omnes буюу нийтийн үүрэг хариуцлага бөгөөд НҮБ-ын Дүрэмд заасан үүргийнхээ дагуу хүний эрх, үндсэн эрх чөлөөг дагаж мөрдөх ба бүх нийтээр хүндэтгэх ёсыг дэлгэрүүлж, дагаж мөрдөнө гэж пактын ерөнхий зүйл дөрөв дэхэд зааснаас урган гарсан.”³²

28. Түүнчлэн бүх оролцогч улс өөр өөрсдийн оронд тулгараад буй хүний эрхийг хамгаалах эрхэд сөргөөр нөлөөлж буй аюулгүй байдлын аливаа аюул заналхийлэл, эсвэл бусад асуудлыг шийдвэрлэхэд бие биетэйгээ шударгаар хамтран ажиллах ёстой. Хэрэв өөр оролцогч улс өөрийнх нь орны хүний эрхийг хамгаалагчдын байдлыг сонирхож байгаа бол тэд үүнийг нөхөрсөг бус үйлдэл гэж үзэх ёсгүй. ЕАБХАБ-ын үүрэг амлалтынхаа хүрээнд мөн хүний эрхийн ажил нь ихэвчлэн хил дамнасан шинжтэй байдаг гэдгийг хүлээн зөвшөөрөх үүднээс оролцогч улсууд улс орондоо хамаатай болон бусад орны хүний эрхийг хамгаалагч нарын хийж байгаа хүний эрхийн ажлыг дэмжих хэрэгтэй.³³

Төрийн бус талуудын хариуцлага

29. Төрийн бус тал гэдгийг олон янзаар тодорхойлдог боловч энэхүү удирдамжийн хүрээнд нэр томъёог өргөн хүрээнд ашигладаг. Үүнд аливаа статус, төртэй албан ёсоор хамааралтай эсэхээс нь үл хамааран төрөөс бусад хувь хүмүүс болон төрийн бус бүх этгээдийг ойлгоно. Иймээс Төрийн бус талууд улс төрийн болон нийгмийн бүлгүүд, шашны үзэл санааны манлайлагчид, байгууллагууд (үүнд тухайн оролцогч улсад онцгой статустай хүмүүсийг багтаасан), хэвлэл мэдээллийн байгууллагууд, бизнес эрхлэгчид (үндэстэн дамнасан корпорацууд, хөдөө аж ахуй, олборлох аж үйлдвэр зэрэг томоохон аж үйлдвэрүүдийг оролцуулаад), гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээ, түүнчлэн зэвсэгт бүлэглэлүүд, гэмт хэргийн бүлэглэлүүд гэх мэт орно.
30. Төрийн бус талуудын хүний эрхийг хамгаалагчдын ажилд хандах хандлагын тухайд, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс “нийгмийн бүхий л салбарын удирдагчид, түүний дотор улс төр, нийгэм, шашны үзэл санааны манлайлагчид, бизнес, хэвлэл мэдээллийн салбарын удирдагчдыг хүний

32 НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны ерөнхий тайлбар №31, CCPR/C/21/Rev.1/Add.13, 2004 оны 5-р сарын 26, 2 дугаар заалтыг үз.

33 Жишээлбэл: Москвагийн баримт бичгийн хүрээнд оролцогч улсууд “Хүний аюулгүй байдлын хэмжүүрийн нөхцөл байдлыг ажиглахын тулд аливаа оролцогч улсуудаас ТББ-ууд өөрсдийн улс оронд айлчлах ажлыг дэмжих” үүрэг амлалт авсан. Москва, 1991 он, 43.4 дүгээр заалтыг үз.

эрхийг хамгаалагчдын чухал үүрэг, тэдний үйл хэргийг дэмжиж буйгаа олон нийтэд нээлттэй илэрхийлэхийг уриалсан.”³⁴

31. Бизнесийн тухайд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс баталсан Бизнес, хүний эрхийн чиглүүлэх зарчмууд нь бизнес эрхлэгчид хүний эрхийг хүндэтгэх ёстой, өөрөөр хэлбэл хүний эрх зөрчигдөхөөс зайлсхийх, эрхэлж буй бизнес үйл ажиллагаанаас нь үүссэн хүний эрхийн сөрөг нөлөөллийг шийдвэрлэх ёстой гэх зэргийг цохон тэмдэглэсэн. Үүний учир уг удирдамжийн баримт бичигт заасны дагуу, бизнес эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд хэмжээ, нөхцөл байдлаасаа хамааран хүний эрхэд нөлөөлж буй өөрсдийн нөлөөллийг хэрхэн тодорхойлох, урьдчилан сэргийлэх, багасгах, хариуцлага хүлээхийг заасан бодлогын үүрэг амлалтыг тусгасан. Мөн хүний эрхийг хангах зохих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх хэрэгтэй ба түүнчлэн өөрсдийн үүсгэсэн, эсвэл үүсгэхэд оролцсон хүний эрхийн аливаа сөрөг үр дагаврыг арилгах үйл явцыг сайжруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхийг зөвлөсөн.³⁵ Бизнесийн корпорацуудыг өөрсдийн үйл ажиллагааны хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдалд үзүүлэх нөлөөлөлд онцгой анхаарч ажиллахыг уриалах нь зүйтэй. Нөлөөллийн үнэлгээ хийхдээ эдгээр байгууллагууд нь ажил хэрэгч зөвлөлдөх уулзалтуудаар дамжуулан хүний эрхийг хамгаалагч нар болон бусад нөлөөлөлд өртөж болзошгүй бүлэг, оролцогч талуудыг татан оролцуулах хэрэгтэй.³⁶

34 A/HRC/RES/22/6,18 дугаар заалт.

35 Ерөнхий нарийн бичгийн даргын хүний эрхийн болон үндэстэн дамнанас корпорацууд болон бусад бизнесийн нэгжүүдийн асуудал эрхэлсэн Тусгай төлөөлөгч Жон Ругигийн “Бизнес ба хүний эрхийн чиглүүлэх зарчмууд: НҮБ-ын ‘Хамгаалах, хүндэтгэх, залруулах’ арга хэмжээг хэрэгжүүлэх нь” ерөнхий төлөвлөгөө, НҮБ-ын Б.6, 2011 оны 3-р сарын 23-ны A/HRC/17/31, зарчим 15-ыг үз. Чиглүүлэх зарчмуудыг НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөл батлав. 2011 оны 6-р сарын 16-ны A/HRC/17/31-р тогтоолын 1 дүгээр заалтыг үз. Энэ асуудлын талаар, мөн: Томоохон бүтээн байгуулалтын ажил дахь Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн тусгай илтгэгчийн бичсэн тайланг үз. НҮБ-ын Б.6, 2013 оны 8-р сарын 5-ны өдөр, A/68/262; хүний эрхийн болон үндэстэн дамнанас корпорацууд болон бизнесийн бусад байгууллагуудын асуудлаарх НҮБ-ын Ажлын хэсгийн тайлан, тухайлбал, “бизнесийн зарим үйл ажиллагааны хүний эрхийн ноцтой сөрөг нөлөө, түүнд арга хэмжээ авах, хохирогчдод хохирлоо барагдуулах арга хэмжээ, үйлчилгээнд хамрагдах боломжийг олгохоор ажиллаж буй (49 дүгээр заалт) хүний эрхийг хамгаалагчид, иргэний нийгмийн байгууллагуудад учирч буй дарамт шахалт, мөрдөлт хавчлага, хариу арга хэмжээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд оролцдог иргэний нийгмийн байгууллага, хүний эрхийг хамгаалагчдын үүргийн талаар ажлын хэсгийн онцлон тэмдэглэсэн, мөн “шүүхийн шугамаар хэргээ шийдвэрлүүлэхээр хандсан хүний эрхийг хамгаалагч, хохирогчдод учирч буй дарамт, хавчлага, хариу арга хэмжээний талаар гүнээ санаа зовниж буйгаа илэрхийлсэн” (47 дугаар заалт) ажлын хэсгийн 2013 оны 3-р сарын 14-ний өдрийн НҮБ-ын Б.6, A/HRC/23/32 -ыг үз.

36 НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын бизнес ба хүний эрхийн асуудал эрхэлсэн Тусгай төлөөлөгч, мөн бизнес эрхлэгч байгууллагууд хүний эрхийн зохих журмыг хэрэгжүүлэх арга хэмжээ явуулахдаа “хүний эрхийг хамгаалагч нар гэх мэт найдвартай, хараат бус хүчнээс зөвлөгөө тусламж авахыг” зөвлөсөн. “Бизнес ба хүний эрхийн удирдамж”, 18-р зарчмын зөвлөмжийг үз.

32. Төрийн бус талууд нь тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хөхиүлэн дэмжих замаар хүний эрхийг хамгаалагчдын хамгааллыг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэж чадах боловч хүний эрхийг хамгаалагчдын эрх, нийтлэг хүний эрхийг ухуулан таниулах, хамгаалахад төр гол үүрэгтэй.³⁷ Иймээс төр хүний эрхийг хамгаалагчдыг төрийн бус талын гаргах зөрчлөөс хамгаалах, тухайлбал ийм зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, шийтгэх, хор нөлөөг засаж залруулах талаар үр дүнтэй хууль тогтоомж болон бусад арга хэмжээ авах замаар хамгаалах үүрэгтэй байдаг.
33. Бизнес, хүний эрхийн чиглүүлэх зарчмын дагуу оролцогч орнууд өөрсдийн нутаг дэвсгэр дээр бүртгэлтэй үйл ажиллагаагаа явуулдаг болон/эсвэл харьяалалтайгаар үйл ажиллагаа явуулдаг бүх аж ахуйн нэгжид үйл ажиллагааныхаа бүхий л үе шатанд хүний эрхийг хүндэтгэх ёстой гэсэн хүлээлтийг тодорхой зааж өгөх шаардлагатай.³⁸ Бусад хувь этгээд, түүний дотор улс төр, нийгмийн болон шашны бүлэглэлүүд, эсвэл байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд үүнтэй ижил шаардлага тавьж болно. Түүнчлэн оролцогч улсууд хүний эрхийг хамгаалагчдын эсрэг хүчирхийлэл үйлдсэн хувийн болон бусад төрийн бус талуудтай үгсэн сүлбэлдэх, гэрээт үйлчилгээ авахаас татгалзаж, тэдэнд хариуцлага хүлээлгэх ёстой. Ялангуяа, цэрэг, аюулгүй байдлын компаниуд болон бусад бүлэг гэх мэт хувийн этгээдээр гэрээгээр гүйцэтгүүлдэг журамтай төрийн эрх мэдэлд хамаарах чиг үүргүүдийн хувьд ихээхэн хамааралтай. Одоогийн хууль тогтоомж, бодлого, практик үйл ажиллагаа нь төрийн бус талуудад хариуцлага хүлээлгэхэд хангалтгүй байгаа тохиолдолд оролцогч орнууд эдгээр хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсвэл энэ зорилгоор шинэ хууль тогтоомж баталж, практикт хэрэгжүүлэх хэрэгтэй.

37 НҮБ-ын хүний эрхийг хамгаалагчдын тунхаг, ерөнхий зүйл 7 дугаарыг үз. Мөн 2008 оны 2-р сарын 6-ны өдөр батлагдсан Европын Зөвлөлийн "Хүний эрхийг хамгаалагчдын хамгааллыг сайжруулах, тэдний үйл ажиллагааг дэмжих тухай Европын Зөвлөлийн үйл ажиллагааны талаарх Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны тунхаглал"-ын 9 дүгээр ерөнхий зүйл; ба НҮБЕА-н A/RES/66/164 тоот тогтоол, 15 дугаар ерөнхий зүйлийг тус тус үз.

38 "Бизнес ба хүний эрхийн чиглүүлэх зарчим", зарчим №2. Ялангуяа гадаад дахь хувийн компаниудын үйл ажиллагааны хувьд НҮБ-ын Хүний Эрхийн Хорооноос уг зарчмыг, тухайлбал, Германы талаар хийсэн дүгнэлтдээ давтан дурдаж, тухайн гэрээний улсыг энэхүү хүлээлтийг тодорхой зааж өгч, мөн гадаадад үйл ажиллагаа явуулж буй германы бизнесийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны золиос болсон хүмүүсийг хамгаалах арга хэмжээг бэхжүүлэх талаар холбогдох арга хэмжээг авахыг уриалсан. НҮБ-ын Б.б, "Германд хийсэн нэгдсэн дүгнэлт", CCPR/C/DEU/CO/6, 2012 оны 11-р сарын 12, 16 дугаар заалтыг үз. Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой хүний эрхийн зөрчлийг шийдвэрлэхэд оролцох төрд суурилсан шүүх механизмын тухай 26-р зарчмын зөвлөмжөөр уг чиглүүлэх зарчмууд нь "хүний эрхийг хамгаалагчдын хууль ёсны, тайван үйл ажиллагаанд саад учруулахгүй байх" талаар тусгайлан зөвлөсөн.

Тэгш байдал ба үл ялгаварлан гадуурхах нь

34. ИУТЭОУП-ын 26 дугаар заалтад “Бүх хүн хуулийн өмнө тэгш эрхтэй бөгөөд аливаа алагчлалгүйгээр хуулиар адил тэгш хамгаалуулах эрхтэй гэж заасан байдаг. Тиймээс арьс өнгө, өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал үүсэл, өмч хөрөнгө, төрсөн байдал, эсвэл бусад аливаа байдлаар ялгаварлан гадуурхах явдлыг хуулиар хориглох бөгөөд хүн бүрийг эдгээрээс найдвартай, эрх тэгш хамгаалуулах баталгааг хангана. Түүнчлэн ИУТЭОУП-ын 2 дугаар заалтад гэрээнд оролцогч улс орнуудаас “нутаг дэвсгэрт нь оршин суудаг, эсвэл хуулийн харьяалалтай бүх хүнийг хүндэтгэж, арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал үүсэл, өмч хөрөнгө, төрсөн байдал, эсвэл бусад аливаа ялгааг нь үл харгалзан энэхүү Пактаар дархалсан эрхийг эдлүүлэхийг” шаарддаг. Үүний нэгэн адил, ЭЗНСЭОУХ-ийн 2 дугаар заалтад энэхүү гэрээнд тусгагдсан эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг дээр дурдсан аливаа алагчлалгүйгээр эдлүүлэх нөхцөлийг баталгаажуулсан юм. Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын хэлцэл (АӨЯГБХУОУХ) нь “улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын болон нийгмийн амьдралын бусад салбарт хүний эрх, эрх чөлөөг эрх тэгшээр хүртэх буюу эдлэх, эн зэрэгт үзүүлэх эрхийг хааж боох, үгүйсгэх нөлөө, эсвэл зорилготой, угсаа гарал, арьсны өнгө, удам угсаа, эсвэл иргэний юм уу, угсаатны харьяаллаар нь аливаа давуу байдал олгох, хязгаарлах, хасах, алагчлах”³⁹ гэж ойлгож арьс өнгөөр ялгаварлан гадуурхахаас хамгаалдаг.
35. Ялгаварлан гадуурхахыг хориглосон заалтууд нь хүний эрхийн тухай бүс нутгийн гэрээнд, түүний дотор ХЭАК⁴⁰-ын 1 ба 24 дүгээр зүйл, ЭШЭК-ийн 14 дүгээр зүйл, ЕХЭК⁴¹-ийн 12 дугаар протокол, Европын зөвлөлийн үндэсний цөөнхүүдийг хамгаалах суурь конвенц (ҮЦХСК)-ын 4 дүгээр зүйл, Европын холбооны угсаатны эрх тэгш байдлыг хангах заавар⁴² гэх мэт бусад стандартад тус тус багтсан болно.
36. “Ялгаварлан гадуурхалтгүйгээр, хуулийн өмнө эрх тэгш байх, хуулиар адил тэгш хамгаалуулах нь хүний эрхийг хамгаалахтай холбоотой үндсэн

39 АӨЯГБХУОУХ, Зүйл 1.

40 ХЭАК-ийн 1-р зүйл нь конвенцоор заасан бүх эрхийг ялгаваргүйгээр хамгаалах боломжийг олгодог бөгөөд үүнээс гадна, 24-р зүйл хуулиар адил тэгш хамгаалуулах нийтлэг эрхийг олгодог.

41 ЕХЭК-ын 14-р зүйлд тусгагдсан ялгаварлан гадуурхалтыг хориглох нь хязгаарлагдмал шинж чанартай бөгөөд зөвхөн Конвенцоор баталгаажсан эрхэд хамаарна. Гэсэн хэдий ч, ЕХЭК-ын 12-р протоколд ялгаварлан гадуурхалтыг бүхэлд нь хориглосон байдаг.

42 Арьс өнгө, үндэс угсаа гарал үүслээс үл хамааран хүмүүст ижил тэгш хандах зарчмыг хэрэгжүүлсэн 2000 оны 6-р сарын 29-ний өдрийн Зөвлөлийн Заавар 2000/43/EC-г <http://eur-lex.europa.eu/LexUriServ/LexUriServ.do?uri=CELEX:32000L0043:en:HTML> холбоосоор үз.

болоод ерөнхий зарчим билээ” гэж НҮБ-ын Хүний эрхийн хорооны баримт бичигт цохон тэмдэглэсэн⁴³ нь хүний эрхийг хамгаалагчдын хамгааллын тухайд ч нэгэн адил үйлчилнэ. ИУТЭОУП-ын 26 дугаар заалтад заасны дагуу хуулийн өмнө тэгш байдал, хуулиар адил тэгш хамгаалуулах байдал нь хуулиуд, түүнчлэн хууль тогтоомжоос үүссэн практик үйл ажиллагаа нь шууд болон шууд бус аль ч аргаар ялгаварлан гадуурхах нөлөө үзүүлэх ёсгүй гэсэн утгатай юм. Иймээс шууд болон шууд бус ялгаварлан гадуурхалтыг хориглоно. Шууд бус ялгаварлан гадуурхалт нь үл ялгаварлан гадуурхсан юм шиг санагдах хуулийн заалт тодорхой бүлгүүдэд харьцангуйгаар нөлөөлөхөд илэрнэ. Хүний Эрхийн Хорооноос тогтоосноор, хуулийн өмнө эрх тэгш байх, ялгаварлан гадуурхахаас ангид байх эрх нь оролцогч улсуудыг бүх салбар дахь төрийн болон төрийн бус талууд, байгууллагын зүгээс үйлдсэн ялгаварлан гадуурхалтыг таслан зогсоохыг шаарддаг.⁴⁴

37. ЕАБХАБ-ын оролцогч орнууд хүний эрх, үндсэн эрх чөлөөгөө хэрэгжүүлэх эсвэл хэрэгжүүлэх зорилго агуулах, хэрэгжүүлэхээр эрмэлзэж буй хувь хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг уг үйлдэхүйнх нь төлөө нь ямар нэг хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх үүрэг хүлээсэн болно.⁴⁵ Иймээс хүний эрхийг хамгаалах, хэрэгжилтийг хөхиүлэн дэмжиж, үүнд эрмэлзэж буй хувь хүмүүс энэ үйл ажиллагааныхаа үр дүнд ялгаварлан гадуурхагдах ёсгүй.
38. Хүний эрхийг хамгаалагчид “бүгд нэн чухал ач холбогдолтой, зохих бүх аргаар хангуулах ёстой” мөн иргэний, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын болон бусад эрх, эрх чөлөөг багтаасан бүх эрхээ эдлэхдээ ялгаварлан гадуурхагдахаас хамгаалуулах ёстой.⁴⁶ Үүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, орон сууц, боловсрол, хөдөлмөр эрхлэлт зэрэг төрийн үйлчилгээг тэгш хүртэх байдал ч хамаарна. Эдгээр үйлчилгээнүүдийг хүртэх боломжийг олгохдоо ялгаварлан гадуурхалтыг ихэвчлэн хүний эрхийг хамгаалагчдыг дуугүй болгох, эсвэл хүний эрхийн ажилд саад

43 НҮБ-ын Хүний Эрхийн Хороо, “Ерөнхий тайлбар №18: Ялгаварлан гадуурхалт”, 1989 оны 11-р сарын 10, 1 дүгээр заалт. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц (ЭЯГБХУК)-ийн 1-р зүйлд заасан “эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах” гэсэн тодорхойлолт дээр үндэслэн “ялгаварлан гадуурхах” гэсэн нэр томъёог, Хүний Эрхийн Хорооны үзэж байгаачлан, ИУТЭОУП-ын 2 ба 26-р зүйлд заасан аливаа эрхэд аливаа давуу байдал олгох, хязгаарлах, хасах, алагчлах болон хүн бүр, эрх тэгш байдлаар, бүх эрх, эрх чөлөөг эдлэх байдлыг хааж боох, үгүйсгэх нөлөө, эсвэл зорилготой гэж ойлгоно. Мөн эх сурв. 7 дугаар заалтыг үз.

44 НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны ерөнхий тайлбар №28, 3-р зүйл, “Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрхийн тэгш байдал”, НҮБ-ын Б.6 ССР/С/21/Rev.1/Add.10, 2000 оны 3-р сарын 29, 31-р заалт.

45 Венын уулзалтын дүгнэлт баримт бичиг - Хельсинкийн бага хурлын 3 дахь удаагийн Давтан уулзалт, Вена, 1989, “Европ дахь аюулгүй байдалтай холбоотой асуудлууд: Зарчмууд”, 13.8 дугаар заалт.

46 46 Вена 1989,12 дугаар заалт.

учруулах хэрэгсэл болгон ашигладаг. Оролцогч улсууд хүний эрхийг хамгаалагч нар болон тэдний гэр бүлийн гишүүд бусадтай адил төрийн үйлчилгээнд тэгш хамрагдах боломжийг хангах ёстой бөгөөд хүний эрхийн ажил, хамаатан садныхаа явуулсан хүний эрхийн үйл ажиллагаанаас шалтгаалан аливаа ялгаварлан гадуурхалтад өртөхөөс хамгаалах ёстой.

39. Үндэстэн, эсвэл угсаатан, шашин шүтлэг, хэлний цөөнх буюу бусад бүлэгт харьяалагддаг зарим бүлэг хүмүүсийн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх, жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхэд ялгаварлан гадуурхсан хязгаарлалт тавих замаар хүний эрхийг хамгаалах эрхийг бусадтай адил тэгш байдлаар чөлөөтэй эдлэхэд нь саад болох зэргээр хувь хүнийг өөрийн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхэд нь дээр дурдсан үндэслэлээр ялгаварлан гадуурхах ёсгүй.
40. Ялгаварлан гадуурхахыг хориглох заалтуудын дагуу улс орнууд иргэний харьяалалгүй байдал, эсвэл иргэншлээс нь үл хамааран өөрийн нутаг дэвсгэр дээрх аливаа хүн болон харьяат иргэн бүрийг хүний эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх нөхцөлөөр баталгаатай хангана.⁴⁷ Үүнд: орогнол хүсэгчид, дүрвэгсэд, цагаач ажилчид болон бусад хүмүүсийг ойлгоно.⁴⁸ НҮБ-ын Үндэсний болон угсаатны, шашин, хэлний цөөнхөд харьяалагдах этгээдийн эрхийн тунхаглалд “цөөнхөд харьяалагддаг хүн/хүмүүс эрхээ бие даан, түүнчлэн бүлгийн бусад гишүүдтэйгээ хамт ялгаварлан гадуурхалтгүйгээр хэрэгжүүлэх боломжтой”⁴⁹ гэж заасан байдаг. Үүний нэгэн адил НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн конвенцод “бүх хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүний эрх, үндсэн эрх чөлөөг тэгш хүртэх явдлыг дэмжих, хамгаалах, хангах”⁵⁰ шаардлагатай байгааг онцолжээ. НҮБ-ын эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (ЭЯГБХУК)-ын 3 дугаар зүйлд заасны дагуу “гэрээний улсууд эрэгтэй хүмүүстэй ижил түвшинд хүний эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх, хүртэх боломжоор хангах зорилгоор эмэгтэйчүүдийн бүх талын хөгжил, дэвшлийг хангахын тулд шаардлагатай бүх арга хэмжээг [...] авна [...]”⁵¹
41. ИУТЭОУП-ын тухайд, Хүний эрхийн хороо нь Пактын 2 ба 26 дугаар зүйл дэх үл ялгаварлан гадуурхах тухай заалтуудад ялгаварлан гадуурхахыг хориглодог үндэслэл болох “секс”-ийн нэг хэсэг болгож, бэлгийн чиг

47 Вена 1989 он.

48 НҮБ-ын Хүний Эрхийн Хороо, ерөнхий тайлбар №31, 10 дугаар зүйлийг үз.

49 Зүйл №3.

50 Зүйл №1.

51 ЭЯГБХУК, зүйл №3.

баримжаагаар ялгаварлан гадуурхахыг хамруулж тайлбарласан болно.⁵² Европын зөвлөлийн сайд нарын хорооны гишүүн орнуудад бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаагаар ялгаварлан гадуурхахтай тэмцэх арга хэмжээний талаарх CM/Rec(2010)5 тоот зөвлөмжид энэ зорилгоор тодорхой алхмуудыг тусгасан.⁵³

42. Иймд оролцогч улсууд хүн бүрийг тэгш эрхтэйгээр хүний эрхийг хамгаалах эрхийг эдлэхэд чиглэсэн арга хэмжээ авах ёстой. Ингэхдээ эрс өөр нөхцөл байдалд байгаа хүмүүст өөр байдлаар хандах шаардлагатай ба зарим тохиолдолд чингэх нь үүрэг ч болдог.⁵⁴ НҮБ-ын Хүний эрхийн хорооны мэдэгдсэнээр тэгш байдлын зарчим нь ялгаварлан гадуурхалтыг бий болгоход хүргэдэг нөхцөл байдлыг багасгах, арилгахын тулд төрөөс энэ талаар тусгайлсан арга хэмжээ авахыг шаарддаг.⁵⁵ АӨЯГБХУОУХ нь ийм хамгаалалт шаардсан тодорхой арьс өнгө, үндэстэн, ястан, эсвэл хувь хүмүүсийн зохистой хөгжил дэвшлийг хангах зорилгоор тусгай арга

52 НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны тайлбар Б.6, Түүнений Австралийн эсрэг нэхэмжлэл. Нэхэмжлэл №488/1992, Н.Ү-ий Б.6 ССРР/С/50/D/488/1992, заалт. №8.7. Амстердамын гэрээний 13-р зүйлд Европын Холбоог “бэлгийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхахын эсрэг шаардлагатай арга хэмжээ авах” -ыг заасан байдаг бөгөөд ЕХ-ны суурь эрхийн дүрмийн 21-р зүйлийн 2-т бэлгийн чиг хандлагын гэх мэт “аливаа үндэслэлээр ялгаварлан гадуурхахыг” хориглосон. Үүнтэй адилаар Салгуэйро да Силва Мотагийн Португалийн эсрэг мэдүүлсэн нэхэмжлэлийн дагуу хуралдсан (1999 оны 12-р сарын 21-ний өдрийн №33290/96 нэхэмжлэл), Европын Хүний Эрхийн Шүүх ЕХЭК-ын 14-р зүйлд тусгасан үндэслэлүүдийн жагсаалтыг “гэх зэрэг аливаа үндэслэл” гэдэг үгс орсон учраас бүрэн дүүрэн биш, үлгэрчилсэн жагсаалт гэдгийг тэмдэглэн хэлсний сацуу, ЕХЭК-ын 14-р зүйлд заасан ялгаварлан гадуурхалтаас хамгаалах нь бэлгийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхахыг мөн багтаасан ойлголт болохыг баталгаажуулсан болно. Түүнчлэн, ялгаварлан гадуурхахыг ерөнхийд нь хориглосон 14-р зүйлийг нэмэлтээр тусгасан ЕХЭК-ын 12-р протоколын тусгай тайланд заасны дагуу энэхүү протокол нь мөн бэлгийн чиг баримжаанд суурилсан ялгаварлан гадуурхалтаас хамгаална. <http://www.conventions.coe.int/Treaty/en/Reports/Html/177.htm>, 20 дугаар заалт. Үүнээс гадна, Йогякарта зарчмууд нь хүн бүр бэлгийн чиг баримжаа, эсвэл хүйсийн онцлогоороо ялгаварлан гадуурхуулалгүйгээр хүний бүх эрхийг эдлэх эрхтэй.” гэдгийг цохон дурдсан. Уг Зарчмууд нь ЕАБХАБ-ын эрх зүйн чадамжтай, хэлцлийн баримт бичиг биш боловч, тэдгээрийг Хүний Эрхийн Зөвлөлийн НҮБ-ын Тусгай илтгэгчид зэрэг 8 хүний бүрэлдэхүүнтэй олон улсын хүний эрхийн мэргэжилтнүүдийн бүлэг боловсруулсан бөгөөд чухал хэрэгтэй удирдамж болно. Йогякарта зарчмуудыг, “Бэлгийн чиг баримжаа, хүйсийн онцлогтой холбоотой хүний эрхийн олон улсын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зарчим”, 2-р зарчмаас үз.

53 Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны 2010 оны 3-р сарын 31-ний өдөр баталсан CM/Rec(2010)5 зөвлөмж, http://www.coe.int/t/dghl/standardsetting/hrpolicy/Publications/LGBT_en.pdf-г үз.

54 “Тухайн улс адил төстэй нөхцөлд байгаа хүнд ялгаатай хандахдаа ямар нэг бодит, үндэслэлтэй шалтгаан хэлээгүй нь Конвенцоор баталгаажуулсан эрхийг эдлэхдээ ялгаварлан гадуурхалтаас ангид байна гэж заасан 14 дүгээр зүйлийг зөрчсөн гэж Шүүх үзсэн [...]. Гэвч Шүүх 14 дүгээр зүйлд заасан ялгаварлан гадуурхахыг хориглосныг зөрчсөн ганц тохиолдол энэ биш гэж, мөн дүгнэжээ. Тухайн улс эрс тэс нөхцөлд байгаа хүнд ялгаатай хандаж чадаагүйдээ ямар нэг бодит, үндэслэлтэй шалтгаан гаргаж тавиагүй нь Конвенцоор баталгаажуулсан эрхийг эдлэхдээ ялгаварлан гадуурхалтаас ангид байна гэж заасан 14 дүгээр зүйлийг зөрчсөн гэж Шүүх мөн үзсэн.” гэж Флименосын Грекийн эсрэг гаргасан (2000) нэхэмжлэлд ЕХЭШ-ийн гаргасан шийдвэрийн 44-р зүйлийг үз.

55 НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны ерөнхий тайлбар №18, 1989 оны 18-р, 10 дугаар заалт.

хэмжээ авахыг нээлттэй зөвшөөрдөг.⁵⁶ Шаардлагатай бол эдийн засаг, нийгэм, улс төр, соёлын амьдралын бүхий л салбар дахь үндэстний цөөнх харьяалагддаг этгээдийн тэгш байдлыг үр дүнтэй хангах зорилгоор зохих арга хэмжээ авахыг уг гэрээний оролцогч улсуудаас ҮЦХСК шаарддаг байдлыг хэмжээг ялгаварлан гадуурхах үзэгдэл гэж үзэхгүй.⁵⁷

43. Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах арга хэмжээг ялгаварлан гадуурхалтын эсрэг үр дүнтэй хууль эрх зүйн болон бусад хамгаалалтаар хангадаг, олон буюу хэд хэдээр давхацсан ялгаварлан гадуурхалтад өртдөг хүмүүс болоод бусад ялгаварлан гадуурхалтад өртөгсдийг хамгаалдаг цогц хууль тогтоомж, бодлогоор дэмжих хэрэгтэй.⁵⁸ Хүний эрхийг хамгаалагчдын хамгааллыг бэхжүүлэх, аюулгүй, таатай орчин бий болгох арга хэмжээнүүд нь ялгаварлан гадуурхалттай тулгарч буй хүний эрхийг хамгаалагчдын онцлог хэрэгцээг тусгасан байх ёстой.
44. Хүний эрхийг хамгаалагчдын хамгааллыг бэхжүүлэх үйл ажиллагаа бүрийг хүйсээс шалтгаалсан болон хэвшмэл ойлголтууд, гадуурхлыг үүсгэж буй хүчин зүйлсийг улам гааруулах санамсаргүй үр дагаварт хүргэж болзошгүй эсэхийг шалгах хэрэгтэй. Үүний дагуу НҮБЕА “бүх насны эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдад тулгарч буй тогтолцоо, бүтцийн ялгаварлал, хүчирхийлэл”-д онцгой анхаарч үзэж буйгаа илэрхийлж, улс орнуудыг “тэдний хамгааллыг хангахад шаардлагатай бүх арга хэмжээг авч, хүний эрхийг хамгаалах аюулгүй, таатай орчныг бүрдүүлэх үйл ажиллагаандаа хүйсийн байдлыг бодолцож байхыг уриалав.”⁵⁹

Хууль эрх зүй, захиргааны болон институтийн таатай тогтолцоо

45. Оролцогч улсууд хүний эрхийг хамгаалагчдад хүний эрхийг хамгаалах эрхээ чөлөөтэй хэрэгжүүлэх боломжийг олгодог аюулгүй, таатай орчныг бүрдүүлэх, бэхжүүлэх хууль тогтоомж, захиргааны болон бусад зохих арга хэмжээг бий болгож хэрэгжүүлэх эерэг үүрэг хүлээнэ. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалын 3 дугаар зүйлд заасны дагуу дотоодын хууль тогтоомж нь хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг, түүний дотор хүний эрхийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлдэг. Иймээс энэ нь оролцогч улсуудын

56 1-р зүйл (4) БТАӨЯГУОУХ.

57 4-р зүйл ҮЦХСК.

58 CM/Rec (2010)5 тоот зөвлөмжийн тайлбар санамж бичигт энэхүү нэр томъёог тайлбарлахдаа: “Аливаа хүн доод тал нь хуулиар хамгаалсан хоёр өөр ялгаварлан гадуурхалтад өртөж, эсвэл энэ төрлийн хоёр ялгаварлан гадуурхалт онцгой байдлаар холилдон нөхцөлөөс хохирсон гэж мэдэгдсэнийг олон тооны ялгаварлан гадуурхалтад өртсөн гэж ойлгож болно. Сүүлийн нөхцөл байдлыг ихэвчлэн давхацсан ялгаварлан гадуурхалт гэж нэрлэдэг. Үүний нэг жишээ бол лесби эмэгтэйг гетеросексуал эмэгтэйтэйгээс дорд, мөн ижил хүйстэн эрэгтэйтэйгээс ч дор гэж үзэх тохиолдол юм.” гэжээ.

59 НҮБЕА-н Тогтоол 68/181, 2013 оны 12-р сар, 5-р заалт.

хүний эрхийн чиглэлээр олон улсын өмнө хүлээсэн үүрэгтэй нийцэж байх ёстой.⁶⁰ Цаашилбал уг орчныг өргөн цар хүрээтэй, олон талын оролцоог хамарсан зөвлөлдөх үйл явцын дүнд сайтар боловсруулж бүрдүүлэх хэрэгтэй.

46. Нэн ялангуяа НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн онцолсноор улс орнууд “хүний эрхийг хамгаалагчдад нөлөөлж буй бүх хууль эрх зүйн заалтууд, тэдгээрийн хэрэглээг тодорхой тайлбарлаж, хэмжигдэхүйц, гуйвуулж хэрэглэхээс сэргийлэхийн тулд буцааж хэрэглэхээргүй байх”⁶¹-д анхаарах ёстой. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн тусгай илтгэгч олон улс орон хүний эрхийн олон улсын хууль тогтоомж, стандартыг зөрчин хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагааг хязгаарлаж, эрүүгийн хэрэг үүсгэхэд хууль тогтоомжийг ашигладагт харамсаж буйгаа Хүний эрхийн зөвлөлийн саяхны илтгэлдээ илэрхийлжээ (Дэлгэрэнгүй мэдээллийг хуулийн дарамт, гэмт хэрэгт тооцох, дур зоргоор баривчлах, албадан саатуулахаас хамгаалах тухай доорх хэсгээс харна уу).⁶²
47. Иймд оролцогч улсууд иргэний нийгмийн байгууллагуудтай зөвлөлдөн, олон улсын холбогдох байгууллагуудын техникийн зөвлөгөөний дагуу хүний эрхийг хамгаалахтай холбоотой бүх хууль тогтоомжийг хянан үзэж, олон улсын стандартад нийцээгүй аливаа хуулийг өөрчлөх, хүчингүйд тооцох шаардлагатай байна. Ингэхдээ тэд хууль эрх зүйн орчинг сайжруулах замаар ардчиллын төлөө Европын зөвлөл (Европын зөвлөлийн Венецийн хороо), ЕАБХАБ/АИХЭГ, ЕАБХАБ-ын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудал эрхэлсэн төлөөлөгч зэрэг олон улсын байгууллагуудын санал бодлыг чиглэл болгохын хамт хэрэгжүүлэх хэрэгтэй юм. Тэд мөн холбогдох бодлого, практик, засаг захиргааны болон институтийн тогтолцооны үйл ажиллагаагаа хянан үзэж, хүний эрхийг хамгаалах эрхийг хэрэгжүүлэхэд

60 НҮБ-ын тунхаглалын 3-р зүйлд “Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хангах чиглэлээр НҮБ-ын дүрэм, төрийн бусад олон улсын үүрэгт нийцсэн дотоодын хууль тогтоомж нь хүний эрх, үндсэн эрх чөлөөг хэрэгжүүлэх, эдлэх ба эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах, үр дүнтэй хэрэгжүүлэх тухай одоогийн Тунхаглалд дурдсан бүхий л үйл ажиллагааг явуулах ёстой хууль эрх зүйн орчин юм.” гэсэн хэсгийг үз. Мөн “Хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагаанд нөлөөлж буй хууль тогтоомж, түүний хэрэглээ нь Иргэний ба Улс төрийн эрхийн олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын хэлцэл зэрэг олон улсын хүний эрхийн хууль тогтоомжид нийцсэн, Бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах “Хувь хүн, Бүлгэм, Нийгмийн байгууллагын эрх, үүргийн тунхаглалыг мөрдлөг болгосон, олон улсын хүний эрхийн хууль тогтоомжийг зөрчсөн зөрчлийн эсрэг явуулсан үйл ажиллагааных нь төлөө хүний эрхийг хамгаалагчдын ажил, үйл ажиллагаанд ямар нэгэн хязгаарлалт тавьж буйг буруушаасан байх ёстой” гэж цохон тэмдэглэсэн “НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн А/HRC/RES/22/6 тогтоолын 3 дугаар зүйлийг үз.

61 А/HRC/RES/22/6, заалт №11.

62 Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайланг үз, А/HRC/25/55, 2013 оны 12 дугаар сарын 23-ны өдөр, зүйл №64.

учирч буй аливаа саад бэрхшээлийг арилгах талаар зохих арга хэмжээ авах хэрэгтэй.

48. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл нь, ялангуяа, ҮХЭИ- үүдийн одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг тогтмол хянаж, тэдгээрийн хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийн талаар мэдээлэхийн сацуу холбогдох, тодорхой зөвлөмж гарган ажиллаж буй Парисын зарчмуудын дагуу байгуулагдсан, үйл ажиллагаагаа явуулж байгаа ҮХЭИ-үүдийн үнэ цэнийг өндрөөр үнэлсэн.⁶³
49. Оролцогч улсууд хууль сахиулах байгууллагын ажилтнууд, шүүх засаглал болон бусад албан тушаалтнууд зэрэг төрийн албан хаагчдаа хүний эрхийг хамгаалах эрх гэх мэтчилэн хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх зэрэг оролцогч улсуудын хүлээсэн үүргийн талаарх сургалтад хамруулах хэрэгтэй.⁶⁴
50. НҮБ-ын Хүний эрхийн хорооноос оролцогч орнууд зөвхөн төрийн албан хаагчдын дунд төдийгүй олон нийтийн дунд уг Пактын талаарх мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр боловсролын болон бусад арга хэмжээг авах ёстой гэдгийг дурджээ.⁶⁵ Оролцогч улсууд хүний эрхийг хамгаалагчдын эрх

63 16 дугаар зүйлийг үз. Мөн “Европын Зөвлөлийн хүний эрхийг хамгаалагчдын эрх ашгийг хамгаалах, тэдний үйл ажиллагааг сурталчлах арга хэмжээний тухай, Хүний эрхийг хамгаалагчдын гаргасан эрх нь зөрчигдсөн талаарх нэхэмжлэлийг хүлээж авах, шийдвэрлэх, зөвлөмж өгөх эрх мэдлийг ҮХЭИ-үүдэд өгөх, эсвэл энэ чадавхыг нь бэхжүүлэхийг зөвлөсөн” Сайд нарын Хорооны Тунхаглалын 2-р зүйлийг үз. Үндэсний байгууллагуудын статустай холбоотой зарчмууд буюу “Парисын зарчим” 1993 оны 12-р сарын 20-ны өдрийн НҮБ-ын 48/134 тоот тогтоолоор батлагдсан. Парисын зарчмуудад хүний эрхийн үндэсний байгууллагуудын үүрэг, бүтэц, статус, чиг үүргийн талаарх стандартуудыг тодорхойлсны зэрэгцээ, тэдний бие даасан байдлыг баталгаажуулсан болно. Хүний эрхийн үндэсний институтүүдийн Олон улсын зохицуулах хороо (ОУЗХ) нь 1993 онд Парисын зарчимд нийцүүлэн хүний эрхийн үндэсний байгууллагуудыг сурталчлах, бэхжүүлэх, хүний эрхийн үндэсний байгууллагуудад хяналт тавих, магадлан итгэмжлэх зорилгоор байгуулагдсан. Зарчмуудыг дараах хаягаар авах боломжтой. Үүнд: <<http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/StatusOfNationalInstitutions.aspx>>.

64 НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн Тогтоол A/HRC/RES/22/6, заалт №12-ыг үз.

65 НҮБ-ын Хүний Эрхийн Хороо, ерөнхий тайлбар №31, “Гэрээний улсуудад тавигдах эрх зүйн ерөнхий хариуцлагын мөн чанар”, НҮБ-ын Б.б. ССРР/С/21/Rev.1/Add.13, 2004 оны 5-р сарын 26, заалт №7. Хүний эрхийн боловсрол, сургалт, бусад арга хэмжээ гэх мэт хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх, орчныг бүрдүүлэх арга хэмжээний ач холбогдлын тухайд, хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд урьдчилан сэргийлэх ажиллагааны гүйцэтгэх үүргийн тухай НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн 2013 оны 9-р сарын 27-ны өдөр батлагдсан A/HRC/RES/24/16 тоот тогтоолын 3 дугаар зүйлийг мөн үз.

ашгийг хамгаалах тал дээр энэхүү удирдамж болон бусад олон улсын стандартуудыг дагаж мөрдөх хэрэгтэй.⁶⁶

Хүний эрхийн ажилтай холбоотойгоор хүний үндсэн эрхэд тавигдах хязгаарлалтуудын хууль ёсны ба зайлшгүй, пропорциональ байдал

51. Хүний эрхийн олон улсын стандартууд нь маш нарийн тодорхойлсон нөхцөлөөр тодорхой эрхүүдэд хязгаарлалт, хориглолт тогтоохыг зөвшөөрдөг. Эдгээрт итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх, жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх (ИУТЭОУП-ын 19, 21, 22 дугаар зүйлүүд, ХЭҮЭЧК-ын 10, 11 дүгээр зүйлүүд, ХЭАК-ын 13, 15, 16 дугаар зүйлүүд); чөлөөтэй зорчих эрх чөлөө (ИУТЭОУП-ын 12 дугаар зүйл, ХЭҮЭЧК-ын 4 дүгээр Протоколын 2 дугаар зүйл, ХЭАК-ын 22 дугаар зүйл); хувийн болон гэр бүлийн амьдралыг хүндэтгэх (ХЭҮЭЧК-ын 8 дугаар зүйл) эрхүүд тус тус орно.⁶⁷ Үнэмлэхүй гэж үздэг эрхүүд болон үндсэн зарчмуудыг ямар ч байдлаар хязгаарлах ёсгүй.
52. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалын 17 дугаар зүйлд “энэхүү Тунхаглалд заасан эрх, эрх чөлөөг эдлэхдээ бие даан болон бусадтай хамтран ажиллаж буй хүн бүр зөвхөн олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалтад нийцсэн, хуулиар тогтоосон хязгаарлалтуудыг бусад хүмүүсийн эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрөх, ардчилсан нийгэмд ёс суртахуун, нийгмийн хэв журам, нийтлэг сайн сайхан байдлын шударга шаардлагыг хангах зорилгоор хүлээн зөвшөөрнө.” гэж заасан.

66 Улс орнууд “өөрийн харьяалалд байгаа бүх иргэний дунд иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгмийн болон соёлын эрхийнх нь тухай ойлголтыг дэлгэрүүлэхэд шаардлагатай хууль тогтоомж, шүүх, захиргааны болон бусад холбогдох арга хэмжээ”-г авч явуулах үүрэгтэйг цохон тэмдэглэсэн НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалын 14-р зүйлийг үз. 15-р зүйлд заасны дагуу, “улс орнууд боловсролын бүх түвшинд хүний эрх, үндсэн эрх чөлөөг заах, сурталчлах, зохион байгуулах, мөн хуульч, хууль сахиулах байгууллагын ажилтнууд, зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, төрийн албан хаагчдын сургалт хариуцсан газрууд сургалтын хөтөлбөртөө хүний эрхийн сургалтын зохих элементүүдийг багтаах зэргээр сургаж буй эсхийг нягтлах үүрэгтэй.

67 Хувийн болон гэр бүлийн амьдралыг хүндэтгэх эрхийн тухайд, хувийн нууц, гэр бүл, орон байр, захидал харилцаанд дур зоргоор болон хууль бусаар хөндлөнгөөс оролцох, түүнчлэн хүний нэр хүнд, алдар хүндэд хууль бусаар халдахаас хамгаалдаг тул ИУТЭОУП-ын холбогдох заалт (ИУТЭОУП-ын 17-р зүйл) нь тусдаа хязгаарлалтын заалтыг агуулаагүй. Хүний Эрхийн Хорооны 17-р зүйлд өгсөн Ерөнхий тайлбар дахь “хууль бус” гэсэн нэр томъёо нь өөрөө Пактын заалт, зорилго, зорилтод нийцсэн хуульд зааснаас бусад тохиолдолд ямар нэгэн хөндлөнгийн оролцоо байж болохгүй гэсэн үг юм. “Дур зоргын хөндлөнгийн оролцоо” гэсэн нэр томъёоны хувьд дур зоргоор гэдэг ойлголт нь хуульд заасан хөндлөнгийн оролцоо нь Пактын заалт, зорилго, зорилттой нийцэж байх ёстой бөгөөд, ямар ч тохиолдолд, тухайн нөхцөлүүдэд (1988 оны 3-р сарын 23-ны өдөр батлагдсан НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны ерөнхий тайлбар №16-ийн 4, 5-р зүйлийг үзнэ үү) тохирсон үндэслэлтэй байх ёстой гэсэн баталгаа юм. Өөрөөр хэлбэл, Хүний Эрхийн Хорооноос хувийн амьдралд хөндлөнгөөс оролцохыг зөвшөөрөхөд тавьдаг шаардлага нь ИУТЭОУП-ын 19, 21, 22-р зүйлд зөвшөөрөгдсөн хязгаарлалтуудтай төстэй юм. Доорх хувийн амьдралыг хүндэтгэх эрх гэсэн хэсгийг үз. ХЭАК-ын 11-р зүйлийг ИУТЭОУП-ын 17-р зүйлтэй ижил төстэйгөөр үгчилж бичсэн бөгөөд иймээс тусдаа хязгаарлалтын заалтыг агуулаагүй болно.

53. Энэ мэт хязгааруудыг тогтоодог эрхийн аливаа хязгаарлалтууд нь дараах бүх шаардлагуудыг чандлан ханган биелүүлэх ёстой. Үүнд:
- а. Тэдгээрийг хуулиар заасан байх ёстой;
 - б. Холбогдох олон улсын стандартуудад заасан хязгаарлалтын тодорхой зөвшөөрөгдсөн үндэслэлд нийцүүлсэн хууль ёсны зорилгод чиглүүлсэн байх ёстой;
 - в. Тэдгээр нь ардчилсан нийгэмд зайлшгүй байх ёстой бөгөөд чиглэсэн зорилгодоо зохих хэм хэмжээтэй байх ёстой.⁶⁸
54. Хүний эрхийг эдлэхэд энэ мэт хязгааруудыг тогтоох аливаа хязгаарлалтын хувьд дээр тавьсан нөхцөлүүд нь нэгдмэл⁶⁹ буюу хууль ёсны байдал, зөвшөөрөгдөх үндэслэлүүд, зайлшгүй, пропорциональ байдлын хувьд бүх шаардлагыг бүгдийг нэгэн зэрэг хангах ёстой гэсэн үг юм. Оролцогч орнууд хязгаарлалтууд нь эрхийн мөн чанарыг дордуулах ёсгүй гэсэн зарчмыг ямагт баримтлах ёстой.⁷⁰ НҮБ-ын Хүний эрхийн комисс эрх ба хязгаарлалт болон дүрэм ба онцгой нөхцөлийн харилцаа эсрэгээрээ байж болохгүй гэдгийг анхааруулсан.⁷¹ Эрх чөлөө бол дүрэм, хязгаар бол онцгой нөхцөл юм.⁷²
55. Тэдгээрийг хуульд заасан байх ёстой гэсэн шаардлага нь хязгаарлалтуудыг албан ёсны хууль эрх зүйн үндэслэлтэй, хувь хүн өөрийн зан үйлийг зохицуулах боломжийг олгох үүднээс хууль нь тодорхой, хоёрдмол утгагүй, нарийн тодорхой томъёологдсон байх ёстой гэсэн үг юм. Цаашилбал хууль нь олон нийтэд хүртээмжтэй байх ёстой бөгөөд түүнийг хэрэгжүүлж буй

68 Жишээлбэл, ИУТЭОУП-ын 19 (3)-т заасны дагуу үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахад тавигдах шаардлагуудын талаар НҮБ-ын Хүний Эрхийн Хороо, ерөнхий тайлбар №34, 19-р зүйл, "итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө", 2011 оны 9-р сарын 12, НҮБ-ын Б.Б. ССРР/С/С/34, заалт №22-ыг үз. Хүний эрхийн олон улсын холбогдох стандартын дагуу, НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн 22/6 тоот тогтоолоор улс орнуудад "хүний эрхийг эдлэхэд хөндлөнгөөс нөлөөлж болзошгүй аливаа заалт, шийдвэр нь хууль ёсны, пропорциональ, ялгаварлан гадуурхалгүй, ардчилсан нийгэмд зайлшгүй байх зарчмыг хангах үүднээс олон улсын эрх зүйд тусгагдсан үндсэн зарчмуудыг тусгаж буйг" баталгаажуулахыг уриалсан (заалт №11 (d)).

69 "НҮБ-ын тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний асуудал эрхэлсэн тусгай илтгэгчийн тайлан", НҮБ-ын Б.Б. А/НRC/23/39, 2013 оны 4 дүгээр сарын 23, заалт №19-ыг үз.

70 НҮ-ий Хүний Эрхийн Хорооны ерөнхий тайлбар №27, Зүйл №12, "Зорчих эрх чөлөө", НҮБ-ын Б.Б. ССРР/С/21/Rev.1/Add.9, 1999 оны 11 дүгээр сарын 2, заалт №13.

71 Эх. сурв.

72 Мөн тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудал эрхэлсэн тусгай илтгэгчийн тайланг үз, НҮБ-ын Б.Б. А/НRC/20/27, заалт №16.

хүмүүст дураар хэрэглэх эрх олгох ёсгүй.⁷³ Уг хууль нь хүний эрхийн олон улсын стандартуудад нийцсэн байх ёстой.

56. ИУТЭОУП-д олон нийтийн аюулгүй байдал, нийгмийн аюулгүй ажиллагаа, нийтийн хэв журам, нийгмийн эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах болон бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор ашиглах эрхийн хязгааруудын зөвшөөрөгдөх үндэслэлүүдийг дурдсан байдаг. Үзэл бодлоо илэрхийлэх эрхийн тухайд НҮБ-ын Хүний эрхийн хорооноос тэдгээр нь Пактаар хамгаалсан бусад эрхэд хязгаарлалт болох үндэслэлтэй байсан ч, 3 дугаар зүйлд заагаагүй үндэслэлүүдээр хязгаарлалт тавихыг зөвшөөрөхгүй гэдгийг онцолсон. Хязгаарлалтуудыг зөвхөн заасан зориулалтаар ашиглах ёстой бөгөөд урьдчилан тодорхойлсон тодорхой хэрэгцээтэй шууд хамааралтай байх ёстой.⁷⁴ “Тодорхой эрхүүдийн хувьд, зөвшөөрөгдсөн хязгаарлалтуудад зориулсан ижил төстэй үндэслэлүүдийг ХЭҮЭЧК-т тусгасан болно. Эдгээр эрхэд хамаарах бүх заалтад хязгаарлалт хийх зөвшөөрөгдсөн үндэслэлийн жагсаалт бүрэн багтсан. Дотоодын хууль тогтоомж дахь нэмэлт үндэслэлүүдийг олон улсын стандартуудад заасан хууль ёсны үндэслэлүүдэд нэмэлтээр тооцох ёсгүй. ХЭҮЭЧК-ын 18 дугаар зүйлд (эрхийн хязгаарлалтыг ашиглахыг хязгаарлах нь) “дурдагдсан эрх, эрх чөлөөнд энэ конвенцоор тавьсан хязгаарлалтуудыг заасан зориулалтаас өөр зорилгоор ашиглах ёсгүй” гэж заасан байдаг. ХЭАК-ын 30 дугаар зүйлд хязгаарлалтын хүрээг хязгаарладаг харьцуулахуйц заалт бий.
57. “Зайлшгүй байх” зарчим нь хөндлөнгөөс “нийгмийн тулгамдсан шаардлага” байгаа бөгөөд хязгаарлалт нь ардчилсан нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх хэмжээний байна гэсэн үг юм.⁷⁵ Европын хүний эрхийн шүүх (ЕХЭШ) “олон ургалч үзэл, хүлцэх, нээлттэй сэтгэлгээтэй байх” зэрэг зарчимгүйгээр ардчилсан нийгэм оршин тогтнох боломжгүй гэж үздэг.⁷⁶ Жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудал эрхэлсэн Тусгай илтгэгчийн хэлсэнчлэн алив хязгаарлалт нь олон ургалч байдал, хүлцэл, нээлттэй байдалд хор учруулах ёсгүй.⁷⁷

73 НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны ерөнхий тайлбар №34, Зүйл №19, “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх”, НҮБ-ын Б.Б. ССР/С/С/С/34, 2011 оны 9 дүгээр сарын 12, заалт №25.

74 НҮБ-ын Хүний Эрхийн Хороо, ерөнхий тайлбар №34, заалт №22.

75 Европын Хүний Эрхийн Шүүхийн тайлбарласнаар, “шаардлагатай” гэдэг тэмдэг нэр нь Зүйл 10 ба 2 дугаарт орсон утгаараа ‘нийгмийн шаардлагаар’ гэсэн утгатай юм.” Жишээ нь: Стил ба Моррисын Нэгдсэн Вант улсын эсрэг нэхэмжилсэн 2005 оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн 68416/01 дугаартай нэхэмжлэлийг үз.

76 Эх. сурв.

77 НҮБ-ын Б.Б. А/НРС/С/20/27, заалт №17 ба 81-ийг үз.

58. Пропорциональ харьцааг хангахын тулд хязгаарлалтыг хэтрүүлж болохгүй бөгөөд хууль ёсны зорилгодоо хүрэх хамгийн хөнгөн хохиролтой аргыг ямагт илүүд үзэх ёстой. НҮБ-ын Хүний эрхийн хорооноос “хязгаарлах арга хэмжээ нь пропорциональ байх зарчимд нийцсэн, хамгаалах зорилгодоо тохирсон, хүссэн үр дүндээ хүрч болох хамгийн хөнгөн хохиролтой арга хэрэгсэл байх, хамгаалах гэж буй ашиг сонирхолтойгоо пропорциональ байх ёстой” гэдгийг цохон тэмдэглэсэн.⁷⁸ Түүнчлэн тус хорооноос “пропорциональ байх зарчмыг зөвхөн хязгаарлалтыг тодорхойлсон хуульд тусгаад зогсохгүй, уг хуулийг хэрэгжүүлэх захиргааны болон шүүхийн эрх бүхий байгууллагууд дагаж мөрдөх ёстой.”⁷⁹ гэжээ.
59. Түүнчлэн хязгаарлалт тавьдаг хууль нь ялгаварлан гадуурхахыг хориглох зэрэг хүний эрхийн бусад үндсэн хэм хэмжээтэй нийцэж байх ёстой.⁸⁰ Тухайлбал, нийтийн ёс суртахууны үндэслэлээр хязгаарлах талаар НҮБ-ын Хүний эрхийн хорооноос “Ёс суртахуун гэдэг ойлголт нь нийгэм, гүн ухаан, шашны олон янзын уламжлалаас гаралтай. Иймээс, ёс суртахууныг хамгаалах зорилготой хязгаарлалт нь зөвхөн нэг уламжлалаас урган гараагүй зарчмууд дээр суурилах ёстой.”⁸¹ гэж заасан. Мөн “уг хороо нь ийм хязгаарлалтыг хүний эрхийн нийтлэг байдал, үл ялгаварлан гадуурхах зарчмын үүднээс ойлгох ёстой.”⁸² гэдгийг нэмж тодруулж хэлсэн.
60. Үүнтэй адил, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл нь “олон нийтийн ёс суртахууныг сахиулахад чиглэсэн хууль тогтоомж нь хүний эрхийн олон улсын хууль тогтоомжид нийцсэн”, мөн “олон нийтийн аюулгүй ажиллагаа, нийгмийн хэв журмыг хангахад чиглэсэн хууль тогтоомж нь үл ялгаварлан гадуурхах зарчим гэх мэт олон улсын хүний эрхийн хуультай нийцсэн заалтуудыг тодорхой тусгасан, эдгээр хууль тогтоомжийг бусад эрхүүдийг дэмжих, хамгаалахад амин чухал үүрэгтэй үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө зэрэг аливаа хүний эрхийг эдлэхэд саад учруулах эсвэл хязгаарлахад ашиглахгүй” байхад анхаарч ажиллахыг уриалсан.⁸³

78 НҮ-ий Хүний Эрхийн Хорооны ерөнхий тайлбар №27, Зүйл №12, заалт №14.

79 Эх. сурв. заалт №15.

80 “19-р хэсгийн 2 дугаар зүйлд дурдсан эрхүүдийг хязгаарласан хуулиуд нь[...] зөвхөн 19-р хэсгийн 3 дугаар зүйлд заасан хатуу шаардлагуудыг дагаж мөрдөөд зогсохгүй, Конвенцын заалт, зорилго, зорилттой нийцэх ёстой. Ялгаварлан үл гадуурхах тухай хэлцлийн заалтуудыг уг хууль тогтоомжууд зөрчих ёсгүй. Жишээ нь: бие махбодын шийтгэл зэрэг уг Хэлцэлд харш шийтгэлийг хуульд тусгах ёсгүй.” гэсэн Хүний Эрхийн Хорооны ерөнхий тайлбар №34-ийн 26-р зүйлийг үз.

81 Эх. сурв. ба Ерөнхий тайлбар №22, ИУТЭОУП-ын Зүйл №18, НҮБ-ын Б.6. ССР/C/21/Rev.1/Add.4, 1993 оны 9 дүгээр сарын 27, заалт №8.

82 Хүний Эрхийн Хорооны ерөнхий тайлбар №34, Зүйл №9, заалт №32.

83 Хүний Эрхийн Зөвлөлийн Тогтоол A/HRC/RES/22/6, заалт №4 ба 11(g)-ийг үз.

61. Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн талаарх өөрийн эрх зүйн практикийн хүрээнд, НҮБ-ын Хүний эрхийн хороо ардчилсан нийгэмд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зарчмын уг Пактаар тодорхойлсон үнэ цэнэ нь олон нийтийн болон улс төрийн зүтгэлтнүүдийн талаарх олон нийтийн хэлэлцүүлгийн хүрээнд онцгой өндөр ач холбогдолтой болохыг ажиглажээ.⁸⁴ Учир нь “мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө аливаа чөлөөт, ардчилсан нийгмийн тулгын чулуу болдог учраас тэр юм. Энэ нь иргэд нь эрх барьж буй улс төрийн тогтолцоо/намуудаас өөр улс төрийн арга хэрэгслүүдийн талаар мэдээлэлтэй байх боломжоор хангуулах ёстой, хөндлөнгийн оролцоо, шийтгэлээс айхгүйгээр засгийн газраа шүүмжлэх, эсвэл ил тод, нээлттэй үнэлж болдог тийм нийгмийн мөн чанар юм.”⁸⁵
62. Хүний эрхийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг бусад эрхийн талаар мөн адил зүйлийг хэлж болно. Тиймээс хүний эрхийн ажилтай холбоотой эрхийг хэрэгжүүлэхэд хязгаарлалт тавих асуудал хөндөгдөхөд зайлшгүй, пропорциональ зарчмыг хангах босго нэлээд өндөр байна гэж тооцож болно.

II. Хүний эрхийг хамгаалагчдын бие махбодын халдашгүй байдал, эрх чөлөө, аюулгүй байдал, нэр төр

A. Заналхийлэл, халдлага, бусад зүй бус үйлдлээс хамгаалах

63. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалын 12 дугаар зүйлийн 3-т заасны дагуу “төр нь бие даан болон бусадтай хамтран ажилладаг хүн бүрийг энэхүү Тунхаглалд дурдсан эрхээ хууль ёсны дагуу эдлэхтэй холбоотойгоор аливаа хүчирхийлэл, заналхийлэл, хариу арга хэмжээ, де-факто эсвэл де-юре сөрөг ялгаварлан гадуурхалт, шахалт, эсвэл аливаа хөндлөнгийн ажиллагаа зэргээс эрх бүхий байгууллагаар хамгаалуулахад шаардлагатай бүх арга хэмжээг авна.”
64. ИУТЭОУП-ын 6, 7 дугаар зүйл, ХЭҮЭЧК-ын 2, 3 дугаар зүйл, ХЭАК-ын 4, 5 дугаар зүйлд улс орнуудаас өөрийн нутаг дэвсгэр болон түүний хуульд харьяалагдах аливаа хүнийг, түүний дотор хүний эрхийг хамгаалагчдыг амьд явах, эрүүдэн шүүхээс ангид байх болон бусад зүй бус харьцаанд өртүүлэхгүй байх эрх нь зөрчигдөхөөс хамгаалахыг шаарддаг. ЕАБХАБ-ын оролцогч орнууд “хүн бүр амьд явах эрхтэй [...] бөгөөд хэн ч эрүүдэн

84 Бодрозикын Серб ба Монтенегрогийн эсрэг нэхэмжлэлд гаргасан Хүний Эрхийн Хорооны тайлбарыг үз. Албан бичгийн №1180/2003, 2005 оны 10 дугаар сар.

85 Эх. сурв. Адюём болон бусдын Того улсын эсрэг нэхэмжлэлийн тайлбарыг дурдсан зүүлт №8, Албан бичгийн №422-424/1990, 1996 оны 7 дугаар сарын 12.

шүүлт болон бусад хэлбэрийн хэрцгий, хүнлэг бус буюу хүний нэр төрийг доромжлон харьцах ба шийтгэх явдалд өртөх ёсгүй” гэж онцолжээ.⁸⁶ Үүнээс гадна эдгээр орнууд эрүүдэн шүүлт болон бусад хэлбэрийн хэрцгий, хүнлэг бус буюу хүний нэр төрийг доромжлон харьцах ба шийтгэх явдлыг арилгах болон эрүүдэн шүүлт, бусад зүй бус харьцаанаас сэргийлэхэд чиглэсэн тасралтгүй, шаргуу, үр дүнтэй арга хэмжээ авах хүчин чармайлтаа эрчимжүүлэх, эрүү шүүлтэд өртсөн хохирогчдын хохирлыг бүрэн дүүрэн нөхөн төлүүлэх нийтлэг ЕАБХАБ-ын үүрэг амлалтаа бүрэн хэрэгжүүлэх эрмэлзлээ дахин баталгаажуулсан.⁸⁷

65. Гэсэн хэдий ч, хэд хэдэн оролцогч улс оронд хүний эрхийг хамгаалагч нар өөрсдийн үйл ажиллагааныхаа төлөө аллага, эрүүдэн шүүх болон бусад зүй бус үйлдэл зэрэг заналхийлэл, хүчирхийлэлтэй тулгарсан хэвээр байна. Европын зөвлөлийн сайд нарын хороо “үндэсний болон олон улсын түвшиндээ гаргаж буй хүчин чармайлтаас үл хамааран хүний эрхийг хамгаалагчид, тэр дундаа сэтгүүлчдийн эрх хэтэрхий олон удаа зөрчигдөж, заналхийлэл, дайралтад өртсөөр буй явдлыг” эрс буруушааж байна.⁸⁸ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл болон Ерөнхий ассамблей хоёулаа “хүний эрхийг хамгаалагчдад ирэх заналхийлэл, дайралт, айлган сүрдүүлэх үйлдлийн улмаас учирч буй эрсдэлийн ноцтой байдал”-д ихээр санаа зовж буйгаа илэрхийлсэн.⁸⁹ ЕАБХАБ-ын гишүүн хэд, хэдэн оронд хүний эрхийг хамгаалагчдын эсрэг заналхийлэл, дайралт, бусад хүчирхийллийн үйлдлүүд, зарим тохиолдолд аллага хүртэл гарсан тухай мэдээнд НҮБ-ын

86 Сайд нарын Хорооны Арван зургаа дахь Уулзалтаас гаргасан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 60 жилийн ойд зориулсан Тунхаглалын баримт бичгийг үз. (Хельсинки 2008)

87 Сайд нарын Хорооны Арван долоо дахь Уулзалтаас гаргасан Эрүүдэн Шүүлт болон бусад хэлбэрийн хэрцгий, хүнлэг бус буюу доромжилсон харьцаа ба шийтгэлийн эсрэг конвенц баталж хэрэгжүүлсний 25 жилийн ойд зориулсан Тунхаглалын баримт бичгийг үз. (Афин 2009), заалт №8 ба 9. Эрүүдэн шүүлт болон бусад хэлбэрийн зүй бус харьцааны талаарх ЕАБХАБ-ын урьдын үүрэг амлалтуудын хувьд, мөн Вена 1989, заалт №23.4; Копенхаген 1990, заалт №16.1; Шинэ Европын Парисын Дүрэм (Парис 1990); Будапешт 1994, заалт №20; Станбул 1999, “Европын Аюулгүй Байдлын Дүрэм: III. Бидний нэгдмэл үүрэг”, заалт №24; ба Сайд нарын Хорооны Арван гурав дахь Уулзалтын баримт бичиг (Любляна 2005), Эрүүгийн шүүхийн тогтолцоо дахь Хүний эрхийн хамгаалал ба Эрхзүйт ёсны талаарх Шийдвэр №12/05-ыг тус тус үз.

88 Хүний эрхийг хамгаалагчдын хамгааллыг сайжруулах, үйл ажиллагааг нь хөхиүлэн дэмжих” Европын Зөвлөлийн арга хэмжээний тухай 2008 оны Хоёрдугаар сарын 6-ны өдөр батлагдсан Сайд нарын Хорооны Тунхаглалын оршлыг үз.

89 2013 оны 3 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн Тогтоол №22/6, НҮБ-ын Б.6. А/HRC/RES/22/6, ба 2011 оны 12 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан НҮБЕА-н Тогтоол №66/164, НҮБ-ын Б.6. А/RES/66/164-ийн оршуудыг тус тус үз. Ялангуяа эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдад заналхийлэл, халдлага учруулахын эсрэг байхын тухайд, мөн 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан НҮБЕА-н Тогтоол №68/181, НҮБ-ын Б.6. А/RES/68/181-ийг үз.

олон улсын гэрээний байгууллагууд санаа зовниж буйгаа илэрхийлсэн.⁹⁰ Европын зөвлөлийн парламентын ассамблей (ЕЗПА) зарим оронд хүний эрхийг хамгаалагчдын өртсөн аллага, хүн хулгайлах, эрүүдэн шүүх зэрэг ноцтой халдлагын хэргүүдийг зохих ёсоор мөрдөн шалгахгүй өнгөрөөснийг эрс буруушаасан билээ.⁹¹ Хүний эрхийн төлөө Европын зөвлөлийн комисс ч тайландаа мөн адил санаа зовниж буйгаа илэрхийлсэн байна.⁹²

66. ЕАБХАБ-ын бүс нутагт багтдаг хэд хэдэн оронд хүний эрхийг хамгаалагчдын эсрэг заналхийлэл, хүчирхийллийн нийтлэг хэлбэрүүд болох аман болон бие махбодын хүчирхийлэл, хүний эрхийг хамгаалагчдын гэр, оффис, автомашиныг галдан шатаах буюу бөмбөг дэлбэлэх, тэдний тоног төхөөрөмж, бусад эд хөрөнгийг устгах, хураах, цагдаагийн нэгжлэг, жагсаал, цуглаан болон бусад хэв журам хамгаалах үйл ажиллагааны нэрийн дор хүний эрхийг хамгаалагчдын эсрэг хэт их хүч хэрэглэх; албадан саатуулах үедээ эрүүдэн шүүх, бусад байдлаар зүй бус харьцах, хулгайлах, эсвэл хүчээр сураггүй алга болгох, гэр ч бүү хэл хүний эрхийг хамгаалагчдыг хөнөөх явдал гарсныг харж болно. Энэ мэт зөрчлүүд нь зөвхөн хүний эрхийг хамгаалагчдын эсрэг төдийгүй, гэр бүлийнх нь гишүүдийн эсрэг чиглэгддэг. Хүчирхийлэл үйлдэгчид хүний эрхийн

90 Жишээ нь: “НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны Украйнд хийсэн нэгдсэн дүгнэлт”, НҮБ-ын Б.б. ССРР/С/УКР/СО/7, 2013 оны 8-р сарын 22, заалт №20; “Сербид хийсэн НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны Нэгдсэн дүгнэлт”, НҮБ-ын Б.б. ССРР/С/SRB/СО/2, 2011 оны 5-р сарын 20, заалт №21; “НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны Узбекистанд хийсэн нэгдсэн дүгнэлт”, НҮБ-ын Б.б. ССРР/С/UZB/СО/3, 2010 оны 4-р сарын 7, заалт №24; “НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны ОХУ-д хийсэн нэгдсэн дүгнэлт”, НҮБ-ын Б.б. ССРР/С/RUS/СО/6, 2009 оны 11-р сарын 24, заалт №16; “НҮБ-ын Эрүүдэн Шүүхийн Эсрэг Хорооны ОХУ-д хийсэн нэгдсэн дүгнэлт”, НҮБ-ын Б.б. САТ/С/RUS/СО/5, 2012 оны 12-р сарын 11, заалт №12; “Беларуст хийсэн НҮБ-ын Эрүүдэн Шүүхийн Эсрэг Хорооны Нэгдсэн дүгнэлт”, НҮБ-ын Б.б. САТ/С/BLR/СО/4, 2011 оны 12-р сарын 7, заалт №25; “Туркменистанд хийсэн НҮБ-ын Эрүүдэн Шүүхийн Эсрэг Хорооны Нэгдсэн дүгнэлт”, НҮБ-ын Б.б. САТ/С/ТКМ/СО/1, 2011 оны 6-р сарын 15, заалт №13; “НҮБ-ын Азербайжанд хийсэн Эрүүдэн Шүүхийн Эсрэг Хорооны Нэгдсэн дүгнэлт”, НҮБ-ын Б.б. САТ/С/AZE/СО/3, 2009 оны 12-р сарын 8, заалт №21-ийг тус тус үз.

91 2012 оны 6-р сарын 27-ны өдөр батлагдсан Европын Зөвлөлийн гишүүн орнуудын хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын талаарх ЕЗПА-н 1891 (2012) тогтоолын заалт №3-ыг үз. Жишээ нь: хүний амь хөнөөх, ийм зөрчил гаргасан тохиолдолд шийтгэл хүлээхгүй мултрах зэрэг бие махбодын бүрэн бүтэн байдалд заналхийлж, халдлага үйлдсэн тохиолдлуудын талаар Тогтоолын Тайлбар Санамж бичиг (Б.б. 12957, Хууль зүй, Хүний Эрхийн Хорооны илтгэл, илтгэгч: Төлөөлөгчид), ялангуяа, заалт №9-12 ба 28-31-ийг тус тус үз. Хүний эрхийг хамгаалагчдын бие махбодын бүрэн бүтэн байдалд халдсан талаарх гомдлуудын тухай ЕЗПА-н Тусгай илтгэгчийн Армен, Азербайжан, Гүрж улсад хийсэн айлчлалын үеэр үйлдсэн, Хууль зүй, Хүний Эрхийн Хороо, “Европын Зөвлөлийн гишүүн орнуудын хүний эрхийг хамгаалагчдын хамгаалал, үүргийг бэхжүүлэх тухай Өмнөд Кавказын бүс нутаг (Армен, Азербайжан, Гүрж) дахь хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын талаарх” 2014 оны 1-р сарын 3-ны өдрийн AS/Jur (2014) мэдээллийн санамж бичгийг үз.

92 Жишээлбэл: түүний Европ дахь цагаачдыг хамгаалах талаар хийсэн тайланг үзвэл хэт даврагч ба хэт барууны үзэлтэй бүлэглэлүүд хүний эрхийг хамгаалагч нар луу ноцтой дайрсан тухай мэдээлсэн байв. “Европ дахь цагаачдын эрхийг хамгаалах тухай, Европын Зөвлөлийн Хүний эрхийн комиссарын Тамгын газраас зохион байгуулсан хүний эрхийн хамгаалагчидтай хийсэн дугуй ширээний уулзалт, Парис, 2012 оны 10-р сарын 5”, CommDH (2013), 2013 оны 4-р сарын 18, заалт №31-32-ыг тус тус үз.

ажилд саад учруулж, хүний эрхийн тодорхой үйлдлийн төлөө хариу арга хэмжээ авах, эсвэл зүгээр л айдас төрүүлэхийг эрмэлздэг тул хүний эрхийг хамгаалагч нар болон тэдний гэр бүлгийг онилдог. Ихэнх тохиолдолд хүний эрхийг хамгаалагчдад учирдаг аюулгүй байдлын эрсдэл нь урт хугацааны, тэднийг дуугүй болгох зорилготой зүй бус үйлдэл байдаг.

67. Ийм хүчирхийллийг улс төрийн түрэмгий бүлэглэлүүд, зэвсэгт бүлэглэлүүд, зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл, хувийн гэрээт харуул хамгаалалтын компаниуд болон бусад хүмүүс зэрэг төрийн бус талууд, төрийн албан тушаалтнууд эсвэл тэдний зөвшөөрөл, дэмжлэг, авлигын тусламжтайгаар үйлддэг. Заримдаа түрэмгий бүлэглэлүүдийн хүчирхийллийг төрийн албан тушаалтнууд ил тод, эсвэл далд хэлбэрээр хуульчилж өгдөг.⁹³
68. Оролцогч улсуудын хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, биелүүлэх үүрэг нь хүний эрхийг хамгаалагчдын эсрэг аливаа аюул занал, хүчирхийллийн үйлдлээс зайлсхийх, төрийн бус оролцогчдын ийм үйлдлээс хамгаалах, тэдний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг тэднээс шаарддаг. НҮБЕА-н тогтоолуудаар улс орнуудыг хүний эрхийг хамгаалагчдын хамгааллыг хангахыг байнга уриалдаг. Европын зөвлөлийн сайд нарын хороо гишүүн орнуудыг “Хүний эрхийг хамгаалагчдыг дайрч доромжлох, дарамтлахаас урьдчилан сэргийлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авах, ийм үйлдлийн хэрэгт хараат бус, үр дүнтэй мөрдөн шалгах ажиллагаа явуулах, буруутай этгээдүүдэд захиргааны арга хэмжээ, эсвэл эрүүгийн хэрэг шүүхэд хянан хэлэлцэх замаар хариуцлага хүлээлгэхийг” уриалсан.⁹⁴ Үүнтэй адил НҮБЕА нь “тодорхой эрсдэлтэй тулгардаг эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдыг заналхийлэл, доромжлол, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар бодит арга хэмжээ авах, зөрчил гаргасан, хүчирхийлэл үйлдсэн этгээдүүдийг [...] шударгаар мөрдөн шалгаж, нэн даруй хариуцлага хүлээлгэх замаар зохих журмыг баримтлан ажиллахыг улс орнуудад уриалжээ.”⁹⁵

93 Жишээлбэл: “Тусгай илтгэгчид төрийн бус талууд, түүний дотор хувийн хэвшлийн корпорацууд гутаан доромжлох, заналхийлэх, дарамт шахалт, халдлага, амь насанд заналхийлэх, амь насыг нь бүрэлгэх зэрэг хүний эрхийг хамгаалагчдын эсрэг зүй бус үйлдлүүд гаргасан тухай баттай мэдээлэл, мэдэгдэл ирсээр байна. Халдлагыг зарим тохиолдолд логикийн дэмжлэг үзүүлэх, эсвэл тэдний үйлдлүүдийг илт ил, далд байдлаар өөгшүүлэх замаар төрөөс шууд ба шууд бус байдлаар дэмжсэн бүлэглэлүүд хийдэг.” гэж дурдсан НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын байдлын талаарх 2013 оны 12-р сарын тайлан, (НҮБ-ын Б.6 А/НRC/25/55, заалт №103)-г үз.

94 “Европын Зөвлөлийн хүний эрхийг хамгаалагчдын хамгааллыг сайжруулах, үйл ажиллагааг нь хөхиүлэн дэмжих арга хэмжээний талаарх Сайд нарын Хорооны Тунхаглал”, 2008 оны Хоёрдугаар сарын 6, заалт №2 (iv)-ыг үз.

95 НҮБЕА-н Тогтоол №A/RES/68/181, заалт №9-ийг үз.

Ял шийтгэлээс ангид байх ба үр дүнтэй шүүн таслах арга хэмжээ

69. НҮБЕА нь хүний эрхийг хамгаалагчдын эсрэг төрийн болон төрийн бус талууд дайрч, заналхийлж, айлган сүрдүүлсэн үйлдэлдээ ял шийтгэл хүлээхгүй өнгөрдөг явдлыг зогсоохын тулд зохих арга хэмжээ авахыг улс орнуудад удаа дараа мэдэгдэж байсан.⁹⁶ Гэвч хүний эрхийг хамгаалагчдын эсрэг үйлдсэн заналхийлэл, хүчирхийллийн хэргүүдэд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан ч гэмт этгээдүүдийг илрүүлэх чадамжгүй байдаг ба ихэвчлэн буруутанд хариуцлага хүлээлгэж чаддаггүй. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч эмэгтэйн хэлснээр түүний бүрэн эрхийн хугацаанд хүний эрхийг хамгаалагчдын эсрэг зөрчлийн анхаарлын төвд байсан хамгийн гол, тогтолцооны чанартай асуудлын нэг нь ял шийтгэл оногдуулахгүй, ангид байх явдал байсан юм.⁹⁷
70. Зөрчлийн талаарх мэдэгдлийг ойшоодоггүй, тэдний эсрэг заналхийллийг дутуу үнэлдэг, эсвэл иймэрхүү нэхэмжлэлийн дагуу нарийвчилсан мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлгүй байдаг гэж ЕАБХАБ-ын оролцогч хэд, хэдэн улсын хүний эрхийг хамгаалагч нар мэдээлжээ. Энэ нь хууль сахиулах байгууллагын ажилтнууд хүний эрхийг хамгаалагчдын эсрэг заналхийлэл, дайралтын эсрэг арга хэмжээ авах чадваргүй, эсвэл хүний эрхийг хамгаалагчдын өртөж болзошгүй эрсдэл, зөрчлийн ноцтой байдлын үнэлэмж дутмаг байгаатай холбоотой юм. Мөн төрийн албан тушаалтнуудын ийм үйл ажиллагаанд шууд оролцдог эсвэл буруутай этгээдүүдийг тэдний сэдэл, үзэл суртлыг далдуур дэмждэгтэй ч холбоотой юм. Мөрдөн шалгах ажиллагаа явуулж, шүүхэд дууддаг ч гэсэн ихэнхдээ хүний эрхийг хамгаалагчдын эсрэг халдлагыг захиалсан этгээдүүдийг шүүлгүй, эдгээр үйлдлүүдийг гардан үйлдсэн хүмүүст чиглүүлж, эсвэл хэрэгтнийг тэднээр хязгаарлах төдийгөөр өнгөрдөг. Шүүхээр орсон ч, хариуцагчдад хариуцлага хүлээлгэхгүй, эсвээс хөнгөн шийтгэл оногдуулах, бүр хэрэгсэхгүй болгох нь их.
71. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалын 9 (5) дугаарт заасны дагуу улс орнууд “шуурхай, шударга мөрдөн шалгах ажиллагаа явуулж, харьяа нутаг дэвсгэрийнх нь хаана ч хүний эрх, үндсэн эрх чөлөөг зөрчсөн гэж үзэх үндэслэл бүхий тохиолдолд байцаалт явуулах үүрэгтэй.”
72. Мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй явуулахын тулд хэд хэдэн чухал шаардлагыг авч үзэх ёстой. Үүнд:

96 НҮБЕА-н Тогтоол №A/RES/66/164, заалт №8-ыг үз. НҮБЕА-н өмнөх Тогтоол №A/RES/64/163 болон A/RES/62/152, A/RES/60/161 ба A/RES/59/192-ыг мөн үз.

97 Хүний эрхийг хамгаалагчдын асуудал эрхэлсэн НҮБ-ын Тусгай илтгэгчийн 2013 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн тайлан, A/HRC/25/55, заалт №73-г үз.

- а) Эрх бүхий. Тодруулбал, буруутай этгээдийг олж тогтоох, шийтгэх чадвартай;
 - б) Далайцтай байх. Тодруулбал, бусад шаардлагаас гадна зөрчилд хүргэсэн аливаа тогтолцооны алдааг тодорхойлох чадвартай;
 - в) Шударга, хараат бус байх. Тодруулбал, мөрдөн шалгах ажиллагааг явуулж буй хүмүүс нь шударга, үйл явдалд оролцсон хүмүүсээс хараат бус байх ёстой;
 - г) Шуурхай байх. Тодруулбал, мөрдөн шалгах ажиллагааг нэн даруй эхлэх ёстой бөгөөд боломжийн хугацаанд дуусгах ёстой;
 - д) Мөн мөрдөн шалгах ажиллагаа, буруутай этгээдэд хариуцлага тооцсон түүний үр дүнг хянах олон нийтийн хяналт шалгалтын хангалттай оролцоотой байх ёстой бөгөөд энэ нь ялангуяа эрх бүхий байгууллага хууль бус үйлдлийг үл хүлцэж, эсвэл түүний талаар зөрчилдөөн үүсэхээс урьдчилан сэргийлж, эрх зүйт ёсыг дагаж мөрдөж буй байдлын талаар олон нийтийн итгэл үнэмшлийг алдагдуулахгүй” байхад нэн чухал”.⁹⁸
73. Хүч хэтрүүлэн хэрэглэсэн, эрүүдэн шүүсэн болон бусад зүй бус харьцсан тухай гомдол, мөн хууль сахиулах байгууллагын ажилтнууд хүчирхийлсэн бусад жишээний талаарх мөрдөн шалгах ажиллагааны тухайд эдгээр үйлдэлтэй холбоотой гомдлыг хүлээн авах, шалгах эрх бүхий бие даасан байгууллагууд байгуулахыг НҮБ-ын олон улсын гэрээний байгууллага нь өөрийн төлөөлөлгүй газрууддаа байнга уриалдаг.⁹⁹ Мөн Европын зөвлөлийн сайд нарын хороо нь улс орнуудыг, шаардлагатай бол, ХЭҮИ-ийн хүний эрхийг хамгаалагчдын гаргасан эрх нь зөрчигдсөнтэй холбоотой гомдлыг шийдвэрлэх мэргэшил, эрх зүйн чадамжийг бэхжүүлэх, эсвэл эдгээрийг бий болгох талаар авч үзэхийг зөвлөдөг.¹⁰⁰ Ямар ч тохиолдолд нэхэмжлэгчдийг нэхэмжлэл гаргасныхаа төлөө ямар нэгэн зүй бус харьцаа,

98 “Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны хүний эрхийн ноцтой зөрчилд Ял шийтгэлээс зугтах явдлыг арилгах удирдамж”, Хэсэг VI. Үр дүнтэй мөрдөн шалгах ажиллагаанд тавигдах шалгуур, 2011 оны 3 дугаар сарын 30-ны өдөр баталсан, <<https://wcd.coe.int/ViewDoc.jsp?id=1769177-g-g> үз.

99 Жишээлбэл: “НҮБ-ын Эрүүдэн Шүүхийн Эсрэг Хорооны Киргизстанд хийсэн нэгдсэн дүгнэлт”, НҮБ-ын Б.б. САТ/С/КГЗ/СО/2, 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдөр, заалт №6; “НҮБ-ын Эрүүдэн Шүүхийн Эсрэг Хорооны Тажикстанд хийсэн нэгдсэн дүгнэлт”, НҮБ-ын Б.б. САТ/С/ТЖ/СО/2, 2013 оны 1 дүгээр сарын 21, заалт №15; “НҮБ-ын Эрүүдэн Шүүхийн Эсрэг Хорооны Армэнд хийсэн нэгдсэн дүгнэлт”, НҮБ-ын Б.б. САТ/С/АРМ/СО/3, 2012 оны 7 дугаар сарын 6-ны өдөр, заалт №12; “НҮБ-ын Эрүүдэн Шүүхийн Эсрэг Хорооны Литвад хийсэн нэгдсэн дүгнэлт”, НҮБ-ын Б.б. САТ/С/LTU/СО/2, 2009 оны 1 дүгээр сарын 19-ны өдөр, заалт №14; ба “НҮБ-ын Эрүүдэн Шүүхийн Эсрэг Хорооны Азербайжанд хийсэн нэгдсэн дүгнэлт”, ССРР/С/AZE/ СО/3, 2009 оны 8 дугаар сарын 13-ны өдөр, заалт №11-ийг тус тус үз.

100 Өм. дурд. “Европын Зөвлөлийн хүний эрхийг хамгаалагчдын хамгааллыг сайжруулах, үйл ажиллагааг нь хөхиүлэн дэмжих арга хэмжээний талаарх Сайд нарын Хорооны тунхаглал”, заалт №2 (v).

айлган сүрдүүлэлт эсвэл хариу арга хэмжээ авхуулахаас хамгаалах ёстой.¹⁰¹ Энэ нь хүний эрхийг хамгаалагч нар гомдол гаргасан хэргээр хариу арга хэмжээний чанартай мөрдөн шалгуулах, эсвэл шүүхээр орох ёсгүй гэсэн үг юм.

74. Хүний эрхийг хамгаалагчийн эсрэг халдлага үйлдсэн этгээдүүдэд мөрдөн шалгах ажиллагаа явуулж хариуцлагад татсан тохиолдолд төр нь буруутай этгээдүүдийг төрийн албан тушаалтан, эсвэл төрийн бус тал эсэхээс нь үл хамааран шийтгэл хүлээлгэх үүрэгтэй.¹⁰² НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авах төрийн хүлээсэн үүрэгтэй холбогдуулан зөвхөн гардан гүйцэтгэсэн гэмт хэрэгтнүүд төдийгүй далдаас зааварлагч буюу захиалагчийг мөрдөн шалгах, хариуцлага тооцох нь нэн чухлыг цохон дурдав.¹⁰³
75. Хэрвээ захирагдах доод албан тушаалтан нь ийм гэмт хэргийг үйлдэж эсвэл үйлдэхээр завдсаныг захирах шууд дээд тушаалын ажилтан нь тухайн үед мэдсэн, эсвэл мэдэх боломжтой байгаад ийм гэмт хэргээс сэргийлэх эсвэл шийтгэх шаардлагатай бүх арга хэмжээг аваагүй бол доод албан тушаалтан аливаа зөрчил гаргасан, ялангуяа эрүүгийн хариуцлагад унасан бол хариуцсан дээд албан тушаалтан нь хариуцлага хүлээхгүй гэсэн үг биш. Доод албан тушаалтны хариуцлагын тухайд гэмт этгээд өөрийн засгийн газрын эсвэл дээд албан тушаалтны тушаалаар үйлдсэн нь тухайн хүнийг өөрийг нь хариуцлагаас чөлөөлөхгүй.¹⁰⁴ Харин хууль бус тушаалыг хэрэгжүүлэхээс татгалзсан доод тушаалын ажилтан эрүүгийн эсвэл сахилгын шийтгэл хүлээхгүй.¹⁰⁵

101 "НҮБ-ын Эрүүдэн Шүүхийн Эсрэг Хорооны Тажикстанд хийсэн нэгдсэн дүгнэлт", НҮБ-ын Б.Б. САТ/С/ТЖК/СО/2, заалт №15.

102 Жишээлбэл: НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны ерөнхий тайлбар №31, "Гэрээний улсуудад оногдуулсан эрх зүйн ерөнхий үүргийн мөн чанар", НҮБ-ын Б.Б. ССРР/С/21/Rev.1/Add.13, 2004 оны 5 дугаар сарын 26, заалт №18-ыг үз.

103 НҮБ-ын Эрүүдэн Шүүхийн Эсрэг Хороо, Ерөнхий тайлбар №2, Оролцогч улсуудын "Зүйл №2-ын хэрэгжүүлэлт", НҮБ-ын Б.Б. САТ/С/ГС/2, 2008 оны 1 дүгээр сарын 24, заалт №9-ыг үз.

104 Дараах тушаал, заавар нь доод албан тушаалтанд ял оногдуулахад хамааралтай байж болно. "Ял шийтгэлээс зугтах явдалтай тэмцэх замаар хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд зориулсан шинэчилсэн бүлэг зарчим", НҮБ-ын Б.Б. Е/CN.4/2005/102/Add.1, 2005 оны Хоёрдугаар сарын 8, зарчим 27. "Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны хүний эрхийн ноцтой зөрчилд Ял шийтгэлээс зугтах явдлыг арилгах удирдамж, Хэсэг XIII. Доод албан тушаалтныг хариуцлага. "Хууль сахиулах ажилтнууд хүч ба галт зэвсэг хэрэглэхэд мөрдөх ерөнхий зарчмууд", Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтнүүдтэй харьцах тухай Наймдугаар Чуулганаар баталсан, Хавана, Куб, 1990 оны Наймдугаар сарын 27-ны өдрөөс 9 дүгээр сарын 7-ны өдөр, 24 ба 26 дугаар зарчмыг тус тус үз.

105 "Хууль сахиулах ажилтнууд хүч ба галт зэвсэг хэрэглэхэд мөрдөх ерөнхий зарчмууд", зарчим 25-ыг үз.

76. Хүний эрхийн ноцтой зөрчил гаргасан нь холбогдох эрх бүхий байгууллагаар тогтоогдсон эсхүл ял шийтгэл хүлээлгүй өнгөрөх явдлыг өөгшүүлсэн, хүлцсэн аливаа төрийн албан хаагчийг албан тушаалаас нь чөлөөлөх буюу бусад зохих сахилгын журмаар хариуцлага тооцох ёстой.¹⁰⁶ Шаардлагатай тохиолдолд эдгээр журамд эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх, ял шийтгэх ажиллагааг ч давхар явуулах ёстой¹⁰⁷ бөгөөд шийтгэл нь үйлдсэн хэрэгт нь нийцэхүйц пропорциональ, тохирсон¹⁰⁸ байх ёстой. Бусад үр нөлөөг үл дурдахад, ийм үйлдлийг тэвчихгүй бөгөөд аливаа ял нь сэдлийг буруулах хангалттай хүчтэй байх ёстой гэсэн үг юм.
77. Ардчилсан нийгэм дэх хүний эрхийн ажлын чухал үүрэг, хүний эрхийн ажилтай холбоотойгоор хүний эрхийг хамгаалагчдад заналхийлэл, хүчирхийлэл үйлдэх нь ихэвчлэн ойрын хохирогч төдийгүй бусад хүний эрхийг хамгаалагчдыг үйл ажиллагаагаа явуулахаас сэргийлэн айдас төрүүлэх зорилготой байдаг. Энэ байдлыг авч үзвэл, оролцогч улсууд ийм төрлийн гэмт хэрэгт ял оногдуулахтай холбоотой хууль тогтоомждоо энэ сэдлийн хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон тусгах хэрэгтэй.¹⁰⁹
78. Нийгмийн тодорхой бүлгийг үл тэвчих шалтгаанаас болж хүний эрхийг хамгаалагч нар түрэмгий дайралтад өртвөл эрх баригчид үзэн ядах гэмт хэргийн эсрэг хууль тогтоомжийн дагуу шийтгэл оногдуулах ёстой. Энэ төрлийн гэмт хэрэгт үндэс угсаа, шашин шүтлэг, “арьс өнгө”, иргэний харьяалал, хүйс, хөгжлийн бэрхшээл болон бусад байдлаасаа шалтгаалан үзэн ядах гэмт хэрэгт өртөмтгий хүмүүсийн эрхийг хамгаалдаг хүний эрхийг хамгаалагчдын эсрэг хийсэн халдлага орж болно. Гэмт хэргийн бай болсон хүмүүс өөрсдөө эдгээр бүлэгт харьяалагддаг эсэх, хүний эрхийн ажлынхаа хүрээнд тэдэнтэй холбоотой эсвэл хамааралтай эсэхээс үл хамааран үзэн ядахтай тэмцэх тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөх ёстой. Оролцогч улсууд шаардлагатай бол үзэн ядах гэмт хэрэгтэй тэмцэх талаар тусгайлсан, тохирсон хууль тогтоомжийг ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу гаргаж, ийм гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан үр

106 “Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны хүний эрхийн ноцтой зөрчилд Ял шийтгэлээс зугтах явдлыг арилгах удирдамж”, Хэсэг III. Ял шийтгэлээс зугтах аас сэргийлэх ерөнхий арга хэмжээ, заалт №7-г үз.

107 Мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй болгоход тавигдах шаардлагуудыг хэрэг хянан хэлэлцэх шатанд ч, мөн тавина. Эх. сурв. Хэсэг VIII.

108 Эх. сурв. Хэсэг X. Ял шийтгэх.

109 Энэ талаар шилдэг туршлагын жишээ гэвэл, хэдийгээр ЕАБХАБ-ын бүс нутагт багтдаг улс биш ч, Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр явуулсан үйл ажиллагаанаас нь сэдэлтэйгээр үйлдсэн бол эрүүгийн хариуцлагад хүндрүүлэх бүрэлдүүнээр авч үздэг Сальвадорын Эрүүгийн хууль. Сальвадор Улсын Эрүүгийн хуулийн 30 дугаар зүйл, <<http://www.asamblea.gob.sv/eparlamento/index-legislativo/buscadador-de-documentos-legislativos/codigo-penal>>-г үз.

нөлөө бүхий шийтгэлийг бий болгох ёстой.¹¹⁰ Оролцогч орнууд, бусад эх сурвалжуудын хамтаар, ЕАБХАБ/АИХЭГ-ээс гаргасан Үзэн ядах гэмт хэргийн эсрэг хуулиуд хууль-Практик удирдамж гэсэн баримт бичгийг одоогийн хууль тогтоомжоо хянаж үзэхдээ удирдлага болгох хэрэгтэй.¹¹¹

79. Европын зөвлөлийн сайд нарын хорооны мэдэгдсэнээр “хүний эрхийн ноцтой зөрчилд институтууд буюу төрийн агентлаг зохих журмын дагуу хариу үзүүлээгүйгээс ял шийтгэлгүй өнгөрдөг. Энэ тохиолдолд төрийн байгууллагууд болоод шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, мөрдөн шалгах ажиллагааны аль ч шатанд алдаа гарсан байж болно.”¹¹² Хариуцлага хүлээлгэхгүй, шийтгэлгүй өнгөрдөг байдлыг дэмжиж буй институтийн соёлоос урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхийн тулд улс орнуудад бодлого боловсруулж, хүний эрхийг хүндэтгэх соёлыг үндэсний хэмжээнд сурталчлах, сургалт, хяналтын зохих механизмыг бий болгох, бэхжүүлэх, авлигын эсрэг бодлогыг нэвтрүүлэх, холбогдох байгууллагуудад үүрэг хариуцлагаа ухамсарлах, тэдгээр үүргээ биелүүлээгүй тохиолдолд зохих шийтгэл оноох, хүний эрхийн ноцтой зөрчлийг үл тэвчих бодлого явуулж, зөрчлүүд болон тэдгээр зөрчлүүдэд эрх баригчдын авсан арга хэмжээний тухай олон нийтийг мэдээллээр хангахын зэрэгцээ бусад практик арга хэмжээг авч ажиллахыг уриалав.¹¹³
80. Оролцогч орнуудыг “шүүх эрх мэдлийн тогтолцоогоо бэхжүүлж, эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн хүмүүст зориулан үр дүнтэй залруулах арга хэрэгслийг бий болгохыг” уриалсан.¹¹⁴ Ийм арга хэрэгсэл нь хүртээмжтэй, бүх шаардлагатай хүчин зүйлсийг тусгасан байх ёстой.¹¹⁵ ЕАБХАБ-ын оролцогч орнууд үр дүнтэй залруулах арга хэрэгслийн нэг хэсэг болох хууль эрх зүйн туслалцаа хайх, хүртэх эрхийг баталгаажуулсан байна.¹¹⁶

110 ЕАБХАБ-ын Сайд нарын Зөвлөл, Шийдвэр №9/09, “Үзэн ядах гэмт хэрэгтэй тэмцэх”, Афин, 2009 оны 12 дугаар сарын 1-2 -ны өдөр, <<http://www.Osce.org/cio/40695>>-г үз.

111 ЕАБХАБ/АИХЭГ, “Үзэн ядах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулиуд – Практик удирдамж”, 2009. Хамаарал, хамаатай байдлын асуудлын тухайд, 49-51-р хуудсыг тус тус үз.

112 “Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны хүний эрхийн ноцтой зөрчилд ял шийтгэлээс зугтах явдлыг арилгах удирдамж”, Хэсэг I. Ял шийтгэлээс зугтах явдалтай тэмцэх хэрэгцээ шаардлага, заалт №2.

113 Эх. сурв. Хэсэг III. Ял шийтгэлээс зугтах аас урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээнүүд.

114 Европын Зөвлөлийн хүний эрхийг хамгаалагчдын хамгааллыг сайжруулах, үйл ажиллагааг нь хөхиүлэн дэмжих арга хэмжээний талаарх Сайд нарын Хорооны тунхаглал, заалт №2 (iii).

115 Жишээлбэл: “Конвенцод тусгасан эрхүүдийг үр дүнтэй хамгаалахын зэрэгцээ, оролцогч улсууд хувь хүн эдгээр эрхийг шаардаж олж авахад нээлттэй, бодитой боломжоор хангахад анхаарах ёстой.” гэж заасан НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны ерөнхий тайлбар №31, 15-р зүйлийг үз. Хүний эрх, суурь эрх чөлөө нь зөрчигдсөн гэж нэхэмжлэгсдэд үйлчлэх хуулийн арга хэмжээтэй холбоотой ЕАБХАБ-ын Хүний аюулгүй байдлын хэмжүүрийн үүрэг амлалтуудыг, жишээ нь: Вена 1989, заалт №13.9; Парис 1990; Копенхаген 1990, заалт №11; Любляна 2005; болон Хельсинки 2008 заалтуудаас тус тус үз.

116 Копенхаген 1990, заалт №11.

81. НҮБ-ын Хүний эрхийн хорооноос мөн зарим бүлэг хүмүүсийн эмзэг байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр ийм арга хэрэгслийг зохицуулан авч ашиглах шаардлагатайг онцолсон байна.¹¹⁷ НҮБЕА эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдын эсрэг үйлдсэн зөрчил, зүй бус үйлдлүүдэд ял шийтгэл хүлээлгэхгүй өнгөрч буйг мэдээлдэггүй, баримтжуулдаггүй, мөрдөн шалгах ажиллагаа явуулдаггүй, шүүхэд хэрэг хянан шийдвэрлүүлэхээр оруулдаггүй, түүнчлэн бэлгийн хүчирхийлэл, ийм зөрчлөөс үүдэлтэй гутаан доромжлол гэх мэт хүйсийн хүчирхийллийг арилгахад учирч буй нийгмийн саад бэрхшээл, хязгаарлалт зэрэг хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалан ноцтой санаа зовоосон асуудал хэвээр байсаар байна гэж онцлон тэмдэглэжээ.¹¹⁸ Иймээс оролцогч улс орнууд тодорхой эрсдэлд байгаа эмэгтэй хүний эрхийг хамгаалагч нар болон хүний эрхийг хамгаалагчдын бусад бүлгүүдэд хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх болон бусад дэмжлэг үзүүлэх зэрэг замаар шударга ёсыг хүртэх байдлыг хангах үүднээс идэвхтэй арга хэмжээ авах хэрэгтэй.¹¹⁹
82. Түүнчлэн, НҮБ-ын Хүний эрхийн хорооноос “тодорхой нөхцөлд үр дүнтэй арга хэмжээгээр хамгаалуулах эрх нь тасралтгүй зөрчлөөс зайлсхийх зорилгоор урьдчилсан эсвэл түр зуурын арга хэмжээ авах, хэрэгжүүлэх, ийм зөрчлийн учруулж болзошгүй аливаа хохирлыг аль болох эрт арилгах хүчин чармайлт гаргахыг оролцогч улс орнуудаас шаарддаг.”¹²⁰ Ямар ч тохиолдолд хүчирхийлэл болон бусад зүй бус үйлдэлд өртсөн хүний эрхийг хамгаалагч нар (тэдний гэр бүл) хохирлоо зохих ёсоор нөхөн төлүүлэхийг шаардах эрхтэй.
83. Нөхөн төлбөр гэдэг нэр томъёог нөхөн төлбөр, нөхөн олговор, нөхөн сэргээлт, сэтгэл ханамж, дахин үйлдэхгүйн баталгаа гэх мэт нийтлэг утгаар тодорхойлдог. Хэрэв боломжтой бол, хохирогчийн нөхцөл байдлыг зөрчлийн өмнөх байдлаар нөхөн сэргээх хэрэгтэй. Хэрэв ингэх боломжгүй бол бие махбодын болон сэтгэлзүйн хохирол, материаллаг хохирол, хууль эрх зүйн болон шинжээчийн туслалцаа үзүүлэх болон бусад үйлчилгээнд шаардагдах зардал гэх мэт санхүүгийн хувьд үнэлэгдэхүйц хохирлын нөхөн төлбөрийг өгөх ёстой. Нөхөн сэргээх гэдэгт зохих эмнэлгийн,

117 Хүний Эрхийн Хорооны ерөнхий тайлбар №31, заалт №15.

118 НҮБЕА-н Тогтоол №A/RES/68/181, 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдөр, ерөнхий зүйл. 10-ыг үз.

119 Жишээлбэл: Арьс өнгөөр Ялгаварлан Гадуурхалтыг Устгах Хороо (АӨЯГУХ) Шведэд хийсэн нэгдсэн дүгнэлтдээ “ялгаварлан гадуурхалтын хохирогчдод хохирол барагдуулах арга хэрэгсэл бий болгож өгөх үүднээс гэрээний улс”-ыг “Ялгаварлан гадуурхалтын хэрэг маргаанд нэхэмжлэгчээр оролцож буй хувь хүн болон хамааралтай этгээдүүдэд санхүүгийн туслалцаа үзүүлэх [...], хууль зүйн туслалцааны тогтолцоог бэхжүүлэхдээ Омбудсмэний санал болгосон арга хэмжээг хэрэгжүүлэхийг зөвлөжээ.” Арьс өнгөөр Ялгаварлан Гадуурхалтыг Устгах Хороо, “Нэгдсэн дүгнэлт: Швед”, НҮБ-ын Б.6. CERD/C/SWE/CO/19-21, 2013 оны 9 дүгээр сарын 23, заалт №21.

120 НҮ-ий Хүний Эрхийн Хорооны ерөнхий тайлбар №31, заалт №19.

сэтгэлзүйн, эрх зүйн болон нийгмийн үйлчилгээг хамруулах ёстой. Сэтгэл ханамж нь тухайн хэргийн нөхцөл байдлаас хамааран янз бүрийн арга хэмжээг багтааж болно. Үүнд: Зөрчлийг таслан зогсоох үр дүнтэй алхмууд; үнэнийг олон нийтэд дэлгэх; хохирогч, тэдний гэр бүлийн гишүүд, эсвэл хохирогчтой ойрхон бусад хүмүүсийн нэр төр, нэр хүнд, эрхийг сэргээсэн албан ёсны мэдэгдэл, эсвэл шүүхийн шийдвэр; олон нийтээс уучлал гуйж, гэм буруутай этгээдэд зохих шийтгэл ногдуулах гэх мэт орно. Эцэст нь дахин давтахгүй байх баталгаанд үр дүнтэй урьдчилан сэргийлэх арга хэмжээг багтаах ёстой.¹²¹

Хамгааллын бодлого, хөтөлбөр, механизмууд

84. НҮБЕА нь бүх улс орнуудад “орон нутгийн болон үндэсний түвшинд хүний эрхийг хамгаалагчдын хамгаалах баталгааг хангахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авахыг” удаа дараа уриалж байсан.¹²² Хүний эрхийг хамгаалагчдад тулгарч буй ноцтой эрсдэл, бэрхшээлийн үндсэн шалтгааныг арилгахын тулд хүний эрхийн ажлын аюулгүй, ээлтэй орчныг бүрдүүлэх зорилгод чиглэсэн нэгдсэн баримт бичигт ийм бүх арга хэмжээг нэгд нэгэнгүй тусгаж өгөх хэрэгтэй. Төрийн өндөр албан тушаалтнууд, үндэсний болон орон нутгийн холбогдох байгууллагууд хүний эрхийг хамгаалагчдын статус, үүрэг, тэдний хийж буй ажлын хууль ёсны байдлыг олон нийтэд ил тод мэдээлж, аливаа халдлага, заналхийлэл болон бусад зүй бус үйлдлийг гарсан даруйд нь нэн даруй буруушаах замаар хүлээн зөвшөөрөх нь хамгаалал, урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах эхний алхам юм.¹²³
85. Бусад газрын нэгэн адил ЕАБХАБ-ын бүс нутагт эрсдэлд өртсөн хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах хөтөлбөр байхгүй тохиолдолд болзошгүй аюул заналхийллийн эсрэг хариу арга хэмжээ авах нь удаан, үр дүн муутай байдаг. Хамгааллын арга хэмжээ авах талаарх зохицуулалт дутагдалтай, хугацаа алдсан, хүнд сурталтай байгаа нь төрийн албан тушаалтнуудын хүний эрхийг хамгаалагчдын аюулгүй байдлын асуудалд нухацтай хандах, аюул занал, хүчирхийллийг судлах хүсэлгүйтэй холбоотой. Хүний эрхийг хамгаалагчдын хүний эрхийн ажлын ач холбогдлыг ойлгох,

121 2005 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Ерөнхий Ассамблейн Тогтоол №60/147-оор батлагдаж, тунхагласан “Олон улсын хүний эрхийн хууль, Олон улсын хүмүүнлэгийн тухай хуулийн ноцтой зөрчлийн улмаас хохирсон хохирогчдын хохирлыг арилгах, нөхөн төлбөр олгох эрхэд тавигдах үндсэн зарчим, удирдамж”-ийн заалт №20-24-ийг үз.

122 НҮБЕА-н Тогтоол №A/RES/ 64/164, заалт №4, ба Ерөнхий Ассамблейн хүний эрхийг хамгаалагчдын талаарх өмнөх тогтоолуудыг үз. Гуравдагч орон дахь хүний эрхийг хамгаалагчдын хамгааллын талаар дэлгэрэнгүй мэдээллийг мөн доорх Хэрэгжилтийн ерөнхий төлөвлөгөө хэсгээс үз.

123 Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн тусгай илтгэгчийн тайланг үз. A/HRC/13/22 заалт №114.

тэднийг хамгаалахад хэрэгцээтэй нөөц, бололцоо байхгүй тул тэдэнд тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг ойлгох, тэднийг хамгаалах талаарх төрийн ойлголт, үйл ажиллагаа хангалтгүй байгаатай салшгүй холбоотой юм. Үүний уршгаар болзошгүй эрсдэлд байгаа хүний эрхийг хамгаалагч нар бие махбодын болон сэтгэлзүйн хамгаалал, аюулгүй газар руу нүүн шилжихэд туслалцаа авах болон бусад шаардлагатай дэмжлэг зэрэг зохих тусламж авч чадахгүй үлдэх нь элбэг.

86. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч нь оролцогч улсуудад, шаардлагатай тохиолдолд, бие махбодын болон сэтгэлзүйн хамгаалал, түүнчлэн материаллаг нөөцийг хангахын тулд төрийн бодлого, тодорхой институтийн механизмыг боловсруулж өгөхийг зөвлөж байна.¹²⁴ Тусгай илтгэгч мөн хамгаалах хөтөлбөр боловсруулахад чиглэсэн ерөнхий удирдамжуудыг танилцуулсан бөгөөд ийм хөтөлбөр боловсруулж, хянахдаа хүний эрхийг хамгаалагчидтай зөвлөлдөхийг оролцогч улсуудад зөвлөсөн. Хамгаалах хөтөлбөрүүдийн бүтцийг хуулиар, харин холбооны мужуудад хамгаалах хөтөлбөрийг холбооны хуулиар тодорхойлж, холбооны засгийн газраас баталдаг байх ёстой. Хамгаалалтын хөтөлбөрт хамгааллын арга хэмжээ шаардлагатай байгааг урьдчилан таамаглах, хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлагыг илрүүлэх аргачлалыг тусгаж өгөх хэрэгтэй. Эдгээр нь мөн эрсдэлд буй хүний эрхийг хамгаалагчдын гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдалд үнэлгээ хийх зохицуулалтыг агуулах ёстой. Хөтөлбөрт хамрагдсан аюулгүй байдал, хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг тусгайлан, зохих ёсоор бэлтгэх ёстой бөгөөд дээр дурдсан ойлголтуудын хүрээнд сургалтад хамрагдаагүй бол бие махбодын хамгаалалтын арга хэмжээг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх ёсгүй. Боловсруулсан хамгаалах хөтөлбөрт хангалттай санхүүгийн эх үүсвэрийг хуваарилах хэрэгтэй.¹²⁵
87. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч маш олон улсадгэрчийг хамгаалах хөтөлбөрийг хүний эрхийг хамгаалагчдыг эрсдэлээс хамгаалах цорын ганц механизм болгон ашигладаг болохыг тогтоосон. Уг зорилгод зориулан боловсруулаагүй учир дийлэнх тохиолдолд ийм хөтөлбөр нь хүний эрхийг хамгаалагчдын аюулгүй байдлыг хангахад хангалтгүй үр дүнтэй байна.¹²⁶ Зарчмын хувьд гэрчийг хамгаалах хөтөлбөрүүдийг хүний эрхийг хамгаалагчийг хамгаалахаар тохируулан орлуулах хэрэгсэл болгон ашиглах ёсгүй.

124 Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн тусгай илтгэгчийн тайланг үз. А/HRC/25/55, заалт №84 ба 131.

125 Хүний эрхийг хамгаалагчдын аюулгүй байдал, хамгааллын асуудлыг өргөнөөр авч үзсэн эх. сурв. 2009 оны 12 дугаар сарын 30-ны өдөр, заалт №88 ба А/HRC/13/22-ыг үз.

126 А/HRC/13/22, заалт №71-74-ийг үз.

Хэрэв улс орнууд эдгээр хөтөлбөрүүдийг хүний эрхийг хамгаалагчдын хамгааллын үндэс болгон ашигладаг бол эдгээр хөтөлбөрүүд нь тодорхой хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа эсэхийг нягтлах эсвэл холбогдох нэмэлт арга хэмжээг багтаасан байх ёстой.

88. Оролцогч улсуудын хүний эрхийг хамгаалагчдыг бие махбодын болон сэтгэлзүйн хувьд хамгаалахад ямар тогтолцоо ашиглаж байгаагаас үл хамааран хамгаалах хөтөлбөрүүд нь хамгаалалт хамгийн их шаардлагатай хүмүүст хүртээмжтэй, түүнийг зохицуулах механизмууд нь бие даасан, ил тод байдлаар, хамгаалуулагчдын бүрэн оролцоотойгоор шударга ажиллах нь чухал юм. Хамгаалах аливаа арга хэмжээг тухайн хүний эрхийг хамгаалагчтай зөвшилцсөн байх ёстой. Түүнчлэн, хууль сахиулах байгууллагын ажилтнууд болон шүүхийн ажилтнууд хүний эрхийг хамгаалагчдад тулгарч буй аюулгүй байдал, аюулгүй байдлын эрсдэлийг олж тогтоох, зохих ёсоор нь шийдвэрлэхэд хангалттай бэлтгэгдсэн, ойлголттой байх шаардлагатай. Итгэлцэл нь аливаа хамгааллын хөтөлбөрийн хэрэгжих урьдач нөхцөл юм. Тиймээс ийм хөтөлбөрт ажиллаж буй албан тушаалтнуудын мэргэшил, шударга байдал нь хүний эрхийг хамгаалагч нар ба эрх баригчдын хоорондын итгэлцлийг хангахад чухал үүрэгтэй юм. Хүний эрхийг хамгаалагч нар ноцтой аюул заналтай тулгарсан үед ерөнхий хамгааллын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор тусгайлан сургасан хууль сахиулах алба хаагчдаас бүрдсэн хангалттай нөөц бүхий ба зорилтот бүлгүүдийг ажиллуулж, бие махбодын аюулгүй байдал болон бусад дэмжлэгийг шуурхай үзүүлэх арга хэмжээ зохион байгуулах хэрэгтэй.
89. Эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдын эрсдэл, аюулгүй байдлын өвөрмөц нөхцөл байдлыг харгалзан НҮБЕА нь эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдыг дэмжсэн цогц, тогтвортой, хүйсийн мэдрэмжтэй төрийн бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхийг уриалав.¹²⁷ Богино болон урт хугацааны хамгааллыг бий болгохын тулд эдгээр бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зохих нөөцийг бүрдүүлэхийн сацуу, үр дүнтэй хамгааллаар баталгаатай хангахын тулд мөн нөөцөө уян хатан, шуурхай зохицуулах боломжийг бүрдүүлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.¹²⁸ Олон нийтийн хамгааллын бодлого, хөтөлбөрүүд нь залуу болон хүүхэд хүний эрхийг хамгаалагч, түүнчлэн эрсдэлтэй хүний эрхийг хамгаалагчдын, тухайлбал үл тэвчих, ксенофобийн (гадаад хүнийг үзэн ядах үзэл) эсрэг тэмцэх зэрэг бусад төрлийн хүний эрхийг хамгаалагчдын тодорхой бэрхшээл, хэрэгцээнүүдийг анхаарч үзэх хэрэгтэй.

127 НҮБЕА-н Тогтоол №A/RES/68/181, заалт №19-г үз.

128 Эх. сурв.

90. Хамгаалах бодлого, хөтөлбөр нь шаардлагатай тохиолдолд хүний эрхийг хамгаалагчдад үзүүлэх тусламж, түүний дотор яаралтай тусламж, орон байр, хүний эрхийн зөрчлийн хохирогчдод сэтгэлзүйн дэмжлэг, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх, хууль эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлэх ёстой.¹²⁹ Мөн бие махбодын хамгаалал, яаралтай нүүлгэн шилжүүлэх зэрэг бодлого, хөтөлбөртэй байх шаардлагатай. Оролцогч улсууд энэ зорилгоор хангалттай хөрөнгө бүрдүүлж, шаардлагатай тохиолдолд олон улсын тусламжийг эрэлхийлэх хэрэгтэй. Тэд мөн ийм үйлчилгээ үзүүлдэг иргэний нийгмийн байгууллагууд болон бусад талыг дэмжиж ажиллах шаардлагатай.
91. Оролцогч улсууд эрсдэлд өртсөн хүний эрхийг хамгаалагчид болон тэдгээрийн байгууллагуудад өөрсдийгөө, чадавхжуулах, чадавхыг бий болгоход нь дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Ингэснээрээ тэдэнд өөрсдийн аюулгүй ажиллагаагаа хангах арга хэмжээ авах, аюулгүй байдлаа сахиулах, хангах, үндэсний болон олон улсын, орон нутгийн болон бүс нутгийн түвшинд эв нэгдлээ бэхжүүлэх, цаг алдалгүй арга хэмжээ авах, дэмжлэгийн сүлжээгээ бий болгох зэрэг арга хэмжээ авах боломж бий болгож өгөх юм.

Б. Хуулийн дарамт, гэмт хэрэгт тооцох, хууль бус дур зоргоор баривчлах, цагдан хорихоос хамгаалах нь

92. “Төрийн байгууллагын бүх үйл ажиллагаа нь эрх зүйт ёсны зарчимд нийцсэн байх ёстой ба улмаар хувь хүний эрх зүйн байдлыг баталгаажуулна”¹³⁰ гэж тунхагласны дагуу оролцогч улсын төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үндсэн зарчим эрх зүйт ёс болохыг дахин баталгаажуулж, улмаар хувь хүнд дур зоргоор болон ялгаварлах гадуурхасан байдлаар хандахыг хориглосон билээ. Үүний дээр оролцогч улсууд “хэнийг ч дур зоргоор баривчлах, албадан саатуулах, нутаг заахаас ангид байлгах” үүрэг амлалт авсан.¹³¹ Сэтгүүлчдийн асуудлыг тусгайлан авч үзээд, тус улсууд “сэтгүүлчдийг дарамталсан, тэдэн рүү дайрсан явдлыг” буруушаан “энэ мэт дайралт, дарамтад буруутай этгээдүүдэд хариуцлага хүлээлгэх” арга хэмжээ авахаар зорьсон.¹³²

129 НУБЕА-н Эмэгтэй эрхийг хамгаалагчдын талаарх тогтоол (A/RES/68/181)-оор улс орнуудад “[...] (b) хүчирхийлэлд өртсөн эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдад зориулсан хамгаалах үйлчилгээ, тэр дундаа хамгаалах байр, сэтгэлзүйн үйлчилгээ, зөвлөгөө өгөх, эмнэлгийн тусламж, хууль эрх зүйн үйлчилгээ зэрэг иж бүрэн үйлчилгээг авах зохих боломжоор хангах зэрэг эмэгтэй хүний эрхийн хамгаалагчдыг үр дүнтэй арга хэрэгслээр хангах бодлого, хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэхийг” уриалсан зүйл №21-ийг үз.

130 Будапешт 1994, “Шийдвэрүүд: VIII. Хүний аюулгүй байдлын хэмжүүр”, заалт №18.

131 Вена 1989, “Европ дахь Аюулгүй байдалтай холбоотой асуудлууд: Зарчмууд”, заалт №23.1.

132 Будапешт 1994, “Шийдвэрүүд: VIII. Хүний аюулгүй байдлын хэмжүүр”, заалт №37.

93. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл улс орнуудад хүний эрхийг дэмжих, хамгаалах үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцохгүй, хүний эрхийг хамгаалагчдыг хүний эрхийн үйл ажиллагаа явуулсных нь төлөө нийтлэг хүний эрхийг эдлэхээс түдгэлзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхийг уриалав. Түүнчлэн, зөвлөл нь аливаа бусад нөхцөлийн хамтаар, хэнийг ч дур зоргоор баривчлахгүй, албадан саатуулахгүй, эрүүгийн болон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг буруугаар ашигласан үйлдэл эсвэл үүгээр айлгасан заналхийлэлд өртүүлэхгүй байх нөхцөлөөр хангахыг оролцогч улс орнуудад уриалсан.¹³³

Гэмт хэрэгт тооцох ба хууль тогтоомжийг дур зоргоор болон гуйвуулж хэрэглэх

94. ЕАБХАБ-ын оролцогч хэд хэдэн улсад хүний эрхийг хамгаалагчдын хүний эрхийг дэмжих, хамгаалах чиглэлээр хууль ёсны үйл ажиллагаа явуулсны төлөө шүүхээр айлган сүрдүүлэх, гэмт хэрэг үйлдсэнд тооцогдох тохиолдол гарсаар байгаа бөгөөд хууль эрх зүйн болон бусад хэлбэрийн дарамтын бай болдог. Энэхүү удирдамжид заасны дагуу “хууль эрх зүйн дарамт” гэдгийг шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон зөрчил мөрдөн шалгах ажиллагааг хууль бусаар явуулах, эсвэл шүүх эрх мэдэл болон мөрдөн шалгах эрх мэдлээ урвуулан ашиглах, хуулийг гуйвуулан хэрэглэж хүний эрхийн үйл ажиллагаанд нь саад учруулах, гутаан доромжлох аливаа хэлбэрийг ойлгоно.
95. Хүний эрхийг хамгаалагчдыг хуулиар дарамтлах, тэдний ажлыг гэмт хэрэгт тооцох явдал нь хэд хэдэн хэлбэрийг агуулдаг. Үүнд: хүний эрхийн хууль ёсны үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцох тодорхой бус хууль тогтоомжийг ашиглан эрүүгийн шийтгэл оногдуулах, ял тохох, худал хэрэг үүсгэх эсвэл хуурамч иргэний нэхэмжлэл гаргах, хөнгөн зөрчилд зохимжгүй шийтгэл оногдуулах болон захиргааны акт, дүрэм, журыг (үүнд: ТББ-ын үйл ажиллагаа, санхүү, татвар эсвэл замын хөдөлгөөний зохицуулалт, хууль, журмыг ашиглах зэрэг багтана) гуйвуулж урвуулан ашиглах орно. Мөн оролцогч зарим улсад хууль сахиулах, тусгай алба, шүүх, төрийн бусад албан тушаалтнууд эрсдэлд буй хүний эрхийг хамгаалагчдын гэр бүлийн гишүүдэд хуулийн дарамт үзүүлсэн гэх тохиолдлуудыг тогтмол мэдээлдэг. Түүнчлэн төрийн бус талууд ч айлган сүрдүүлж, дарамт шахалт үзүүлдэг ба үүнийг нь төр хүлээн зөвшөөрөх эсвэл идэвхтэй дэмждэг. Хуулийн дарамтад оруулж, эрүүгийн хэрэгт татсанаар хүний эрхийг хамгаалагчдыг

133 НҮ-ий Хүний Эрхийн Зөвлөл, Хүний эрхийг хамгаалагчдын хамгааллын тухай тогтоол №A/HRC/RES/22/6, заалт №6 ба 11 (a).

дур зоргоор баривчлах, албадан саатуулах¹³⁴, удаан хугацаагаар шоронд хорих эсвэл бусад шалтгаанаар, тухайлбал, хүчээр сэтгэцийн эмчилгээ хийх зэргээр хариуцлага хүлээлгэж эрх чөлөөг нь хязгаарлах зэрэг хууль бус ажиллагаанд өртөхөд хүргэдэг.¹³⁵

96. Хууль сахиулах болон шүүхийн байгууллагын албан тушаалтнууд зэрэг төрийн байгууллагын төлөөлөгчид арьс өнгөөр, сексист үзэл болон бусад ялгаварлан гадуурхсан хандлага гаргах нь цөөнхийн эрх эсвэл хүйсийн тэгш эрхийн асуудлаар ажилладаг хүний эрхийг хамгаалагчдад чиглэсэн заналхийлэл болон хүчирхийллийг буруутгах, мөрдөн шалгах, шийтгэх чадавх болон улс төрийн хүсэл зоригд нөлөөлж болзошгүй юм.¹³⁶ Эдгээр хүний эрхийг хамгаалагчдыг чиглэсэн эрх баригчдын болон шүүх эрх мэдлийн хавсарсан хуулийн дарамт шахалтад хүргэж болзошгүй. Жендэрт суурилсан хүчирхийлэл, эмэгтэйчүүдийн эрх зэрэг зарим оролцогч орнуудад эмзэг гэж үздэг асуудлаар ажилладаг хүний эрхийг хамгаалагч нар ажлаа хийж явахдаа энэ төрлийн зохисгүй үйлдлүүдтэй тулгарах эрсдэл мэдэгдэхүйц өндөр байна.
97. Дарамтлах, айлган сүрдүүлэх нь дийлэнхдээ хуульд далд хэлбэрээр тусгагсан байж болно. Хүний эрхийг хамгаалагчдыг гэмт хэрэгт татахад хууль тогтоомжийн доорхой, тогтворгүй байдлыг ашиглаж болзошгүй. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч нь “[...] тэдний үйл ажиллагааг гэмт хэрэг болгохын тулд хууль эрх зүйн болон зөрчлийн тухай зүйл заалтын хэрэглэх эсвэл

134 Беларус дахь Хүний эрхийн нөхцөл байдлын асуудал эрхэлсэн НҮБ-ын Тусгай илтгэгч, жишээ нь: “Шүүх хурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэгжилт жигд бус байгаа тухай мэдээллүүдийн зэрэгцээ, хүний эрхийг хамгаалагчдыг байнга айлган сүрдүүлэх, шүүхийн дарамт шахалтад оруулах нь зарим тохиолдолд шоронд хорих ял болон хүнд торгууль ногдуулах хүртэл даамжирч буй” мэдээллүүд байгааг онцолсон. НҮБ-ын Б.Б. А/НRC/23/52, 2013 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр, заалт №92.

135 АИХЭГ-т ирүүлсэн мэдээллээр, хүний эрхийг хамгаалагчдыг чимээгүй болгох үүднээс сэтгэцийн эмнэлэгт албадан хэвтүүлэх үед ихэвчлэн албадан эмчилгээ хийлгэхэд хүрдэг бөгөөд энэ нь хувийн амьдралд хөндлөнгөөс оролцсон хэрэг бөгөөд бие махбодын халдашгүй байдлын эрхийг ноцтой зөрчсөн гэж үзэж болох юм. Жишээлбэл: Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн тусгай илтгэгч зэрэг хэд хэдэн НҮБ-ын Тусгай Удирдлагын төлөөлөх эрхийн төлөөлөгчид Украин болон Казакстаны засгийн газарт гаргасан хамтарсан шуурхай мэдэгдэлдээ хүний эрхийг хамгаалагчдад сэтгэцийн эмчилгээ албадан хийдэг, тэднийг албадан саатуулдаг байж болзошгүй талаар санаа зовниж буйгаа илэрхийлжээ. UKR 2/2013, 2013 оны 7-р сарын 22 <[https://spdb.ohchr.org/hrdb/24th/public_-_UA_Kazakhstan_22.08.13_\(4.2013\).pdf](https://spdb.ohchr.org/hrdb/24th/public_-_UA_Kazakhstan_22.08.13_(4.2013).pdf)>.

136 Доорх “Доромжлол, гадуурхалтай тэмцэх нь” хэсэгт дурдсанчлан, эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдын талаар гаргасан тогтоолдоо НҮБЕА эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдын чухал үүрэг, тэдний үйл ажиллагааны хууль ёсны байдлыг олон нийтийн зүгээс дэмжиж байгаагаа илэрхийлэхээр уригдсан улс төр, цэрэг, нийгмийн болон шашны зэрэг салбараас манлайлагчид элэхдээ: эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хүлцэх арга хэрэгслийн үүрэг гүйцэтгэдэг ялгаварлан гадуурхсан заншил, нийгмийн хэм хэмжээ, эсвэл хэв маягт онцгойлон санаа зовж буйгаа илэрхийлсэн. А/RES/68/181, оршил ба зүйл заалт. 15-г үз.

шүүх эрх мэдлийн тогтолцоог буруугаар ашиглах зэрэг”¹³⁷ хүний эрхийг хамгаалагчдын ажилд хөндлөнгөөс нөлөөлөх арга нь нарийсч төвөгтэй хэлбэрүүдийг ашиглах хандлага байгааг ажиглажээ. Тусгай илтгэгчийн цохон тэмдэглэснээр “энэ арга хэлбэр нь бие махбодын халдашгүй байдалд заналхийлээд зогсохгүй, хүний эрхийг хамгаалагчдын ажлыг сулруулахын зэрэгцээ айдас хүйдэс төрүүлж, нийгэмд айлган сүрдүүлсэн ойлголт өгдөг.”¹³⁸

98. Олон улсын case law буюу жишгийн эрх зүйд хүний эрхийг хамгаалагчдыг дуугүй болгохын тулд хуулийн цоорхойг ашиглах нь хууль бус болохыг нотолж байна. Зөвшөөрөлгүй жагсаал, цуглаан зохион байгуулсан шалтгаанаар захиргааны зөрчлөөр албадан саатуулагдсан нэг хүний эрхийг хамгаалагчийн тохиолдлыг авч үзэхэд дотоодын хууль тогтоомжид нь ийм зөвшөөрөл шаардаагүй тул ЕХЭШ нь энэ эрхийн талаарх хуулийн цоорхой гарсан нь өөр бас бус эрхээс гадна жагсаал, цуглаан хийх эрх чөлөө зөрчигдсэн гэж үзжээ.¹³⁹
99. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч “бүртгэлгүй бүлгүүдийн явуулсан үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцох эвгүй хандлага ажиглагдаж байна” гэж тэмдэглэжээ.¹⁴⁰ Үүгээр ч барахгүй, бүртгүүлэх гэсэн оролдлогуудад нь хэд хэдэн удаа татгалзсан бүлгүүд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах нь эрүүгийн хэргээр шүүхэд татах хялбар бай болж байна. Гадаадаас хүлээн авсан ТББ-ын санхүүжилтэд урьдчилсан зөвшөөрөл шаарддаг оролцогч улсад хүний эрхийг хамгаалагч нар зөвшөөрөл олгох шаардлагыг хангаагүй тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэж болзошгүй юм. Энэ практикийг НҮБ-ын Хүний эрхийн хорооноос зэмлэн буруушааж байгаа бөгөөд төрийн бус байгууллагууд “үйл ажиллагаагаа урьдчилсан зөвшөөрөл, санхүүжилтийн хяналт, төрөөс эрхийг хасах гэх мэт Пактын 22 дугаар зүйл [эвлэлдэн нэгдэх эрх чөлөө] -тэй зөрчилдөхүйц саадгүйгээр үйл ажиллагаагаа явуулах эрхтэй”.¹⁴¹ Үүнтэй адил НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороо ч бүртгэлгүй үйл

137 Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн тусгай илтгэгчийн тайлан, A/HRC/25/55, 2013 оны 12 дугаар сарын 23 -ны өдөр, заалт №59.

138 Эх. сурв.

139 Европын Хүний Эрхийн Шүүх, Украины эсрэг Веренцев, Нэхэмжлэл №20372/110, 2013 оны 4 дүгээр сарын 11-ний дүгнэлтийг үз.

140 Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн тусгай илтгэгчийн тайлан, A/HRC/25/55, заалт №68.

141 “НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны Египетэд хийсэн нэгдсэн дүгнэлт”, НҮБ-ын Б.Б. CCPR/CO/76/EGY, 2002 оны 11 дүгээр сарын 28, заалт №21.

ажиллагаа явуулж буй ТББ-ын гишүүдийг гэмт хэрэг үйлдсэнд тооцдог асуудалд санаа зовниж буйгаа илэрхийлэв.¹⁴²

100. Үүнтэй адил алан хядлага, “шашны хэт даврах үзэл”-ээс урьдчилан сэргийлэх, ял шийтгэхэд чиглэсэн хуулиуд хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцох шалтгаан болох нь олонтоо. Алан хядах ажиллагааг санхүүжүүлэх, мөнгө угаахтай тэмцэх гэсэн нэрийн дор хүний эрхийн бүлгүүдийг дуугүй болгохын тулд ТББ-ын санхүүжилтийн талаар дурдсан хязгаарлалтыг урвуулан ашиглаж байна.¹⁴³ Үндэсний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн тухайд, НҮБ-ын Тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний Тусгай илтгэгч “хүний эрхээ эдлэхэд тавьсан хязгааруудыг зөвтгөхөд ашигладаг үндэсний аюулгүй байдлын тухай тодорхойгүй үзэл баримтлал”-ын хэрэглээ, үзэл баримтлал нь “өргөн цар хүрээг хамарч тодорхойлогдсон, иймээс, төр уг байдлыг хүний эрхийг хамгаалагчид, сэтгүүлчид эсвэл идэвхтнүүд гэх мэт эмзэг байдалтай бүлгүүдэд чиглэсэн үйл ажиллагаануудаа зөвтгөх арга хэрэгсэл болгон урвуулж ашиглахад хялбар” байгаад санаа зовниж буйгаа дахин илэрхийлэв.¹⁴⁴
101. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл алан хядах ажиллагаатай холбоотой гэмт хэргийн тодорхой, хоёрдмол утгагүй тодорхойлолтыг хуульд тусгахын зэрэгцээ алан хядах ажиллагааны сэжигтнүүд шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны туршид хууль ёсны байх баталгаагаар хангуулах шаардлагатайг онцлон тэмдэглэсний сацуу алан хядах ажиллагаатай тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хадгалахад чиглэсэн арга хэмжээнүүдийг цохон дурдаж, ийм арга хэмжээнүүдийг “хүний эрхийг дэмжих, хамгаалахад оролцсон хувь хүн, бүлэг, иргэний нийгмийн байгууллагуудын ажил, аюулгүй ажиллагаанд саад учруулахааргүй

142 “НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хорооны Беларуст хийсэн нэгдсэн дүгнэлт”, ХЭК/С/BLR/CO/3-4, 2011 оны 4 дүгээр сарын 8, заалт №23-24.

143 Жишээлбэл: Тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудал эрхэлсэн тусгай илтгэгчийн тайлан, НҮБ-ын Б.Б. А/HRC/20/27, 2012 оны 5 дугаар сарын 21, заалт №94; ба Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн тусгай илтгэгчийн тайлан, НҮБ-ын Б.Б. А/64/226, 2009 оны 8 дугаар сарын 4, заалт №94-ийг үз.

144 Тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудал эрхэлсэн тусгай илтгэгчийн тайлан А/HRC/23/40, заалт №60-ыг үз.

байлгахыг” уриалав.¹⁴⁵ Иймээс оролцогч улсууд алан хядах ажиллагааг санхүүжүүлэх зэрэг алан хядах ажиллагаатай холбоотой зөрчлүүдийг гэмт хэрэгт тооцоход зориулсан хууль тогтоомжийг улс төрийн зорилгоор эсвэл өөрөөр гуйвуулан хэрэглэх эрсдэлийг багасгахын тулд маш нарийн үгчилж боловсруулах шаардлагатай.

102. Хүний эрхийг хамгаалагчдыг гэмт хэрэгтэнд тооцох, хуулийн дарамттай үр дүнтэй тэмцэх нь хууль сахиулах байгууллагын шударга байдлыг сайжруулах, шүүх, прокурорын тогтолцооны хараат бус байдлыг сайжруулах чиглэлээр төрийн байгууллагуудын хамтын хүчин чармайлт, ажиллагааг шаарддаг. Энэ нь төрийн бус талуудын үйлдсэн айлган сүрдүүлэлт, ялгаварлан гадуурхах сэдэлтэй хүчирхийллийн үйлдлүүдийг нээлттэй буруушаахын сацуу хууль тогтоомжийн эрх зүйн зарчимд нийцсэн тодорхой, шаардлагыг урьдчилан мэдэх боломжтой байдлыг хангах бөгөөд гадуурхагдсан буюу эмзэг байдалтай бүлгүүдийг чадавхжуулна. Энэ чиглэлээр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл “хүний эрхийг хамгаалагчдын ажил, үйл ажиллагаанд нөлөөлж буй хууль тогтоомж, түүний хэрэгжилтийг үр дүнтэй хянахын тулд шүүх засаглалыг хараат бус, шударга, чадамжтай байлгах”-ыг улс орнуудад уриалав.¹⁴⁶

145 “Алан хядлагатай тэмцэх ба үндэсний аюулгүй байдлыг хамгаалахад дараах зүйлсийг анхаарахыг оролцогч орнуудад уриалсан. Үүнд:

- a) олон улсын хууль тогтоомж, ялангуяа хүний эрхийн олон улсын хууль тогтоомжийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлж байгаа бөгөөд хүний эрхийг сурталчлах, хамгаалах үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүн, бүлэг, нийгмийн байгууллагын ажил, аюулгүй ажиллагаанд саад учруулахгүй байх;
- b) алан хядлагатай тэмцэх явцдаа хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах асуудал эрхэлсэн тусгай илтгэгчийн боловсруулсан аргуудыг нэг бүрчлэн анхаарч үзэн, ил тод, урьдчилан тооцоолох боломжтой шалгууруудыг тодорхойлох замаар ямар гэмт хэргийг алан хядах ажиллагаа гэж тооцохыг тодорхой томъёолох;
- c) хүнийг хууль ёсны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баталгаагүйгээр албадан саатуулах, албадан саатуулагдсан хүнийг хууль ёсны хамгаалалтаас гадуур байлгах, эсвэл эрх чөлөөг хууль бусаар хязгаарлах, алан хядах ажиллагаанд сэжиглэгдэж буй этгээдүүдийг хууль бусаар шилжүүлэх зэрэг байдлаар эрх чөлөөг хязгаарлах, эсвэл сэжигтнүүдийг шүүхийн хууль ёсны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн баталгаагүйгээр хууль бусаар амьд явах, шүүхээр шүүлгэх эрхийг хязгаарлах зэрэг нөхцөлд байдалд хүргэхийг хориглох, ийм нөхцөл бий болгохгүй байх, эсвэл ийм үр дагавар үүсгэхгүй байх;
- d) алан хядлагын эсрэг болон үндэсний аюулгүй байдалтай холбоотой бусад хууль тогтоомжийн дагуу албадан саатуулагдаж байгаа хүмүүст холбогдох олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, байгаа бол дотоодын хүний эрхийн үндэсний институтүүдтэй холбогдох зохих боломжийг олгож, үндэсний аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомжийн дагуу албадан саатуулагдагсад болон яллагдагчдад хууль зүйн туслалцаа үзүүлсэн хүний эрхийг хамгаалагч нар дарамтад өртөх, хууль шүүхээр шийтгүүлэхгүй байхад анхаарах” тухай Хүний Эрхийн Зөвлөл, Хүний эрхийг хамгаалагчдын хамгааллын тухай тогтоол №A/HRC/RES/22/6, заалт №10-ыг үз.

146 A/HRC/RES/22/6, заалт №11 (b)-г үз.

103. Прокурор болон хууль сахиулах байгууллагуудаа үйл ажиллагаандаа ёс суртахууны дээд хэм хэмжээг сахиулах чадавхыг бэхжүүлэх талаар хүчин чармайлт гаргах хэрэгтэй. Ялангуяа, оролцогч улсууд буруутай үйлдлүүдийг нэн даруй илрүүлж, бие даан шалгаж, зохих сахилгын шийтгэл ногдуулах эсвэл ийм зөрчил гаргасан тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэж ажиллахын тулд цагдаагийн байгууллагын иргэний хяналтын зөвлөл гэх мэт дотоод, гадаадын хяналтын механизмыг хөгжүүлэх ажлыг чухалчлах хэрэгтэй. Шүүхийн дарамт шахалт, бусад зөрчил болон хүний эрхийг хамгаалагчдын нийгэм дэх чухал үүрэг, тэдний үйл ажиллагааны үр дүнд учирч буй тодорхой эрсдэл, хамгааллын хэрэгцээний талаар мэдлэг, мэдээлэл олгох зорилгоор хууль сахиулах, шүүх засаглалын болон бусад холбогдох албан тушаалтнуудыг сургах шаардлагатай. Ялгаварлан гадуурхагдсан эсвэл бусад эмзэг нөхцөл байдалтай хүмүүсийн эрхийг дэмжих, хамгаалах чиглэлээр ажиллаж буй хүний эрхийг хамгаалагчдыг дарамтлах явдлыг таслан зогсоохын тулд хууль сахиулах байгууллагын ажилтнууд болон төрийн албан хаагчдын дунд тархсан хор хөнөөлтэй хэвшмэл ойлголттой тэмцэх, ялгаварлах сэдэлтэй гэмт хэрэг болон хүйсийн хүчирхийллийн тохиолдлуудыг далайцтай мөрдөн шалгах явдлыг хөхиүлэн дэмжихэд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй.
104. Хүний эрхийг зөрчсөн хэргээр аливаа байгууллага, хувь хүний эсрэг нэхэмжлэл гаргаж буй хүний эрхийг хамгаалагчдын нэр төрд хүндэтгэлтэй хандаж, хариу арга хэмжээний шинжтэй ял тулгах, дур мэдэн шүүх болон бусад хуулийн ажиллагаанд өртөхөөс үр дүнтэй хамгаалах хэрэгтэй. Энэ нь, ялангуяа, гадуурхагдсан буюу эмзэг нөхцөл байдалтай бүлэгт хамаарах хүмүүсийн төлөөлж оролцож буй эсвэл шүүхийн албан тушаалтан, хариуцагчийн өмгөөлөгчийн зүгээс хууль бус хэтэрхий хувийн, доромжилсон эсвэл түрэмгий асуулт тавьж болзошгүй зэрэг байдалтай хүний эрхийн стратегийн өмгөөлөл хийж буй хүний эрхийг хамгаалагчдын хувьд онцгой ач холбогдолтой юм. Үндэстэн, угсаатны, шашин шүтлэг, хэлний цөөнхөд харьяалагддаг этгээдийг өмгөөлж буй “мэргэжлийн чиг үүргээ гүйцэтгэж буй хуульч, өмгөөлөгчид аливаа дарамт эсвэл хариуцлага хүлээлгэх эсвэл хүлээлгэхээр айлган сүрдүүлж болохгүй.”¹⁴⁷ Үүнтэй адилаар хүний эрх зөрчигдсөн талаар төрийн албан тушаалтан эсвэл байгууллагын эсрэг мэдүүлэг өгсөн гэрчийг аливаа дарамт шахалтаас ангид байлгахар хамгаалах ёстой.

147 “Сайд нарын Хорооны Арван дөрөвдүгээр уулзалтын баримт бичиг”, Эрүүгийн хэргийн шүүхийн тогтолцооны тухай Брюсселийн тунхаглал, 2006-г үз.

Дур зоргоор албадан саатуулах, албадан саатуулах үеийн харьцаа

105. ИУТЭОУП-ын 9 дүгээр зүйл, ХЭҮЭЧК-ын 5 дугаар зүйл, ХЭАК-ын 7 дугаар зүйлд хүний эрх чөлөө, аюулгүй байдал, дур зоргоор албадан саатуулахаас урьдчилан сэргийлэх үндсэн хамгаалалтыг тусгасан болно. Дур зоргоор албадан саатуулахтай холбоотой асуудал хариуцсан НҮБ-ын ажлын хэсгийн аргачлалын дагуу, өөр бусад асуудлаас гадна, эрх чөлөөг хязгаарласан тохиолдолд “эрх чөлөөг хязгаарласныг зөвтгөх эрх зүйн үндэслэл байх боломжгүй нь илт”, итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх, түүнчлэн Хүний эрхийн түгээмэл тунхаглал ба ИУТЭОУП-д заасан бусад үндсэн эрх, эрх чөлөөг эдэлсний төлөө эрх чөлөөг хязгаарласан бол дур мэдэн хязгаарласан гэж үзэх, мөн “шударга шүүхийн эрхэд хамаарах олон улсын хэм хэмжээг бүхэлд нь буюу хэсэгчлэн дагаж мөрдөхгүй байх [...] гэх мэт харгалзан үзэх нөхцөлүүд нь эрх чөлөөг дур зоргоор хассан гэж үзэхэд хүргэх хүчин зүйлст тооцогдоно.”¹⁴⁸ Албадан саатуулах бусад хэлбэрүүдээс гадна, эрх чөлөөг хязгаарлах тохиолдлуудад урьдчилан хорих, ял шийтгэсний дараа шоронд ял эдлүүлэх, гэрийн хорионд оруулах, албадан эмнэлэгт хэвтүүлэх эсвэл сэтгэцийн эмнэлэгт эмчлүүлэх зэрэг орно.
106. Олон улсын стандартын дагуу албадан саатуулах ажиллагааг эрх бүхий хуулийн байгууллагын зөвшөөрлөөр явуулах ёстой ба албадан саатуулагдсан хүмүүс хууль зүйн зөвлөгөө авах, уг албадан саатуулах ажиллагааны хууль ёсны эсэхэд гомдол гаргах эрхээ саадгүй эдлэх боломжтой байх шаардлагатай. НҮБ-ын Хүний эрхийн хорооноос онцолсноор энэ зарчим нь эрүүгийн хэрэгт холбогдсон эсэх, эсхүл сэтгэцийн өвчин, тэнүүчлэл, мансууруулах бодисын хамаарал, боловсролын зорилгоор эсвэл цагаачлалын хяналт гэх мэт болон аливаа бусад үндэслэлээр шийтгэгдсэн эсэхээс үл хамааран баривчлагдах эсвэл албадан

148 Ажиллах арга барил, “Хувь хүний нэхэмжлэл, яаралтай давж заалдах нэхэмжлэл”, Дур зоргоор албадан саатуулах тухай асуудал хариуцсан ажлын хэсгийн талаарх мэдээллийг <<http://www.ohchr.org/EN/Issues/Detention/Pages/Complaints.aspx>>-с үз. Хоёр дахь ангиллын хэргүүдийн тухайд Ажлын хэсэг нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 7, 13, 14, 18, 19, 10, 21-р зүйл, гэрээнд оролцогч улсуудын хувьд, Улс төрийн эрхийн олон улсын пактын 12, 18, 19, 21, 22, 25, 26, 27-р зүйлээр тус тус баталгаажуулсан эрх, эрх чөлөөг хэрэгжүүлсний төлөө эрх чөлөөг хасахыг дур зоргын гэж үзнэ.”

саатуулагдах замаар эрх чөлөөгөө хасуулсан бүх хүмүүст хамаарна.¹⁴⁹ Ерөнхийдөө оролцогч улсууд өөр бусад шийтгэлийн хэлбэрүүдийг бүрэн дүүрэн ашиглах ёстой бөгөөд хөнгөвтөр гэмт хэргүүдэд албадан саатуулах арга хэмжээ авахаас татгалзах хэрэгтэй.

107. Өөрсдийн болон бусдын хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд оролцдог зэвсэгт хүчний алба хаагчид ч дур мэдэн албадан саатуулагдахаас урьдчилан сэргийлэх үндсэн хамгаалалтыг эдлэх ёстой.¹⁵⁰ Хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаатай холбоотойгоор сахилгын эсвэл эрүүгийн хэргээр шийтгүүлсэн зэвсэгт хүчний болон хууль сахиулах алба хаагчдад шударга сонсгол, хараат бус байгууллагад давж заалдах боломжийг олгох ёстой. Тэд шударга ёсны үндэслэлгүйгээр баривчлагдах, албадан саатуулагдах ёсгүй.
108. Хүний эрхийг хамгаалагчдыг хууль бус албадан саатуулагдсан гэж үзвэл тэр даруй болон болзолгүйгээр суллаж, зохих нөхөн төлбөр өгөх ёстой. Оролцогч улсууд олон улсын шүүхийн шийдвэр, тухайлбал, Европын холбооны хүний эрхийн шүүхийн шийдвэр, түүнчлэн дур зоргоор албадан саатуулах тухай асуудал хариуцсан НҮБ-ын ажлын хэсэг, НҮБ-ын Хүний

149 НҮБ-ын Хүний Эрхийн Хороо, ерөнхий тайлбар №8, 9-р зүйл, “Эрх чөлөө, хүний аюулгүй байдлын эрх”, 1982 оны 6-р сарын 30, заалт №1-ийг үз. Хүний Эрхийн Хороо 9-р зүйлд шинэ ерөнхий тайлбар боловсруулж байна. Одоо мөрдөгдөж байгаа төсөлд зааснаар “эрх чөлөөг боогдуулсан үйлдлүүдийн жишээнд албадан саатуулах, цагдан хорих, ял шийтгэсний дараа шоронд хорих, гэрээр баривчлах, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх, нисэх онгоцны буудлын тусгай бүсэд саатуулах, түүнчлэн хүчээр тээвэрлэх зэргийг оруулсан байна.” Ерөнхий тайлбар № 35, НҮБ-ын Б.Б. ССРР/С/107/R.3, 2013 оны 1-р сарын 28, заалт №6. Ерөнхий тайлбар №8-д заасны дагуу 9 дүгээр зүйлд заасан баталгаа нь урьдчилан хорих байранд ч хамаарна. Заалт №4-ийг үз.

150 Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны Зөвлөлийн CM/Res (2010) 4 дүгээр зөвлөмжид зааснаар, ХЭҮЭЧК-н 5(1) дүгээр заалт, хуульд заасан журмаас бусад тохиолдолд Зэвсэгт хүчний гишүүний эрх чөлөөг хасах ёсгүй. Баривчилсан, эсвэл албадан саатуулсан бол тэднийг баривчилсан, эсвэл албадан саатуулсан шалтгаан, тэдэнд тулгаж буй ял, процессийн эрхийнх нь талаар өөрсдөд нь нэн даруй мэдэгдэх ёстой. Цаашлаад, эрх чөлөөгөө хасуулсан зэвсэгт хүчний алба хаагч албадан саатуулагдсаныхаа хууль ёсны байдлыг шүүхээр хянан хэлэлцүүлэх эрхтэй. 5-р зүйлийн 1-д заасны дагуу эрх чөлөөг хязгаарлах хэмжээний сахилгын шийтгэл, арга хэмжээ нь энэ заалт (Зөвлөмжийн хавсралт, 22-27-р зүйл)-ын шаардлагыг хангах ёстой. Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухайд, уг зөвлөмж нь цэргийн сахилгын хариуцлага шударга байх ёстой бөгөөд хууль ёсны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баталгааг хангаж; зөвхөн цэргийн сахилга бат, дэг журам, аюулгүй ажиллагаа, эсвэл аюулгүй байдалд заналхийлж болзошгүй үйлдлүүдийг сахилгын зөрчил гэж тодорхойлж болох ба сахилгын зөрчил гаргасан хэрэгт шийтгүүлж буй зэвсэгт хүчний алба хаагчдад буруутгаж буй үндэслэлийн мөн чанар, шударга сонсгол хийлгэх (Шударга шүүхээр шүүлгэх эрхийн талаарх ХЭҮЭЧК-ын 6 дугаар зүйл энд хамаарна) эрхтэйг нь нэн даруй, дэлгэрэнгүй мэдээлэх ёстой ба, мөн тэд илүү дээд шатны, хараат бус байгууллагад давж заалдах боломжтой байх ёстой (17, 21-р зүйлийг үзнэ үү). Цаашилбал, зэвсэгт хүчний алба хаагчийн эсрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа шүүх эрх мэдлийн байгууллагын хараат бус, шударга байдлыг хангахын тулд прокурорын байгууллага болон шүүхийн шийдвэрийг гардуулж буй хүмүүсийн хооронд тодорхой зааг байх ёстой. Сайд нарын хорооноос гишүүн орнуудад гаргасан 2010 оны 2-р сарын 24-ний өдөр батлагдсан Зэвсэгт хүчний алба хаагчийн хүний эрхийн асуудлаарх Зөвлөмж №СМ/Res (2010)4-ийг үз.

эрхийн хороо зэрэг хагас-шүүхийн байгууллагуудын санал дүгнэлтийг цаг тухайд нь бүрэн хэрэгжүүлэх ёстой.

109. Эрх чөлөөгөө хасуулсан хүний эрхийг хамгаалагч нар хүнлэг ёсоор хандуулах, нэр төрөө хүндэтгүүлэх эрхтэй.¹⁵¹ Уг нөхцөлийг хангахын тулд албадан саатуулах байрны нөхцөл нь тэднийг хүнлэг бус, доромжилсон байдалд оруулахааргүй байх ёстой. Эрх чөлөөгөө хасуулсан хүний эрхийг хамгаалагчдын хүний эрхийн төлөө хийсэн ажлынх нь шийтгэл маягаар ялгаварлан гадуурхах эсвэл тийм албадан саатуулах нөхцөлд байлгах ёсгүй. Тэднийг эрүүдэн шүүх, бусад зүй бус харьцаа, бусад хоригдлуудын болзошгүй хүчирхийллээс найдвартай хамгаалах ёстой. Эрх чөлөөгөө хасуулан хоригдсон хүний эрхийг хамгаалагчидтай харьцах харьцаа нь НҮБ-ын Ялантай харьцах жишиг дүрэм, Аливаа төрлийн албадан саатуулах байранд эсвэл шоронд байгаа бүх хүнийг хамгаалах гол зарчмууд, Ялантай харьцах үндсэн зарчимд нийцэх ёстой.¹⁵²
110. Эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдыг албадан саатуулах үед тулгарч болзошгүй тодорхой бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд оролцогч улс хүйсийн хүчирхийллээс хамгаалах арга хэмжээг авч, НҮБ-ын Эмэгтэй хоригдол болон эмэгтэй гэмт хэрэгтэнтэй харьцах албадан саатуулах бус арга хэмжээний дүрмийн дагуу үйлчилгээ үзүүлэх ёстой (Бангкокийн дүрэм).¹⁵³ Үүнтэй адил оролцогч улсууд хүчирхийлэл болон бусад зүй бус үйлдэлд өртөх өндөр эрсдэлтэй хүний эрхийг хамгаалагчдын бусад бүлгүүдийн хэрэгцээг хангах арга хэмжээ авах ёстой.¹⁵⁴

Шударга шүүх

111. ИУТЭОУП-ын 14 дүгээр зүйл, ХЭҮЭЧК-ын 6 дугаар зүйл, ХЭАК-ын 8 дугаар зүйлд заасны дагуу эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдаж байгаа хүн бүхэн хууль ёсны, хараат бус шударга шүүх, олон нийтийн сонсголоор шүүлгэх эрхтэй. Шүүхээр гэм буруутай нь нотлогдоогүй л бол хэнийг ч гэмгүйд

151 ИУТЭОУП-ын Зүйл №10-ыг үз.

152 1955 онд Женев хотод болсон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтнүүдтэй харьцах тухай НҮБ-ын Нэгдүгээр чуулганаар баталж, Эдийн Засаг, Нийгмийн Зөвлөлийн 1957 оны 7-р сарын 31-ний 663 С (XXIV), 1977 оны 5-р сарын 13-ны 2076 (LXII) тогтоолоор зөвшөөрсөн “Ялантай харьцах жишиг дүрэм” ба Ерөнхий Ассамблейн 1990 оны 12-р сарын 14-ний өдрийн 45/111 тогтоолоор батлан тунхагласан “Хоригдлуудтай харьцах үндсэн зарчим”.

153 НҮБ-ын 2010 оны 12-р сарын 21-ний өдрийн A/RES/65/229-р тогтоолоор батлагдсан “Эмэгтэй хоригдлуудтай харьцах, эмэгтэй хоригдлуудад албадан саатуулах бус арга хэмжээ авах НҮБ-ын дүрэм (Бангкокийн дүрэм)”.

154 Үүнд, тэдний бэлгийн чиг хандлага, хүйсийн онцлог, хүйсийн илэрхийлэл зэргийг багтаана. Жишээлбэл, НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газар, “Тусгай хэрэгцээтэй хоригдлуудын талаарх гарын авлага”, 2009, <http://www.unodc.org/documents/justice-and-prison-reform/Prisoners-with-special-needs.pdf>; ЛГБТИ хүмүүсийн талаарх тодорхой зөвлөмжийг 119-122-р хуудаснаас үзнэ үү.

тооцох ёстой. Цаашилбал ИУТЭОУП-ын 14 дүгээр зүйлд, бусад зүйлсийг үл дурдан дараах зүйлсийг заасан байдаг. Үүнд: оногдуулсан ялын мөн чанар, шалтгааныг цаг тухайд нь нарийвчлан мэдэх эрх, өмгөөлөх бэлтгэлийг хангахад хангалттай цаг хугацаа, боломжоор хангуулах эрх, өөрийн сонгосон өмгөөлөгчийг авах эрх, шаардлагатай бол үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрх, шүүхийн үйл ажиллагаанд өөрийн биеэр байлцах эрх, өөрийн нэрийн өмнөөс гэрч дуудах, шалгах эрх, өөрийгөө өмгөөлөх, өөрийн эсрэг мэдүүлэг өгөхийг тулгахаас ангид байх, гэм буруугаа хүчээр хүлээхээс ангид байх эрх орно.¹⁵⁵

112. Ял шийтгүүлж буй хүний эрхийг хамгаалагч нар олон улсын хүний эрхийн хууль тогтоомж, ЕАБХАБ-ын холбогдох үүрэг амлалтын дагуу шударга шүүх, шүүн таслах ажиллагааны бүрэн хамгаалалтыг авах эрхтэй.¹⁵⁶ Шударга шүүхийн зарчим зөрчигдсөн тохиолдолд үр дүнтэй залруулах арга хэмжээ, зохих нөхөн төлбөрийг авах эрхтэй. Ялангуяа шударга шүүх хуралдаанд оролцох эрхийг эрс зөрчиж байгаа эрүү шүүлт зэрэг гэм бурууг хүчээр хүлээлгэсэн тухай гомдлыг нэн даруй, үр дүнтэй, хараат бус, хөндлөнгийн байдлаар мөрдөн шалгаж, аливаа нотлох баримт, түүний дотор эрүүдэн шүүх болон бусад зүй бус аргаар олж авсан гэрчийн мэдүүлэг гэх мэт нотлох баримтын зүйлийг ашигласан үйлдлийг шүүх ажиллагаанаас шүүгч татах ёстой.¹⁵⁷
113. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл “эргэлзээтэй нотлох баримт ашиглах, хууль бус мөрдөн шалгах ажиллагаа явуулах ба процессийн алдаа гаргах зэргээс урьдчилан сэргийлэхийн тулд хүний эрхийг хамгаалагчдын эсрэг үүсгэсэн эрүүгийн хэрэг зэрэгт олон улсын хүний эрхийн хууль тогтоомжид нийцсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах, хууль ёсны эсэхийг хамгаалах замаар бүх үндэслэлгүй хэргийг хурдан шуурхай хаах, иргэдийн

155 Зүйл №14 (3) -г үз.

156 Жишээлбэл: Вена 1989; Копенхаген 1990; Любляна 2005; ба Хельсинки 2008.

157 Хүний эрхийн олон улсын механизмууд нь хүний эрхийг хамгаалагчдаас мэдүүлэг авахын тулд эрүүдэн шүүсэн хэд хэдэн тохиолдол гарсанд санаа зовж буйгаа илэрхийлсэн. Тухайлбал, Киргиз улсад томилолтоор ажилласныхаа дараа НҮБ-ын Эрүүдэн шүүлт болон бусад хэлбэрийн хэрцгий, хүнлэг бус буюу хүний нэр төрийг доромжилсон харьцаа ба шийтгэлийн асуудал эрхэлсэн тусгай илтгэгч хэлэхдээ: “Албадан саатуулагдах үед нь түүнийг болон бусад шүүгдэгчдийг тарчлаан тамласнаас гадна, мэдүүлгийг эрүүдэн шүүх замаар гаргуулсан гэж мэдэгдсээр атал 2010 оны 6-р сард гарсан үймээний хэрэгт буруутган шүүсэн нэрт хүний эрхийг хамгаалагч Азимжан Аскарлов болон бусад яллагдагчдад насаар нь хорих ял шийтгэснийг хэвээр баталсан Улсын дээд шүүхийн 2011 оны 12-р сарын 20-ны өдрийн шийдвэр нь хамгийн дээд шатны шүүхийн байгууллага эрүү шүүлт, зүй бус үйлдлийн талаарх мэдэгдэлд зохих арга хэмжээ авч чадаагүйн жишээ юм. Тамлан зовоосон ёс бус үйлдлүүдийг нь гэрчилсэн эмнэлгийн баттай нотолгоо байсаар атал хохирогчийг эрүүдэн шүүсэн хэргээр яллагдагчаар татагдсан дөрвөн цагдааг цагаатгасан доод шатны шүүхийн тогтоолыг хэвээр баталсан Дээд шүүхийн 2011 оны 12-р сарын 9-ний өдрийн шийдвэр нь шүүхийн байгууллагын итгэл алдармаар байдлын нэг жишээ боллоо.” гэжээ. А/HRC/19/61/Add.2, 2012 оны 2-р сарын 21-ний заалт №49-г үз.

холбогдох эрх бүхий байгууллагад гомдол гаргах боломжид үр дүнтэй хувь нэмэр оруулахыг”¹⁵⁸ уриалсан.

114. ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтуудынхаа дагуу оролцогч улсууд цаашид шүүх гаднын нөлөөтэй, улс төрийн сэдэлтэй шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах эсвэл өрөөсгөл дүгнэлт, шийдвэр гаргах эрсдэлийг багасгахын тулд шүүхийн хараат бус байдлыг улам бэхжүүлэх хэрэгтэй. Ялангуяа оролцогч улсууд шударгаар шүүлгэх эрхийн практик хэрэгжилтэд хяналт тавих механизм болгон шүүх хуралдаанд ажиглагч оролцохыг зөвшөөрөх, дэмжих хэрэгтэй. Үүнтэй холбогдуулан оролцогч улс орнууд “итгэлцлийг бий болгох хэмжүүр болгон оролцогч улсууд, төрийн бус байгууллага болон бусад сонирхсон хүмүүсийн төлөөллийг шүүхийн процесс, хуралдаануудад байлцуулах”-ыг зөвшөөрөх шийдвэр гаргасан.¹⁵⁹ Түүнчлэн “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь зөвхөн хуульд заасан нөхцөлд, олон улсын хууль тогтоомж, олон улсын өмнө хүлээсэн үүрэгтэй нийцэж байгаа тохиолдолд л камерын өмнө явагдах боломжтой гэж ойлгож болно”¹⁶⁰ гэж мэдэгдсэн. Үүний дагуу, процессын ил тод байдлыг хангах үүднээс шүүх хуралдааны хуваарь болон шүүхийн шийдвэр болон бусад холбогдох баримт бичгийг олон нийтэд нээлттэй гаргах үүрэгтэй.

В. Доромжлол, гадуурхалтай тэмцэх нь

115. Хувь хүмүүс, бүлэг, байгууллага болон институтүүдийн идэвхтэй оролцоо нь өөрсдийн хамтын зорилго, зорилтууддаа хүрч, үргэлжлүүлэн ахиц дэвшил гаргахад чухал үүрэг гүйцэтгэдэг гэдгийг оролцогч улсууд хүлээн зөвшөөрсөн. Эдгээр зорилтууд нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн хамгаалах, эдлүүлэх нөхцөл байдлыг бэхжүүлэхэд оршино. Түүнчлэн оролцогч улсууд “хүний эрх, үндсэн эрх чөлөөг дэмжих, хамгаалахад бие даан эсвэл бусадтай хамтран идэвхтэй оролцох иргэдийнхээ эрхийг хүндэтгэх”¹⁶¹ мөн “хүн бүрийн бие даан эсвэл бусадтай хамтран хүний эрх, үндсэн эрх чөлөөний талаарх үзэл бодлоо илэрхийлэх, мэдээллийг олж авахтүүнчлэн тэдгээр үзэл бодол, мэдээллийг түгээх, нийтлэх зэрэг эрхийг” хүндэтгэх үүрэг хүлээсэн.¹⁶²
116. НҮБ-ын тунхаглалд хүн бүр төрийн бус эсвэл засгийн газар хоорондын байгууллагатай холбоо тогтоох (5 (с) зүйл), бие даан, эсвэл бусадтай хамтран энх тайван аргаар хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих,

158 НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн Тогтоол №A/HRC/RES/22/6, заалт №11 (с)-г үз.

159 Копенхаген, 1990, заалт №12.

160 Эх. сурв.

161 Вена 1989, “Европ дахь Аюулгүй байдалтай холбоотой асуудлууд: Зарчмууд”, заалт №13 (5).

162 Копенхаген 1990, заалт № (10.1).

хамгаалахад ашиглах зорилгоор мэдээллийн эх үүсвэр авах хүсэлт гаргах, хүлээн авах, ашиглах эрхийг (13 дугаар зүйл) дахин баталгаажуулж өгсөн.

117. Олон оронд эдгээр болон бусад үүрэг амлалтыг үл харгалзан, хүний эрхийг хамгаалагч нар эдгээр эрх, үйл ажиллагааг хэрэгжүүлснийхээ төлөө гутаан доромжлуулсан хэвээр байна.¹⁶³ Ихэвчлэн эрх баригчдыг шүүмжилж, олонхын үзэл бодлыг сорьдог тул хүний эрхийн ажлыг улс төрийн ажил буюу улс төрийн сөрөг хүчний үйл ажиллагаа гэж үздэг. Гэсэн хэдий ч олон улсын стандартын дагуу хувь хүн төрийн эрхийг хэрэгжүүлэхэд оролцох, тэр дундаа хүний эрхийг хамгаалах ажлыг хэрхэн бэхжүүлэх талаарх шүүмжлэл, саналыг эрх баригчдад хүргүүлэх эрхтэй. Олон нийтийн санаа бодол, шийдвэр гаргахад нөлөөлөх үйл ажиллагаа нь хүний эрхийн ажлын чухал хэсэг бөгөөд хүний эрхийн хэрэгжилтийг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс хүний эрхийн ажлыг улс төрийн намуудын партизан үйл ажиллагаатай андуурч болохгүй. Үүний оронд оролцогч улсууд хүний эрхийн ажлын ач холбогдол, хууль ёсны байдлыг хүлээн зөвшөөрөх ёстой.
118. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн тусгай илтгэгч хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагааг хууль бусад тооцохын тулд төрийн дайсан буюу алан хядагчид гэж нэрлэдэгт санаа зовниж буйгаа илэрхийлсэн.¹⁶⁴ ЕАБХАБ-ын бүс нутагт хүний эрхийг хамгаалагчдыг хэт даврагч, урвагч, тагнуул гэж нэрлэх, төрийн удирдлагыг түлхэн унагаах зорилготой хэмээн үйл ажиллагааг нь гутаах эсвэл хүний эрхийг хамгаалагчдыг гэмт хэрэгтнийг хамгаалсан гэж буруутгах эсвэл өөрсдийг нь гэмт хэрэгтэн гэж буруутгах зэрэг нийтлэг оролдлогууд гардаг.
119. ЕЗПА “тухайн байгууллагын хэд хэдэн гишүүн оронд хүний эрхийг хамгаалагч нарын эсрэг гутаан доромжлох зорилготой гүтгэлгийн кампанит ажил эсвэл эх оронч бус, урвагчид, ‘тагнуулчид’, ‘хэт даврагчид’ гэж дуудуулах явдалтай учирч байгаа”-д санаа зовниж буйгаа илэрхийлсэн.¹⁶⁵ Түүнчлэн ЕЗПА гишүүн улс орнуудаа хүний эрхийг

163 Тухайн үед Ерөнхий нарийн бичгийн даргын Тусгай төлөөлөгч байхдаа 2001 онд НҮБЕА-д илгээсэн хүний эрхийг хамгаалагчдын талаар хийсэн анхны тайландаа тэрээр “Хүний эрхийг хамгаалагчдын ажлыг унагах зорилгоор харлуулах кампанит ажил явуулах нь улам бүр түгээмэл болсон” гэж мэдэгджээ. Хүний эрхийг хамгаалагчдыг гутаан доромжлох аргууд бүр ч илүү нарийн боловсронгуй болсон ч энэ үеийнхээс тийм ч өөрчлөгдөөгүй. Ерөнхий нарийн бичгийн даргын хүний эрхийг хамгаалагчдын асуудал эрхэлсэн Тусгай төлөөлөгч Хина Жилани, НҮБ-ын Б.Б. 2001 оны 9-р сарын 10-ны А/56/341, заалт №36-40.

164 Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн тусгай илтгэгчийн /HRC/25/55, 2013 оны 12 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан, заалт №86-г үз.

165 2009 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан Европын Зөвлөлийн гишүүн улсууд дахь хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын тухай ЕЗПА-н 1660 (2009) тоот Тогтоолын, заалт №4-г үз.

хамгаалагчдыг “хэт даврагч эсвэл гадаад хүчний ‘гадаадын төлөөлөгч’ хэмээн үндэслэлгүй буруутгахаа зогсоохыг уриалав.”¹⁶⁶

120. ЕАБХАБ-ын оролцогч хэд хэдэн улсад санхүүжилт авдаг, эсвэл мэргэжлийн түвшинд үйл ажиллагаагаа явуулдаг хүний эрхийг хамгаалагчдыг хүний эрхийн сэдлээр гэхээсээ илүү санхүүгийн ашиг олдог гэсэн үндэслэлээр нэлээд өргөн хүрээнд гутаан доромжлох, харлуулах кампанит ажлуудыг явуулдаг. Түүнээс гадна, зарим оролцогч улс орнуудад, жишээлбэл: гадаадын санхүүжилт авдаг хүний эрхийг хамгаалагчдыг ‘гадаадын төлөөлөгч’ гэж тодорхойлсон хууль тогтоомжийг батлах замаар хүний эрхийн ажлын утга учрыг алдагдуулдаг.¹⁶⁷ Ийм хуулийг хүний эрхийг хамгаалагчидтай зөвшилцөж хянан үзэх хэрэгтэй ба шаардлагатай бол нэмэлт, өөрчлөлт оруулах эсвэл хүчингүй болгох хэрэгтэй.
121. Хүний эрхийг хамгаалагч нар эсвэл тэдгээрийн байгууллагуудын нэр хүнд, байгууллагын итгэлтэй байдлыг алдагдуулсан мэдээллийг хэвлэлээр болон бусад аргаар цацагддаг зохион байгуулалттай харлуулах кампанит ажил, бусад хэлбэрийн гутаан доромжлох ажиллагааны бай болж байна. Жишээлбэл эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдыг гутаан доромжлохын тулд хүйсийн хэвшмэл ойлголтуудыг байнга ашигладаг.¹⁶⁸ Хууль, практикт эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг НҮБ-ын Ажлын хэсэг эмэгтэй хүний эрхийг хамгаалагч нар цахим дарамт, заналхийлэл, хүйсээр

166 2012 оны 6 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан 1891 (2012) тоот ЕЗПА-н Тогтоолын заалт №5.8-ыг үз.

167 Оросын ТББ-ын тухай хууль тогтоомжийн талаарх үзэл бодлоо илэрхийлэхдээ Европын Зөвлөлийн Хүний эрхийн комиссар, жишээлбэл: “гадаадын төлөөлөгчийн газар” гэх нэр томъёог хэрэглэсээр буй нь иргэний нийгмийг гадуурхан үзэхэд хүргэх бөгөөд иргэний нийгмийн үйл ажиллагаанд “хор хөнөөлтэй” үр дагавар учруулж: энэ нь оросын түүхэнд ихэвчлэн ‘гаднын тагнуул’ ба/буюу ‘урван тэрслэгч’ гэсэн утгаар ойлгогддог бөгөөд улмаар ялгаварлах, эсвэл гадуурхах хандлага ч үүнтэй дагалддаг учраас “гадаадын төлөөлөгчийн газар” (иностранный агент) гэдэг нэр томъёоны хэрэглээ нь Гадаадын төлөөлөгчийн газрын тухай хуульд харьяалагдах байгууллагуудад онцгой санаа зовоосон асуудал болж байна.” гэснийг үз. Европын Зөвлөлийн Хүний эрхийн комиссарын Оросын Холбооны улсын арилжааны бус байгууллагын тухай хууль тогтоомжийг Европын Зөвлөлийн стандартуудын хүрээнд нягталж үзсэн тухай үзэл бодлыг CommDH(2013)15, 2013 оны 7 дугаар сарын 15, <<https://wcd.coe.int/ViewDoc.jsp?id=2086667>>, заалт №57 ба 80-аас үз. Сөрөг коннотаци агуулдаг “гадаадын төлөөлөгчийн газар” гэдэг нэр томъёоны тухайд, мөн Хуулиар ардчиллыг сахиулах Европын Хорооны (Венецийн хороо), ба ЕАБХАБ-ын Ардчилсан институт ба Хүний эрхийн Газар (ЕАБХАБ/АИХЭГ)-ын “Бүгд Найрамдах Киргиз улсын Арилжааны бус байгууллагын тухай болон бусад хууль эрх зүйн актад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хийсэн хамтарсан урьдчилсан дүгнэлт”, CDL-AD (2013)030, 2013 оны 10 дугаар сарын 16, заалт №47-г үз.

168 Тогтоол 68/181 дэх, жишээлбэл: НҮБЕА нь “эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба энэ мэт хүчирхийлэл агуулсан үйлдлийг өөгшүүлдэг практикийг хулцэн тэвчдэг нийгмийн хэм хэмжээ, хэв маяг”-аас үүдэлтэй, улмаар эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдын эсрэг хүчирхийлэл, зүй бус үйлдэл гаргах, тэдний ажлын нэр хүндийг унагаахад хүргэсэн түүхэн улбаатай бөгөөд тогтолцооны тэгш бус байдлын хор нөлөөнд гүнээ санаа зовниж байгаагаа илэрхийлэв.” гэснийг үз. НҮБ-ын Б.Б. А/RES/68/181, оршил.

доромжилсон дайралтад өртдөг гэдгийг онцолсон аж.¹⁶⁹ Хүүхэд зэрэг залуу хүний эрхийг хамгаалагчдыг үзэл бодлоо илэрхийлэхэд хэтэрхий залуу гэж үзэн, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг нь эдлүүлдэггүй. Хүний эрхийг хамгаалагчдыг бодит эсвэл мэдрэмжийн бэлгийн чиг баримжаагаар нь гутаан доромжлох, түүнчлэн хувийн нууцтай байх эрхийг зөрчиж, хувийн мэдээлэл, өгөгдлийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр задруулах нь хүний эрхийг хамгаалагчдыг гутаахад ашигладаг өргөн дэлгэрсэн тактик болсон байна.

122. ИУТЭОУП-ын 17 дугаар зүйлд заасан хувийн нууцтай байх эрхэд хүний нэр төр, алдар хүндийн эсрэг хууль бус халдлагаас хамгаалахыг мөн ойлгоно.¹⁷⁰ НҮБ-ын Хүний эрхийн хороо онцлон тэмдэглэсэн бөгөөд гэрээний улсууд нь төрийн эрх бүхий байгууллага эсвэл хувь хүн, хуулийн этгээд үйлдсэнээс үл хамааран хүний эрхийг хамгаалагчдыг эдгээр халдлагаас хамгаалах үүрэг хүлээдэг.¹⁷¹ Гэсэн хэдий ч уг хорооны зүгээс мөн дурдсанчлан, 17 дугаар зүйлд заасан эрхийг хамгаалах үүднээс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хязгаарлалт тогтоож болох ба ийм хязгаарлалтуудыг маш болгоомжтой хэрэглэх хэрэгтэй гэж заасан байна.¹⁷² Ялангуяа энэхүү эрхийг хууль бусаар хязгаарлахгүйн тулд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх олон улсын стандартад хатуу нийцсэн байх ёстой бөгөөд хэн нэгний хүний эрхийг хамгаалах эрхийг хясан боогдуулахад гуйвуулан ашиглах ёсгүй.
123. Маш олон оролцогч улс оронд хүний эрхийг хамгаалагчдыг харлуулах кампанит ажлыг төрийн эрх мэдэл, албан тушаалтнууд эсвэл төрийн өмчит хэвлэл мэдээллийн хэрэгсэл шууд зохион байгуулдаг гэсэн мэдээлэл байна. Тэднийг ихэвчлэн төрийн бус талууд, түүний дотор түрэмгий үндсэрхэг үзэлтэй бүлэглэлүүд, шашны удирдагчид, байгууллагууд эсвэл

169 Хууль, практик дахь эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах үзэгдлийн асуудал хариуцсан Ажлын хэсгийн тайлан, НҮБ-ын Б.Б. А/HRC/23/50, 2013 оны 4 дүгээр сарын 19-ны өдөр, заалт №66-г үз. Уг Ажлын хэсэг, жишээлбэл: Wikipedia хаяг дээр нь Арьс өнгөөр ялгаварласан доромжлол бичиж, уг эмэгтэй хүний эрхийг хамгаалагчийг бүлэглэн хүчиндэхийг уриалсан нэрээ нууцалсан сөрөг кампанит ажил явсан тухай мэдээлсэн.

170 ИУТЭОУП -аас ялгаатай нь ХЭУЭЧК-ын 8 дугаар зүйлд нэр хүнд, алдар хүндийг хүндэтгэх тухай тусгайлан тусгаагүй боловч, Европын Хүний Эрхийн шүүх өөрийн эрхзүйдээ тодорхой нөхцөлд хүний нэр хүндээ хамгаалах эрхийг хувийн амьдралыг хүндэтгэх эрхийн нэг хэсэг болгон Конвенцын 8 дугаар зүйлд тусгажээ. Доорх *Хувийн амьдралыг хүндэтгэх эрхийн* хэсгийг үз.

171 НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны ерөнхий тайлбар №16, Зүйл №17, “Хувийн нууцын эрх”, 1988 оны 4 дүгээр сарын 8, зүйлүүд ба №1 ба №11-г үз.

172 НҮ-ий Хүний Эрхийн Хорооны ерөнхий тайлбар №34, Зүйл №19, “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө”, НҮБ-ын Б.Б. CCPR/C/GC/34, 2011 оны 9 дүгээр сарын 12, заалт №28.

хувийн корпорацууд удирддаг.¹⁷³ Хүний эрхийг хамгаалагч нарыг болон тэдний үйл ажиллагааг гутаан доромжлох гэсэн ийм оролдлогуудыг заримдаа улс төрийн зүтгэлтнүүд болон төрийн албан хаагчдын улс, орон нутаг, хотын түвшний мэдээллийн хэрэгслээр хийсэн гутаан доромжилсон эсвэл бүр өдөөн хатгасан мэдэгдлүүд дэвэргэдэг.

124. Нийгэм, шашин шүтлэг, “арьс өнгө”, иргэний харьяалал, хүйс, хөгжлийн бэрхшээл эсвэл бусад байдал гэх мэт нийгмийн ялгаварлал, үл тэвчих байдалтай тулгардаг бүлэгт хамааралтай эсвэл холбоотой хүний эрхийг хамгаалагч нар нь энэ төрлийн зүй бус үйлдлүүдийн бай болдог. Ийм бүлэгт харьяалагддаг эсвэл холбоотой байдаг хүний эрхийг хамгаалагчдын эсрэг үзэн ядалтыг түгээх, өдөөхөд интернэт сүлжээг ашиглах нь улам бүр нэмэгдсээр байна. Түүнчлэн хүний эрхийг хамгаалагчдын эсрэг ялгаварлан гадуурхалт, дайсагнал, хүчирхийллийг өдөөн турхирахтай тэмцэх арга хэмжээ авах нь ихэнх тохиолдолд үр дүнд хүрдэггүй.
125. Ерөнхийдөө гутаан доромжлох, харлуулах кампанит ажил нь хүний эрхийг хамгаалагчдын эсрэг аман болон бие махбодын халдлагыг өдөөсөн уур амьсгалыг бий болгож, дарамт шахалт, мөрдөн мөшгөхийг өөгшүүлэн дэмжсэнээр тэдний аюулгүй байдлыг эрсдэлд оруулж байна.
126. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс “тэдний эрхийг хамгаалах нь амин чухал зүйл учир тэдний үйл ажиллагааг гутаан доромжлохоос зайлсхийх, байгууллагынх нь бие даасан байдлыг хүндэтгэхийн сацуу хүний эрх, ардчилал, эрх зүйт ёсыг хөгжүүлэхэд хүний эрхийг хамгаалагчдын үүргийн чухал, хууль ёсны байдлыг олон нийтэд нээлттэй хүлээн зөвшөөрөхийг”¹⁷⁴ улс орнуудад уриалав. Хүний эрхийн зөвлөл нь мөн нийгмийн бүхий л салбарын удирдагчдыг, түүний дотор улс төр, нийгмийн болон шашны удирдагчид, бизнесийн болон хэвлэл мэдээллийн салбарын удирдагчдыг хүний эрхийг хамгаалагчдын үүргийн чухал ач холбогдол, тэдний

173 Жишээлбэл: Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн НҮБ-ын Тусгай илтгэгчийн цохон тэмдэглэсэнээр, ЛГБТИ хүмүүсийн төлөө ажилладаг хүний эрхийг хамгаалагч нар ихэвчлэн өөр бусад бүлгүүдээс гадна бүлэглэлүүд ба шашны удирдлагууд эсвэл хэвлэл мэдээллийн зүгээс гадуурхалт, дайралтад өртдөг. НҮБ-ын Б.Б. А/HRC/25/55, 2013 оны 12 дугаар сарын 23-ны өдөр, заалт №104-ийг үз.

174 НҮ-ий Хүний Эрхийн Зөвлөлийн Тогтоол №A/HRC/RES/22/6, оршил.

ажлын хууль ёсны байдлыг олон нийт дэмжиж буйг үзүүлж, таниулахыг уриалсан.¹⁷⁵

127. Ялгаварлал, дайсагнал эсвэл хүчирхийллийг өдөөсөн үндэстний, арьс өнгө, шашны үзэлд тулгуурласан үзэн ядалтыг олон нийтэд сурталчлах шинжийг агуулж буй төрийн болон төрийн бус талуудын санаархлыг ИУТЭОУП-ын 20 дугаар зүйлд заасны дагуу хуулиар хориглох ёстой.¹⁷⁶ НҮБ-ын итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах асуудлаарх Тусгай илтгэгчийн анхааруулж хэлсэнчлэн ИУТЭОУП-ын 19 дүгээр зүйлд заасны эсрэг хууль ёсоор илэрхийлсэн санал бодлыг хязгаарлахгүйн үүднээс энэ төрлийн хуулийг шүүгч нар болгоомжтой тайлбарлаж, хэрэгжүүлэх ёстой.¹⁷⁷
128. Үндэсний, арьс өнгө, шашны үзэн ядалтыг өдөөх, тэр дундаа хүний эрхийг хамгаалагчдын эсрэг чиглэсэн үйл ажиллагаатай тэмцэхийн тулд, тухайлбал, ялгаварлан гадуурхах, дайсагнал, хүчирхийллийг өдөөх үндэсний, арьс өнгө, шашны үзэн ядалтыг сурталчлахыг хориглосон Рабатын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу эдгээр хуулиудыг мэдлэг боловсрол, чадавхыг дээшлүүлэх арга хэмжээгээр дэмжиж өгөх хэрэгтэй.¹⁷⁸ Ийм арга хэмжээнд аюулгүй байдлын хүчин, хууль сахиулах байгууллагын ажилтнууд, шударга ёсыг хэрэгжүүлэхэд оролцож ажилладаг хүмүүсийг сургах, мэдлэг туршлага суулгах, түүнчлэн хүний эрхийн боловсрол олгох, хүний эрхийн үнэт зүйлс, зарчмуудын талаарх сургалт орох, түүний дотор сургуулиудад заах хүртэл орно.

175 Өм. дурд. А/HRC/RES/22/6, заалт №18. Үүнтэй адилаар, НҮБЕА эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдын талаар гаргасан тогтоолдоо армийн удирдлагуудыг, ялангуяа, эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдыг дэмжиж буйгаа олон нийтэд нээлттэй илэрхийлэхийг урьсан (А/RES/68/181, заалт №15-г үз.). Хууль сахиулах байгууллага, шүүхийн албан тушаалтнууд ээрэг төрийн байгууллагын төлөөлөгчдийн гаргадаг Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, сексист болон бусад төрлийн алагчлах байдлын хор уршгийн тухайд, цөөнхийн эрх, хүйсийн асуудлаар ажиллаж буй хүний эрхийг хамгаалагчдад чиглэсэн заналхийлэл, хүчирхийллийг буруушааж, мөрдөн шалгах, шүүхээр шүүх улс төрийн хүсэл зоригийн талаар мөн дээр дурдсан “Гэмт хэрэгт тооцох болон хуулийг дур зоргоор, мушгин гуйвуулж хэрэглэх” гэсэн хэсгийг үз.

176 ИУТЭОУП-ын 20-р зүйлд заасан үүрэг амлалтынхаа дагуу, ЕАБХАБ-ын гишүүн орнууд “өөрсдийн үндсэн хууль эрх зүйн тогтолцоо, олон улсын өмнө хүлээсэн үүрэгтэй нийцүүлэн хувь хүн, бүлгийн эсрэг еврейн эсрэг үзэл гэх мэт үндэсний, арьс өнгө, үндэс угсаа, эсвэл шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхалт, дайсагнал, үзэн ядалтын сэдэлтэй хүчирхийллийг өдөөх аливаа үйлдлээс хамгаалах үр дүнтэй арга хэмжээ авах, шаардлагатай бол, тийм хууль батлах” үүрэг амлалт авсан. Копенхаген 1990 зүйл (40.1); мөн Женев 1991-ийг тус тус үз.

177 Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн асуудал эрхэлсэн тусгай илтгэгч тайлан. НҮБ-ын Б.б. А/67/357, 2012 оны9 дүгээр сарын 7, заалт №76 ба 77.

178 “Ялгаварлан гадуурхалт, дайсагнал, хүчирхийллийг өдөөх үндэсний, арьс өнгө, шашны үзэн ядалтыг сурталчлах үйл ажиллагааг хориглох Рабатын төлөвлөгөө, 2011 онд ХЭДКГ-ын зохион байгуулсан дөрвөн бүс нутгийн шинжээчдийн зөвлөгөөнөөс гаргасан дүгнэлт, зөвлөмжүүд. Марокко, Рабат хот 2012 оны 10-р сарын 5, <http://www.ohchr.org/Documents/Issues/Opinion/SeminarRabat/Rabat_draft_outcome.pdf>, 7-8-р хуудас.

129. Цаашилбал албан тушаалтнууд тэдний үндэс угсаа, шашин шүтлэг, “арьс өнгө”, иргэний харьяалал, хүйс, хөгжлийн бэрхшээл болон бусад байдал зэргээс хамаарч гадуурхагдсан зарим бүлгүүдэд хандахдаа одоогийн байдлаар хүлээн зөвшөөрөгдсөн ба үл гутаан доромжилсон нэр томъёог ашиглах ёстой. Үүний тулд төрийн эрх баригчид зохих, хоёрдмол утгагүй нэр томъёоны талаар хүний эрхийг хамгаалагчидтай байнга зөвлөлдөж, ийм нэр томъёог бичгэн болон аман харилцаанд хэвшүүлэхийн тулд арга хэмжээ авах хэрэгтэй.
130. Үзэн ядалт агуулсан илтгэл болон бусад түрэмгий үндсэрхэг үзэл, Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, шовинизм буюу үндэсний дээрэнгүй үзэл, ксенофоби буюу гадаад хүнийг үзэн ядах үзэл, антисемитизм буюу семитийн эсрэг үзэл, түрэмгий хэт даврах үзэл, түүнчлэн шашин шүтлэг, итгэл үнэмшилд суурилсан ялгаварлан гадуурхах үзэгдлийн эсрэг олон нийтэд нээлттэй хагуу байр суурьтай байх ЕАБХАБ-ын амлалтын дагуу¹⁷⁹ улс орнууд үндэсний хэмжээнд, бүс нутгийн болон орон нутгийн түвшинд ажилладаг төрийн байгууллага, албан тушаалтнууд, хүний эрхийг хамгаалагчдын эсрэг эдгээр санаархал илэрсэн тохиолдол бүрд түүнийг олон нийтэд нээлттэйгээр буруушаах ёстой.
131. Гутаан доромжлох нь эцэстээ гадуурхагдахад хүргэдэг. Ерөнхийдөө энэ нь хүний эрхийн үйл ажиллагааны ач холбогдол, нэр хүндийг бууруулж, үр дагаварт нь энэ ажлыг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц, дэмжлэг орж ирэх замыг хаадаг байна. Хүний эрхийг хамгаалагчдыг гутаан доромжлохын оронд оролцогч улсууд хүний эрхийг хамгаалагчидтай идэвхтэй, бүтээлчээр харилцан тэдний оруулсан хувь нэмрийн ач холбогдол, нийгмийн ач тусыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Хараат бус ХЭҮИ-ийн ажилтнууд нь хүний эрхийг хамгаалагч нар мөн гэдгийг хүлээн зөвшөөрснөө илтгэж, оролцогч орнууд нь шаардлагатай тохиолдолд, Парисын зарчмын дагуу тэдний төлөөлөх эрхийг бэхжүүлж, олон нийтийн яриа хэлэлцүүлгийн оролцоогоо нэмэгдүүлэхийн тулд бусад хүний эрхийг хамгаалагчидтай холбоо тогтоох боломжийг олгох хэрэгтэй. Тэд засгийн газарт шүүмжлэлтэй хандаж байсан ч, хараат бус ХЭҮИ-ууд болон бусад хүний эрхийг хамгаалагчдын зөвлөмж, үзэл бодолд зохих анхаарал хандуулан авч үзэх хэрэгтэй.
132. Хүний эрхийг хамгаалагчдын ажил нь ихэнхдээ засгийн газрын бодлого, үйл ажиллагааг шүүмжилдэг ч, засгийн газрууд ийм шүүмжлэлийг сөргөөр хүлээж авах шаардлагагүй. “Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны талаар бие даасан бодолтой байх, чөлөөт хэлэлцүүлэг өрнүүлэх зарчим нь хүний эрхийг хамгааллыг илүү дээр түвшинд гаргах суурь бөгөөд

179 Аравдугаар Сайд нарын Хорооны Уулзалтын баримт бичиг (Порто 2002), заалт №8.

туршиж үзсэн, шалгарсан арга барил билээ. Хүний эрхийг хамгаалагч нар засгийн газрыг хүний эрхийг дэмжих, хамгаалах үйл ажиллагаа, чиглэлд нь тусалж чадна. Зөвлөлдөх ажлын хүрээнд тэд зохих хуулийн төсөл боловсруулахад туслах, хүний эрхийн талаар үндэсний төлөвлөгөө, стратеги боловсруулахад туслах үүрэг гүйцэтгэдэг. Энэ үүргийг ч бас хүлээн зөвшөөрч, дэмжих хэрэгтэй.”¹⁸⁰

III. ХҮНИЙ ЭРХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АЮУЛГҮЙ, ТААТАЙ ОРЧИН

Г. Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээллийн эрх чөлөө

133. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын (ХЭТТ) 19 дүгээр зүйлээс гадна, ИУТЭОУП,¹⁸¹ ХЭҮЭЧК,¹⁸² ХЭАК¹⁸³ болон ҮЦХСК¹⁸⁴ зэрэг олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн олон улсын гэрээнд итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг баталгаажуулсан байдаг. ХЭТТ-ын үзэл баримтлалын дагуу хүн бүр өөрийн итгэл үнэмшилтэй байж, үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй ба үүнд аливаа хөндлөнгийн оролцоогүйгээр итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ямар ч хэвлэл мэдээллийн хэрэгслээр, хил хязгаараас үл хамааран мэдээлэл, санаа бодлыг олж авах, түгээх эрх чөлөө зэрэг эрхүүд багтана.”
134. Оролцогч улсууд “мэдээллийн салбар дахь хамтын ажиллагааг дэмжих, бусад улс оронтой мэдээлэл солилцох явдлыг хөхиүлэн дэмжих зорилгоор бүх төрлийн мэдээллийг илүү хурдан, өргөн хүрээнд түгээн дэлгэрүүлэх” үүрэг хүлээсэн.¹⁸⁵ Тэд мөн “хүн бүр харилцаа холбоо тогтоох зэрэг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэхүү эрхэд үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл, санаа бодлыг төрийн эрх мэдлийн оролцоогүй, хил хязгаараас үл хамааран хүлээн авах, түгээх эрх чөлөө хамаарна.” гэдгийг мөн дахин баталгаажуулан зөвшөөрсөн.¹⁸⁶ Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн

180 “Хамгааллыг хангах-Хүний эрхийг хамгаалагчдын хамгааллын Европын холбооны удирдамж”, <<http://www.consilium.europa.eu/uedocs/cmsUpload/GuidelinesDefenders.pdf>>, заалт №5. Уг удирдамж нь анх 2004 онд батлагдсан ба 2008 онд хянасан.

181 ИУТЭОУП, Зүйл №19.

182 ХЭҮЭЧК, Зүйл №10.

183 Хүний Эрхийн америкийн конвенцын 13 дугаар зүйл. Тус хорооноос 2000 оны 10-р сард баталсан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зарчмуудын тунхаглалыг хариуцсан хүний эрхийн Америкийн Улсууд Дундын хороо нь Америкийн конвенцын 13-р зүйлийг тайлбарлах талаар цаашдын удирдамжийг өгнө. <<http://www.oas.org/en/iXЭАК/expression/showЗүйл№.asp?artID=26&IID=1>> -г үз.

184 ҮЦХСК, Зүйл №7.

185 Хельсинки 1975, “Хүмүүнлэгийн болон бусад салбар дахь хамтын ажиллагаа”.

186 Копенхаген 1990, заалт №9.1.

гол үүргийг “хүний эрхийн суурь, ардчилсан нийгмийн үндсэн хүчин зүйл” гэж дахин тэмдэглэсэн.¹⁸⁷ Түүгээр ч үл барам оролцогч улсууд мэдээллийн чөлөөт урсгалын ач холбогдол¹⁸⁸, мөн чөлөөт хэвлэл мэдээллийн чухал үүргийг хүлээн зөвшөөрөв.¹⁸⁹

135. НҮБ-ын Хүний эрхийн хорооноос дурдсанчлан мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрхийг багтаасан итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь аливаа нийгэмд зайлшгүй бөгөөд чөлөөт, ардчилсан улс бүрийн үндэс суурийг бүрдүүлдэг гэжээ.¹⁹⁰ Мөн түүнчлэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө нь хүний эрхийг дэмин, хамгаалдаг ил тод, хариуцлагатай байх зарчмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөхцөл бий болгодог байна. Энэ нь эргээд хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалахад чухал ач холбогдолтой юм.”¹⁹¹ гэжээ. Өөрөөр хэлбэл итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэх нь хүний эрхийг хамгаалагчдад хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай. Үүний дагуу НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалын 6 дугаар зүйлд хүний эрхийн талаарх мэдээллийг мэдэх, хайх, олж авах, хүлээж авах, хадгалах эрх; хүний эрхийн талаарх үзэл бодол, мэдээлэл, мэдлэгийг чөлөөтэй нийтлэх, түгээх, тараах; хүний эрхийг дагаж мөрдөх талаар судлах, хэлэлцэх, эвлэлдэх, итгэл үнэмшилтэй байх; хүний эрхийн асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах хувь хүний эрхийг дахин баталгаажуулсан.
136. Гэвч, олон улсын хууль тогтоомжид баталгаажсан ч, хүний эрхийг хамгаалагчдын итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь хэд хэдэн ЕАБХАБ-ын оролцогч орнуудад хууль бусаар хязгаарлагдсан хэвээр байна. ЕАБХАБ-ын Парламентын ассамблей нь оролцогч орнуудыг өөр бусад асуудлаас гадна хүний эрхийг хамгаалагчдын ажиллах орчинд сөргөөр нөлөөлж буй “хэт хязгаарласан төрөл бүрийн хууль тогтоомж, бодлогын уршгаар аюул заналхийлэлд өртөж”, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор “үлдсэн бэрхшээл, удааширсан үйл явц, хоцрогдол”-оо шийдвэрлэхийг 2007 онд уриалсан.¹⁹² Сүүлийн жилүүдэд энэ байдал дорвитой өөрчлөгдөөгүй боловч энэ бүс

187 Будапешт 1991, “Шийдвэрүүд: VIII. Хүний аюулгүй байдлын хэмжүүр”, заалт №34.

188 Станбул 1999, “Европын Аюулгүй Байдлын Дүрэм: III. Бидний нэгдмэл үүрэг”, заалт №26.

189 Astana 2012, заалт №6.

190 Зүйл №19, заалт №2-ын тухай НҮ-ий Хүний Эрхийн Хорооны нэгдсэн дүгнэлт №34.

191 Эх. сурв. заалт №3.

192 ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн ЕАБХАБ-ын хүний эрхийг хамгаалагч нар болон хүний эрхийн үндэсний байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх тухай тогтоол, заалт №17, “Арван зургаа дахь удаагийн жилийн ээлжит хуралдаанаар баталсан Киевийн тунхаглал ба тогтоолууд”, Киев, 2007 оны 7 дугаар сарын 5-9-ний өдөр, хуу. №28-30, <<http://www.ЕАБХАБра.org/publications/declarations/2007-kyiv-declaration/250-kyiv-declaration-english/file>>.

нутгийн зарим хэсэгт улам бүр дордсоор байгаа юм. Үндэсний аюулгүй байдал (ялангуяа алан хядах ажиллагаатай тэмцэхтэй холбоотой), эрүүл мэнд, олон нийтийн ёс суртахуунд, үндэслэлгүй, пропорциональ харьцааг үл хангах хязгаарууд тогтоохыг зөвшөөрдөг хуулиуд байнга асуудал дагуулсаар байна. Үүнтэй адилаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах зорилгоор дур мэдэн ашиглаж болох нарийн тодорхой биш хуулиуд зарим муж улсад асуудлын шалтгаан болсоор байна. Мөн адилаар хэд хэдэн оронд ЛГБТИ хүмүүсийн хүний эрхийг хамгаалагчдыг олон нийтийн ёс суртахууныг сахин хамгаалах, насанд хүрээгүй хүүхдийг хор хөнөөлөөс хамгаалах гэсэн үндэслэлээр үйл ажиллагааг нь явуулахгүй саатуулсаар ирсэн.¹⁹³

137. Оролцогч улсууд өөрсдийн мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрх зэрэг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн олон улсын стандартууд, ЕАБХАБ-ын

193 Жишээлбэл: Европын Зөвлөлийн Хүний эрхийн асуудал эрхэлсэн комиссарын 2013 оны 5-р сарын 22-24-ний өдрүүдэд Азербайжанд хийсэн томилолтынхоо дараа гаргасан ажлын тайланг үзнэ үү. 2013 оны 8-р сарын 6-ны өдрийн CommDH (2013). Комиссар Урван тэрслэхийн эсрэг хуульд ашигласан хэл нь хэтэрхий ойлгомжгүй, өргөн цар хүрээтэй тул хүссэнээрээ тайлбарлах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ хэрэгжүүлэхэд учир дутагдалтай хязгаарлалт хийх боломжийг олгож байна (Европын Зөвлөлийн стандартыг харгалзан арилжааны бус байгууллагын тухай ОХУ-ын хууль тогтоомж"-д Хүний эрхийн комиссарын гаргасан санал дүгнэлтийг, CommDH (2013), 2013 оны 7-р сарын 15, заалт №24-өөс үз.). Түүнчлэн Комиссар нь "Гадаадын төлөөлөгчийн газрын тухай хуульд "улс төрийн үйл ажиллагаа" гэдгийг тодорхойлсон ойлголт, "гадаад төлөөлөгч "гэсэн нэр томъёог ашиглах, хуулийг "хорт сэдлээр" зөрчсөнийг эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар шийдэх боломжийг олгосноороо Европын хүний эрхийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны жишгийн эрх зүйд заасны дагуу эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд саад учруулж байна."(82-р зүйл) гэжээ. 2009 онд ОХУ-д хийсэн нэгдсэн дүгнэлтээрээ Хүний Эрхийн Хороо нь "хэт даврах үйл ажиллагаа" гэсэн тодорхойлолтыг дур зоргоороо тайлбарлан хэрэглэх аливаа боломжийг хаах үүднээс илүү нарийвчлалтай болгож, "Хэт даврах үйл ажиллагаатай тэмцэх тухай Холбооны хуулийг шинэчлэн батлахыг" гэрээний улсуудад уриалав." CСPR/C/RUS/CO/6, 2009 оны 11-р сарын 24, заалт №24-ийг үз. 2012 оны Турк улсад хийсэн нэгдсэн дүгнэлтдээ Хүний Эрхийн Хороо "алан хядах ажиллагааны тодорхойлолтын тодорхойгүй байдал", "хүний эрхийг хамгаалагч, өмгөөлөгч, сэтгүүлч, тэр ч байтугай хүүхдүүд санал бодлоо чөлөөтэй илэрхийлсэн, ялангуяа Курдын асуудлаар энх тайвнаар хэлэлцсэнийхээ төлөө алан хядах ажиллагааны эсрэг хуулиар буруутгагдаж буй хэргүүд" -д маш их санаа зовж байгаагаар илэрхийлэв. НҮБ-ын Б.6, CСPR/C/TUR/CO/1, 2012 оны 11-р сарын 13, заалт №16-г үз. 2011 онд Европын Зөвлөлийн тэр үеийн Комиссар асан Томас Хаммарберг Турк улс дахь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний талаарх дэлгэрэнгүй тайланг нийтлүүлж, түүндээ эрх баригчдыг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахад пропорциональ бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүгийн хууль, алан хядлагатай тэмцэх зэрэг хуулиудын олон заалтыг сайтар боловсруулж, нэмж, өөрчлөхийг уриалжээ(2011 оны 4-р сарын 27-29-нд Турк улсад томилолтоор ажилласныхаа дараа Европын Зөвлөлийн Хүний эрхийн асуудал эрхэлсэн комиссар асан Томас Хаммарбергийн бичсэн тайланг, 2011 оны 7-р сарын 12, 25-ны өдрүүд, CommDH(2011)-ээс үз.). Жишээлбэл: олон нийтийн ёс суртахуун, насанд хүрээгүй хүүхдийг хамгаалах хууль тогтоомжийн тухайд, Хүний Эрхийн Хороо Литвад хийсэн нэгдсэн дүгнэлтдээ: "Эцэг эхийн хамгаалалтын тухай хууль зэрэг зарим хууль эрх зүйн арга хэрэгслүүд, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн буруу нөлөөнөөс хамгаалах тухай хууль (заалт №7) зэрэг тодорхой баримт бичгүүдийг Конвенцоор баталгаажсан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хууль бусаар хязгаарлах, Лесби, Гэй, Бисекс, Трансжендер (ЛГБТ) хүмүүст чиглэсэн ялгаварлан гадуурхалтыг зөвтгөхөд ашиглаж болзошгүй" гэдэгт санаа зовж буйгаа илэрхийлсэн. CСPR/C/LTU/ CO/3, 2012 оны 8-р сарын 31, заалт №8-ыг үз.

үүрэг амлалтуудаа бүрэн биелүүлэхийн тулд хууль эрх зүйн орчноо эргэн харах ёстой. Тодруулбал эдгээр эрхэд тогтоосон аливаа хязгаарлалтууд нь хууль ёсны, зайлшгүй, пропорциональ байх зарчмуудыг чандлан дагаж мөрдөх ёстой. Ингэхдээ хуулийг хэрэглэхэд эргэлзээтэй ойлголт, хуулийн хийдэл болон хууль ёсны байх шаардлагад нийцээгүй заалтуудыг арилгахад онцгой анхаарах хэрэгтэй. Үүний зэрэгцээ олон улсын хууль тогтоомжоор хүлээн зөвшөөрөгдөөгүй үндэслэлээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хориглосон, хязгаарласан заалтыг нэн даруй өөрчлөх буюу цуцлах шаардлагатай.

138. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл “олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журам сахиулахад чиглэсэн хууль тогтоомж нь үл ялгаварлан гадуурхах зарчим, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө зэрэг хүний эрхийн олон улсын хууль тогтоомжид нийцсэн байх шаардлагатай бөгөөд заалтуудыг тодорхой томъёолсон эсэхийг ханган ажиллах ёстой”.¹⁹⁴ уриалжээ. Цаашилбал үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх зэрэг олон нийтийн ёс суртахууныг хамгаалах зорилгоор тогтоосон хязгаарлалтууд үл ялгаварлан гадуурхах зарчмыг зөрчих ёсгүй.¹⁹⁵ НҮБ-ын Хүний эрхийн хорооноос цохон дурдсанчлан, дээрх хязгаарлалтууд хүний эрх болон үл ялгаварлан гадуурхах зарчмын үндсэн дээр хийгдэх ёстой.¹⁹⁶
139. ЕАБХАБ-д оролцогч хэд хэдэн улсад хүний нэр төрийг гутаан доромжлох тухай хуулиуд хүний эрхийг хамгаалагчдыг дуугуй болгох, бүр зарим тохиолдолд шоронд хориход ашиглагддаг тохиолдол давтагдан гарсаар байна. Улс төрчдийн алдар хүнд, нэр төрийг хамгаалах зорилготой хуулиуд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх явдлыг бодит байдал дээр болон цахимаар боогдуулж байгаа талаар мэдээлэл ч байна. НҮБ-ын Хүний эрхийн хороо өөрийн бүрэн эрхийн хүрээнд ардчилсан нийгэм дэх мэтгэлцээн, ялангуяа хэвлэл мэдээллийн хэрэгслээр, улс төрчдийн мэтгэлцээнд ИУТЭОУП үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж байгаад өндөр ач холбогол өгч байгаа тухай ажиглагдсаныг тэмдэглэжээ.¹⁹⁷ Цаашлаад тус Хорооноос “Гэрээний орнууд хүний нэр төрийг гутаан доромжлох гэмт хэргийг эрүүгийн зүйл ангид авч үзэхгүй байх бөгөөд зөвхөн маш ноцтой тохиолдолд л хэрэглэх ёстой

194 А/HRC/RES/22/6, заалт №4.

195 НҮ-ий Хүний Эрхийн Хорооны, Ерөнхий тайлбар №34, Зүйл №19, заалт №26.

196 Эх. сурв. заалт №32.

197 Жишээлбэл: Серби, Монтенегрогийн эсрэг Бодрозикын нэхэмжлэлд гаргасан Хүний Эрхийн Хорооны тайлбар, Баримт №1180/2003, 2005 оны 10 дугаар сар, заалт №8, Үндсэн зарчмын тухай хэсгээс дээр дурдсаныг үз.

ба ямар ч тохиолдолд цагдан хорих ял огт тохирох шийтгэл биш.”¹⁹⁸ гэжээ. ЕАБХАБ-ын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудлаар эрхлэн гаргадаг санал, дүгнэлтэд олон улсын байгууллага, институтууд хүний нэр төрийг хамгаалахын тулд эрүүгийн гэмт хэрэгт тооцох шаардлагагүй бөгөөд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд сөргөөр нөлөөлж буй хортой үр дагаврыг нь бодолцон эрүүгийн хэрэгт тооцох зүйл заалтыг хүчингүй болгох ёстой гэдэгтэй санал нийлж бүрэн зөвшилцөж, харилцан тохиролцсон байдгийг үргэлж тодотгодог.¹⁹⁹ НҮБ-ын Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний Тусгай илтгэгч, АУДБ (Америкийн улсууд дундын байгууллага)-ын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудал хариуцсан Тусгай илтгэгч, ЕАБХАБ-ын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудал эрхэлсэн төлөөлөгч нар хамтдаа нэр төрд халдах, гүтгэх зөрчлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцох тухай хуулийг хүчингүй болгож, шаардлагатай тохиолдолд, гүтгэх, нэр төрд халдах зөрчлийг иргэний хуулийн ангилалд оруулан солихыг удаа дараа шаардаж байна.²⁰⁰

140. Нэр төрд халдан гутаан доромжлох иргэний хууль нь хүний нөр хүндэд халдах, гутаан доромжилсон зөрчилд харьцангуй өндөр торгууль

198 НҮ-ий Хүний Эрхийн Хорооны, Ерөнхий тайлбар №34, Зүйл №19, заалт №47. Нэгдсэн дүгнэлтдээ тус Хороо нь оролцогч орнуудыг гүтгэхийг гэмт хэрэгт тооцохоо зогсоохыг мөн байнга уриалдаг. Жишээлбэл: НҮБ-ын Хүний Эрхийн Хороо, “Бүгд Найрамдах Чех улсад хийсэн нэгдсэн дүгнэлт”, НҮБ-ын Б.б. ССРР/С/СЗЕ/СО/3, 2013 оны 8 дугаар сарын 22, заалт №21; “Турк улсад хийсэн нэгдсэн дүгнэлт”, НҮБ-ын Б.б. ССРР/С/ТУР/СО/1, 2012 оны 11 дүгээр сарын 13, заалт №24; “Серби улсад хийсэн нэгдсэн дүгнэлт”, НҮБ-ын Б.б. ССРР/С/СРБ/СО/2, 2011 оны 5 дугаар сарын 20, заалт №21; “Узбекистан улсад хийсэн нэгдсэн дүгнэлт”, НҮБ-ын Б.б. ССРР/С/УЗВ/СО/3, 2010 оны 4 дүгээр сарын 7, заалт №24; “Орос улсад хийсэн нэгдсэн дүгнэлт”, НҮБ-ын Б.б. ССРР/С/РУС/СО/6, 2009 оны 11 дүгээр сарын 24, заалт №23. -г үз. Мөн Европын Зөвлөлийн Хүний эрхийн комиссарын Азербайжанд хийсэн томилолтын тайлан, CommDH (2013)14, хуу. №8-10-г үз.

199 Жишээлбэл ЕАБХАБ-ын Хэвлэлийн эрх чөлөөний асуудал хариуцсан төлөөлөгчийн Литва улсын хуулийн төслүүдэд хийсэн хуулийн дүн шинжилгээ, 2014 оны 1 дүгээр сар, <<http://www.Osce.org/fom/111060>>; ба Итали улсад хийсэн, 2013 оны 11 дүгээр сар: <<http://www.Osce.org/fom/108108>> -ыг тус тус үз.

200 “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжих олон улсын механизмууд, НҮБ-ын Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудал эрхэлсэн тусгай илтгэгч, ЕАБХАБ-ын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудал эрхэлсэн Төлөөлөгч, АУДБ-ын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудал эрхэлсэн тусгай илтгэгч нарын хамтарсан тунхаглал” 2002 оны 12-р сар, <<http://www.osce.org/fom/39838>>. “Арван жилийн ойн хамтарсан тунхаглал: Дараагийн арван жилд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд тулгарах Арван гол бэрхшээл”, 2010 оны 2-р сар, <[Http://www.osce.org/fom/41439](http://www.osce.org/fom/41439)>-өөс үз. Европын Зөвлөлийн Парламентын Ассамблей (ЕЗПА) нь тус байгууллагын гишүүн орнуудыг гуйвуулан хэрэглэх болон үндэслэлгүй яллах эрсдэлийг арилгах зорилгоор нэр төрийг гутаан доромжлохын эсрэг хуулиудыг хянан үзэж, шаардлагатай бол нэмж, өөрчлөхийг уриалав. Нэр төрийг гутаан доромжилсон явдлыг гэмт хэрэгт тооцохыг болиулах талаар ЕАБХАБ-ын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудал эрхэлсэн төлөөлөгчдийн гаргасан хүчин чармайлтыг сайшаасан, 2007 оны 10-р сарын 4-ний өдөр батлагдсан “Гутаан доромжлохыг гэмт хэрэгт тооцуулахгүйн төлөө” Тогтоол №1577 (2007), 1814 (2007) тоот зөвлөмжийг тус тус үз.

ногдуулснаар хүний үг хэлэх эрхийг боогдуулах боломжтой байдаг.²⁰¹ Энэ чиглэлээр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл “гүтгэлэг, хүний нэр хүндэд халдсан шийтгэлийг учруулсан хор уршгийн хэмжээ, нөхөн төлбөрийн пропорциональ харьцаагаар хязгаарлагдаж байхаар тогтоохыг” улс орнуудад уриалав.”²⁰² Үүнээс гадна, санкц нь өөрөө тухайн хүн, байгууллага эсвэл хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаанд аюул учруулахгүй, дампууралд хүргэхгүйн үүднээс торгуулийг ногдуулахдаа зөрчлийн ноцтой байдал, тухайн этгээдийн эдийн засгийн байдалд бие даасан үнэлгээ хийсний дараа тогтоох ёстой. Хэтрүүлэн арга хэмжээ авах, шийтгэл ногдуулах нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг ерөнхийд нь дордуулах аюултай.

141. Өөрсдийн хуулиудыг нягтлах, шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулж, олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэхийн тулд оролцогч улсууд иргэний нийгмийн байгууллагууд зэрэг оролцогч талуудтай идэвхтэй зөвлөлдөх хэрэгтэй. Мөн ЕАБХАБ-ын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудал эрхэлсэн газар, Венецийн хороо зэрэг олон улсын холбогдох байгууллагуудаас техникийн зөвлөгөө авч, тэдний санал бодлыг бүрэн тусгах нь зүйтэй.
142. Өөрийн үзэл бодол, байр сууриа илэрхийлсэн хэргээр саатуулагдаж, шоронд хоригдсон эсхүл үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх олон улсын стандартын хатуу шаардлагыг хангаагүй хуулиудад үндэслэн тавигдсан бусад хориг арга хэмжээ ногдуулсан хүмүүсийг нэн даруй суллаж, торгууль, хураасан эд хөрөнгө зэргийг буцаан олгох ёстой. Түүнчлэн оролцогч улсууд хүний эрхийг хамгаалагчдын төрийн бодлого, үйл ажиллагааг ил тод шалгах эрхийг нээлттэй хүлээн зөвшөөрч, лавшруулан баталгаажуулах ёстой. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс цохон тэмдэглэснээр, хүний эрхийг хамгаалагчид төрийн бодлого болон үйл ажиллагааг шүүмжилж, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хүлээн зөвшөөрч, баталгаажуулах ёстой.²⁰³ ЕХЭШ нь олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу үзэл бодлоо чөлөөтэй

201 Жишээлбэл: НҮБ-ын Хүний Эрхийн Хороо “Молдова улсад хийсэн нэгдсэн дүгнэлт”-дээ бие даасан сэтгүүлчдийн эсрэг иргэний гүтгэлгийн хууль тогтоомжийг улс төрийн нөлөө бүхий ашиг сонирхлын бүлгүүд болон хувь хүмүүс ашиглаж байгаа тухай мэдээлэл буйд санаа зовж байсан. Мөн бие даасан телевизийн байгууллагуудыг яллагдагчаар татан оролцуулсан тухай мэдээллийг санаа зовнин тэмдэглэжээ.”; НҮБ-ын Б.б, ССРР/С/МДА/СО/2, 2009 оны 11-р сарын 4, зүй №21-ийг үз. “Тажикстан улсын талаар хийсэн нэгдсэн дүгнэлт” -дээ мөн “гүтгэлгийн хэрэг маргааныг хэвлэл мэдээллийн байгууллагуудыг айлган сүрдүүлэх хэрэгсэл болгон ашиглаж буй”-д санаа зовниж байгаагаа илэрхийлсэн (Эрүүгийн хуулиас гүтгэлгийн шинжтэй зүйлүүдийг устгасанд талархал илэрхийлэхийн сацуу, тус хороо нь ерөнхийлөгч, засгийн газрын төлөөлөгчдийг доромжилж бичсэний төлөө шийтгэл хүлээлгэх хуулийн заалт байсаар байгаад нэгэн зэрэг санаа зовниж буйгаа илэрхийлэв. , НҮБ-ын Б.б, ССРР/С/ТЖ/СО/2, 2013 оны 8-р сарын 22, заалт №22.

202 A/HRC/RES/22/6, заалт №11 (f).

203 A/HRC/RES/22/6, заалт №11 (i)

илэрхийлэх эрх чөлөөгь дан ганц өөрт таатай үзэл бодлыг хамгаалаад зогсохгүй шүүмжлэл болон бусад өөрсдийн эсрэг үзэл бодлыг ч хамгаалдаг байх ёстой бөгөөд зөвхөн маш онцгой тохиолдолд л хязгаарлалт тогтоохыг зөвшөөрнө гэдгээ ямагт дахин давтан баталгаажуулдаг.²⁰⁴

Нийтийн эрх ашигт хамаатай мэдээлэл авах боломж болон шүгэл үлээгчид

143. ИУТЭОУП-ын 19 дугаар зүйлийн 2-т заасны дагуу үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд “хил хязгаараас үл хамааран бүх төрлийн мэдээлэл болон санааг бичгэн, аман эсхүл хэвлэмэд байдлаар өөрийн сонгосон дурын хэвлэл мэдээллийн хэрэгслээр хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.” Шүүн таслах ажиллагаа, цуглаан ажиглах гэх мэт хүний эрхийн хяналт явуулах эрх нь мэдээлэл хайх, түгээх эрхээс урган гарсан эрх болно.
144. Мэдээлэл авах боломжийг хязгаарлах нь хүний эрхийн үйл ажиллагааг таслан зогсоох олон янзын хэлбэрийг бий болгодог. Нийгмийн эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах үндэслэлээр хүний эрхийг хамгаалагчдын мэдээлэл олж авах, түгээх боломжийг хязгаарлах нь олон нийтийг танин мэдүүлэх, мэдлэг олгох ажил, арга хэмжээнд саад болдог, тухайлбал нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох эсхүл хүйсээр ялгаварлан гадуурхахтай тэмцэх талаарх боловсрол олгох зэрэг үйлчилгээг үйлчлүүлэгчдэдээ үзүүлэх боломжгүй болгох магадлалтай. Нийтийн ашиг сонирхолтой холбоотой мэдээллийг хэт нууцлах, хүний эрхийг хамгаалагчид болон бусад талуудад мэдээлэл өгөхгүй байгаагаа үндэсний аюулгүй байдлаар ихэвчлэн халхавчилдаг бөгөөд төрийн эрх бүхий албан тушаалтны үйлдсэн авлига болон хүний эрхийн эсрэг үйл ажиллагааг нийтэд мэдээлэх гэсэн шүгэл үлээгч болон эрэн сурвалжлах сэтгүүлчдэд нэгэн саад тотгор болдог. Мэдээлэл хайх, түгээх тухай хүний эрхийн олон улсын стандарт, хэм хэмжээг давсан болон эрх чөлөөг хязгаарласан, хууль ёсны, хэрэгцээтэй, пропорциональ байх зарчимд нийцэхгүй аливаа хуулийг нэн даруй хүчингүй болгож, нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгтэй.
145. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл улс орнуудад хандан “хүний эрхийг ноцтой зөрчсөн тухай мэдээллийг төрийн байгууллагууд өөрсдийн санаачилгаар нээлттэй мэдээлдэг байх нөхцөлийг хангах ёстой бөгөөд хууль тогтоомж, бодлогоо ил тод, тодорхой болгож нарийн зохицуулалт, хязгаарлаагүй

204 Жишээлбэл: “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь ардчилсан нийгмийн үндэс суурь, түүний хөгжил дэвшил, хувь хүн өөрийгөө бүрэн дүүрэн илэрхийлэх боломжийг бий болгодог үндсэн нөхцөлийн нэг юм. 10 дугаар зүйлийн 2 дахь заалтыг дагаж мөрдөхдөө “мэдээлэл” ба “санаа”-г зөвхөн эергээр хүлээн зөвшөөрөгдсөн, доромж бус, төвийг сахисан төдийгүй доромжилсон эсвэл, гомдоосон, цочирдуулсан, эсвэл сэтгэл түгшээсэн байдалтай байж болно гэж ойлгоно. Олон ургалч үзэл, хүлцэл, нээлттэй сэтгэлгээ зэрэггүйгээр “ардчилсан нийгэм” (заалт №53) гэж байхгүй.” гэж дурдсан Паломо Санчез ба бусад нэхэмжлэгчийн Испанийн эсрэг гаргасан Нэхэмжлэлд хийсэн 2011 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн ЕХЭШ-ийн дүгнэлт, Нэхэмжлэл №28955/06, 28957/06, 28959/06 ба 28964/06-г мөн үз.

бол олон нийт мэдээллийг авахаар хүсэх, хүлээн авах эрхтэй байхыг” уриалсан.²⁰⁵

146. Баримт бичгүүдэд нууцын зэрэглэлийг туйлшруулан тогтоох, нууцын зэрэглэлээс гаргах хугацааг хэт урт тогтоох, түүхэн архивд нэвтрэхэд үндэслэлгүй хязгаарууд тогтоохоос сэргийлсэн тодорхой, ил тод журмыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Олон нийтэд нээлттэй байсан мэдээлэл эсвэл эрдэм шинжилгээний судалгааг түгээх, нийтлэхэд тухайн мэдээллийн олон нийтэд дэлгэн нууцын тухай хууль тогтоомжийг зөрчсөн байсан ч төрийн нууцыг хууль бусаар задруулсан гэж үзэж болохгүй.
147. Төрийн байгууллагын мэдээлэлд олон нийт нэвтрэх, танилцах эрхийг оролцогч улсууд хангах хууль тогтоомжийг батлах ёстой. НҮБ-ын үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах асуудлаарх тусгай илтгэгчийн хэлснээр “төрийн байгууллагын мэдээлэлд нэвтрэх эрхийг хамгийн өргөн хүрээнд бодитоор бүрдүүлсэн үндэсний норматив хууль тогтоомжийг батлах нь үндэсний хэмжээнд мэдээлэлд нэвтрэх эрхийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд нэн чухал юм. Хууль тогтоомж нь нээлттэй байх зарчимд үндэслэсэн байх ёстой.”²⁰⁶ Ил тод болгохоос татгалзах үндэслэлийг нарийн болон дэлгэрэнгүй тодорхойлох ёстой; мэдээллийг нийтэд дэлгэхгүй байх үндэслэлийг хэрэг тус бүрээр тодорхойлох ёстой ба тухайн эрх зүйн зохицуулалтаар хамгаалж буй ашиг сонирхол нь нийтийн ашиг сонирхлоос их байгаа тохиолдолд л мэдээллийг нууцлах эрхтэй. Цаашилбал, хүсэлтийн дагуу мэдээлэл өгөхөөс илүүтэйгээр зөвхөн зайлшгүй тохиолдолд зарим хязгааруудад захирагдахаас бусдаар төрийн байгууллагууд аливаа мэдээллийг олон нийтэд түгээх, нийтлэх үүрэгтэй гэсэн зарчмыг баримтласан зохицуулалттай байвал зохино.²⁰⁷ Иймээс үндэсний, бүс нутгийн, орон нутгийн түвшний төрийн байгууллагууд өөрсдийн төсөв, төсвийн гүйцэтгэл болон бусад үйл ажиллагаатайгаа холбоотой мэдээллийг тогтмол хэвлэн сурталчлан, зөвхөн хүсэлт, шаардлагын дагуу бус өөрсдийн санаачилгаар түгээн, ямагт нэвтрэхэд хялбар байлгах хэрэгтэй. Мөн оролцогч улсууд хувийн хэвшлийн

205 A/HRC/RES/22/6, заалт №11 (e).

206 Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хамгаалал, дэмжлэгийн асуудал эрхэлсэн тусгай илтгэгчийн тайлан, НҮБ-ын Б.Б. А/68/362, 2013 оны 9 дүгээр сарын 4, заалт №98.

207 Мэдээлэл авах эрхийн тухай үндэсний хууль тогтоомж боловсруулах, хэрэгжүүлэх гол зарчим ба удирдамжуудыг агуулсан Эх. сурв. заалт №76 ба заалт №99-ийг үз. Мөн мэдээлэл авах эрхтэй холбоотой хууль тогтоомж, практикаа шинэчилж буй улсууд харгалзан үзэх ёстой хэд хэдэн зүйлийг 9 дүгээр зүйлд тодотгож өгсөн ЕЗПА-н Тогтоол 1954 (2013)-ыг мөн үз. Эдгээр нь үндэсний аюулгүй байдлыг сахиулагчид, академиуд, иргэний нийгэм, олон улсын байгууллагууд зэрэг олон тооны мэргэжилтний баталсан These are based on the “Цэвэрийн Зарчмууд” (Үндэсний Аюулгүй Байдал ба Мэдээлэл Авах Эрхийн Даяан Дэлхийн Зарчмууд)-ыг үз. ЕЗПА нь энэ чиглэлийн хууль тогтоомж, практикаа шинэчилж буй Европын Зөвлөлийн гишүүн улсууд уг зарчмуудыг харгалзан үзэх ёстой гэж уриалсныг дэмжсэн.

компаниуд гэх мэт төрийн бус талуудын олон нийтийн ашиг сонирхолд хамааралтай мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах эсхүл нэвтрэх боломжтой байлгаж ба зөвхөн тодорхой нөхцөлд мэдээллийг хязгаарлах боломжтой. ЕЗПА “Бизнесийн байгууллагууд, тэр дундаа хувийн цэргийн болон аюулгүй байдлын компаниуд хүний эрхээ эдлэхэд нөлөөлж болзошгүй нөхцөл байдал, үйл ажиллагаа, үйлдлийн талаарх мэдээллийг нээлттэй байлгах үүрэгтэй” гэж мэдэгджээ.²⁰⁸

148. НҮБ-ын үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг дэмжих, хамгаалах асуудлаарх Тусгай илтгэгч хүний эрхийг ноцтой зөрчсөн тухай мэдээллийг үндэсний аюулгүй байдалтай холбож болохгүйг цохон тэмдэглэсэн. “Хязгаарлалтыг шаардлагатай гэж үзвэл, оролцогч улсууд эдгээр тусгай нөхцөлүүд нь олон улсын хүний эрхийн хууль тогтоомжид нийцэж буйг нотлох үүрэгтэй. Хүний эрхийн бусад зөрчилтэй холбоотой мэдээлэл нээлттэй байх ёстой гэсэн хатуу ойлголтоор хандах ёстой бөгөөд ямар ч тохиолдолд үндэсний аюулгүй байдалтай холбоотой хариуцлага хүлээлгэхээс зайлсхийх эсвэл хохирогчийг эрхээ сэргээлгэх, нөхөн төлүүлэх боломжийг хаах зорилгоор ашиглаж болохгүй.”²⁰⁹ Үүнтэй адилаар, ЕЗПА нь “хүн алах, хүчээр сураггүй алга болгох, эрүүдэн шүүх, хулгайлах зэрэг хүний эрхийн ноцтой зөрчил гаргасан төрийн төлөөлөгчдийн хариуцлагын талаарх мэдээллийг нууцад тооцохгүй.” гэдгийг дахин баталгаажуулсан. Ийм мэдээллийг “төрийн нууц” гэсэн нэр томъёогоор халхлан, шүүх, парламентын хяналт шалгалтаас зугтаалгах ёсгүй бөгөөд хүний эрх эсвэл хүмүүнлэгийн хууль тогтоомж ноцтой зөрчсөн тухай мэдээллийг ямар ч нөхцөлд үндэсний аюулгүй байдлын үндэслэлээр хамгаалж болохгүй.”²¹⁰
149. ЕЗПА улс орнуудыг шүгэл үлээгчдийг хамгаалах тухай хууль тогтоомжоо дахин нягталж үзэхийг уриалахын зэрэгцээ шүгэл үлээх тухай хууль тогтоомж нь чимээгүй байхтай ижил өөр аюулгүй арга замыг хангахад

208 ЕЗПА-н Тогтоол 1954 (2013), “Үндэсний Аюулгүй Байдал ба Мэдээлэл Авах Эрх”, 2013 оны 10 дугаар сарын 2-ны өдөр батлагдсан, заалт №9.

209 А/68/362, заалт №106.

210 Тогтоол 1954 (2013), заалт №6 ба 9.6-г үз.

анхаарлаа хандуулах хэрэгтэйг онцолжээ.²¹¹ Үүнтэй нэгэн адил, ЕАБХАБ-ын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудал эрхэлсэн төлөөлөгч, НҮБ-ын үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг дэмжих, хамгаалах асуудлаарх Тусгай илтгэгч, АУДБ-ын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудал эрхэлсэн тусгай илтгэгч нар бүгд шүгэл үлээгчид хууль зөрчсөн, төрийн байгууллагуудын буруутай үйл ажиллагаа, нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн буй орчинд ноцтой аюул заналхийлэл учруулсан, хүний эрх, хүмүүнлэгийн тухай хууль зөрчсөн талаарх мэдээллийг “үнэнч шударгаар” өгч, мэдээлснийх нь төлөө хуулийн болоод захиргааны зөрчлийн хариуцлага хүлээлгэхгүй бөгөөд хөдөлмөр эрхлэлтэй холбоотой шийтгэл оногдуулах арга хэмжээ авахаас хамгаалахыг уриалсан.²¹² Тэд “шүгэл үлээгч” гэдэг нь албан хаагч эсхүл нууцлал, нууц мэдээлэл хадгалах үүрэг бүхий этгээд байсан ч хамаагүй нууц мэдээллийг түгээн, ил болгож буй хэн бүхэн багтана гэж мэдэгдсэн. Нууцыг хамгаалах хууль ёсны үүрэг хүлээсэн төрийн албан тушаалтан эсвэл төртэй холбоотой хувь хүмүүс (өөрөөр хэлбэл шүгэл үлээгчид) ийм хамгаалалтаар хамгаалуулах ёстой гэдгийг тэмдэглэн хэлсний сацуу НҮБ-ын Тусгай илтгэгч олон нийтийн ашиг сонирхолыг хөндсөн нууц мэдээллийг хүлээн авсан, хадгалсан, түгээсэн сэтгүүлчид, бусад хэвлэл мэдээллийн ажилтнууд, иргэний нийгмийн төлөөлөгчид зэрэг бусад хүмүүс өөр хэн нэгэнд хүнд ноцтой хохирол учруулаагүй тохиолдолд хариуцлага хүлээх ёсгүй гэж мэдэгдсэн.²¹³

150. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл цахим сүлжээгээр мэдээлэл түгээх гэх мэт харилцаа холбооны шинэ шийдлүүд хүний эрхийг хамгаалагчдад хүний эрхийг дэмжих, түүнийг хангах эрмэлзэлд нь чухал хэрэгсэл болж

211 ЕЗПА-н Тогтоол 1729 (2010), “Шүгэл үлээгчдийн хамгаалал”, 2010 оны 4 дүгээр сарын 29-нд батлагдсан, заалт №6.1 ба 6.2. ЕЗПА-н үзэж байгаагаар ийм хууль тогтоомж нь дотоод шүгэл үлээх аргуудыг, ашигладаг шударга үнэн хүмүүсийг аливаа хариу арга хэмжээ (шударга бусаар халах, дарамт шахалт үзүүлэх эсвэл өөр ямар нэгэн шийтгэл, ялгаварлан гадуурхах хэлбэр гэх мэт)-нд өртөхөөс хамгаалах ёстой. Ийм дотоод сувгууд байхгүй, эсвэл байгаа нь үр дүн муутай тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэх мэт гаднын шүгэл үлээх арга хэрэглэснийг ч бас хамгаалах ёстой. Мэдээлэл авах тухай үндэсний хууль тогтоомжийг боловсруулж, хэрэгжүүлэхэд чиглэсэн зарчмуудыг тодорхойлж, НҮБ-ын үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хөхиүлэн дэмжих эрхийг хамгаалах асуудал эрхэлсэн тусгай илтгэгч мэдээлэл авах эрхийн үндэсний хууль тогтоомж нь шүгэл үлээгчдийг мөн хамгаалах ёстой гэдгийг онцгойлон дурдав. А/68/362, заалт №76 (i) -г үз.

212 НҮБ-ын Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хөхиүлэн дэмжих олон улсын механизмууд, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудал эрхэлсэн тусгай илтгэгч, ЕАБХАБ-ын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудал эрхэлсэн Төлөөлөгч, АУДБ-ын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудал эрхэлсэн тусгай илтгэгч нарын хамтарсан тунхаглал, “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх олон улсын механизм”, 2004 оны 12-р сарын 6, <<http://www.Osce.org/fom/38632>>-г үз.

213 А/68/362, заалт №68, 107 ба 108-ыг үз. Мөн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих асуудал эрхэлсэн НҮБ-ын Тусгай илтгэгч, Америкийн Улсууд Дундын Хүний Эрхийн Хорооны үзэл бодлоо илэрхийлэх эрхийн асуудал эрхэлсэн тусгай илтгэгч, “Мэдээллийн тандалтын арга хэмжээнүүд ба тэдгээрийн үзэл бодлоо илэрхийлэх эрхэд тусаж буй үр дагаврын тухай Хамтарсан тунхаг”, заалт №15.

чадна гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Үүнд “мэдээллийн технологид нэвтрэх, ашиглах, радио, телевиз, интернэтэд нэвтрэх зэрэг өөрийн хүссэн хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах явдлыг улсын хэмжээнд, улс хоорондын болон олон улсын түвшинд хөхиүлэн дэмжих, зохион байгуулах ёстой.” гэдгийг цохон дурджээ.²¹⁴ Гэсэн хэдий ч зарим оролцогч улс оронд эрх баригчдад шүүмжлэлтэй хандсан эсвэл маргаантай хэргүүд гарч нийгмийн эрүүл мэндэд эрсдэл учруулсан гэж үзсэн мэдээллийг хуваалцах, мэдээлэлд нэвтрэхийг хязгаарлах зорилгоор цахим хуудсыг хаасан зэрэг мэдээлэл байна. Зарим оролцогч улс орнуудад цахим хуудас руу нэвтрэх эрхийг хэсэгчлэн хязгаарлах эсвэл бүрэн хаахын эсрэг хамгаалсан зохицуулалт байдаггүй, үүнд бие даасан, хараат бус шүүхийн хяналт зэрэг багтана. Ийм хамгаалалт байхгүй тохиолдолд эрх баригчид цахим ертөнцөд контентбайршуулж буй хүмүүсийн хувийн мэдээлэл зэргийг Мэдээлэл харилцаа холбооны өгөгдөл, интернэтийн үйлчилгээ эрхлэгчдээс авах боломжтой байдаг. Ийм мэдээллийг дараа нь тэднийг дуугүй болгоход ашиглаж болзошгүй юм.

151. Интернэт үйлчилгээ эрхлэгчид зэрэг төрийн бус талуудаас хүний эрхийг хамгаалах хууль ёсны үйл ажиллагааг хязгаарлахаас хамгаалсан арга хэмжээ авах хэрэгтэй. Оролцогч улсууд интернэтийн үйлчилгээ эрхлэгч, олон нийтийн цахим сүлжээний компаниуд зэрэг интернэтийн зуучлагчид блогчид эсвэл нийгмийн цахим сүлжээний хэрэглэгчдийн хувийн мэдээллийг төрийн байгууллагад дамжуулахыг шаардах эрхгүй зохицуулалтыг нэвтрүүлэх хэрэгтэй. Байрлуулсан контент нь үзэн ядалт эсвэл хүчирхийллийг уриалах зэрэг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө болох олон улсын стандартаар хамгаалагдсан зохицуулалтыг зөрчсөн байж болзошгүй гэж эрх бүхий байгууллагаас үзсэн бол буруутай этгээд нь олон улсын стандартын дагуу мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагааг дагаж мөрдөх ёстой.

Хэвлэлийн эрх чөлөө

152. ЕАБХАБ-ын гишүүн орнууд “хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээлэл, мэдээ, үзэл бодлыг олж авах, мэдээлэх, түгээх эрхийг” дахин баталгаажуулж, “энэхүү эрхийг хэрэгжүүлэхэд тавигдах аливаа хязгаарлалтыг хууль, олон улсын стандартад нийцүүлэн тогтооно” гэдгийг онцолсон. Мөн бие даасан хэвлэл мэдээллийн “чөлөөт, нээлттэй нийгэм, Засгийн газрын хариуцлагатай тогтолцоонд болон [...] хүний эрх, үндсэн эрх чөлөөг

214 А/HRC/RES/22/6, оршил ба заалт №7.

хамгаалахад” чухал ач холбогдлыг нээлттэйгээр хүлээн зөвшөөрч байна.²¹⁵ Үүнээс гадна бие даасан хэвлэл мэдээллийн хэрэгслийн ач холбогдлыг дахин баталгаажуулж, чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгслийн үндсэн нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авахаа амласан болно.²¹⁶

153. Хэвлэл мэдээллийн орчин нь олон ургалч, олон нийтийн хэлэлцүүлэг, мэдээнд төрөл бүрийн талуудын оролцоог чөлөөтэй дэмждэг байх нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ардчилсан нийгэм дэх чиг үүргээ хэрэгжүүлэх боломжийг олгодог. Энэ тухайд НҮБЕА дурдахдаа сэтгүүлзүй нь мэдээлэл, санаа сэдлийг цахимаар болон цахим бус аргаар хайж олдог, хүлээн авдаг, түгээдэг хэвлэл мэдээллийн байгууллагууд, хувь хүмүүс, бүх төрлийн байгууллагын мэдээллийг хамруулах тал дэр тасралтгүй хөгжиж, [...] ингэснээрээ олон нийтийн хэлэлцүүлгийг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулж байгааг хүлээн зөвшөөрч буйгаа мэдэгдсэн.²¹⁷ Үүнтэй адил НҮБ-ын Хүний эрхийн хорооноос “сэтгүүл зүй бол орон тооны мэргэжлийн сэтгүүлч, шинжээч, блогч, интернэт болон бусад талбарт бие даан хэвлэж нийтлэх замаар оролцдог хүмүүс юм.”²¹⁸ Хүний эрхийг илүү хүндэтгэн хамгаалах, дэмжихийн тулд хэвлэл мэдээллийн орчин нь хүний эрхийг хамгаалагчдад мэргэжлийн сэтгүүлч эсэхээс нь үл хамааран олон нийтийн мэтгэлцээнд оролцох, байлцах боломжийг олгох шаардлагатай. Эсвэл хүний эрхийн асуудлаар мэдээлэх, үүнтэй холбоотой мэтгэлцээн өрнүүлэхэд хувь нэмэр оруулах боломжоор хангах ёстой. Энэ нь хууль ёсны байдал, улмаар хүний эрхийг хамгаалагчдын хамгааллыг бэхжүүлэх талаасаа чухал ач холбогдолтой юм.
154. Хэвлэл мэдээллийн тухай хууль, бодлого, практик нь хүний эрхийг дэмжсэн үйл ажиллагаанд ээлтэй бөгөөд хүний эрхийг хамгаалагчдын эрх ашгийг хамгаалахад хувь нэмрээ оруулдаг нээлттэй, олон ургалч хэвлэл мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх ёстой. Үүнд хүрэхийн тулд удирдамж,

215 Москва 1991, зүйл. 26. 1997 онд оролцогч улсууд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийг хамгаалах, энэ чиглэлээрх ЕАБХАБ-ын холбогдох зарчмууд, хүлээсэн үүрэг хариуцлагын хэрэгжилтийг бэхжүүлэх шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрч, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудлаарх ЕАБХАБ-ын Төлөөлөгчийн газрыг байгуулахаар шийдвэрлэжээ. “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудлаарх ЕАБХАБ-ын төлөөлөгчийн газар байгуулах, ЕАБХАБ-ын хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудлаарх төлөөлөгчийн газрын төлөөлөх эрх”-ийн талаарх Байнгын зөвлөлийн 1997 оны 11-р сарын 5-ны өдрийн 193-р шийдвэрийг үз. Үүрэг амлалт: Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, Мэдээллийн чөлөөт урсгал - 1975-2012, 2013 он, <<http://www.Osce.org/fom/99565?download=true>>, хуу. №32.

216 Станбул 1999, “Европын Аюулгүй Байдлын Дүрэм: III. Бидний нэгдмэл үүрэг”, заалт №26.

217 НҮБЕА-н Тогтоол №68/163, “Сэтгүүлчдийн аюулгүй ажиллагаа ба Ял шийтгэлээс зугтах тухай асуудал”, НҮБ-ын Б.6. А/RES/68/163, батлагдсан 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан, оршил-г үз.

218 НҮ-ий Хүний Эрхийн Хороо, ерөнхий тайлбар №34, Зүйл №19, заалт №44.

ёс зүйн хэм хэмжээ эсвэл бусад стандарт, өөрийгөө зохицуулах механизм боловсруулахад хэвлэл мэдээллийн байгууллагуудыг хөхиүлэн дэмжих нь зүйтэй. “Хэвлэлийн зөвлөл, омбудсман зэрэг үр дүнтэй өөрийгөө зохицуулах механизмын ач холбогдол”, түүнчлэн “зөвлөлдөх, оролцооны явцад байгуулагддаг механизмуудтай болох, [...] засгийн газрын ашиг сонирхлоос хараат бус байх”²¹⁹ хэрэгцээ шаардлагыг ерөнхийд нь хүлээн зөвшөөрдөг. Өөрийгөө зохицуулах ийм арга хэмжээ нь хүний эрх, хүний эрхийг хамгаалагчийг хамгаалах чиглэлээр ажилладаг хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг хариуцлагыг тусгах ёстой.

155. Оролцогч улсууд цахим хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд шууд, эсвэл шууд бус байдлаар шүүлтүүр тавих ёсгүй. Мөн хүний эрхийг хамгаалдаг сэтгүүлчдийг, мөн хүний эрхийн асуудлаар мэдээлдэг, холбогдох олон нийтийн хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулдаг бусад хүмүүсийг зогсоох зорилготой төрөл бүрийн дарамт шахалт үзүүлэхээс татгалзах үүрэгтэй. Нөлөө бүхий хэвлэл мэдээллийн корпорацууд, эсвэл нөлөө бүхий бүлэглэлүүд гэх мэт хувийн хэвшлийнхэн хүний эрхийг хамгаалагчдад шүүлтүүр тавих, дарамт үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх ёстой. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг бодитоор хангах чухал арга хэмжээнүүдийн нэг болгож, ЕАБХАБ-ын гишүүн орнууд “бүх төрлийн мэдээллийг чөлөөтэй, өргөн хүрээнд түгээн дэлгэрүүлэх, мэдээллийн салбар дахь хамтын ажиллагааг дэмжих, сэтгүүлчдийн ажиллах нөхцөлийг сайжруулах чиглэлээр цаашид хүчин чармайлт гарган ажиллах үүрэг хүлээсэн.”²²⁰ Ялангуяа “сэтгүүлчийн мэргэжлийн хууль ёсны үйл ажиллагаа тэднийг албадан гаргах, эсхүл аливаа өөр шийтгэл хүлээлгэх шалтгаан болохгүй. Сэтгүүлчдийн бэлтгэсэн сурвалжилгын агуулга, эсвэл хэвлэлийн мэдээллээс нь болж сэтгүүлчийн мэргэжлийн үнэмлэхийг хураан авах, эсвэл түүнийг албадан гаргах гэх мэт хязгаарлалтын арга хэмжээ авахаас зайлсхийх үүрэг хүлээснийг нь эргэн сануулсан.”²²¹ Хүний эрхийн асуудлаар мэдээлэх, эсвэл холбогдох олон нийтийн хэлэлцүүлэгт хувь нэмрээ оруулахдаа үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангахын тулд мэргэжлийн сэтгүүлч биш боловч, олон нийтийн хэлэлцүүлэгт хувь нэмрээ оруулдаг хувь хүнийг хөндлөнгийн хууль бус нөлөөллөөс хамгаалах зохих арга хэмжээ авах хэрэгтэй.

219 “15 дахь Төв Азийн Хэвлэл мэдээллийн Чуулган: ЕАБХАБ-ын хэвлэл мэдээллийн эрх чөлөөний үүрэг амлалтаа дүгнэх нь”, Бишкек, Киргизстан, 2013 оны 6 дугаар сарын 27-28, 15 жилийн ойн Тунхаг, заалт №13, <<http://www.Osce.org/fom/104110>>.

220 Вена 1989, “Хүмүүнлэгийн болон бусад салбар дахь хамтын ажиллагаа”, заалт №34.

221 Эх. сурв. заалт №39.

156. Иймд оролцогч улсууд дараах арга замаар “сэтгүүлчдэд бие даан, хууль бус хөндлөнгийн нөлөөнөөс ангид ажлаа хийх аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлэх ёстой. Үүнд: (а) хууль тогтоомжийн арга хэмжээ; (б) шүүх засаглал, хууль сахиулах байгууллагын ажилтнууд, цэргийн алба хаагчид, түүнчлэн сэтгүүлчдэд иргэний нийгэмд олон улсын хүний эрхийн болон хүмүүнлэгийн хуулиар хүлээсэн сэтгүүлчийн аюулгүй байдалтай холбоотой үүрэг хариуцлага, үүрэг амлалтуудын талаар мэдлэг олгох; (в) сэтгүүлчдийн эсрэг халдлагыг хянах, мэдээлэх; (г) халдлагыг олон нийтэд нээлттэй буруушаах; (д) ийм халдлагыг мөрдөн шалгах, шүүн таслахад шаардлагатай нөөцийг зориулах”²²² зэрэг болно. Хүний эрхийг хамгаалахад хувь нэмрээ оруулж буй сэтгүүлчдийг түрэмгий хэт даврагч болон зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд зэрэг төрийн болон төрийн бус талуудын аль алины зүгээс үйлдэх халдлага, бусад зөрчлөөс үр дүнтэй хамгаалах нь чухал юм.

Д. Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө

157. НҮБ-ын тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхийн тухай Тусгай илтгэгч “тайван жагсаал, цуглаан хийх нь ардчилсан өөрчлөлт хийх уриалга гаргах; хүний эрхийг илүү хүндэтгэх [...] ба хүний эрхийн зүй бус үйлдэл, зөрчилд хариуцлага тооцох хууль ёсны бөгөөд хүчирхэг хэрэгсэл юм.”²²³ Үүнтэй холбогдуулан тэрбээр иргэний нийгмийн төлөөлөл, тэр дундаа хүний эрхийг хамгаалагчид үзэл, бодлоо олон нийтэд таниулах, хамгаалж буй эрхийн хэрэгжилтэд хувь нэмэр оруулах боломжийг олгодог тул тайван жагсаал, цуглаан зохион байгуулах боломж нэн чухал болохыг онцолсон.²²⁴

158. Тайван жагсаал, цуглаан хийх эрх нь ХЭТТ-ийн 20 дугаар зүйл, ИУТЭОУП-ийн 21 дүгээр зүйл, ХЭҮЭЧК-ын 11 дүгээр зүйл, ХЭАК-ийн 15 дугаар зүйл, ҮЦХСК-ын 7 дугаар зүйл зэрэг олон улсын хүний эрхийн хэд хэдэн баримт бичигт тусгагдсан болно. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглал нь энэхүү эрхийг дахин баталгаажуулж, улсын болон олон улсын түвшинд хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилгын хүрээнд ач холбогдлыг онцгойлон тэмдэглэсэн (5 дугаар зүйл).²²⁴

159. ИУТЭОУП-ын 21 дүгээр зүйлд заасны дагуу ардчидсан нийгэмд зайлшгүй байх үндэсний аюулгүй байдал, олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журам, нийгмийн эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах эсвэл бусдын

222 А/RES/68/163, заалт №6.

223 А/HRC/23/39, 2013 оны 4 дүгээр сарын 24, заалт №80. Тусгай илтгэгч нь энэ мэдэгдлийг гаргахдаа “Арабын хавар”, “эзэл хөдөлгөөн” зэргийг дурдсан.

224 Эх. сурв. заалт №43.

эрх, эрх чөлөөг хамгаалахаас бусад тохиолдолд тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хязгаарлахыг хориглон гэж заасан байдаг.²²⁵ Эдгээр бүх хязгаарлалт хууль ёсны, зайлшгүй байх болон пропорциональ зарчмыг чандлан дагаж мөрдөх ёстой. Түүнчлэн ялгаварлан гадуурхахыг хориглох зэрэг хүний эрхийн бусад үндсэн хэм хэмжээтэй нийцэж байх ёстой бөгөөд тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний мөн чанарыг алдагдуулж болохуйц байдлаар ашиглах ёсгүй.²²⁶ НҮБ-ын тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний асуудал хариуцсан Тусгай илтгэгч улс орнууд тогтоосон аливаа хязгаарлалтдаа цаг тухайд нь нарийвчилсан, бичгэн тайлбар өгч, тэрхүү хязгаарлалтыг цаг алдалгүй, бие даасан, хараат бус шүүхээр хянан шийдвэрлэх боломжоор хангах ёстой гэдгийг дахин онцолсон.²²⁷

160. ЕАБХАБ-ын үүрэг амлалтад зааснаар “хүн бүр тайван жагсаал, цуглаан хийх эрхтэй. Эдгээр эрхийг хэрэгжүүлэхэд аливаа хязгаарлалтыг хуулиар тогтоох бөгөөд олон улсын стандартад нийцсэн байна.”²²⁸ Цаашлаад ЕАБХАБ/АИХЭГ-Венецийн Хорооны Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай удирдамжид “хүний үндсэн эрх болохын хувьд тайван жагсаал, цуглаан хийх эрхийг аль болох эрх зүйн зохицуулалтгүйгээр эдлэх ёстой” гэж заасан.²²⁹ Тайван жагсаал, цуглааныг хөхиүлэн дэмжих, хамгаалах, энэ эрх чөлөөг хууль бус хүнд сурталтай зохицуулалтаас ангид байлгах нь төрийн үүрэг.²³⁰
161. Эдгээр болон бусад баталгааг үл харгалзан хүний эрхийг хамгаалагч нар энэ эрхийг бүрэн хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн болон захиргааны саад

225 ХЭҮЭЧК-ын 11-р зүйлд энэхүү заалт нь зэвсэгт хүчин, цагдаа, эсвэл төрийн захиргааны байгууллагын гишүүдийн эдгээр эрхийг эдлэх явдалд хууль ёсны хязгаарлалт тавихыг хориглохгүй гэж заасан байдаг. Гэсэн хэдий ч, аливаа хязгаарлалт нь хуулиар тогтоосон, зайлшгүй, пропорциональ байх ёстой бөгөөд эдгээр бүлэгт багтдаг хүний эрхийг хамгаалагч нар мөн үндэслэлгүйгээр тогтоосон хязгаарлалтаас ангид тайван цуглаан, жагсаал хийх эрхээ эдлэх ёстой.

226 НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны ерөнхий тайлбар №31, “Конвенцод нэгдсэн улсуудад тавигдах эрх зүйн ерөнхий хариуцлагын мөн чанар”, НҮБ-ын Б.Б. ССРР/С/21/Rev.1/Add.13, 2004 оны 5-р сарын 26, заалт №6-г тус тус үз. Ёс суртахууныг хамгаалахад хязгаарлалт тавих тухайд, НҮБ-ын Хүний Эрхийн Хорооноос ёс суртахууны ойлголт нийгмийн, гүн ухааны, шашны олон уламжлалаас гаралтай болохыг онцолжээ. Тиймээс ёс суртахууныг хамгаалах зорилгоор тавих хязгаарлалт нь зөвхөн нэг уламжлалаас үүдсэн бус зарчмууд дээр суурилах ёстой ч, нэгэн зэрэг хүний эрхийн нийтлэг байдал, үл ялгаварлан гадуурхах зарчмын үүднээс ойлгогдох ёстой. Ерөнхий тайлбар №34, Зүйл №19, НҮБ-ын Б.Б. ССРР/С/GC/34, 2011 оны 9 дүгээр сарын 12, заалт №32-г үз. Дээрх хэсгийг Ерөнхий зарчмууд - Хүний эрхийн ажлын хүрэн дахь үндсэн эрхийн хязгаарлалтын хууль ёсны ба пропорциональ байдал гэснээс үз.

227 А/HRC/23/39, 2013 оны 4 дүгээр сарын 24, заалт №81 (с).

228 Копенхаген 1990, заалт №9 (2).

229 ЕАБХАБ/АИХЭГ-Венецийн Хороо, Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний удирдамж, 2 дахь хэвлэл, (Варшав/ Страссбург, 2010), заалт №2.1.

230 Эх. сурв. заалт №2.2.

бэрхшээлтэй оролцогч олон оронд тулгарсаар байна. Тухайлбал зарим оролцогч улс оронд жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй холбоотой үндэсний хууль тогтоомж нь ерөнхий зохицуулалттай бөгөөд тодорхой, нарийвчлан зохицуулах зарчим, хянан шийдвэрлэх ажиллагаагүй байна. Практикт энэ нь холбогдох заалтуудыг дур зоргоороо, хэт хязгаарласан утгаар тайлбарлах, хэрэглэхэд хүргэдэг. Олон оролцогч улсад жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй холбоотой хууль тогтоомж нь эрх баригчдад цуглааны агуулга, арга хэлбэр, цаг хугацаа, болох газар зэрэг жагсаал, цуглааныг зохицуулах хэт давуу эрх олгож, жагсаал, цуглаан зохион байгуулагчдад дарамттай, хэт өндөр хариуцлага хүлээлгэдэг. Түүнчлэн зарим оролцогч улс орны хууль тогтоомжид тайван жагсаал, цуглаан хийхээсээ өмнө төрөөс зөвшөөрөл авахыг шаарддаг ба хууль, тогтоомжийг зөрчсөнтөхиолдолд харьцангуй хариуцлага ногдуулдаг бөгөөд хүмүүсийг тайван жагсаал, цуглаан хийх эрхээ эдлэхээс татгалзахад хүргэдэг.

162. **Хууль, эрх зүйн орчин:** Оролцогч улсуудын жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй холбоотой хууль тогтоомж нь олон улсын хүний эрхийн стандарт, ЕАБХАБ-ын хүлээсэн үүрэгтэй бүрэн нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах ёстой. Холбогдох хууль тогтоомжууд нь энэхүү эрхийг хамгаалах үндсэн зарчмуудыг тодорхой тусгаж өгөх ёстой. Эдгээрт тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө нь хүний үндсэн эрх бөгөөд ардчилсан нийгэмд зайлшгүй чухал байх ёстой зарчим юм; жагсаал, цуглаан зохион байгуулахыг дэмжих үзэл хандлага; тайван жагсаал, цуглааныг дэмжих, хамгаалах эерэг үүрэг; хууль ёсны, пропорциональ, үл ялгаварлан гадуурхах, сайн зохицуулалтын зарчмууд зэрэг багтана.²³¹ Эдгээр зарчим, хүний эрхийн олон улсын стандартад нийцэхгүй хууль, практикийг нэн даруй нэмж, өөрчлөх буюу хүчингүй болгох шаардлагатай.
163. Оролцогч улсууд иргэний нийгэм, түүний дотор хүний эрхийг хамгаалагчидтай утга учиртай, үл ялгаварлан гадуурхсан зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулж, холбогдох хууль, эрх зүйн санаачилгуудыг талаарх хэлэлцүүлэгт тэдний чөлөөт, идэвхтэй оролцоог хангах ёстой. Тэдний хувь нэмрийг бүрэн дүүрэн хангахын тулд хүний эрхийг хамгаалагчдыг зөвлөлдөх уулзалтад аль болох анхнаас нь оролцуулах хэрэгтэй. Холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулах эсвэл хянах шатанд оролцдог эрх бүхий байгууллагууд, түүнчлэн түүнийг хэрэгжүүлэхэд оролцсон улсын, бүс нутгийн болон орон нутгийн засаг захиргаа, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн зэрэг байгууллагуудад ЕАБХАБ/АИХЭГ-Венецийн Хорооны тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний удирдамжийг хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Уг удирдамжид заасны дагуу

231 Эх. сурв. заалт №2.1-2.6.

“дотоодын хууль тогтоомжийг олон улсын болон бүс нутгийн холбогдох эрх зүйн болон сайн туршлагад нийцүүлэн боловсруулж, тайлбарлаж, хэрэгжүүлэх ёстой.”²³² Иймд оролцогч улс орнууд ЕАБХАБ/АИХЭГ, Европын Зөвлөлийн Венецийн хороо зэрэг хууль эрх зүйн дүн шинжилгээгээр мэргэшсэн олон улсын байгууллагуудын шинжээчдийн тусламжийг эрэлхийлж, эдгээр болон Европын зөвлөлийн хүний эрхийн комиссар, НҮБ-ын тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч, НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн тусгай илтгэгч зэрэг хүний эрхийн бусад механизмын санал, зөвлөмжийг тусгаж хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

164. **Хууль эрх зүйн зохицуулалтын хэрэглээ, процессийн тухай:** Оролцогч улсууд хүний эрхийг хамгаалагчдын тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг бүрэн эдлэхийг идэвхтэй хөхиүлэн дэмжих ёстой. Холбогдох хууль тогтоомж нь олон улсын стандартад нийцсэн байх бөгөөд хуульд зааснаас бусад тохиолдолд тайван жагсаал, цуглаан хийхийг хориглож үл болно. Энэхүү эрхээ хэрэгжүүлэхдээ эрх бүхий байгууллагаас урьдчилан зөвшөөрөл авах ёсгүй. Харин урьдчилан мэдэгдсэнээр эрх бүхий байгууллага, эрх баригчид “жагсаал, цуглаан хийх эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах, эрхээ эдлэх боломж бололцоог бүрдүүлэхэд шаардлагатай зохицуулалтуудыг хийж, бэлтгэл ажлыг хангах” ёстой.²³³ Шаардлагатай тохиолдолд урьдчилан мэдэгдэх журам нь энгийн бөгөөд шуурхай байх хэрэгтэй. Үүнд эрх бүхий байгууллага хэзээ ба хэрхэн жагсаал, цуглаан хийхийг хориглох боломжтойг нарийвчлан тодорхойлж өгснөөр эрх бүхий байгууллагын бүрэн эрхийн асуудал мэт болохоос хамгаалах юм. Хэрэв эрх бүхий байгууллага мэдэгдэлд цаг хугацаанд нь хариу өгөхгүй бол олон нийтийн жагсаал, цуглааныг зохион байгуулагчид өөрсдийн мэдэгдэлдээ заасан нөхцөл, хугацааны дагуу хорио, хязгаарлалтгүйгээр үйл ажиллагаагаа зохион байгуулах боломжтой байх ёстой.²³⁴
165. Гэсэн хэдий ч зарим оролцогч улс бодит байдал дээр үндэслэлгүй хязгаарлалт тогтоох, тайван жагсаал, цуглаанд саад болох, үймүүлэх янз бүрийн тактик ашиглах зэргээр тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг ихээхэн хязгаарладаг. Үүний үр дүнд цөөнхийн буюу гадуурхагдсан бүлгийн тэгш эрхийн төлөө эсвэл эрх баригчдыг шүүмжилсэн олон нийтийн уулзалт, явган жагсаал, эсэргүүцлийн жагсаал зохион байгуулахаар ажиллаж буй хүний эрхийг хамгаалагчдад ихэнх тохиолдолд зөвшөөрөл

232 Эх. сурв. заалт №12.

233 ЕАБХАБ/АИХЭГ-Венецийн Хороо, “Найрамдах Киргиз улсын тайван цуглаан, жагсаал хийх эрхийн тухай хуулийн төсөлд хийсэн хамтарсан дүгнэлт”, CDL-AD (2010)050, заалт №13.

234 ЕАБХАБ/АИХЭГ-Венецийн Хорооны Удирдамж, заалт №4.1.

олгодоггүй эсвэл зохион байгуулах боломжгүйд хүргэдэг.²³⁵ Жагсаал, цуглааныг нийгэмд маргаантай гэж үзсэн тодорхой үзэл бодлыг тусгасан эсвэл эрх баригчдын эсрэг үзэл бодлоо илэрхийлэхээр зохион байгуулах гэж буйг хориглон агуулгад үндэслэсэн хязгаарлалтууд тогтоох нь олон улсын холбогдох стандарт, зарчимтай нийцэхгүй.²³⁶ Мөн жагсаал, цуглааны агуулгад албан ёсоор үндэслэн хориглоогүй ч боловч зохион байгуулагчид нь эрх баригчдыг шүүмжилдэг эсвэл нийгэмд маргаантай асуудалтай холбоотой гэж үзсэний улмаас хязгаарлахыг дээр дурдсаны адилд тооцно. Олон улсын хүний эрхийн стандартын дагуу жагсаал, цуглааны үеэр илэрхийлсэн аливаа санаа, агуулгад тавигдах хязгаарлалтад маш өндөр босго тогтоох ёстой бөгөөд зөвхөн хүчирхийллийн шууд аюул заналхийлж байгаа тохиолдолд л тавих ёстой.²³⁷

166. Үүнтэй адил тайван жагсаал, цуглаан хийх цаг хугацаа, газар, арга хэлбэрт тавих хязгаарлалтууд зөвхөн олон улсын стандарт, хууль ёсны, зайлшгүй, пропорциональ, үл ялгаварлан гадуурхах зарчимд бүрэн нийцсэн байх ёстой. Оролцогч улсууд аюулгүй байдлын эрсдэлийг үнэлэх, түүнийг шийдвэрлэх замаар тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг бодитоор хэрэгжүүлэх боломжийг хангах арга барил, журмыг бий болгох ёстой. Жагсаал, цуглаанд ямар нэгэн хууль ёсны хязгаарлалт хийх талаар эцсийн шийдвэр гаргахаасаа өмнө эрх бүхий байгууллага зохион байгуулагчдад

235 Жишээлбэл: 2006, 2007, 2008 онуудын турш Москвад ЛГБТ Бахархлын явган жагсаал хийхийг хориглосон тухай Алексеевын Оросын эсрэг мэдүүлсэн хэрэгт Европын Хүний эрхийн шүүхийн гаргасан шийдвэр (Өргөдөл №1916 / 07, 25924/08, 14599/09, 2010 оны 10-р сарын 21) -ийг үз. Эрх баригчид зөвшөөрөлгүй жагсаалуудыг тарааж, зөрчсөн оролцогчдыг захиргааны зөрчил гаргасанд тооцож хориггоо хэрэгжүүлсэн. Нийтийн хэв журам зөрчигдөж болзошгүй, оролцогчдын эсрэг хүчирхийлэл гарч болзошгүй байсан ба нийтийн ёс суртахууныг хамгаалах зорилгоор энэхүү хориг зайлшгүй шаардлагатай байсан гэж холбогдох албаны хүмүүс мэдэгдэв. ЕХЭШ шийдвэртээ ХЭҮЭЧК-ын 11 дүгээр зүйл нь хөхиүлэн дэмжиж буй санаа, эсвэл шаардлагыг хандуулан тавьж буй хүмүүсийн дургүйцлийг хүргэх, эсвэл гутаан доромжилж болзошгүй жагсаалуудыг хамгаалдаг болохыг нотолсон (заалт №73). Цаашилбал, “Хэрэв жагсаалын үеэр сөрөг бүлгүүд хоорондын хурцадмал байдал, халуун маргаан үүсэх магадлал бүр нь түүнийг хориглоход хүргэх юм бол нийгэм олонхын санаа бодлыг хөндөж буй аливаа асуудалд өөр бусад байр суурийг сонсох боломжоо хасуулж байна гэсэн үг. “2005 онд Варшавт болсон ЛГБТ-ийн бахархлын жагсаалыг хориглосон нь тайван цуглаан, жагсаал хийх эрх чөлөө, түүнчлэн ялгаварлан гадуурхалтыг хориглох, түүнээс хохирсон хохирлоо нөхөн сэргээлгэх эрхийг зөрчсөн гэж тус Шүүх тогтоосон Белжковски ба бусдын Польшийн эсрэг гаргасан шүүхийн нэхэмжлэлийг (Өргөдөл №1543/06, 2007 оны 5-р сарын 3-ны өдөр) үз.

236 Жишээлбэл: НҮБ-ын Хүний Эрхийн Хороо “Босни-Херцеговинд хийсэн нэгдсэн дүгнэлт”, НҮБ-ын Б.б. ССРР/С/ВИН/СО/2, 2012 оны 11-р сарын 13, заалт №19. Тус хороо хотын дарга Омарскад болсон хүчирхийллээс хойш 20 жил өнгөрсний ойг тэмдэглэхийг хориглосон Прижедор хотод 2012 оны 5-р сард цуглаан, жагсаал хийхийг хязгаарласан тухай мэдээнд санаа зовниж буйгаа илэрхийлсэн. Хорооноос Омарскад үйлдсэн гэмт хэргийг дурдахдаа: “төрлөөр устгах” гэсэн нэр томъёо хэрэглэхийг хориглосон заалтыг дагаж мөрдөөгүй тохиолдолд шүүхэд татах болно гэсэн олон нийтэд зарласан мэдэгдлүүд санааг нь зовоож буйг мэдэгдсэн. Хороо нь тухайн гэрээний улсыг цуглаан, жагсаал хийх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх тухай Пактын хатуу шаардлагыг дагаж мөрдөхийг уриалж, Прижедор хотод хүндэтгэл үзүүлэх ёслолыг хориглосон явдал хууль ёсны эсэхийг судлахыг уриалав.

237 Эх. сурв. заалт №3.3.

мэдэгдэж, энэ асуудлаар байр сууриа илэрхийлэх боломжийг олгох ёстой. Мөн тайван жагсаал, цуглааныг өөр газар хийлгэх бол зорилтот бүлгийнхээ “нүдэнд харагдаж, чихэнд сонсогдохуйц” байрлалд жагсаал, цуглааныг зохион байгуулах боломжит хувилбаруудыг санал болгох ёстой.²³⁸

167. Эрх бүхий байгууллага жагсаал, цуглаан хийх газруудыг тодорхойлохдоо нийтийн тээврээр хүрч очиход хүндрэлтэй эсвэл боломжгүй газруудад цуглаан хийлгэдэг бөгөөд хүний эрхийг хамгаалагчид зорилтот бүлэгтээ хүрч ажиллах боломжийг хаадаг. Явган хүний болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, худалдааны болон өдөр тутмын бусад үйл ажиллагаанд саад учруулж гэдэг нь хязгаарлалтыг зөвтгөх түгээмэл шалтгаан юм. “Байршил нь жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний гол хүчин зүйлсийн нэг” бөгөөд олон нийтийн жагсаал, цуглаанд оролцогчид цэцэрлэгт хүрээлэн, талбай, гудамж, зам, өргөн чөлөө, явган зам гэх мэт төв, хүртээмжтэй нийтийн эзэмшлийн газруудыг бусад хүмүүсийн адил зохих хугацаагаар ашиглах эрхтэй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй юм.²³⁹
168. Жагсаал, цуглаанд очих замыг хаах, жагсаал, цуглаанд нэгдэхээр яваа оролцогчдыг зогсоох, саатуулах, айлган сүрдүүлэх эсвэл зохион байгуулагч, оролцогчдын жагсаал, цуглааны өмнө болон жагсаал, цуглааны үеэр зохион байгуулалтын зорилгоор ашигладаг интернэт, гар утасны үйлчилгээнд нэвтрэх эрхийг хязгаарлах гэх мэт болон бусад тактик ашиглан өмнө нь дурдсан жагсаал, цуглааныг зорилтот бүлгийн “нүд, чих”-нээс хол байлгах аргатай хослуулан хэрэглэж тайван жагсаал, цуглаан хийх эрхээ бүрэн эдлэхэд саад болж жагсаал, цуглааныг тараан, бутаргадаг. Жагсаал, цуглаанд оролцох иргэдийн хүсэл болон зохион байгуулагчдын жагсаал, цуглаан зохион байгуулах хүслийн аль алинд саад болох ёсгүй.
169. Хуульд жагсаал, цуглаан зохион байгуулахтай холбоотой ерөнхий хязгаарлалтад бүх жагсаал, цуглааныг тодорхой цагт, тодорхой газар эсвэл жагсаал, цуглаанд тохиромжтой газарт зохион байгуулахыг хориглох нь пропорциональ байдлын шалгуурт тэнцэхгүй бөгөөд тохиолдол тус бүрийн нөхцөл байдлын онцлогийг тусгадаггүй.²⁴⁰ Иймд оролцогч улсууд эдгээр хоригийг хууль, практик хэрэглээнээс хасч, цуглаан бүрийн тодорхой нөхцөл байдлыг зохих байдлаар харгалзан үзэх ёстой.
170. Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалын 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу оролцогч улсууд тайван жагсаал, цуглаан хийх эрх

238 A/HRC/23/39, заалт №83 (с).

239 Тунис дэх “олон нийтийн уулзалт, явган жагсаал, цугларалт, эсэргүүцлийн жагсаал, цуглааны зохицуулалтын эрх зүйн баримт бичигт өгсөн дүгнэлт”, OSCE/ODIHR, FOA-TUN/218/2012, заалт №56.

240 ЕАБХАБ/АИХЭГ-Венецийн Хорооны Удирдамж, заалт №43.

чөлөөгөө бие даан болон бусадтай эвсэн хууль ёсоор эдэлснийхээ төлөө “аливаа хүчирхийлэл, заналхийлэл, хариу арга хэмжээ, де-факто эсвэл де-юре ялгаварлан гадуурхалт, дарамт шахалт болон бусад аливаа дур зоргоор аашлах үйлдэлд өртөхөөс хүн бүрийг эрх бүхий байгууллага хамгаалах баталгааг хангахад шаардлагатай бүх арга хэмжээг авна. “Уламжлалт үнэт зүйлсэд шүүмжлэлтэй хандаж буй эсвэл улс төрийн хэт туйлширсан үзэл бодлыг эсэргүүцэх зорилготой тайван жагсаал, цуглааныг мөн эрх тэгш хамгаалах ёстой. Энэ төрлийн жагсаал, цуглаанд үндэстний цөөнх, угсаатны эсвэл шашны бүлэгт харьяалагддаг хүмүүс, Рома, Синти, дүрвэгчид, цагаачдын төлөөх, ЛГБТИ-ийн бахархлын явган жагсаал зэрэг арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, ксенофоби буюу гадаад хүнийг үзэн ядах үзэл, үл тэвчих явдлыг эсэргүүцэх жагсаал багтах төдийгүй үүгээр хязгаарлагдахгүй. НҮБ-ын Тайван жагсаал, цуглаан, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч хэлсэн үгэндээ “хүчирхийлэл, ялгаварлан гадуурхах эрсдэлд хамгийн их өртөж буй бүлгүүд эдгээр жагсаал, цуглаан хийх боломж байх нь тэдний хувьд маш их ач холбогдолтой бөгөөд цөхрөнгөө барсан нөхцөл байдлаа утга учиртай арга хэлбэрээр илэрхийлж буй хэлбэр юм” гэжээ.²⁴¹ Мөн хувь хүн болон бүлэг, түүний дотор бүртгэлтэй болон бүртгэлгүй холбоод энэ үндсэн эрхээ эдэлж, ашиглах боломжтой байж, үүнийг төрийн зүгээс бүрэн хамгаалах ёстой гэдгийг давтан дурдах нь зүйтэй. Оролцогч улсуудын тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг баталгаажуулах үүрэг нь төрийн бүх салаа салбарт бүхэлдээ хамаатай. Иймд засгийн газрын төв удирдлагууд, нутгийн өөрөө удирдах болон бусад эрх баригчид ч энэ үүргийг дагаж мөрдөх ёстой бөгөөд холбооны муж улсуудын хувьд холбооны бүх байгууллагууд энэ үүргийг нэгэн адил хүлээх ёстой.

171. НҮБ-ын Тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний эрхийн асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч нь жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх боломжийг бий болгоход мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологи, түүний дотор интернэт, гар утасны үйлчилгээ чухал үүрэг гүйцэтгэж байгааг тэмдэглэв.²⁴² Түүнээс гадна НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл “бүх хүний цахимаар болон цахим бус аргаар [...] тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хүндэтгэж, бүрэн хамгаалах” оролцогч улсуудын үүргийг цохон тэмдэглэв.²⁴³ Үүний дагуу оролцогч улсууд хүний эрхийг хамгаалагчид жагсаал, цуглаан зохион байгуулах, удахгүй болох үйл явдлын талаарх мэдээлэл түгээх, бусад холбогдох үйл ажиллагааг зохион байгуулах зэрэгт технологийг чөлөөтэй

241 A/HRC/23/39, 2013 оны 4 дүгээр сарын 24, заалт №80.

242 A/HRC/20/27, 2012 оны 5 дугаар сарын 21-ий өдөр, заалт №32 ба 84 (k).

243 A/HRC/RES/24/5, 2013 оны 10 дугаар сарын 8.

ашиглах боломжийг бүрдүүлж өгөх үүрэгтэй. Эдгээр хэрэгслийг хүний эрхийг хамгаалагчид ашиглах, нэвтрэхийг хориглосон практик, хууль тогтоомжийг эрх баригчид цуцлах ёстой. Ийм нэвтрэх, ашиглахтай холбоотой аливаа хязгаарлалтыг шүүх хянан шийдвэрлэх ёстой.²⁴⁴

172. **Аяндаа үүссэн, давхацсан ба урьдчилан мэдэгдээгүй жагсаал, цуглаанууд:** Оролцогч улсууд төрөл бүрийн тайван жагсаал, цуглаан, тэр дундаа төлөвлөөгүй болон давхацсан цуглаануудыг зохицуулж, хамгаалалтаар хангах ёстой. Аяндаа үүссэн жагсаал, цуглаанууд нь ихэвчлэн тодорхой үйл явдлын улмаас гэнэт болдог тул урьдчилан мэдэгдэх шаардлага байсан ч, түүнийг хангах боломжгүй юм. Цаашилбал ийм арга хэмжээ нь ихэвчлэн урьдчилсан зарлал, урилгагүй, тодорхой зохион байгуулагчгүй болдог тул урьдчилж мэдэгдэл хийх боломжгүй байдаг. Гэсэн хэдий ч аяндаа үүссэн тайван жагсаал, цуглаан хийх явдлыг бүрэн хамгаалж, хуулиар хүлээн зөвшөөрөн, “эрүүл ардчиллын (онцгой гэхээсээ илүү) агуулах ёстой шинж чанар” гэж үзэх хэрэгтэй.²⁴⁵ Үүний нэгэн адил давхацсан жагсаал, цуглааныг мөн зөвшөөрөх, хамгаалах, зохион байгуулах болон байршлаар хангах шаардлагатай. “Хэрэв ингэх боломжгүй бол (жишээ нь: зай талбай байхгүй г.м) талуудад харилцан сэтгэл ханамжтай шийдвэрлэх арга замыг олохын тулд яриа хэлэлцээ хийхийг зөвлөх хэрэгтэй.”²⁴⁶ Эсэргүүцлийн жагсаал, цуглаан зохион байгуулагдах үед эрх баригчид тэднийг зорилтот олон нийтдээ “харагдахуйц, сонсогдохуйц” байхаар шаардлагатай бүх арга хэмжээг авах хэрэгтэй. Гэсэн хэдий ч, “эсэргүүцлийн жагсаал, цуглааний гол үйл явдлыг тасалдуулахгүй байх нь төрийн үүрэг хариуцлага гэдгийг анхаарах хэрэгтэй.”²⁴⁷

173. Урьдчилан мэдэгдээгүй жагсаал, цуглаанд оролцсон хүний эрхийг хамгаалагчдад ийм жагсаал, цуглаанд жагсагчаар оролцсоных нь төлөө торгууль, хорих ял, шийтгэл, эрүүгийн эсвэл захиргааны хариуцлага хүлээлгэж болохгүй.²⁴⁸ Жагсаал, цуглаан хийхэд тавигдах албан ёсны эрх зүйн шаардлагыг биелүүлээгүйн улмаас ногдуулж буй хариуцлагын арга хэмжээ нь гаргасан хохиролын хэмжээтэй пропорциональ байх ёстой бөгөөд түүнийг үл ялгаварлан гадуурхах зарчим хэрэглэх ёстой. Хуулийн холбогдох аливаа заалтыг дагаж мөрдөөгүй тохиолдолд тооцох хариуцлагыг нарийн тодорхой заах ёстой. Оролцогч улсууд тайван

244 А/HRC/23/39, заалт №83 (e).

245 ЕАБХАБ/АИХЭГ-Венецийн Хорооны Удирдамж, заалт №128.

246 Эх. сурв. заалт №122.

247 Эх. сурв.

248 А/HRC/20/27, заалт №29.

жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбоотой захиргааны болон бусад зөрчилд буруутгагдаж байгаа бүх хүмүүс өөрийн сонгосон өмгөөлөгч авах болон шүүх хуралдаанд хариуцагчаар татагдахад хангалттай бэлдэх хугацаа өгөх зэрэг шүүхэд хэрэг хянан шийвэрлэх тухай хуулиар хамгаалагдсан хууль ёсны байдлыг хангах ёстой. Тайван жагсаал, цуглааныг зохион байгуулсан хүний эрхийг хамгаалагчид жагсаал, цуглааны үед бусад оролцогчдын хууль бус үйлдэлд оролцоогүй бол хариуцлага хүлээх ёсгүй.

174. **Хэв журам сахиулах ба хүч хэрэглэх:** Хууль сахиулах байгууллагын ажилтнууд жагсаал, цуглааны үеэр хүч хэрэглэхээс зайлсхийх, хэрэв боломжгүй бол байж болох хамгийн бага хэмжээнд хүртэл хязгаарлах ёстой.²⁴⁹ Хэрэглэсэн хүч нь зөвхөн үймээнд гар бие оролцсон этгээдүүдэд чиглэх ёстой ба пропорциональ зарчмыг хатуу баримтлана. Оролцогчдын цөөн хэсэг эсхүл гаднын этгээдүүд эсвэл хөлсний өдөөн турхирагчид зүй бус үйлдэл гаргасан тохиолдолд тайван жагсаал, цуглаан автоматаар тайван бус жагсаал, цуглаан болж хувирдаггүй.²⁵⁰ Жагсаал, цуглааны хэв журам сахиулж буй хууль сахиулах ажилтнууд ийм үйлдлүүдэд төвлөрч тайван байсан жагсаал, цуглааныг хүчээр тараах зэргээр тайван оролцогчдын жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг зөрчилгүйгээр, ялгамжтай хариу үйлдэл үзүүлэх ёстой.

249 НҮБ-ын Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудын ёс зүйн дүрмийн дагуу хууль сахиулах байгууллагын ажилтнууд зөвхөн, нэн шаардлагатай тохиолдолд, үүргээ гүйцэтгэхэд шаардагдах хэр хэмжээгээр л хүч хэрэглэж болно. Энэ нь хүч хэрэглэх нөхцөл шаардлага нь бөгөөд ямар ч тохиолдолд зохистой хэмжээнээс давах ёсгүй гэсэн үг юм. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1979 оны 12-р сарын 17-ны өдрийн 34/169 тогтоолоор батлагдсан НҮБ-ын “Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудын ёс зүйн дүрэм”-ийн 3-р хэсгийг” үз. Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд хүч, галт зэвсэг ашиглах НҮБ-ын үндсэн зарчим (цаашид НҮБ-ын үндсэн зарчим гэх) цаашид хууль сахиулах байгууллагын ажилтнууд үүргээ гүйцэтгэхдээ хүч хэрэглэхээсээ өмнө аль болох хүчирхийлэлгүй арга хэрэгслийг ашиглах, бусад арга нь үр дүнгүй хэвээр байгаа тохиолдолд л хүч ашиглахыг заасан болно. Хууль ёсоор хүч хэрэглэхээс зайлсхийх боломжгүй тохиолдолд хууль сахиулах байгууллагын ажилтнууд өөр бусад арга хэмжээнээс гадна, тайван байдлыг эрхэмлэж, хохирол, гэмтлийг багасгаж, гэмтэж бэртсэн, нэрвэгдсэн хүнд тусламж, эмнэлгийн тусламжийг аль болох түргэн үзүүлнэ. (“НҮБ-ын суурь” Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд хүч, галт зэвсэг ашиглах зарчим.” НҮБ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтнүүдтэй харьцах асуудлаарх Наймдугаар их хурлаар батлагдсан, Куба, Хавана, 1990 оны 8-р сарын 27-оос 9-р сарын 7, зарчим 4, 5). Эдгээр зарчмыг галт зэвсэг хэрэглэхэд ерөнхийдөө баримталдаг боловч, НҮБ-ын Үндсэн зарчимд хүний эсрэг галт зэвсэг ашиглахыг биеэ хамгаалах, бусдыг амь насыг хамгаалах, биед ноцтой хохирол учруулахаас урьдчилан сэргийлэхээс бусад тохиолдолд хэзээ ч зөвшөөрөх ёсгүй гэж заасан байдаг (зарчим 9). Хэт их хүч хэрэглэх байдлын талаар, жишээ нь: Хууль сахиулах байгууллагын ажилтнууд ихэвчлэн жагсаал цуглаан зохион байгуулах, олон түмний хяналттай холбоотойгоор хүч хэтрүүлэн хэрэглэсэн гэсэн галт тасралтгүй ирж байгаад тус Хороо санаа зовж байгаагаа илэрхийлсэн НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо, “Грек улсад хийсэн нэгдсэн дүгнэлт” (НҮБ-ын Б.б. САТ/С/ГРС/СО/5-6, 2012 оны 6-р сарын 27, 11-р зүйл) -ийг үз. Мөн тус Хороо уг гэрээний улсыг хууль сахиулах байгууллагын ажилтнууд зөвхөн зайлшгүй шаардлагатай үед, үүргээ гүйцэтгэх хэмжээнд шаардагдах төдий хүчээр л хүч хэрэглэж байх тал дээр нэн даруй, нухацтай арга хэмжээ авахыг шамдуулсан. “Канад Улсад хийсэн нэгдсэн дүгнэлт” (НҮБ-ын Б.б. САТ/С/CAN/СО/6, 2012 оны 6-р сарын 25, 22-р зүйл) -ийг үз. Тус хороо эдгээр мэдэгдлийг цаг алдалгүй, бодитойгоор шалгаж, ийм зөрчил гаргасан хүмүүст хариуцлага тооцохын тулд хүчин чармайлтаа бэхжүүлэхийг тус гэрээний улсад зөвлөв.

250 ЕАБХАБ/АИХЭГ-Венецийн Хорооны Удирдамж, заалт №164.

175. НҮБЕА, Хүний эрхийн зөвлөл тайван жагсаал, цуглааны үеэр хэнд ч хэтрүүлэн, ялгамжгүйгээр хүч хэрэглэх ёсгүйг олонтоо давтан мэдэгдсэн.²⁵¹ Ямар ч нөхцөлд хууль сахиулах байгууллагууд тайван жагсаал, цуглаан, үйл явдлын талаар мэдээлж буй сэтгүүлчид, жагсаал, цуглааны ажиглагч (мониторинг) эсвэл ойр тойронд зогсож байгаа хүмүүс, үймээнд гар бие оролцсон этгээдүүдийг хооронд нь ялгахгүйгээр хүчийг хэтрүүлэн ба хавтгайруулан хэрэглэхээс татгалзах ёстой. Тухайлбал жагсаал, цуглааны үеэр хаа нэг үүссэн үймээн эсвэл цөөн тооны эсэргүүцэгчдийн өдүүлсэн үймээнд хавтгайруулан хүч хэрэглэх нь хурцадмал байдлыг дэвэргэж, улмаар үймээнийг улам бүр нэмэгдүүлж болзошгүй юм. Хүч хэрэглэхээсээ илүү зөрчлийг намжаах талаар яриа хэлэлцээ хийх эсвэл зуучлахыг ямагт эрхэмлэх ёстой.²⁵² Онцын шаардлагагүй үед эсвэл тэнцвэргүй хүч хэрэглэхээс зайлсхийхийн тулд хууль тогтоомжид хүч хэрэглэх үндэслэл бүхий нөхцөл байдал, янз бүрийн аюул заналхийллийн үед хэрэглэх хүчний зөвшөөрөх түвшнийг тодорхой заажтусах ёстой.²⁵³ Европын зөвлөлийн хүний эрхийн комиссар жагсаал, цуглаантай холбоотойгоор хүч хэрэглэхэд мөрдөх тодорхой дүрэм тогтоохыг улс орнуудад зөвлөж байна.²⁵⁴
176. Жагсаал, цуглааны хэв журам сахиулахтай холбоотойгоор хууль сахиулах байгууллагын ажилтнууд хүч хэтрүүлэн эсвэл хавтгайруулан хэрэглэсэн ба бусад ёс зүйгүй үйлдэл гаргасан гэх бүх гомдлын мэдэгдлийг сайтар

251 НҮБЕА-н “Бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах ‘Хувь хүн, Бүлгэм, Нийгмийн байгууллагын эрх, үүргийн тунхаглалыг сурталчлах тухай’ тогтоолыг үз. НҮБ-ын Б.Б. А/RES/66/164, заалт №6; НҮБЕА “Эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах тухай тогтоол”, НҮБ-ын Б.Б. А / RES / 68/181, 2013 оны 12-р сарын 18, заалт №8; Хүний Эрхийн Зөвлөл “Тайван эсэргүүцлийн жагсаал, цуглааны хүрээнд хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах тухай” тогтоол №A/HRC/RES/19/35, 2012 оны 3-р сарын 23-ны өдөр, заалт №6; болон Хүний Эрхийн Зөвлөлийн “Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах тухай тогтоол”, A/HRC/RES/22/6, заалт №6-г үз.

252 ЕАБХАБ/АИХЭГ-Венецийн Хорооны Удирдамж, заалт №5.4 ба 5.5, ба дэлгэрэнгүйг хуу. №75-89-өөс үз.

253 Эх. сурв. заалт №171.

254 Жишээлбэл, Комиссарын Турк улсад хийсэн томилолтын тайланг үз. Тэрээр эрх баригчдад жагсаалын үеэр хүч хэрэглэх, ялангуяа, нулимс асгаруулагч хий, галт зэвсэг ашиглахтай холбоотой тодорхой журам батлах, хууль сахиулах байгууллагын ажилтнууд хууль бус үйлдэл хийх, жагсаал, цуглаан хийх эрхийг зөрчихөөс хамгаалах илүү сайн хамгаалалт бий болгохыг зөвлөж байна. 2013 оны 7-р сарын 1-ээс 5-ны хооронд Туркэд хийсэн томилолтынхоо дараа Европын Зөвлөлийн Хүний эрхийн асуудал эрхэлсэн комиссар Нилс Мижижнексийн хийсэн тайланг үз. С оmmDH (2013)24, 2013 оны 11 дүгээр сарын 26.

судалж, ёс зүйгүй үйлдэл гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэх ёстой.²⁵⁵ Энэ мэт буруутай үйлдэл гаргасан хэн ч ял шийтгэлээс ангид үлдэх ёсгүй. Хүний эрхийн холбогдох стандарт, ЕАБХАБ-ын хүлээсэн үүрэг амлалт дагуу засгийн газрууд хүч, галт зэвсгийг дур зоргоор болон зүй бусаар ашигласан хууль сахиулах байгууллагын ажилтнуудад хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.²⁵⁶

177. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг олон улсын хүний эрхийн эрх зүйн гэх мэт зохих сургалтад хамруулахыг улс орнуудад уриалав.²⁵⁷ НҮБ-ын Үндсэн зарчмын дагуу хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг сургахдаа хүч, галт зэвсгийн хэрэглээг хязгаарлах зорилгоор зөрчлийг тайван замаар шийдвэрлэх, хуралдсан олны авир байдлыг ойлгох, ятган үнэмшүүлэх, хэлэлцээр хийх, зуучлалын арга хэрэглэх гэх мэт хүч, галт зэвсэг ашиглахаас өөр арга хувилбаруудад онцгой анхаарал хандуулах хэрэгтэй.²⁵⁸

178. **Жагсаал, цуглааны хяналт-шинжилгээ (мониторинг, ажиглалт):** НҮБЕА болон Хүний эрхийн зөвлөл нь тайван жагсаал, цуглааны хүрээнд хүний эрхийг хамгаалагчид чухал үүрэгтэйг хүлээн зөвшөөрдөг билээ.²⁵⁹ Хүний эрхийг хамгаалагчид жагсаал, цуглааны зохион байгуулагч эсвэл оролцогчцуглаан болон хэв журам сахиулах ажиллагаа нь олон улсын хүний эрхийн стандартад нийцэж байгаа эсэхийг ажиглаж, тайлагнадаг жагсаал, цуглааны хяналт-шинжилгээний ажиглагч зэргээр өөрсдийн үүргээ янз бүрийн байдлаар гүйцэтгэх боломжтой. Хүний эрхийг хамгаалагчдын жагсаал, цуглаанд хийдэг мониторинг нь цуглаан, түүний хэв журам сахиулах үйл ажиллагааны байдлыг үнэлэхэд тусалдаг.

255 Жишээлбэл: эсэргүүцлийн жагсаал, цуглааны хүрээнд хүч хэтрүүлэн хэрэглэсэн гэсэн үндэслэлээр шалгах асуудлаар НҮБ-ын Хүний Эрхийн Хорооноос ОХУ-д: “Цагдаагийн ажилтнууд хэт их хүч хэрэглэсэн болон эрх мэдлээ зүй бусаар ашигласан тухай бусад гомдлыг хүлээн авах, судлах, шүүхээр шийдвэрлэх эрх бүхий бие даасан байгууллага байгуулахыг санал болгов.” “Орост хийсэн нэгдсэн дүгнэлт” -г үз. НҮБ-ын Б.б. ССРР/С/RUS/CO/6, 2009 оны 11-р сарын 24, заалт №25. Гүрж улсад ажилласныхаа дараа НҮБ-ын тайван цуглаан, жагсаал хийх, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудал эрхэлсэн тусгай илтгэгч тус улсын эрх баригчдад 2011 оны 5-р сарын 26-ны үйл явдлыг нарийвчлан шалгах бие даасан комисс байгуулж, сөрөг хүчний улс төрийн нам, төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл, идэвхтэн, хүний эрхийг хамгаалагч, иргэний нийгмийн гишүүд зэрэг бүх оролцогч талыг оролцуулж, ил тод, олон талт оролцоог хангасан байдлаар нухацтай авч үзэхийг зөвлөсөн. НҮБ-ын тайван цуглаан, жагсаал хийх, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудал эрхэлсэн тусгай илтгэгчийн тайланг үз. Майн Киай, Нэмэлт, Гүржийн томилолт, НҮБ-ын Б.б. А/HRC/20/27/ Нэмэлт.2, 2012 оны 6-р сарын 8, заалт №91(е). Мөрдөн шалгах ажиллагааны үр дүнтэй байдалд тавигдах шаардлагын талаар дэлгэрэнгүй мэдээллийг дээр гарсан “Ял шийтгэлээс зугтах ба үүний эсрэг үр дүнтэй арга хэмжээ” хэсгээс үз.

256 ҮН-ий Үндсэн Зарчмууд, зарчим 7.

257 А/HRC/RES/19/35, заалт №7.

258 ҮН-ий Үндсэн Зарчмууд, зарчим 20.

259 А/HRC/RES/226, заалт №6; А/RES/68/181, заалт №8; А/RES/66/164, заалт №6-г үз.

Үүгээрээ жагсаал, цуглаан хийх тухай хууль эрх зүйн алдаа дутагдлыг арилгахад шаардлагатай арга хэмжээнүүд, хууль сахиулах байгууллагын ажилтнуудын сургалтын хэрэгцээ эсвэл жагсаал, цуглааны хэв журам сахиулахад нэмэлт эх үүсвэр, тоног төхөөрөмж шаардлагатай эсэх талаар мэдээлэл сайтай олон нийтийн мэтгэлцээн хийхэд хувь нэмрээ оруулдаг.²⁶⁰

179. НҮБ-ын Тайван жагсаал, цуглаан, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудал эрхэлсэн Тусгай илтгэгчийн тэмдэглэснээр, тайван жагсаал, цуглаан хийх эрх нь зөвхөн цуглаан хийх эсвэл оролцох эрхийг хамгаалаад зогсохгүй тайван жагсаал, цуглаанд ажиглалт хийж буй хүмүүсийн эрхийг хамгаалдаг.²⁶¹ Тиймээс тэрээр тайван жагсаал, цуглааны үеийн зөрчил, зүй бус үйлдлийн талаарх мэдээллийг ажиглаж, мэдээлж буй хүмүүсийг хамгаалахыг улс орнуудад уриалсан.²⁶² Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдал хариуцсан Ерөнхий нарийн бичгийн даргын Тусгай төлөөлөгч мөн ажиглах үүргээ гүйцэтгэхэд нь тусалж, хүний эрхийг хамгаалагчдыг жагсаал, цуглааны үеэр чөлөөтэй ажиллах боломж олгохыг уриалсан юм.²⁶³
180. Оролцогч улсууд хүний эрхийг хамгаалагчдын бие даан жагсаал, цуглааныг ажиглаж, тайлагнах санаачилгыг идэвхтэй дэмжиж, зохион байгуулж өгөх ёстой. Эрх баригчид жагсаал, цуглааны ажиглагчидтай хэв журам сахиулах ажиллагаанд бэлтгэх, эрсдэлийн үнэлгээ хийх зорилгоор урьдчилан урьдчилан уулзах, жагсаал, цуглааны үеэр олж илрүүлсэн болзошгүй алдаа дутагдлыг засаж залруулах болон тухайн үед төрийн албан тушаалтнуудын гаргасан аливаа зүй бус үйлдлийг зохих ёсоор шийдвэрлэх зорилгоор жагсаал, цуглаан дууссаны дараа мөн уулзаж зөвлөлдөхийг зөвлөж байна. Цаашилбал эрх баригчид хууль сахиулах болон бусад холбогдох албан тушаалтнуудыг сургахдаа бие даан жагсаал, цуглааны ажиглалт хийдэг хүний эрхийг хамгаалагчидтай хамтран ажиллах нь зүйтэй. Мөн АИХЭГ зэрэг байгууллагуудаар жагсаал, цуглааны олон улсын ажиглалт хийлгэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрх баригчдад зөвлөж байна.
181. Жагсаал, цуглаан зохион байгуулагч, хууль сахиулах байгууллагын ажилтнуудын олон нийтийн хариуцлагыг нэмэгдүүлэхийн тулд оролцогч улсууд хараат бус мэдээ, мэдээлэл бэлтгэх боломж олгон хэвлэл мэдээллийн

260 ЕАБХАБ/АИХЭГ-Венецийн Хорооны Удирдамж, заалт №5.9, ба дэлгэрэнгүйг хуу. №94-110-аас тус тус үз.

261 А/HRC/20/27, Нэгдсэн дүгнэлтийг үз.

262 А/HRC/20/27, заалт №94.

263 Ерөнхий нарийн бичгийн даргын Тусгай төлөөлөгчийн тайлан, НҮБ-ын Б.Б. А/62/225, 2007 оны 8 дугаар сарын 13, заалт №101 (f) (i)-г үз.

хэрэгслийг жагсаал, цуглаанд чөлөөтэй нэвтрэх эрхийг олгох ёстой.²⁶⁴ Хэвлэлийн эрх чөлөөний асуудал эрхэлсэн ЕАБХАБ-ын төлөөлөгч цохон тэмдэглэхдээ “цуглаан, жагсаалууд нь үг хэлэх эрх чөлөөг эдлэх явдал учраас цуглаан, жагсаалыг саадгүй мэдээлнэ гэдэг бол жагсаал, цуглаан хийх эрхийн чухал нэг хэсэг юм” гэжээ.²⁶⁵

Е. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, ТББ байгуулах, тэдгээрт элсэх, идэвхтэй оролцох эрх

182. ХЭТТ-ын 20 дугаар зүйлд зааснаар “хүн бүр тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөтэй” бөгөөд “хэнийг ч жагсаал, цуглаанд оролцох, эвлэлдэн нэгдэхийг албадах ёсгүй.” ИУТЭОУП-ын 22 дугаар зүйлийн 1-т “хүн бүр өөрийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс үйлдвэрчний эвлэл байгуулах, нэгдэх эрх зэрэг бусадтай эвлэлдэн нэгдэх эрх чөлөө эдлэх эрхтэй” гэж заасан байдаг. ХЭҮЭЧК-ын 11 дүгээр зүйлийн 1-т “хүн бүр өөрийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс үйлдвэрчний эвлэл байгуулах, нэгдэх эрх зэрэг эвлэлдэн нэгдэх эрх чөлөө эдлэх эрхтэй” гэсэн ижил төстэй заалт бий. Мөн Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын хэлцэл (ЭЗНСЭОУХ)-ийн 8 дугаар зүйлд эдийн засаг, нийгмийн ашиг сонирхлыг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилгоор хувь хүмүүсийн үйлдвэрчний эвлэл байгуулах, өөрийн сонгосон үйлдвэрчний эвлэлд элсэх эрхийг баталгаажуулсан болно. ХЭАК-ийн 16 дугаар зүйлд зааснаар хүн бүр “үзэл суртлын, шашны, улс төрийн, эдийн засгийн, хөдөлмөрийн, нийгмийн, соёлын, спортын болон бусад зорилгоор чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхтэй.” ҮЦХСК-ийн 17 дугаар зүйлээр үндэстний цөөнхөд харьяалагддаг хувь хүмүүст эвлэлдэн нэгдэх эрх чөлөө олгосон байдаг. Улмаар ҮЦХСК-ийн 17 дугаар зүйлийн 2-т уг олон улсын гэрээнд оролцогч талууд “үндэстний цөөнх болсон хүмүүсийн үндэсний болон олон улсын түвшинд төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд оролцох эрхэд саад болох ёсгүй” гэж тодотгосон. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалын 5 дугаар зүйлээр хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилгоор хүн бүр төрийн бус байгууллага, холбоо, бүлэгт элсэх, нэгдэх, оролцох эрхтэй гэдгийг давхар баталгаажуулдаг.
183. Хуулиар тогтоосон, хууль ёсны зорилгодоо нийцсэн, ардчилсан нийгэмд зайлшгүйгээс бусад шалтгаанаар холбоонд эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг эдлэхэд ямар нэгэн хязгаарлалт тавихгүй. Олон улсын хууль тогтоомжид

264 Эх. сурв. заалт №101 (f) (ii).

265 ЕАБХАБ-ын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудал эрхэлсэн төлөөлөгч, Тусгай тайлан, “Улс төрийн жагсаалын үеэр хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харьцах байдал, ажиглалт, зөвлөмж”, 2007 оны 6-р сарын 21, <<http://www.osce.org/fom/25744>>. Жагсаалд хяналт-шинжилгээ хийхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүргийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ЕАБХАБ/АИХЭГ-Венецийн Хорооны Удирдамж, 97-100-р хуудаснаас тус тус үз.

заасны дагуу зөвхөн үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол; нийтийн аюулгүй байдал, нийгмийн эрүүл мэнд эсвэл ёс суртахууныг хамгаалах; эмх замбараагүй байдал, эс бөгөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх; мөн бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах нь эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлахыг зөвшөөрөх үндэслэл болно. Энэхүү үндсэн эрхийг хэрэгжүүлэхэд тавьсан аливаа хязгаарлалт нь олон улсын хэм хэмжээ, стандартуудыг чандлан дагаж мөрдөх ёстой бөгөөд үл ялгаварлан гадуурхах, пропорциональ зарчмуудад нийцсэн байх ёстой. Цаашилбал НҮБ-ын Жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө эдлэх эрхийн асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч аливаа хязгаарлалт тавихдаа энэ талаар нарийвчлан заасан, цаг тухайд нь гаргасан бичгэн тайлбар өгч, бие даасан, хараат бус шүүхээр хянан шийдвэрлэх боломжоор хангахыг улс орнуудад зөвлөж байна.²⁶⁶

184. Эдгээр зүйл нь эвлэлдэн нэгдэх эрхээ эдэлж буй зэвсэгт хүчин, цагдаагийн байгууллагын гишүүдэд хууль ёсны хязгаарлалт тавихад саад болохгүй гэж ИУТЭОУП-ын 22 ба ХЭҮЭЧК-ын 11 дүгээр зүйлүүдэд тодорхой заасан. Зэвсэгт хүчний, цагдаа эсвэл төр захиргааны байгууллагын гишүүдэд тавьсан зарим хязгаарлалт уг эрхийг хэрэгжүүлэхэд тэдний олон нийтийн үүрэгтэй зөрчилдөх ба/эсвэл улс төрийн төвийг сахисан байдалд сөргөөр нөлөөлөх үндэслэлтэй байж болох ч ийм хязгаарлалт нь хууль ёсны, зайлшгүй, пропорциональ зарчимд мөн нийцэж байх ёстой. Ингэснээрээ тэдний хүний эрхийг хамгаалах гэх мэт зорилгоор бусадтай чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхийг хамгаалах юм. Иймд зэвсэгт хүчин, цагдаа эсвэл төрийн захиргааны байгууллагын гишүүн хүний эрхийг хамгаалагчид ч мөн өөрсдийн нийтлэг эрх ашгийг хамтдаа эрэлхийлэх, хөхиүлэн дэмжих, хамгаалахын тулд эвлэлдэн нэгдэх эрхтэй. Эдгээр эрх хязгаарлагдсан тохиолдолд тавигдсан хязгаарлалтыг цуцлах зорилгоор Европын зөвлөлийн сайд нарын хорооноос санал болгосны дагуу тогтмол шалгаж байх ёстой.²⁶⁷

185. ЕАБХАБ-ын оролцогч орнууд “эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаатай эдлүүлнэ” гэдгээ дахин нотолж, “үйлдвэрчний эвлэл, хүний эрхийн хяналт-шинжилгээ хийдэг бүлгүүд зэрэг хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах эрмэлзэл бүхий төрийн бус байгууллага байгуулах, түүнд элсэх, нэгдэх, идэвхтэй оролцох эвлэлдэн нэгдэх эрхээ

266 А/HRC/23/39, 2013 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр, заалт №81.

267 Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны Зөвлөмж CM/Rec(2010)4, Зэвсэгт хүчний алба хаагчийн хүний эрхийн талаарх тайлбар санамж бичиг, 2010 оны 2-р сарын 24, заалт №53-57, <http://www.coe.int/t/dghl/standardsetting/hrpolicy/publications/cmrec_2010_4en.pdf>. Мөн Зэвсэгт хүчний мэргэжлийн боловсон хүчний эвлэлдэн нэгдэх эрхийн тухай ЕЗПА-н 1572 (2002) зөвлөмжийг 2002 оны 9-р сарын 3-аас үз. <<http://assembly.coe.int/main.asp?Link=/documents/adoptedtext/ta02/errec1572.htm>>.

хувь хүн бүр эдлэх боломжийг хангах” үүрэг амлалт өгсөн.²⁶⁸Тэдгээр улсууд “өөрсдийгөө энэ мэтээр тунхаглагсад”-ыг ²⁶⁹ТББ хэмээн хүлээн зөвшөөрч, ТББ-ын иргэний нийгмийн цаашдын хөгжил, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх соёлд хувь нэмрээ бүрэн дүүрэн оруулах чадварыг нэмэгдүүлж чадах хүчтэй иргэний нийгмийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг” гэж [амласнаараа] үздэг”²⁷⁰

186. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө нь “бусад үндсэн эрх чөлөөний зайлшгүй урьдач нөхцөл” болох үндсэн эрх бөгөөд “үзэл бодлоо илэрхийлэх, жагсаал, цуглаан хийх, бусад хүний эрхтэй [...] нягт уялдаатай.”²⁷¹ Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө нь хүний эрхийн хамгааллын салшгүй хэсэг мөн. Үүнийг хүний эрхийг хамгаалагчдын бие даан болон бусадтай хамтран үйл ажиллагаа эрхлэх эрхийг янз бүрийн заалтаараа баталгаажуулсан НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалд заасан байдаг (5-9, 11-13, 17 дугаар зүйлүүд).
187. Оролцогч олон улсад эдгээр болон холбогдох бусад баталгаа байдаг хэдий ч хүний эрхийг хамгаалагчид ТББ эсвэл бусад холбоонд элсэх, нэгдэх, идэвхтэй оролцох эрхээ бүрэн эдлэхэд хууль эрх зүйн болон захиргааны саад бэрхшээл тулгарсаар байна. Холбоо байгуулах, түүний үйл ажиллагаа, санхүүжилтийг зохицуулах хууль тогтоомж нь ихэвчлэн ойлгомжгүй эсвэл хэт хязгаарлагдмал байдаг тул олон улсын стандартад нийцдэггүй. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч 2012 оны тайландаа “Сүүлийн үед янз бүрийн улс орнуудын хууль эрх зүйн өөрчлөлтүүд чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхийг улам бүр хязгаарлаж байна” гэж тэмдэглэжээ.²⁷² Эдгээр хуулийг ихэнхдээ иргэний нийгэмтэй зөвлөлдөхгүйгээр баталдаг ба хуулийн хүний эрхийн стандарттай нийцэж буй эсэх талаар олон улсын шинжээчдийн эрх зүйн дүгнэлтүүд болон оролцогч улс орнуудад тусгайлан өгдөг зөвлөмжүүд хэрэгждэггүй.
188. Хэд хэдэн оролцогч улс оронд засаг захиргааны хувьд асар их бэрхшээл тулгарч байгаа нь хүний эрхийг хамгаалагчдыг эвлэлдэн нэгдэх эрх чөлөөгөө идэвхтэй эдлэхэд саад болж байгаа тухай мэдээлж байсан. Нэлээд тооны оролцогч улс оронд холбоодыг бүртгүүлээгүй тохиолдолд хууль ёсны

268 Копенхаген 1990, заалт №9.3 ба 10.3.

269 Москва 1991, заалт №43.

270 Станбул 1999, “Европын Аюулгүй Байдлын Дүрэм: III. Бидний нэгдмэл үүрэг”, заалт №27.

271 Венецийн Хороо, “Азербайжан улсын төрийн бус байгууллагын тухай хууль тогтоомжийн хүний эрхийн стандарттай нийцэх байдалд хийсэн санал дүгнэлт”, CDL-AD (2011) 035, заалт №45; Венецийн Хороо ба АИХЭГ, “Арилжааны бус байгууллагын тухай хууль болон Киргизийн бусад эрх зүйн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал дүгнэлт”, CDL-AD (2013) 030, заалт №14.

272 A/67/292, 2012 оны 8 дугаар сарын 10-ны өдөр, заалт №40.

гэж тооцдоггүй. Үүний зэрэгцээ, ихэвчлэн дур зоргын байдлаар ашигладаг төвөгтэй, хүнд сурталтай журам нь бүртгэлийн явцыг ихээхэн хүндрүүлдэг. Энэ мэт хүнд сурталтай бүртгэлийн бэрхшээлүүд дээр ихэнхдээ ТББ-ыг бүртгэснийхээ дараа санхүүгийн, татварын хяналт шалгалт гэх мэт хэт их тайлагнах шаардлагууд, дур зоргын хяналт шалгалтууд нэмэгддэг. Ийм журам, практик үйл ажиллагаа нь ихэвчлэн ТББ-ын дотоод зохион байгуулалт, тэдгээрийн үйл ажиллагаа, бие даасан шийдвэр гаргахад төрийн оролцоог бий болгох зорилготой буюу ийм байдал үүсэхэд хүргэдэг. Тэд ТББ-уудын хууль ёсны ажлыг боогдуулж, хүний эрхийг хамгаалагчдад дарамт үзүүлэхийг хичээдэг.

ТББ-ын үйл ажиллагааг зохицуулах хууль, захиргааны журам, шаардлага

189. Оролцогч улсууд хүний эрхийг хамгаалагчдыг эвлэлдэн нэгдэх эрхээ чөлөөтэй эдэлж, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалахыг эрмэлздэг ТББ-ууд байгуулах, түүнд нэгдэх, идэвхтэй оролцох эрх зэргийг чөлөөтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх ёстой. Ийм хуулиуд нь нарийн, тодорхой бөгөөд олон улсын хүний эрхийн стандартад нийцсэн байх ёстой. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл үндэсний хууль тогтоомжийг НҮБ-ын дүрэм, олон улсын хүний эрхийн хууль тогтоомжид нийцүүлэх нь нэн чухал болохыг тэмдэглэхийн сацуу улс орнуудыг “хууль, практик дээр иргэний нийгмийн саад тотгор, баталгаагүй байдлаас ангид үйл ажиллагаа явуулах аюулгүй, таатай орчныг бүрдүүлж, цогцлоох”-ыг уриалав.²⁷³
190. Оролцогч улсууд чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрх чөлөөгөө аливаа ялгаварлалгүйгээр эдлэх эрхийг баталгаажуулж өгөх ёстой. НҮБ-ын Тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч улс орнуудад эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг “эмэгтэйчүүд болон бэлгийн чиг баримжаа, хүйсийн илэрхийлэл, залуучууд, үндэстний цөөнх, уугуул иргэд, харьяалалгүй хүмүүс, дүрвэгсэд, цагаачид гэх мэт харьяалалгүй хүмүүс, шашны бүлгийн гишүүн гэдгээрээ ялгаварлан гадуурхалтад өртсөн хохирогчид мөн эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хөхиүлэн дэмжигчид зэрэг аливаа бүртгэлтэй эсвэл бүртгэгдээгүй этгээд, хүн бүр эдлэх боломжоор хангах”-ыг²⁷⁴ уриалав.
191. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгчийн ажигласнаар “байгууллагын үйл ажиллагааг хөндлөнгийн оролцоогүйгээр явуулах боломжийг өргөн хүрээнд

273 A/HRC/RES/22/6, 2013 оны 3 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан, заалт №2; ба A/HRC/RES/24/21, 2013 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр батлагдсан, заалт №2.

274 A/68/299, 2013 оны 8 дугаар сарын 7-ны өдөр, заалт №58 (b).

хязгаарласан” буюу “эрүүл иргэний нийгмийн бие даасан үйл ажиллагаа”-г алдагдуулж буй хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах эсхүл хүчингүй болгох ёстой.²⁷⁵ Ийм зорилготой хууль тогтоомжийн санаачилгыг иргэний нийгэмтэй хамтран нээлттэй, ил тод хэлэлцүүлэх шаардлагатай. Хэлэлцүүлгийг аль болох эрт үе шатанд нь, эхний төслийг боловсруулахаас өмнө хийх ёстой бөгөөд тодорхой бүлгүүдтэй холбоотой байдал эсвэл хамгаалж буй эрхийнх нь шинж чанараар ялгаварлан гадуурхахгүйгээр ТББ-д нээлттэй хандах ёстой.

192. ТББ болон бусад холбоодын харилцааг зохицуулдаг дотоодын хууль тогтоомжийн хүний эрхийн стандарттай нийцэх байдлыг хангахын тулд оролцогч улсуудад ЕАБХАБ/АИХЭГ, Европын зөвлөлийн Венецийн хороо зэрэг хууль тогтоомжийн дүн шинжилгээгээр мэргэшсэн олон улсын байгууллагуудаас мэргэжлийн туслалцаа авахыг зөвлөж байна. НҮБ-ын Тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч, НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгчид хүний эрхийн бусад механизмын санал, дүгнэлтийг авч үзэж, хэрэгжүүлэхийг зөвлөж байна.
193. Оролцогч улсууд цахим хэлбэрээр чөлөөтэй эвлэлдэн нэгдэх бүх хүний эрхийг хүндэтгэж, бүрэн хамгаалах ёстой.²⁷⁶ Европын зөвлөлийн сайд нарын хорооны тунхагласны дагуу үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний хамт эвлэлдэн нэгдэх эрх чөлөө нь хүмүүсийн олон нийтийн хэлэлцүүлэг, ардчилсан иргэний харьяаллаа хэрэгжүүлэхэд оролцох оролцоонд амин чухал бөгөөд, үүнийгээ (цахим/цахим бусын ялгамжгүйгээр) баталгаатай эдлэх ёстой [...]”²⁷⁷ Мэдээлэл, харилцаа холбооны технологи, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөгөө эдлэхэд ашигладаг хэрэгсэлд нэвтрэх, ашиглах үйл ажиллагааг зохицуулдаг хууль тогтоомж нь мөн эвлэлдэн нэгдэх эрх чөлөөгөө эдлэх нөхцөлийг хангах ёстой. Цахимаар чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхэд тавьсан аливаа хязгаарлалт нь хүний эрхийн олон улсын стандартыг чанд мөрдөх ёстой.

275 А/64/226, 2009 оны 8 дугаар сарын 4-ний өдөр, заалт №53 ба 54.

276 А/HRC/RES/24/21, 2013 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр батлагдсан, заалт №1.

277 Европын Зөвлөл Сайд нарын Хороо, “Хувиараа ажиллуулдаг Интернэт цахим талбар, цахим үйлчилгээ үзүүлэгчидтэй холбоотой үзэл бодлоо илэрхийлэх, цуглаан, жагсаал зохион байгуулах, эвлэлдэн нэгдэх эрхийн Тунхаглал”, 2011 оны 12 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан, <<https://wcd.coe.int/ViewDoc.jsp?id=1883671>>, заалт №1.

ТББ-ын бүртгэлтэй холбоотой асуудлаар:

194. ТББ-ыг бүртгүүлэхгүйгээр оршин тогтнох, үйл ажиллагаагаа явуулахыг зөвшөөрөх ёстой.²⁷⁸ ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу оролцогч улсууд улсынхаа дотоод хууль журмын дагуу өөрсдийгөө тунхаглаж буй холбоодыг ТББ-ууд гэж хүлээн зөвшөөрнө.²⁷⁹ Улсын дотоод хууль журмаа хүний эрхийн олон улсын стандартад болон ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэгтээ нийцүүлсэн байна.
195. Гэсэн хэдий ч хэд хэдэн оролцогч улс ТББ-ыг төрийн байгууллагад албан ёсоор бүртгүүлж, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах шаардлага тавьдаг. Нэмж дурдахад, зарим оролцогч улсад бүртгэлийн журам нь сунжирсан, зардал ихтэй бөгөөд үүнийгээ дур зоргоороо, ялгаварлан гадуурхсан байдлаар хэрэглэдэг. Баримт бичигт хэт их шаардлага тавьдаг ба давхар давхар хүнд суртал нь бүртгэлийн явц хойшлогдоход хүргэдэг эсвэл бүр холбоодыг бүртгүүлэхэд нь саад болдог.²⁸⁰
196. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч бүртгэлгүй бүлгүүдийн явуулж буй үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцож байгаа нь хамгийн сэтгэл зовниулсан хандлагуудын нэг гэж тэмдэглэжээ.²⁸¹ Зарим оролцогч улсад бүргүүлэлгүйгээр бусадтай эвсэн нэгдэж, хүний эрхийн үйл ажиллагаа явуулсныг эрүүгийн эсвэл захиргааны зөрчилд тооцдог. Олон тооны хүний эрхийг хамгаалагчид эдгээр үндэслэлээр шоронд хоригдож эсвэл улс орноо хүчээр орхиж, олон улсын хамгаалалт хүсэх шаардлагатай тулгарч байна. Бүртгэгдээгүй хүний эрхийн үйл ажиллагааг шууд болон шууд бус байдлаар гэмт хэрэгт тооцдог, олон улсын хүний эрхийн үндсэн баталгааг зөрчсөн хууль, тогтоомж, практикийг нэн даруй цуцлах ёстой.²⁸²
197. Заавал бүртгүүлэх албагүй боловч ТББ болон бусад холбоод зөвхөн хуулийн этгээдэд олгох төрийн нэмэлт дэмжлэг, татаасыг авахын тулд хуулийн этгээдээр бүртгүүлэх эрхтэй. Эдгээр тэтгэмжийг авахын тулд бүртгүүлэх

278 Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайланг үз, НҮБ-ын Б.б. А/59/401, 2004 оны 10 дугаар сарын 4-ны өдөр, заалт №82 (а)-г үз. НҮБ Тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудал эрхэлсэн тусгай илтгэгчийн тайланг үз, НҮБ-ын Б.б. А/HRC/23/39, 2013 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр, заалт №82 (а).

279 Москва 1991, заалт №43.

280 А/64/226, 2009 оны 8 дугаар сарын 4-ний өдөр, заалт №70 ба 71.

281 Эх. сурв.

282 Тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудал эрхэлсэн НҮБ-ын Тусгай илтгэгч 2012 гаргасан тайландаа "Бүртгэлгүй холбоонд хамрагдсан хүмүүс тайван жагсаал, цуглаан явуулах, оролцох зэрэг аливаа арга хэмжээ явуулах эрхтэй байх ёстой бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёсгүй." гэдгийг дахин дурдсан. (А/HRC/20/27, 2012 оны 5 дугаар сарын 21-ий өдөр, заалт №56).

эсэхээ ТББ эсвэл холбоо өөрөө шийднэ. Дотоодын хууль тогтоомжоор ашгийн бус байгууллага, сан эсвэл бусад гэх мэт өөр өөр хуулийн этгээдийн хэлбэрийг тусгасан тохиолдолд хуулийн этгээдээр бүртгүүлэхэд тавигдах шаардлага нь холбоонд хамгийн тохиромжтой эрх зүйн хэлбэрийг сонгоход хангалттай уян хатан байдлыг хангаж өгөх ёстой ба хүний эрхийг хамгаалагчдад саад учруулахаас илүүтэй бусадтай хамтран ажиллах чадамж суулгах үүрэг гүйцэтгэх ёстой.

198. НҮБЕА нь улс орнуудад “иргэний нийгмийн байгууллагуудыг бүртгэх журамтай бол түүнийгээ ил тод, ялгаварлан гадуурхаагүй, түргэн шуурхай, зардал багатай, давж заалдах боломжтой, дахин бүртгүүлэхийг шаардахаас зайлсхийсэн [...] байх зохицуулалттай байлгах”-ыг уриалав.²⁸³
199. ЕХЭШ нь улсын бүртгэлд бүртгүүлэх явцыг ноцтой саатуулж, холбоог бүртгэх талаар эцсийн шийдвэр гаргадаг эрх бүхий байгууллагууд удаа дараа бүртгээгүй тухай асуудал үүсгэсэн бол үүнийг де-факто татгалзсан ба эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний эрхээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс үндэслэлгүй нөлөөлсөнд тооцно гэж үзжээ.²⁸⁴ Ийм саатал гарахаас бүрэн хамгаалах зохицуулалтыг дотоодын хууль тогтоомжид тусгах ёстой. Ингэхдээ эрх баригчид шийдвэр гаргахад шаардлагатай цаг хугацааны тодорхой хязгаар, хуульд заасан хугацаанд арга хэмжээ аваагүй тохиолдолд үүсэж болох үр дагаврыг сайтар нарийн тодорхойлж заах ёстой (тухайлбал цаг тухайд нь шийдвэр гаргахын тулд автомат бүртгэл ашиглах гэх мэт).²⁸⁵
200. Бүртгэлийн байгууллага нь бүртгэлийн явцад холбоодын тусгаар, бие даасан байдалд саад учруулах ёсгүй. Тухайлбал үүсгэн байгуулагч, гишүүдийн байгууллагын нэр, тэмдэг, бэлгэдлийг сонгох, түүний зорилго, үйл ажиллагааг тодорхойлох эрх чөлөөнд хууль бусаар хөндлөнгөөс оролцох

283 А/RES/66/164, 2012 оны 4 дүгээр сарын 10-ы өдөр.

284 Рамазанова ба бусад хүмүүсийн Азербайжаны эсрэг гаргасан нэхэмжлэлд хийсэн ЕХЭШ-ийн дүгнэлт. Нэхэмжлэл №44363/02, 2007 оны Хоёрдугаар сарын 1, заалт №56-68.

285 Цаашилбал, ЕХЭШ нь “Гэрээт улс өөрийн дотоодын улсын бүртгэлийн системийг зохион байгуулж, холбогдох байгууллагуудаар дотоодын хуулиар тогтоосон цаг хугацааг дагаж мөрдүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авах, энэ үйлчилгээг авахад шаардлагагүй саатал гаргахаас зайлсхийх үүрэгтэй”; өөрөөр хэлбэл, нөөц боллоцоо хомс байгаа нь хуульд заасан хугацааг дагаж мөрдөхгүй байх үндэслэл биш юм (65-р зүйл) гэдгийг цохон тэмдэглэв.

ёсгүй.²⁸⁶ Зарим оролцогч улс оронд эрх баригчид хүний эрхийн тодорхой асуудлууд эсвэл цөөнхийн бүлэгтэй холбоотой хүсээгүй үг хэллэг, тэмдэг, үйл ажиллагаа, зорилгыг хасахыг шаардах эсвэл тухайн байгууллагын нэр, тэмдэг нь цөөнхийн бүлгийн нэрийг агуулж байвал бүртгэхээс татгалзах гэх мэтээр ТББ-ын статуст шүүлтүүр тавьсан баримттай тохиолдол гарсан. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгчийн хэлснээр зарим засгийн газар “засгийн газрын бодлогыг шүүмжилж буй эдгээр бүлгүүдийг шүүх” зорилгоор²⁸⁷ арга хэмжээ авч, үйл ажиллагааг нь нэлээд хязгаарладаг.

201. ҮЦХСК-д зааснаар эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, ТББ-ын үйл ажиллагаанд оролцох эрх цөөнхийн бүлгүүдэд ч хамаатай. Дур зоргоороо хязгаарлалт тавих ёсгүй бөгөөд зөвхөн олон улсын хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн тохиолдолд л ашиглах ёстой. ЕХЭШ нь өөрийн эрх зүйдээ цөөнх, үндэстний болон угсаатны цөөнх зэрэг цөөнхийн бүлэгт харьяалалтай хүмүүст эвлэлдэн нэгдэх эрх чөлөө нь онцгой чухал гэдгийг тэмдэглэжээ.²⁸⁸ Хэрэв хуульд заасан бөгөөд конвенцод дурдсан үндэслэлийн аль нэгний эрх ашгийн үүднээс ардчилсан нийгэмд зайлшгүй гэж үзвэл эвлэлдэн нэгдэх эрх чөлөөнд тодорхой хязгаарлалт тавьж болно гэдгийг хүлээн зөвшөөрөхийн сацуу ЕХЭШ нь зөвхөн тухайн улсын нутаг дэвсгэрт эрхээ бүрэн хангуулж чаддаггүй үндэстний цөөнх байдаг гэсэн санааг дэлгэрүүлэхээс сэргийлэх үүднээс холбоог бүртгэхээс татгалзахыг ХЭҮЭЧК-ын 11 дүгээр зүйлийг зөрчсөнд тооцохоор эрх зүйн практиктаа

286 2006 оны 3-р сарын 17-ны өдрийн Узбекистаны эсрэг Кунгуровын гаргасан 1478/2006 дугаартай нэхэмжлэлийн тухайд, НҮБ-ын Хүний Эрхийн Хороо “Ардчилал ба эрх” төрийн бус байгууллагыг улсаас, тухайлбал, уг холбоо нь аливаа албан ёсны байгуулагаас үйл ажиллагаа явуулж буй хүний эрхийн үйл ажиллагаанд оролцох ёсгүй бөгөөд орон нутгийн ТББ бус, харин “үндэстний” ТББ гэж тооцуулахын тулд узбекистаны бүх бүс нутагт төлөөлөгчтэй байх ёстой гэсэн дотоодын хуулийн хоёр шаардлагад нийцээгүй гэж бүртгэхээс татгалзсан тухай хэрэг гэж үзсэн. Тус Хорооноос тус гэрээний улс ардчилсан нийгэмд яагаад холбооны бүртгэхэд үүний үйл ажиллагааны цар хүрээг төрийн байгууллага ажиллаагүй тодорхой бус асуудлуудаар хязгаарлах, эсвэл бүсийн салбартай байх шаардлагатай вэ гэдэг дээр үндэслэлтэй тайлбар хийж чадаагүй гэж үзсэн (8.5-р зүйл).

287 А/64/226, 2009 оны 8 дугаар сарын 4-ний өдөр, заалт №60.

288 Горзелик болон бусад, Польш, Нэхэмжлэл №44158/98, 2004 оны 2-р сарын 17, заалт №93-ыг үз. Өөрсдийгөө Сайлез “үндэстний цөөнх”-ийн байгууллага гэж тодорхойлсон холбоог төрөөс бүртгэхээс татгалзсантай холбоотой хэрэг. Тус холбоог хуулийн этгээдээр бүртгэсний дараа сонгуулийн хуулиар эдлэх статус, давуу талыг тооцож үзвэл нэхэмжлэл гаргасан хөндлөнгийн оролцоог пропорциональ бус гэж үндэслэлгүй юм гэж шийдсэн сацуу, тус Шүүх өөрийн онцлогоо сурталчлах, илэрхийлэх зорилгоор холбоо байгуулах нь цөөнхийг эрхээ хадгалах, эдлэхэд нь туслах арга зам болох юм гэдгийг онцлон тэмдэглэсэн. Ингэхдээ Шүүх нь олон үндэстнээс бүрдсэн, жинхэнэ ардчилсан нийгэм зөвхөн үндэстний цөөнхөд хамаардаг хүн бүрийн гарал угсаа, соёл, хэл, шашны өвөрмөц онцлогийг хүндэтгээд зогсохгүй, өвөрмөц онцлогоо илэрхийлэх, хадгалах, хөгжүүлэх боломжтой нөхцөлийг бүрдүүлэх ёстой гэж заасан үндэстний цөөнхүүдийг хамгаалах тухай Европын Зөвлөлийн суурь конвенцын оршлыг давтан дурдсан.”

тусгасан.²⁸⁹ Шүүх мөн “тухайн мужийн оршин суугчид тухайн бүс нутгийн онцлог шинж чанарыг сурталчлахын тулд холбоо байгуулах эрхтэй”-г онцлон тэмдэглэсэн. Ямар нэг холбоо цөөнхийн ухамсрыг илтгэж буй нь Конвенцын 11 дүгээр зүйлд заасан эрхүүдэд хөндлөнгөөс нөлөөлж байна гэх үндэслэл болж чадахгүй.²⁹⁰ Түүнчлэн шүүх нь нэгдмэл сонирхлын хүрээнд хамтын үйл ажиллагаа эрхлэхийн тулд хуулийн этгээд байгуулах чадвартай байхыг эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний нэг чухал хэсэг гэдгийг өөрийн эрх зүйн практикт тусгасан. Иймээс холбоог бүртгэх тухай эцсийн шийдвэр гарахаас өмнө дүрмийг дотоодын хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн өөрчлөх боломж холбоог үүсгэн байгуулагчдад өгөхгүйгээр холбооны дүрмийг дотоодын хууль тогтоомжид нийцээгүй гэсэн үндэслэлээр хуулийн этгээдээр бүртгэхээс татгалзсан тохиолдолд эвлэлдэн нэгдэх эрх зөрчсөнд тооцож болно.²⁹¹

-
- 289 Бекир-Оуста болон бусад хүмүүсийн Грекийн эсрэг гаргасан Нэхэмжлэл №35151/05, 2007 оны 10-р сарын 11-ний өдөр, түүнчлэн хоёулаа 2008 оны 3-р сарын 27-нд батлагдсан Эмин ба бусад Грекийн эсрэг гаргасан Нэхэмжлэл №34144/05, Туркики Еноси Ксантис ба бусад хүмүүсийн Грекийн эсрэг гаргасан Нэхэмжлэл №26698/05-ийн шүүхийн дүгнэлтийг үз. Уг нэхэмжлэлүүд нь бүгд бүртгэхээс татгалзсан тохиолдолтой холбоотой. Нэг тохиолдолд Баруун Фракийн Грекийн нутагт байрлах Лалын цөөнхийн холбоодыг байгууллагуудын нэр нь 1923 оны Лозаннагийн гэрээний дагуу Баруун Фракт зөвхөн мусульман төдийгүй турк үндэстний цөөнх бүртгэгдээгүй учраас холбоо нь шашны цөөнх, эсвэл угсаатны цөөнхийн төлөөлөл үү гэдэг дээр тухайн байгууллагуудын гарал үүсэл, зорилгын талаар олон нийтийг төөрөгдүүлэх шинжтэй гэсэн үндэслэлээр татан буулгахаар шүүхээс шийдвэрлэсэн. Шүүхээс шийдэхдээ, ялангуяа тус холбооны гишүүд хүчирхийлэл, эсвэл ардчиллын эсрэг, эсвэл үндсэн хуулийн эсрэг үйлдлийг ухуулаагүй тохиолдолд үндэстний цөөнх байна гэсэн ойлголтыг түгээхийг ардчилалд заналхийлсэн үйлдэл гэж үзжээ. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөөнд хүн бүр өөрсдийн угсаатны онцлогийн талаарх итгэл үнэмшлийг хуулийн хүрээнд илэрхийлэх эрх багтдагийг Шүүхээс онцолсон. *Туркики Еноси Зантасис болон бусдын Грекийн эсрэг нэхэмжлэлийг үз, Зүйл № 56.*
- 290 Станков ба македонийн нэгдсэн холбооны байгууллага Илинден нар Болгарын эсрэг нэхэмжилсэн хэрэг. Нэхэмжлэл №29221/95 ба 29225/95, 2001 оны 10-р сарын 2, заалт №89. Түүнчлэн Сидиропулос ба бусад Грекийн эсрэг. Нэхэмжлэл №26695/95, 1998 оны 7-р сарын 10, заалт №44-ийг тус тус үз. Станков, Нэгдсэн Македонийн байгууллага Илинцентэй холбоотой хэрэгт шүүх нь бусад санал дүгнэлтээс гадна, түүхэн үйл явдлыг дурсах зорилготой олон нийтийн жагсаалын үеэр салан тусгаарлагч үзэл санаа, мэдэгдлийг илэрхийлсэн нь (уг холбоог өмнө нь үндсэн хуулийн эсрэг гэсэн үндэслэлээр бүртгэхээс татгалзсан байжээ.) нь ийм арга хэмжээг зохион байгуулахыг эрх баригчид татгалзах үндэслэл болох уу (агуулга болон бусад байдлаас шалтгаалан жагсаалд тавих хязгаарлалтыг тайван цуглаан, жагсаал хийх эрхийн тухай дээрх хэсгээс үз.) гэдгийг авч үзсэн. Тус Шүүх нь “хэсэг бүлэг хүмүүс өөртөө засахыг уриалсан, эсвэл тухайн улсын нутаг дэвсгэрийн зарим хэсгийг салган авахыг шаардсан, улмаар үүндээ үндсэн хууль, нутаг дэвсгэрийн өөрчлөлтийг шаардаж байсан ч, энэ нь автоматаар тэдний жагсаал, цуглаан хийхийг хориглох үндэслэл болж чадахгүй юм. Илтгэл, жагсаалаар нутаг дэвсгэрийн өөрчлөлтийг шаардах нь тухайн улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, үндэстний аюулгүй байдалд заналхийлэх зүйл биш юм. [...] Эрх зүйт ёсонд суурилсан ардчилсан нийгэмд, одоо байгаа дэг журмыг эсэргүүцэж, хэрэгжүүлэх арга замыг тайван замаар ухуулж буй улс төрийн санаануудыг жагсаал, цуглаан хийх, түүнчлэн хууль ёсны арга хэмжээгээр илэрхийлэх боломжоор хангах ёстой.” (97 дугаар зүйл).
- 291 Өзбек ба Бусад хүмүүсийн Туркийн эсрэг мэдүүлсэн хэргийн дүгнэлтийг үз. Нэхэмжлэл №35570/02, 2009 оны 10 дугаар сарын 6-ны өдөр.

202. Түүнчлэн ТББ байгуулахад үндэслэлгүй их тооны гишүүн шаарддаг эсвэл цөөнх бүлэгт хамааралтай хүмүүсийг холбоо байгуулахад саад болж болзошгүй үр дагаварт хүргэдэг үүсгэн байгуулагчдын иргэний харьяалалд шаардлага тавьдаг заалт бүхий хууль тогтоомжийг цуцлах ёстой.²⁹² Ийм шаардлагууд нь ТББ байгуулахаас сэргийлж, хүний эрхийг хамгаалагчдыг хамтдаа нийтлэг зорилгоо хэрэгжүүлэхээр хуулийн этгээд болоход саад болж болзошгүй юм.
203. Эрх баригчдын хууль бус хөндлөнгийн оролцоог дуусахыг нь хүлээх зуур хүний эрхийг хамгаалагчдыг бусадтай хамтран үйл ажиллагаагаа явуулахад нь саад учруулж болзошгүй хууль бус, удаан бүртгэлийн ажиллагаанаас зайлсхийх үүднээс ТББ хуулийн этгээдээр бүртгүүлэхийн тулд бүртгэлийн байгууллагаас зөвшөөрөл хүсэхийн оронд үүсгэн байгуулснаа мэдэгддэг журам хэрэгжүүлэхийг НҮБ-ын Жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч зөвлөсөн. Байгууллага үүсгэн байгуулсан тухай мэдэгдлийг эрх бүхий байгууллагад ирүүлсний дараа автоматаар хуулийн этгээд болно.²⁹³
204. Бүртгэлийн байгууллагаас аливаа шалтгаанаар хуулийн этгээдээр бүртгэхээс татгалзсан нь үндэслэлтэй бөгөөд олон улсын хүний эрхийн стандартад нийцсэн байх ёстойн сацуу бие даасан, хараат бус, шударга шүүхэд гомдол гаргах эрхтэй байх ёстой. Үүний нэгэн адил бүртгэлийн, эрх бүхий байгууллагын бусад захиргааны шийдвэр эсвэл хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль эрх зүйн үр дүнтэй арга хэрэгсэлтэй байх ёстой. Нэмж дурдахад, олон улсын түвшинд ажилладаг байгууллагууд, түүнчлэн олон улсын ТББ-уудын салбар зэрэг нийгэмлэгүүдийн сүлжээ, салбар үүсгэн байгуулахад мэдэгдлийн ижил журмыг дагаж мөрдөх ёстой.²⁹⁴ Цаашилбал НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч бүртгэлтэй ТББ дахин бүртгүүлэх шаардлагагүй, харин хууль ёсны дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлж

292 Европ дахь төрийн бус байгууллагын эрх зүйн байдлын талаар Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооноос зөвлөснөөр “хоёр ба түүнээс дээш хүн гишүүнлэлтэй ТББ байгуулах боломжтой байх ёстой гэсэн хэдий ч, ТББ байгууллага байгуулах боломжгүйд хүргэх хүртэл олон тоогоор л биш бол хуулийн этгээдээр бүртгүүлэхэд илүү олон хүнтэй байхыг шаардаж болно.” CM/REC (2007)14, 2007 оны 10-р сарын 10, заалт №17. НҮБ-ын тайван цуглаан, жагсаал зохион байгуулах, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний эрхийн асуудал эрхэлсэн тусгай илтгэгч нь холбоо байгуулахад хоёроос илүүгүй хүнтэй байхыг шаардахыг хууль тогтоомжийн хувьд хамгийн сайн практик гэж үзсэн. Эвлэлдэн нэгдэх, улс төрийн нам байгуулахын тулд илүү өндөр тоо шаардагдаж болох ч, энэ тоог хүмүүсийг холбоо байгуулахаас шантрах хүртэл өндөр түвшинд тогтоож болохгүй гэдгийг тэмдэглэн хэлжээ. Тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудал эрхэлсэн тусгай илтгэгчийн тайланг үз. НҮБ-ын Б.Б. А/ HRC/20/27, 2012 оны 5 дугаар сарын 21-ий өдөр, заалт №54.

293 А/HRC/20/27, 2012 оны 5 дугаар сарын 21-ий өдөр, заалт №58.

294 Эх. сурв. заалт №59.

байгаа гэж үзэж, шинэ хууль батлагдсан тохиолдолд бүртгэлээ шинэчлэх ажлыг түргэвчилсэн журмаар хангах ёстой гэдгийг онцлон дурдсан.²⁹⁵

ТББ-уудын үйл ажиллагааны талаар:

205. ТББ байгуулагдсаны дараа оролцогч улсууд ТББ бүртгэлтэй эсэхээс үл хамааран тэдний үйл ажиллагаа болон дотоод шийдвэр гаргах үйл явцад саад болохгүй байх үүрэгтэй. Гэсэн хэдий ч НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгчийн ажигласнаар сүүлийн үеийн хууль тогтоомжийн өөрчлөлтүүдээс харахад ТББ-ын тухай олон хууль тогтоомжууд төрийн байгууллагад ТББ-ын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, хяналт тавих өргөн эрх мэдэл олгож байна.²⁹⁶ Алан хядах ажиллагааны эсрэг, хэт даврах үзлийн эсрэг хуулиудыг иргэний нийгмийн үйл ажиллагааг хязгаарлах, хянах зорилгоор ашиглах явдал тодорхой улс орнуудад улам бүр нэмэгдэж байна.
206. Зарим оролцогч орнуудад ТББ-ын бичиг баримт, ажлын байранд ихэвчлэн дур зоргын, урьдчилан мэдэгдээгүй үзлэг, шалгалт хийх, тайлангийн хэтэрхий их шаардлага тавих, хүний эрхийн зарим үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох зэрэг хөндлөнгийн оролцоо, хяналттай байдаг. Зарим оролцогч улс орны эрх баригчид олон нийтийн аюулгүй байдал, эрүүл мэнд, ёс суртахууныг хохироосон үндэслэлээр хүний эрхийн тодорхой асуудлуудыг хөндсөн мэдээлэл сурталчилгааны кампанит ажил, бусад төрлийн төслийг хориглодог байна. Зарим тохиолдолд тодорхой хүний эрхийн сэдвүүдийг асуудал дагуулаагүй тул түүний талаар хөндөх, авч хэлэлцэх шаардлагагүй гэсэн үндэслэлээр хүний эрхийн үйл ажиллагаанд тавьсан хязгаарлалтуудыг зөвтгөдөг. Мөн зарим оролцогч улсууд тодорхой цөөнх бүлгүүд байдгийг үгүйсгэж, эдгээр бүлэгт харьяалагдах хүмүүсийн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихтэй холбоотой ТББ-ын үйл ажиллагааг хориглодог.
207. ТББ-уудын үйл ажиллагаанд эрх баригчид өөрсдийн хяналт, удирдлагыг нэмэгдүүлэхийн тулд зарим оролцогч улсад ТББ-ын ажилтан эсвэл гишүүдийн талаар мэдээлэл цуглуулахаас гадна, ТББ-аас зохион байгуулдаг сургалт, семинар, бусад арга хэмжээнд оролцогч, төслийн зорилтот үйлчлүүлэгчдийн талаар мэдээлэл цуглуулдаг. Төрийн эрх баригчид үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчдийг дотор болон гадна, талбай, байгууламжийг ТББ-д түрээслэхээс урьдчилан сэргийлэхийн тулд дарамт шахалт үзүүлсэн бодит тохиолдол ч гарч байсан.

295 А/59/401, заалт №82 (i).

296 А/67/292, 2012 оны 8 дугаар сарын 10-ны өдөр, заалт №46.

208. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч хэлэхдээ: ийм заалт, практик үйл ажиллагаа нь чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхийн ноцтой зөрчилд хүргэдэг.²⁹⁷ ТББ болон бусад холбоод “төрийн оролцоогүйгээр өөрсдийн дүрэм, бүтэц, үйл ажиллагааг чөлөөтэй тодорхойлж, шийдвэр гаргах ёстой”.²⁹⁸ Оролцогч улсууд ТББ-ууд өөрсдийн хөтөлбөр, үйл ажиллагааг боловсруулж, нөөцөө удирдах, түүний дотор санхүүжилтийг бие даан, эрх баригчдын оролцоогүйгээр удирдах эрхийг хүндэтгэх ёстой.²⁹⁹ ТББ-ууд ямар нийгмийн бүлгүүдтэй эсвэл хүний эрхийн ямар асуудлаар ажиллаж болох, болохгүй нь эрх баригчдын шийдэх асуудал биш юм. Европын Зөвлөлийн Европ дахь ТББ-уудын эрх зүйн байдлын талаар гаргасан зөвлөмжид “ТББ нь баримталж буй байр суурь нь төрийн бодлоготой нийцэж буй эсвэл хууль өөрчлөх шаардлагатай эсэхээс үл хамааран олон нийтийн хэлэлцүүлгийн асуудлаар судалгаа, боловсрол, ухуулгын ажлыг чөлөөтэй явуулах ёстой.” гэж онцолжээ.³⁰⁰ ТББ нь төрийн байгууллагуудын удирдлага чиглэлээр ажиллах ёсгүй; улмаар холбоодын зарим эсвэл бүх үйл ажиллагаанд урьдчилж зөвшөөрөл олгох тогтолцоо нь эвлэлдэн нэгдэх эрх чөлөөтэй нийцэхгүй байна.³⁰¹ Иймээс оролцогч улсууд ийм тогтолцоог нэн даруй устгах хэрэгтэй.
209. Улс орнууд ТББ болон бусад холбоодод тавьдаг тайлангийн шаардлага нь үндэслэлтэй, үйл ажиллагааных нь бие даасан байдалд нь саад учруулахааргүй байхад анхаарах ёстой.³⁰² Үүнтэй адилаар ТББ, түүний санхүүгийн тайлангийн аудит, шалгалттай холбоотой хууль тогтоомж, дүрэм журам нь тодорхой, ил тод, урвуулан ашиглахаас бүрэн сэргийлсэн байх ёстой. ТББ-д бэлтгэхэд хангалттай хугацаа өгөхийн тулд хяналт шалгалтаас өмнө хангалттай эрт мэдэгдэнэ. Хэрэв ТББ нь тайлагнах зохих ёсны шаардлага, бусад зохицуулалтыг дагаж мөрдөөгүй тохиолдолд тухайн байгууллагад нэмэлт баримт бичиг явуулах, залруулга хийх

297 Эх. сурв.

298 A/HRC/20/27, заалт №97.

299 Үйлдвэрчний эвлэлийн хувьд, жишээлбэл: Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын (ОУХБ) Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, зохион байгуулах эрхийг хамгаалах тухай Конвенц №87-д ажилчин ба ажил олгогч байгууллагууд өөрсдийн гэрээ, дотоод журам, дүрмийг боловсруулах, өөрсдийн төлөөлөгчөө бүрэн чөлөөтэй сонгох эрхтэй. үндсэн хууль, дүрмийг баталж, өөрсдийн төлөөлөгчдөө бүрэн чөлөөтэй сонгох, удирдлага, үйл ажиллагаагаа зохион байгуулах, хөтөлбөрөө зохиж боловсруулах эрхтэй байна.” (3 дугаар зүйлийн 1) гэж заасан.

300 CM/REC (2007) 14, заалт №12.

301 CDL (2013)017, “Эвлэлдэн нэгдэх ба төрийн бус байгууллага (ТББ-ууд) байгуулах эрх чөлөөтэй холбоотой стандарт ба хууль тогтоомжид хийсэн зарим урьдчилсан санал дүгнэлт”, 2013 оны 3 дугаар сарын 28, заалт №19-21-ийг үз.

302 A/HRC/RES/22/6, 2013 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр.

боломжийг олгосон зохих мэдэгдэл илгээх ёстой.³⁰³ Зохих үндэслэлтэй шаардлага, журам давтан зөрчигдсөн тохиолдолд ногдуулдаг торгууль, улсын татаас, бусад хөнгөлөлтийг цуцлах зэрэг аливаа хориг арга хэмжээ нь пропорциональ байх ёстой ба төлөвлөсөн зорилгодоо хүрэх хамгийн бага хөндлөнгийн оролцоо шаардсан арга сонгохыг эрхэмлэнэ.³⁰⁴ Урвуулан ашиглахаас хамгаалахын тулд ямар ч тохиолдолд ийм шийтгэлийг давж заалдах үр дүнтэй арга хэрэгсэл бий болгох хэрэгтэй. Хуулийн этгээдийн статус байхгүй ТББ эсвэл бусад холбоодын хувь гишүүнд хариуцлага хүлээлгэхийг хууль тогтоомжоор шаардаж болох боловч, ийм заалтуудыг хүний эрхийг хамгаалагч хувь хүний хууль ёсны хүний эрхийн үйл ажиллагаанд дарамт үзүүлэх арга хэрэгсэл болгон ашиглах ёсгүй. Оролцогч улсууд ТББ-д үйлчилгээ үзүүлдэг гэрээт хувь хүн, байгууллага болон төслийн зорилтот үйлчлүүлэгчдийг дарамтлах, айлган сүрдүүлэх явдлыг арилгах хэрэгтэй.

Санхүүжилт, эх үүсвэр олох

210. Дотоод, гадаад, олон улсын эх үүсвэрээс санхүүгийн эх үүсвэр хайх, авах чадвар нь эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний чухал хэсэг юм.³⁰⁵ НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхагалд “хүн бүр бие даан болон бусадтай хамтран энхийн замаар хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих,

303 Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн НҮБ-ын Тусгай илтгэгч, Улс орнууд иргэний нийгмийн байгууллагын тухай хуулийг мөрдөөгүйг гэмт хэрэгт тооцох ёсгүй гэдгийг цохон тэмдэглэсэн “Хүний эрхийг хамгаалагчдын тунхагалд хийсэн тайлбар”, хуу. №46, заалт хiii-ыг үз.

304 “Виасна” гэх хүний эрхийн байгууллагыг татан буулгахтай холбоотой Беларусын эсрэг гаргасан Беляцкийн нэхэмжлэлд өгсөн санал дүгнэлтдээ (Баримт №1296/2004, 2007 оны 7-р сарын 24, НҮБ-ын Б.Б. ССРР/С/90/D/1296/2004), НҮБ-ын Хүний Эрхийн Хорооноос: “Бараг таамаг шахам боломжит, бодит үндэслэл нь эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлахад хангалттай биш юм. Гэрээний улс нь цаашид үндэсний аюулгүй байдал, эсвэл ардчилсан хэв журамд тулгарсан бодит, зөвхөн таамаг төдий бус аюулаас зайлсхийх, тухайн зорилгод хүрэхэд энгийн арга хэмжээ авах боломжгүй болсон тул эвлэлдэн нэгдэх эрхийг хориглох нь зайлшгүй” гэдгийг батлан харуулж байх ёстой (7.3-р зүйл). Корнеенко ба бусдын Беларусын эсрэг гаргасан өөр нэг хүний эрхийн байгууллагыг (1) гадаадын буцалтгүй тусламжаар хүлээн авсан багаж хэрэгслийг суртал ухуулгын материал үйлдвэрлэх, суртал ухуулгын үйл ажиллагаа явуулах замаар зохисгүй ашигласан; (2) холбооны баримт бичиг алдаа мадагтай гэсэн хоёр үндэслэлээр шүүхээс татан буулгасан тухай хэргийн нэхэмжлэл (Баримт 1274/2004, 2006 оны 10-р сарын 31-ний өдөр, НҮБ-ын Б.Б. ССРР/С/88/D/1274/2004)-ыг үз. Тус Хороо нь татан буулгасан нь ИУТЭОУП-ын 22 (2) -т заасан шаардлагыг зөрчсөн бөгөөд өөр бусад зүйлсийг дурдсанаас гадна, бичиг баримт нь дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг бүрэн хангаагүй байсан ч, холбоог татан буулгасан гэрээний улсын эрх бүхий байгууллагын арга хэмжээ нь пропорциональ бус гэж үзсэн (заалт №7.6). Европын Зөвлөлийн Венецийн Хороо, мөн “ТББ-ыг татан буулгах нь хэт хатуу арга хэмжээ байсан ба ийм шийдвэр нь маш сайн бодит үндэслэл дээр суурилсан байх ёстой бөгөөд зөвхөн онцлог нөхцөл байдалд л хэрэглэдэг олон улсын жишгийн эрх зүйн дагуу тогтоосон баттай үндэслэлийг хангах ёстой. “Беларусын Бүгд Найрамдах Улсын бүртгэлгүй нийгэмлэгүүдийн эрхийн тухай Эрүүгийн хуулийн 193-1-р зүйлийн хүний эрхийн нийтлэг стандартуудад нийцэх байдалд гаргасан санал дүгнэлт”, CDL-AD (2011) 036, заалт №107-г үз.

305 A/HRC/23/39, 2013 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр.

хамгаалах зорилгоор хөрөнгийн эх үүсвэр хайх, олж авах, ашиглах эрхтэй [...] гэж заасан”.³⁰⁶ НҮБ-ын Тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний эрхийн асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч улс орнууд бүртгэлтэй болон бүртгэлгүй аль аль холбоодыг санхүүжилт, тэр дундаа гадаад эх үүсвэрээс санхүүжилт авах боломжийг хязгаарлахгүй, боломжоор хангах үүрэгтэй гэж мэдэгджээ.³⁰⁷

211. Цөөнгүй оролцогч улс оронд ТББ-уудын санхүүжилт авах, ялангуяа гадаадаас санхүүжилт авах эрхийг ноцтойгоор боогдуулдаг. Зарим оролцогч улс орнуудын хууль тогтоомж, бусад норматив тогтоол журам нь тухайлбал, хөрөнгө босгох үйл ажиллагаа эрхлэхэд төрийн зөвшөөрөл авахыг, байгууллагын санхүүгийн тайлангийн хүнд хэцүү шаардлагыг дагаж мөрдөхийг шаардах, босгосон хөрөнгийн бүртгэлд тусгай шаардлага тавих зэргээр ТББ-уудын гадаад санхүүжилт хайх, авах эрх чөлөөнд хөндлөнгөөс оролцдог. Үүнээс гадна, гаднын хандивлагчдын буцалтгүй тусламжийн хувиарлалтыг хянах, эс бөгөөс тодорхой ТББ эсвэл төсөлд хуваарилах замаар төрийн эрх баригчид хөрөнгө босгох ажилд хөндлөнгөөс шууд оролцдог.

212. Оролцогч улсууд “гадаадын хөндлөнгийн оролцоо” -той тэмцэх, “үндэсний эрх ашгийг” хамгаалах гэсэн шалтгаанаар тавьсан гадаадын санхүүжилтийн эх үүсвэр дэх бүх хязгаарлалтыг цуцлах, хүний эрхийг бүх талаар сурталчлах, хамгаалах ТББ-ын эрхийг хүндэтгэх ёстой. Тэд ТББ-уудад санхүүжилт, түүний дотор гадаадын санхүүжилтийг засгийн газраас урьдчилж зөвшөөрөл авалгүйгээр, тэгш нөхцөлд авах боломжийг хангах ёстой. Аливаа шаардлага нь “ил тод, хариуцлагатай байхын тулд улс дахь хүний эрхэд хамааралгүй бусад үйл ажиллагаанд тавигдах шаардлагууд”³⁰⁸-тай нийцэж байх ёстой бөгөөд “гадаад валютын болон гаалийн нийтээр дагаж мөрддөг хууль тогтоомжид нийцсэн байх ёстой.”³⁰⁹ Түүнчлэн “аливаа хуулиар хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийг гарал үүслээс нь шалтгаалан гэмт хэрэгт тооцох буюу хууль бусад үзэх ёсгүй”.³¹⁰

213. Мөнгө угаах болон алан хядах ажиллагааны санхүүжилтээс урьдчилан сэргийлэхийг ТББ-уудын санхүүжилт авах эрхийг хязгаарлах үндэслэл эсвэл шаардлага болгон ашиглах ёсгүй. Энэ асуудлаар НҮБ-ын Тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудал эрхэлсэн Тусгай

306 Зүйл №13.

307 A/HRC/23/39, 2013 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр, заалт №17-18, 79 ба 82.

308 A/HRC/RES/22/6, 2013 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр, заалт №9 (b).

309 A/64/226, 2009 оны 8 дугаар сарын 4-ний өдөр, заалт №123.

310 A/HRC/RES/22/6, 2013 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр, заалт №9 (b).

илтгэгч тэмдэглэн хэлэхдээ “улс орнуудын үндэсний аюулгүй байдал болон олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах сонирхол нь эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлах хууль ёсны үндэслэлтэй ч, алан хядах ажиллагаатай тэмцэхийн зэрэгцээ улс орнууд хүний эрхийн олон улсын хуулийг дагаж мөрдөх шаардлагатай байна” гэжээ. Олон улсын жишигт нийцэхийн тулд эвлэлдэн нэгдэх эрх, түүний дотор санхүүжилттэй холбоотой аливаа хязгаарлалт нь зөвхөн хууль ёсны зорилгоо биелүүлэхээс гадна, тухайн зорилгодоо хүрэхэд шаардлагатай бөгөөд пропорциональ харьцаатай байх гэсэн зарчмыг мөрдөх ёстой. Тусгай илтгэгчийн хэлсэнчлэн “терроризм буюу алан хядлагын эсрэг эсвэл экстремизм буюу хэт даврах үзэлтэй тэмцэх” арга хэмжээг шүүмжлэлт үзэл бодол эсвэл хараат бус иргэний нийгмийг хязгаарлах шалтаг болгон ашиглах зэрэг нь олон улсын хууль тогтоомжийг зөрчиж байна.³¹¹

214. Оролцогч зарим улсад гадаадын санхүүжилт авдаг ТББ-ыг “гадаадын төлөөлөгч” гэх муу нэр өгөх, тэдний үйл ажиллагааны нэр хүнд, нийгэм дэх ерөнхий үүргийг сөрөг байдлаар харуулдаг. “Гаднаас санхүүжигчдийг муу нэр авахад хүргэдэг зохицуулалтын арга хэмжээнүүд нь санхүүжилт хайх, авах, ашиглах эрхэд халддаг үндэслэлгүй үйлдлүүдийг хууль ёсны болгож хувиргадаг.”³¹² Иймэрхүү муу нэр холбогдсох хувь хүмүүс, албан байгууллагуудад үл итгэсэн, айдастай, дайсагнасан уур амьсгалыг бий болгож, улмаар нийгмээрээ шившиглэхэд хүргэж болзошгүй юм. Энэ нь хүний эрхийн бие даасан ажлын үр дүнд саад болж, хүний эрхийг хамгаалагчдын нэр төр, бие махбодын халдашгүй байдал, аюулгүй байдалд заналхийлж болзошгүй юм. Ийм хууль, практикууд нь “эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэхэд хөндлөнгөөс оролцох явдлын тод жишээ”³¹³ бөгөөд даруй нэмэлт, өөрчлөлт хийх эс бөгөөс хүчингүй болгох ёстой. Оролцогч зарим улсад ийм журмыг дагаж мөрдөхгүй бол хүний эрхийг хамгаалагчид ноцтой хариуцлага хүлээж, торгууль төлөх эсвэл бүр эрүүгийн хэрэгт татагдах, шоронд хоригдоход ч хүргэж болзошгүй байдаг.

215. Оролцогч улсууд нь бие даасан хүний эрхийн үйл ажиллагаанд хөрөнгө хайх, олж авахад нь тусалж, дэмжлэг үзүүлэх замаар ТББ болон бусад холбоодын дотоод, гадаадын санхүүжилт болон бусад эх үүсвэрүүдэд хандах боломжийг нэмэгдүүлж өгөх ёстой. Оролцогч улсууд нь хүний

311 A/HRC/23/39, 2013 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр, заалт №22 ба 23.

312 A/HRC/23/39, 2013 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр, заалт №82 (d).

313 Венецийн Хороо ба ЕАБХАБ/АИХЭГ, “Бүгд Найрамдах Киргиз улсын Арилжааны бус байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл ба бусад эрх зүйн актад хийсэн хамтарсан урьдчилсан дүгнэлт”, CDL-AD (2013)030, 2013 оны 10 дугаар сарын 11-12-ны өдрүүд.

эрхийг хамгаалагчдын зарим тодорхой бүлэгт шууд болон шууд бус байдлаар ялгаварлан гадуурхсан хязгаарлалт тавихаас татгалзаж, төрийн санхүүжилтийг тэгш, ялгаварлан гадуурхалтаас ангид хуваарилах боломжоор хангах ёстой. Холбогдох журмуудыг ил тод, шударга байлгаж, өргөдөл хүлээн авах зарыг тодорхой ТББ-уудыг ажиллаж байгаа хүний эрхийн асуудлаас нь шалтгаалж ялгахгүйгээр аль болох өргөн хүрээнд, олон нийтэд хүргэхэд шаардлагатай арга хэмжээг авах хэрэгтэй байна. Засгийн газрын санхүүжилт эсвэл бусад дэмжлэг үзүүлэх арга хэрэгслийг ТББ-уудын үйл ажиллагаа эсвэл дотоод шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөх дарамтлах арга болгон ашиглах ёсгүй.

Ё. Бодлогын үйл ажиллагаанд оролцох олон нийтийн эрх

216. НҮБ-ын Хүний эрхийн хорооноос цохон тэмдэглэснээр, ИУТЭОУП-ын 25 дугаар зүйлд заасан засгийн газрын болон олон нийтийн бодлогын үйл ажиллагаанд оролцох эрх нь зөвхөн сонгох, сонгогдох эрх төдийгүй, хүссэнээрээ сонгосон төлөөлөгчидтэйгээ олон нийтийн мэтгэлцээн, яриа хийх замаар нөлөө үзүүлж бодлогын үйл ажиллагаанд олон нийтийн оролцох эрх хамаарна.³¹⁴ Бодлогын үйл ажиллагаанд олон нийтийн оролцох эрхийг ХЭАК-ын 23 дугаар зүйлд тусгасан байдаг бол ҮЦХСК-ын 15 дугаар зүйлд олон улсын гэрээний талууд нь “үндэсний цөөнхөд харьяалагддаг хүмүүст соёл, нийгэм, эдийн засгийн амьдрал, ялангуяа тэдэнд нөлөөлж буй олон нийтийн бодлогын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлж өгнө” гэж заасан байдаг.
217. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглал нь хүний эрхийн зөрчлийг үр дүнтэй арилгахад хувь нэмэр оруулж буй хувь хүн, нийгэмлэгийн үнэлж баршгүй ажлыг хүлээн зөвшөөрч, хүн бүр бие даан болон бусадтай хамтран хүний эрхийн талаар мэдээлэл, мэдлэг түгээх, хуульд заасан болон практикт хэрэглэдэг хүний эрх, үндсэн эрх чөлөөг дагаж мөрдөж буй байдлын талаар итгэл үнэмшилтэй байх, итгэл үнэмшилд хүрэх, эдгээр асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах (6 дугаар зүйл) эрхтэй гэж мэдэгджээ. Түүнчлэн, хүн бүр хүний эрхийн шинэ үзэл санаа, зарчмыг боловсруулж, хэлэлцүүлж, сурталчлах (7 дугаар зүйл), үл ялгаварлан гадуурхах зарчмаар өөрийн улсын засгийн газар, бодлогын үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог бодит боломжоор хангуулах эрхтэй (8 дугаар зүйл) гэж тунхагласан.
218. Бодлогын үйл ажиллагаанд хувь хүмүүс, нийгэмлэг, түүний дотор ТББ-уудын оролцоо нь “хамгийн чухал ач холбогдолтой бөгөөд эрүүл иргэний

314 НҮ-ий Хүний Эрхийн Хорооны ерөнхий тайлбар 25, НҮБ-ын Б.Б. ССРР/С/21/Rev.1/ Add.7, 1996 оны 7 дугаар сарын 12, заалт №8.

нийгмийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм.”³¹⁵ ЕАБХАБ-ын хэд хэдэн үүрэг амлалтад томъёолсончлон ардчилал, хүний эрх, эрх зүйт ёсыг хөхиүлэн дэмжихэд ТББ, бүлэг, хувь хүмүүс чухал үүрэгтэйг дахин нотолж³¹⁶, ЕАБХАБ-ын оролцогч улсууд нь “ТББ болон холбогдох төрийн эрх баригчид, засгийн газрын байгууллагуудын хооронд харилцаа холбоо тогтоох, санал бодлоо солилцох нөхцөлийг сайжруулах” зорилгоо биелүүлэхээр үүрэг амлалт авчээ.³¹⁷

219. Гэсэн хэдий ч олон оролцогч улс оронд хүний эрхийг хамгаалагч нар олон нийтийн бодлогын үйл ажиллагаанд оролцох эрхээ бүрэн хэрэгжүүлэхэд саад бэрхшээл тулгарсаар байна. Практикт, хүний эрхийг хамгаалагч, ТББ-уудын нийгмийн хөгжил, ардчиллыг бэхжүүлэхэд оруулсан хувь нэмрийг үл тоомсорлох эсвэл дутуу үнэлдэг. Цаашилбал зарим оролцогч улсууд хүний эрхийг хамгаалагчдын хууль ёсны үйл ажиллагааг ихээхэн хязгаарласан эсвэл хориглосон хууль тогтоомж, практикийг нэвтрүүлдэг. Хүний эрхийг хамгаалагч, тэдний ТББ-аас гаргасан тандалт судалгаа, тайлан, бусад судалгааг ихэвчлэн “улс төрийн далд санаатай” эсвэл туйлширсан, хамааралгүй мэтээр харуулдаг. Хүний эрхийн ажлын бусад чухал элементүүд болох олон нийтэд мэдлэг олгох, сурталчлах, ухуулах зэрэг үйл ажиллагаанууд хэд хэдэн оролцогч улсад ТББ-ын сонгосон сэдэв эсвэл газарзүйн цар хүрээтэй холбоотой үндэслэлгүй хязгаарлалтуудтай тулгардаг. Зарим оролцогч улсад, ТББ-уудыг зөвхөн албан ёсоор бүртгүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид үйл ажиллагаагаа явуулахыг зөвшөөрдөг гэсэн мэдээлэл байна. Ийм журам нь эдгээр ТББ-уудын эмзэг, цөөнхийн бүлгүүд эсвэл хөдөө, алслагдсан бүс нутагт хүний эрхийн чиглэлээр ажиллах, түүнчлэн тэдний бодлогын үйл ажиллагаанд оролцох эрхийг хязгаарладаг. Оролцогч улсууд хүний эрхийг хамгаалагч, ТББ-уудын олон нийтийн ажилд идэвхтэй, чөлөөтэй, утга учиртай оролцоход саад болж буй аливаа зохицуулалт, практикийг арилгах ёстой.
220. Хэд хэдэн оролцогч улсад нийгмийн чухал асуудлууд болон хүний эрхийг хамгаалагч, ТББ-уудын хууль ёсны ажил, зорилгоо гүйцэлдүүлэхэд шууд нөлөөлдөг зохицуулалтуудтай холбоотой хууль тогтоомжийн

315 Венецийн Хороо ба ЕАБХАБ/АИХЭГ, “Бүгд Найрамдах Киргиз улсын Арилжааны бус байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл ба бусад эрх зүйн актад хийсэн хамтарсан урьдчилсан дүгнэлт”, CDL-AD (2013)030, 2013 оны 10 дугаар сарын 11-12-ны өдрүүд, заалт №15.

316 Жишээлбэл, Парис 1990, “Ардчилал, энх тайван, эв нэгдлийн шинэ эрин үе”; Хельсинкийн баримт бичиг, Өөрчлөлтийн тулгамдсан асуудал, Төр болон Засгийн газрын тэргүүн нарын Дээд Хэмжээний Уулзалт, Шийдвэр: IV. Олон улсын байгууллагатай харилцаа холбоо, Оролцогч бус улс орнуудтай харилцаа холбоо, Төрийн бус байгууллагуудын үүрэг (ТББ)” заалт №1; Станбул 1999 он, “Европын аюулгүй байдлын дүрэм: III. Бидний нийтлэг хариу арга хэмжээ”, заалт №27.

317 Москва 1991, заалт № (43.1).

хэлэлцээ, санаачилгуудад тэдэнтэй огт зөвлөлддөггүй эсвэл дорвитой зөвлөлддөггүй. Эдгээр зөвлөлдөх уулзалтууд тэгш оролцоо, үл ялгаварлан гадуурхах зарчмыг хангадаггүйгээс гадна ТББ-уудад хууль тогтоомжийн санаачилгын үр нөлөөг үнэлэх, бүрэн оролцоог хангахад хангалттай цаг хугацаа өгөхгүйгээр гэнэтийн байдлаар зохион байгуулдаг. Европын зөвлөлийн сайд нарын хороо бүх шатны төрийн байгууллагыг “төрийн бодлогын зорилт, шийдвэрийн талаар хэлэлцэх, зөвлөлдөхдөө аливаа ялгаварлалгүйгээр ТББ-уудын идэвхтэй оролцоог хангаж, тэдний статус, санхүүжилт, үйл ажиллагаанд нөлөөлөх хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа ТББ-уудтай зөвлөлдөх нь зүйтэй” гэж цохон тэмдэглэв.³¹⁸ Ийм зөвлөлдөх уулзалтууд нь хэлэлцэж буй хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын стандарттай нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахад нөлөөлж чадна. Хууль, тогтоомжид мэргэжлийн, оновчтой санал өгөх боломжийг бүрдүүлсэн дээрх механизм нь ТББ болон төрийн байгууллагуудын, цаашлаад нийгмийн ашиг сонирхолд нийцдэг.³¹⁹

221. Үр дүнтэй оролцоо гэж зөвхөн албан ёсны зөвлөгөөн зохион байгуулаад өнгөрөхийг хэлэхгүй. Оролцооны үр дүнтэй байдлыг хангахын тулд зөвлөлдөх механизм нь үйл явцын эхнээс дуустал бүхий л үе шатанд оролцох бололцоог хангах ёстой ба хэлэлцэгдэж буй асуудлын талаарх олон ургалч үзэл бодол, санаанууд, тэдгээрийг эцсийн шийдвэр гаргахдаа бүх талаас нь авч үзэхэд нээлттэй хандах ёстой. Иргэний нийгмийн оролцогчид, тэр дундаа хүний эрхийг хамгаалагч нар ба НҮБ-ын хоорондын харилцааны тухайд, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл олон талт оролцоог хангасан, нээлттэй яриа хэлэлцээ хийх шаардлагатай байгааг дахин нотолж, иргэний нийгмийн оролцоог ил тод, шударга, үл ялгаварлан гадуурхах зарчмаар зохион байгуулах нь зүйтэй гэж цохон тэмдэглэв. Эдгээр нь ЕАБХАБ-ын оролцогч орнуудад ч хамаатай. Хамгаалж буй эрхийн мөн чанар, нийгмийн тодорхой бүлэгт хамааралтай эсвэл төрийн бодлого, үйл ажиллагаанд шүүмжлэлтэй байр суурь баримталдаг эсэхээс үл хамааран хүний эрхийг хамгаалагч нар ба тэдгээрийн байгууллагууд оролцох, олон талт оролцооны болон зөвлөлдөх механизмыг үр дүнтэй ашиглах боломжтой байх ёстой.³²⁰

222. Оролцох, зөвлөлдөх үйл ажиллагаа нь бүх сонирхогч талуудад нээлттэй байх боломжийг хангахын хамтаар оролцогч улсууд нь санаачилгаараа хүрч үйлчлэн, ялангуяа тухайн сэдвээр тодорхой туршлага бүхий хүний

318 CM/REC (2007)14, заалт №76 ба 77.

319 “Европ дахь төрийн бус байгууллагын эрх зүйн байдлын тухай” Сайд нарын хорооны гишүүн орнуудад илгээсэн Сайд нарын хорооны CM / Rec (2007)14 тоот зөвлөмжийн тайлбар санамж бичиг”, Европын Зөвлөлийн Сайд нарын Хороо, заалт №135.

320 A/HRC/RES/22/6, 2013 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр, заалт №15 ба 17.

эрхийг хамгаалагч хэлэлцэж буй бодлого, хууль тогтоомжийн болон бусад арга хэмжээний нөлөөлд өртөгсдийн төлөөлөл болсон хувь хүмүүс, бүлгүүдийг татан оролцуулах хэрэгтэй.³²¹ Тэд онцгой хэрэгцээтэй хүмүүст, тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалагчдад оролцох, зөвлөлдөх механизмын нээлттэй байдлыг хангах практик арга хэмжээ авах хэрэгтэй.³²² Цаашилбал, Парисын зарчимд нийцүүлэн үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд, хүний эрхийг хамгаалагчид, бие даасан ҮХЭИ-үүдтэй хамтран тэдний олон нийтийн үйл ажиллагааны идэвхтэй, зорилготой оролцоог хангах үүднээс оролцогч улсууд түүхэн туршид гадуурхагдаж ирсэн эсвэл ялгагддаг хасагддаг бүлгүүд, эрхээ хамгаалахаар ухуулга хийдэг хүний эрхийг хамгаалагчдын чадавхыг дээшлүүлэх алхмууд авч хэрэгжүүлэх хэрэгтэй.³²³

-
- 321 Холбогдох зөвлөмжийг, жишээ нь: “Тус Хороо нь хүүхдийн эрхийг сурталчлах, хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн, түүний дотор, ТББ, хүүхдийн холбоо нэгдлийг бодлого боловсруулах шат, хамтарсан төслүүд, түүнчлэн тус Хорооны нэгдсэн дүгнэлтийн мөрөөр хийх дүгнэлт, дараагийн хугацаат тайлангийн бэлтгэлд оролцуулах гэх мэт замаар хүүхдийн бодлогыг хэрэгжүүлэхэд идэвхтэй, системтэйгээр оролцуулахыг гэрээний улсад зөвлөж байна.” гэсэн НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны Хороо, “Нэгдсэн дүгнэлт: Нидерланд”, НҮБ-ын Б.Б. CRC/C/NLD/CO/3, 2009 оны 3-р сарын 27, заалт №25-аас үз. Үүнтэй төстэй зөвлөмжийг “Нэгдсэн дүгнэлт: Серби”, НҮБ-ын Б.Б. CRC/C/SRB/CO/1, 2010 оны 6-р сарын 22, заалт №24-өөс үз. Жишээлбэл: Арьс өнгөөр ялгаварлан гадуурхалтыг устгах Хороо(АӨЯГУХ) “төрөөс, тухайлбал, Арьс өнгөөр ялгаварлан гадуурхалтыг зогсоох тухай зэрэг хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудтай дараагийн хугацаат тайлангийн бэлтгэл ажилтай холбогдуулан зөвшилцөж, харилцан яриагаа өргөжүүлэхийг гэрээний улсад зөвлөж байна.” НҮБ-ын Арьс өнгөөр ялгаварлан гадуурхалтыг устгах хороо, “Нэгдсэн дүгнэлт: Канад”, НҮБ-ын Б.Б. CERD/C/CAN/CO/19-20, 2012 оны 4-р сарын 4, заалт №26.
- 322 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай конвенцын 29-р зүйл уг олон улсын гэрээний оролцогч орнуудад “хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн ялгаварлан гадуурхалд өртөлгүйгээр, бусадтай адил тэгш байдлаар (i) тухайн улсын нийгэм, улс төрийн амьдралд хамаарах төрийн бус байгууллага, холбоодод оролцох [...]; (ii) Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг олон улсын, үндэсний, бус нутгийн болон орон нутгийн түвшинд төлөөлөх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага байгуулах, нэгдэх замаар олон нийтийн үйл хэрэгт үр дүнтэй, бүрэн дүүрэн оролцох боломжтой орчныг санаачилга гарган дэмжихийг шаарддаг.” Энэхүү заалтыг хэрэгжүүлэхэд уг конвенцын 9-р зүйлд заасны дагуу оролцоо, зөвлөлдөх механизмуудын хүртээмжийг хангах, тухайлбал, өөр бусад зүйлсийн сацуу, уулзалтад биечлэн оролцох, зөвлөлдөх баримт бичгүүдтэй танилцах, ажиллах боломж олгох зэрэг практик алхмууд авч хэрэгжүүлэх шаардлагатай болно. Конвенцын 9-р зүйлд: “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бие даан амьдрах, амьдралын бүхий л салбарт оролцох боломжоор хангахын тулд гэрээний улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусадтай адил тэгш эрхтэйгээр бодит орчин нэвтрэх, тээвэр ашиглах, мэдээлэл, харилцаа холбоо, түүний дотор мэдээлэл, холбооны технологи, систем, бусад байгууламж, хотын болон хөдөөгийн иргэдэд нээлттэй буюу тэдэнд зориулсан үйлчилгээг хүртэх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд зохих арга хэмжээг авна.” гэж заасан.
- 323 Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн тусгай илтгэгч хатагтайн Томоохон бүтээн байгуулалтын төсөл ба хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагааны хоорондын уялдаа холбооны талаар гаргасан тайландаа тусгасан улс орнуудад зориулсан зөвлөмжийг НҮБ-ын Б.Б. а/68/262, заалт №81(g)-ээс үз. Тус тайланд Тусгай илтгэгч нь мөн хувийн компаниудад: “томоохон бүтээн байгуулалтын төслүүдийн бүхий л үе шатанд оролцогч талуудыг, ялангуяа нөөлөлд өртсөн иргэд, тэдний эрх ашгийг хамгаалж буй хүмүүсийг татан оролцуулж, эдгээр талуудтай зөвхөн ёс төдий биш, шударгаар, үр дүнтэй хамтран ажиллахыг” уриалсан. Эх. сурв. заалт №83 (c)-ийг үз.

223. Оролцогч улсууд хүний эрхийг хамгаалагч болон ТББ нарыг холбогдох мэдээллээр хангах, бие даасан судалгаа явуулахад дэмжлэг үзүүлэх, төрийн бодлогын талаарх мэтгэлцээнд оролцох, шүүн таслах ажиллагаа болон бусад процессийн ажиллагаанд ажиглалт хийх гэх мэт хүний эрхийн хяналт-шинжилгээний үйл ажиллагаанд нээлтэй хандах замаар тэгш, үр дүнтэй оролцоог дэмжиж, санаачилга гарган зохион байгуулах ёстой. Эрх зүйт ёсыг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд оролцох оролцооны нэг хэлбэр болсон хууль тогтоомж ба түүний нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах, хянах, зөвлөлдөх хэлэлцүүлэгт хүний эрхийг хамгаалагчдыг оролцуулахаас гадна, шүүхийн эрх мэдлийн тогтолцоонд хяналт-шинжилгээ хийх боломж олгож шүүх, шүүхийн байгууллагуудад саадгүй нэвтрэх боломжоор хангах ёстой. Түүнчлэн, хүний эрхийг хамгаалагчдыг албадан саатуулах байр болон бусад төрийн байгууллагуудад хяналт шалгалтын үйл ажиллагаа эрхлэх, бие даасан хяналтын байгууллагуудыг байгуулах, ажиллуулахад зохих ёсоор оролцохыг зөвшөөрөх хэрэгтэй.³²⁴ Оролцогч улсуудад холбогдох төрийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, төрийн албан тушаалтнуудыг хүний эрхийн талаар сургах, хүний эрхийг хамгаалагчдын ажлын хууль ёсны байдал, ач холбогдлыг ухамсарлуулахад хүний эрхийг хамгаалагч нар болон тэдний бүлэг, байгууллагуудаас туслалцаа авахыг зөвлөж байна (мөн доороос Хэрэгжилтийн ерөнхий төлөвлөгөө хэсгийг үзнэ үү).

324 Жишээлбэл: Болгар Улсад хийсэн нэгдсэн дүгнэлтдээ НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо (ЭХЭШ) "Болгарын Хельсинкийн хорооноос шүүгдэхээр албадан саатуулагдсан хүмүүстэй уулзахын тулд прокурорын зөвшөөрөл шаарддаг гэх мэтчилэн ямар ч төрлийн албадан саатуулсан тохиолдолд иргэний нийгмийн байгууллагуудын хараат бус хяналт тавихыг зөвшөөрдөггүй" байдалд санаа зовниж буйгаа илэрхийлсэн ба "төрийн бус байгууллагуудаар бүх албадан саатуулах газарт хараат бус, үр дүнтэй, тогтмол хяналт тавиулахыг" гэрээний улсуудад зөвлөж байна. "Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны нэгдсэн дүгнэлтийг: Болгар", CAT/C/BGR/CO/4-5, 2011 оны 12-р сарын 14, заалт №11-ээс үз. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол (ЭШЭКНП)-ын дагуу албадан саатуулах газруудад хяналт тавих үндэсний урьдчилан сэргийлэх механизм (ҮУСМ)-ыг бий болгох тухай, Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх дэд хорооны удирдамжид ҮУСМ-ыг бий болгох, эсвэл тодорхойлохдоо дараах зарчмыг баримтална гэж заажээ. Үүнд: "Иргэний нийгмийн гэх мэт бүхий л хамааралтай талуудын оролцоог хамарсан нээлттэй, ил тод, оролцооны үйл явц" байх ёстой бөгөөд энэ нь ҮУСМ-ын гишүүдийг сонгох, томилох үйл явцад мөн хамаарна. Эрүүдэн шүүх болон бусад харгис, хүнлэг бусаар, нэр төрийг гутаан харьцах, шийтгэхээс урьдчилан сэргийлэх дэд хороо, "Үндэсний урьдчилан сэргийлэх механизмын удирдамж", CAT/OP/12/5, 2010 оны 12-р сарын 9-ийг үз. Дур зоргоор албадан саатуулахтай холбоотой асуудал хариуцсан ажлын хэсэг, жишээ нь: Гүржийн Засгийн газарт "цагдаагийн газар, шоронгийн байгууламжид хяналт-шинжилгээ, үзлэг хийхэд иргэний нийгмийн системтэй оролцоог хангах; энэ үүднээс иргэний нийгмийн байгууллагуудад (үндэсний урьдчилан сэргийлэх механизмд багтсанаас бусад) хүмүүс албадан саатуулагдаж байгаа бүх байр, байгууламжид нэвтрэх эрх олгох ёстой." гэж зөвлөсөн. "Дур зоргоор албадан саатуулах тухай, нэмэлт, Гүрж улсад ажилласан тухай ажлын хэсгийн тайлан", НҮБ-ын Б.Б. А/HRC/19/57/Add.28 2012 оны 1-р сарын 27, зүйл. 98(с)-г үз. ЭШЭХ мөн цагдаагийн байгууллагаас явуулсан улсаас албадан гаргах ажиллагааны хүрээнд хяналтыг сайжруулах зорилгоор ТББ-аар хяналт хийлгэхийг зөвлөв. НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо, "Нэгдсэн дүгнэлт: Бельги", НҮБ-ын Б.Б. CAT/C/BEL/CO/3, 2014 оны 1-р сарын 3, заалт №20.

Ж. Чөлөөтэй зорчих эрх ба хилийн дотор болон хил дамнансан хүний эрхийн ажил

224. ИУТЭОУП-ын 12 дугаар зүйл, ХЭҮЭЧК-ын 4 дүгээр Протокол нь хувь хүн аливаа улс орноос, түүний дотор эх орноосоо явах, түүнчлэн эх орон руугаа орох эсвэл нэвтрэх эрхийг баталгаажуулж өгдөг. Цаашилбал ХЭТТ-ын 13 дугаар зүйл нь улс бүрийн хил дотор аливаа хүн зорчих, оршин суух эрх чөлөөг олгосон байхад ИУТЭОУП-ын 12 дугаар зүйл, ХЭҮЭЧК-ын 4 дүгээр Протокол нь эдгээр эрхийг хуулийн дагуу хилийн дотор оршин суугаа хүн бүрд олгодог.³²⁵ ХЭАК-ын тухайд зорчих, оршин суух эрх чөлөөтэй холбогдох ижил төстэй заалтуудыг оруулсан болно.
225. ИУТЭОУП-ын заалт №12(3), ХЭҮЭЧК-ын 4 дүгээр Протокол 2(3) ба № 22(3) зүйлд эдгээр эрхийг зарим тохиолдолд хязгаарлаж болох онцгой нөхцөл байдлыг тусгасан болно. Ийм онцгой нөхцөлүүд нь үндэсний аюулгүй байдал, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах, нийтийн хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах эсвэл бусдын эрх, эрх чөлөөг хамгаалахаар хязгаарлагддаг. Эдгээ хязгаарлалтууд нь хүний эрхийн олон улсын стандартын дагуу хууль ёсны, зайлшгүй, пропорциональ байх зарчмуудад хатуу нийцэх ёстой. Цаашлаад ялгаварлан гадуурхахыг хориглох зэрэг хүний эрхийн бусад үндсэн хэм хэмжээний нийцлийг хангах ёстой. Оролцогч улсууд олон улсын хүний эрхийн стандартад бүрэн нийцэж байгаа эсэхийг магадлахын тулд зорчих эрхтэй холбоотой хууль тогтоомж, практик үйл ажиллагаагаа эргэн нягтлах ёстой. Тэд хууль тогтоомжоо олон улсын жишигт нийцүүлэх хууль эрх зүйн санаачилгыг хэлэлцүүлэхдээ иргэний нийгмийн, түүний дотор хүний эрхийг хамгаалагчдын олон талт оролцоог хангасан, ач холбогдолтой, нээлттэй зөвлөх уулзалтууд зохион байгуулахыг анхаарах ёстой.
226. Оролцогч улсууд хүн бүр улсынхаа хил хязгаарын дотор оршин суух, зорчих эрх чөлөөтэй байх, өөрийн болон аливаа улсаас гарах, эх орондоо орох эрхийг дахин баталгаажуулсан.³²⁶ Цаашилбал өөр улсын иргэд өөрсдийнх нь нутаг дэвсгэр рүү нэвтрэх журамтай холбогдуулан хэд

325 НҮБ-ын Хүний Эрхийн Хороо ИУТЭОУП-ын 12-р зүйлд гаргасан Ерөнхий тайлбар №27-доо “зарчмын хувьд тухайн улсын иргэд ямагт тухайн улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суудаг” ба “тухайн улсад хууль бусаар орж ирсэн ч, оршин суух эрх нь албан ёсоор бүртгэгдсэн гадаадын иргэн тухайн нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин сууж буйд тооцогдох ёстой.” НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны Зорчих эрх чөлөөний тухай (12-р зүйл) Ерөнхий тайлбар №27, 1999 оны 11-р сарын 2, заалт №4-ийг үз. Түүнчлэн тус Хорооноос “чөлөөтэй зорчих эрх нь бүх улсын нутаг дэвсгэрт, түүний дотор холбооны улсуудын бүх хэсэгт хамаатай” гэж заасныг онцолсон (заалт №5).

326 Жишээлбэл: Вена 1989, “Европ дахь Аюулгүй байдалтай холбоотой асуудлууд: Зарчмууд”, заалт №20.

хэдэн үүрэг амлалт авсан. Үүнд: “бие даан эсвэл хамтдаа, хувь хүн, албан байгууллага, институтүүдийн дунд хувиараа болон албаны шугамаар чөлөөтэй зорчих, харилцаа холбоо тогтоохыг дэмжих” хүсэл зориггоо илэрхийлсэн. Тодруулбал, тэд гарах, орох журмыг аажмаар хялбаршуулж, уян хатан зохицуулах үүрэг хүлээсэн; бусад оролцогч улсуудаас өөрийн нутаг дэвсгэрт байгаа иргэдийн зорчих хөдөлгөөнтэй холбогдсон журмыг хөнгөвчилж; шаардлагатай тохиолдолд виз, албан ёсны аялал жуулчлалын хураамжийг бууруулна.³²⁷ Үүнээс гадна, тэд нутаг дэвсгэртээ нэвтрүүлэх бодлогоо Төгсгөлийн баримт бичгийн холбогдох заалтад заасан зорилгод бүрэн нийцүүлэхээ амласан.³²⁸ Цаашлаад олон удаагийн виз олгох, визийн мэдүүлгийг харилцан хөнгөвчлөх тухай хэлэлцээр байгуулах саналыг нухацтай авч үзэж, хоорондоо байгуулсан гэрээнд үндэслэн нэвтрэх визийг харилцан хүчингүй болгох боломжийг авч үзнэ.”³²⁹ гэж мэдэгдсэн.

227. Оролцогч улсууд хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд ЕАБХАБ-ын бүс нутагт илүү чөлөөтэй зорчих, харилцаа холбоо чухал болохыг тэмдэглэв. Энэ үүднээс тэд хүний эрхийг хамгаалахыг эрмэлзэж буй хүний эрхийн хяналт-шинжилгээний бүлгүүд болон ТББ-уудын гишүүдэд “өөрийн улс орны болон хилийн чанад дахь ижил төстэй байгууллагууд, олон улсын байгууллагуудтай холбоо тогтоох, харилцах”-ыг зөвшөөрөх үүрэг хүлээсэн болно.³³⁰ Иймээс визийн мэдүүлгийг аль болох хурдан боловсруулж, виз мэдүүлэхтэй холбоотой хураамжийг хамгийн бага хэмжээнд хүргэх замаар виз мэдүүлгийн журмыг хялбаршуулахыг амласнаа дахин баталгаажуулсан.³³¹ Цаашлаад аль ч оролцогч улсуудаас хүний аюулгүй байдлын хэм хэмжээнд мониторинг хийх зорилготой ТББ-уудыг өөрсдийн улс оронд хүлээн авах үүрэг хүлээсэн.³³²

228. Эдгээр болон бусад үүрэг амлалтыг үл харгалзан зарим оролцогч улс дахь хүний эрхийг хамгаалагчид өөрсдийн улс орны хил хязгаарын дотор болон бусад улс орнууд руу зорчих эрхээ эдлэхэд хүнд хэцүү саад бэрхшээлтэй тулгарсаар байна. Энэ нь тухайлбал, тухайн газар нутаг болон түүний гаднах харьяа газар нутагт, зорилтот бүлэгт, жагсаал, цуглаан эсвэл хүний эрхийн хурал, сургалтын арга хэмжээнд өөрийн биеэр очих боломжийг хязгаарласнаараа хүний эрхийг хамгаалагчдыг хууль ёсны үйл ажиллагаагаа явуулах боломжид ихээхэн саад болдог төдийгүй, үйл

327 1975 он, Хельсинки Төгсгөлийн баримт бичиг хэсэг “1. Хүний харилцаа холбоо” ба, тодруулбал, Хувийн болон мэргэжлийн шалтгаанаар аялах” дэд хэсгийг үз.

328 Вена 1989, “Хүмүүнлэгийн болон бусад салбар дахь хамтын ажиллагаа”, заалт №2.

329 Эх. сурв. заалт №22.

330 Копенхаген 1990, заалт №10 (4).

331 Эх. сурв. заалт №19, 19 (1) ба 19 (2).

332 Москва 1991, заалт №43.2.

ажиллагаагаа явуулахаас сэргийлдэг. Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын талаар НҮБ-ын Тусгай илтгэгчийн тэмдэглэн хэлснээр зорчих хөдөлгөөний ийм хязгаарлалт нь НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалын үзэл санаа, хувь хүн, бүлэг, холбоодын үндэсний болон олон улсын түвшинд хүний эрх, үндсэн эрх чөлөөний тухай мэдлэгийг хүндэтгэх, дэлгэрүүлэхийг хөхиүлэн дэмжих эрхийг хүлээн зөвшөөрсөн явдалд харшилж байгаа юм.³³³ Оролцогч зарим улс оронд хүний эрхийг хамгаалагч нар гадаадад хүний эрхийн арга хэмжээнд оролцсоны дараа эх орондоо буцаж ирэхдээ дарамт шахалтад өртсөн тухай мэдээлэл байна. Цаашилбал оролцогч улсуудын визийн зохицуулалтын хэт хатуу нөхцөл, хүнд сурталтай холбогдох дүрэм журам нь ихэвчлэн, хүний эрхийн хяналт-шинжилгээ явуулах, баримт цуглуулах ажиллагаа, олон улсын зөвлөгөөн, сүлжээ байгуулах, чадавхыг бэхжүүлэх арга хэмжээнд оролцох зэрэг хүний эрхийг хамгаалагчдын гадаад улс дахь үйл ажиллагаанд саад тотгор учруулдаг.

229. **Эх орноо орхих ба буцаж ирэх эрх:** Оролцогч улсууд хүний эрхийг хамгаалагчдын аливаа улс орныг түүний дотор эх орноосоо гарах эрхээ бүрэн эдлэх нөхцөлийг баталгаажуулах ёстой. Энэхүү эрхийг эдлэхэд учирч буй хязгаарлалт, тухайлбал, хүний эрхийн төлөө тэмцэгчдийг зөвхөн хүний эрхийн үйл ажиллагаатай холбоотой шалтгаанаар улс орноос гарахад саад болж байгаа бичиг баримт олгохыг үндэслэлгүй хойшлуулах, зорчих эрхийн хориг зэрэг асуудлыг нэн даруй арилгах хэрэгтэй. НҮБ-ын Хүний эрхийн хороо мөн гадаадад зорчихын тулд хувь хүмүүс улсаасаа гарах виз авах шаардлага гардагт санаа зовниж буйгаа илэрхийлж, ийм тогтолцоог халах ёстой гэж мэдэгджээ.³³⁴ Оролцогч улсууд ЕАБХАБ-ын үүрэг амлалтууд болон олон улсын өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу хүн бүр аливаа улс орныг, түүний дотор эх орноосоо гарч, орох эрхийг хүндэтгэж байгаагаа дахин баталгаажуулсан. Иймд энэхүү эрхэд тавигдах хязгаарлалт нь маш ховор тохиолдох шинж чанартай, зөвхөн нийтийн тодорхой хэрэгцээ шаардлагад үндэслэсэн, хууль ёсны зорилгын тулд бөгөөд уг зорилгодоо нийцсэн байх ёстой ба дур зоргоороо эсвэл урвуулан ашиглахгүй гэдгийг мэдэгдсэн.”³³⁵

230. Хүний эрхийг хамгаалагчдыг эх орноосоо гарах эрхийг түдгэлзүүлсэн тохиолдолд тэдгээр хүмүүсийн нэр тухайн улсаас гарахыг түдгэлзүүлсэн

333 Хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн НҮБ-ын Тусгай илтгэгч, “Бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах хувь хүн, бүлэг, иргэний нийгмийн байгууллаудын эрх, үүргийн тунхаглалын тайлбар”, 2011 оны 7 дугаар сар, хуу. №53.

334 НҮБ-ын Хүний Эрхийн Хороо, “Узбекстанд хийсэн нэгдсэн дүгнэлт”, НҮБ-ын Б.6. ССРР/С/УЗВ/СО/3, 2010 оны 4 дүгээр сарын 7, заалт №18, ба “Казакстанд хийсэн нэгдсэн дүгнэлт”, НҮБ-ын Б.6. ССРР/С/КАЗ/СО/1, 2011 оны 8 дугаар сарын 19 2011, заалт №18-ыг тус тус үз.

335 Копенхаген 1990, заалт №9.5.

хүмүүсийн нэрийн жагсаалтад оруулах шийдвэр гарсан даруйд энэ статусынх нь талаар мэдэгдэх шаардлагатай бөгөөд ийм шийдвэрийг гаргасан бодитой үндэслэлээ мэдэгдэж, зорчих хязгаарлалтыг бие даасан, хараат бус, шударга шүүхэд гомдол гаргах эрхийг олгох ёстой. Тэднийг жагсаалтад оруулах хууль ёсны үндэслэл байхгүй бол хүний эрхийг хамгаалагчдын нэрийг уг жагсаалтаас нэн даруй хасах хэрэгтэй. Хүний эрхийг хамгаалагчдад зорчих хязгаарлалт тавихтай холбогдсон журам нь ил тод, хууль ёсны бөгөөд хариуцлагатай байх ёстой.

231. **Улсын хил хязгаарын доторх зорчих эрх чөлөө:** Оролцогч хэд хэдэн улс оронд хүний эрхийг хамгаалагчид улсынхаа нутаг дэвсгэрийн хил хязгаар дотор чөлөөтэй зорчихтой холбоотой хэт их хязгаарлалттай тулгарсаар байна. Тэднийг тухайн улсын тодорхой хэсэг, өөртөө засах бүс, маргаантай нутаг дэвсгэр рүү нэвтрэх эрхийг хориглосноор тухайн газарт хүний эрхийг сахин хамгаалах явдлыг хөхиүлэн дэмжих зорилгоор хяналт-шинжилгээ явуулах, мэдээлэх болон бусад арга хэмжээ явуулах нөхцөлийг нь боогдуулж байгаа юм. Цаашилбал зарим оролцогч улс оронд эрх баригчдад шүүмжлэлтэй эсвэл цөөнх, гадуурхагдсан бүлгүүдийн тэгш эрхийн төлөөх агуулгатай уулзалт, эсэргүүцлийн жагсаал, явган жагсаал зэрэг олон нийтийн тодорхой арга хэмжээнд оролцохоос сэргийлэх зорилгоор чөлөөтэй зорчихыг хязгаарладаг.³³⁶ ЕАБХАБ-ын гишүүн орнууд “өөрийн болон гадаадын иргэд, түүнчлэн байнгын оршин суух эрх бүхий иргэдэд нутаг дэвсгэрт нь зорчиход тавьдаг цэргийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа, экологийн болон бусад хууль ёсны засгийн газрын ашиг сонирхлын тулд ЕАБХАБ-ын үүрэг амлалт, олон улсын хүний эрхийн үүрэгт нийцүүлэн баталсан үндэснийхээ хууль тогтоомжийн

336 Европын Хүний эрхийн шүүхийн үзэж байгаагаар тухайн хүнийг олон нийтийн тодорхой бүсээс, жишээлбэл хотын төвийн бүсээс хөөх нь зорчих эрх чөлөөний эрхэд хөндлөнгөөс нөлөөлсөн явдалд тооцогдоно. (Оливиерагийн Нидерландын эсрэг нэхэмжлэл, Өргөдөл №33129/96, 2002 оны 11-р сарын 6). Түүнчлэн, хэн нэгийг гэрээсээ гарах, эсвэл тодорхой газраас гарахыг хориглох нь зорчих эрх чөлөөнд хөндлөнгөөс оролцсон жишээ юм. (Ивановын. Украины эсрэг гаргасан нэхэмжлэл, 2007 оны 3-р сарын 7-ны 15007/02-р өргөдлийг үзнэ үү). ОХУ-ын эсрэг Шимоволосын гаргасан нэхэмжлэлд (2011 оны 6-р сарын 21-ний өдрийн 30194/09 дугаартай нэхэмжлэл) Шүүх холбогдох эрх бүхий байгууллагаас уг хүний эрхийн төлөө тэмцэгчийг: нэхэмжлэгчийг “хэт даврагч шинж чанартай” гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой гэж үзэж баривчлахдаа 5 дугаар зүйл (эрх чөлөөтэй, аюулгүй байх эрх)-ийг зөрчсөн болохыг тогтоов. Гэсэн хэдий ч, дотоодын дүгнэлтээс үзвэл түүний нэр “Тандалтын мэдээллийн санд” бүртгэлтэй байснаас нэхэмжлэгчийн эсрэг цагдаагийн арга хэмжээ авсан (тандалтын мэдээллийн санд дурдагдсан хүн галт тэрэг, эсвэл онгоцны тийз худалдаж авах үед Тээврийн Дотоод хэргийн хэлтэс автомат мэдэгдэл хүлээн авдаг.) байна. Цагдаагийн рапортоос харахад Самарад эсэргүүцлийн жагсаал зохион байгуулахаар төлөвлөсөн гэсэн мэдээлэлд үндэслэн өргөдөл гаргагчийг шалгаж, баривчилсан бөгөөд Дотоод хэргийн яам нь “хууль бус, хэт даврагч үйлдэл” хийхээс урьдчилан сэргийлэх зорилгоор зарим сөрөг хүчний байгууллагын гишүүдийг энэхүү жагсаалд оролцохоос сэргийлэх шаардлагатай байсан гэж үзжээ. Шүүхээс, мөн нэхэмжлэгчийн мэдээллийг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх хангалттай арга хэмжээ авалгүй мэдээллийн санд оруулснаараа хувийн амьдралыг хүндэтгэх эрхийг зөрчсөн болохыг тогтоов. Доорх *Хувийн амьдралыг хүндэтгэх эрх* хэсгийг үз.

дагуу зайлшгүй бөгөөд албан ёсоор зарласан хязгаарлалтуудаас бусад бүхий л хууль эрх зүйн болон бусад хязгаарлалтыг цуцлах амлалт авсан. Оролцогч улсууд ийм хязгаарлалтуудыг хамгийн бага хэмжээгээр тогтоох үүрэгтэй.”³³⁷

232. Тухайлбал, жагсаал, цуглаан, эсэргүүцлийн цуглаан зохион байгуулж байгаа эсвэл эрх чөлөөгөө хязгаарлуулсан, түдгэлзүүлсэн зэрэг холбогдох газарт ажиглалт (хяналт-шинжилгээ) хийх, мэдээлэх болон бусад хүний эрхийн үйл ажиллагааны зорилгоор хүний эрхийг хамгаалагч нарыг нэвтрэхээс сэргийлэх нь дурдагдаж буй үүрэг амлалтын агуулгын хүрээнд хууль ёсны үндэслэл биш юм. Хүний эрхийг хамгаалагчдын хүний эрхийн үйл ажиллагаагаа нь оролцогч улсуудын хүний эрхийн төлөөх үүрэг амлалтыг хэрэгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулдаг тул улсынхаа нутаг дэвсгэр, тэр дундаа алслагдсан бус нутагт чөлөөтэй зорчих боломжоор ханган дэмжих хэрэгтэй. Тэд мөн хүний эрхийг хамгаалагчдын хүний эрхийн мониторинг (ажиглалт, хяналт-шинжилгээ) хийх, мэдээлэх зорилгоор холбогдох газар, байршил руу нэвтрэх боломжийг шуурхай хангаж өгөх хэрэгтэй.³³⁸

233. **Улсад орох журам:** Хүний эрхийг хамгаалагч нар ухуулга, уулзалт, жагсаал, цуглаанд оролцох, ажиглах, мэдээлэх зэрэг хүний эрхийн үйл ажиллагаа явуулах зорилгоор бусад оролцогч улс оронд нэвтрэн ороход нь чөлөөтэй хүлээн авч, зохицуулж өгөх ёстой. НҮБ-ын Хүний эрхийн хорооноос олон улсын байгууллага, ТББ-ын төлөөлөгчид, сэтгүүлчид, хүний эрхийг хамгаалагч нар бусад оронд нэвтрэн орох, тухайн улсад хүний эрхийн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөх ёстой ба үйл ажиллагаагаа явуулахдаа үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг баталгаажуулж өгөх хэрэгтэй гэж тэмдэглэжээ.³³⁹ Визийн болон холбогдох журмаар эдгээр хөдөлгөөн, зорчих эрхэд хэт хязгаарлалт хийх ёсгүй бөгөөд аль болох хялбаршуулах ёстой. Оролцогч улсууд хүний эрхийн хяналт-шинжилгээ явуулах, мэдээлэх болон хүний эрхийн бусад үйл ажиллагааг айлчлалын хууль ёсны зорилго гэж хүлээн зөвшөөрч, тухайн зорилгоор виз авах боломжийг олгох ёстой. Хүний эрхийг хамгаалагчдад олгох визийн шаардлагын мэдээлэл үнэн зөв, тодорхой бөгөөд олж мэдэхэд хялбар байх хэрэгтэй. Үүний зэрэгцээ

337 Москва 1991, заалт №33.

338 Энэ нь олон улсын хүний эрхийн байгууллагуудын зөвлөмжтэй нийцэж байгаа юм. Жишээлбэл: НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо Беларусь улсад хийсэн нэгдсэн дүгнэлтдээ “тус улсын аюулгүй байдлын үйлчилгээний байр, цагдаагийн хэлтсийн албадан саатуулах байр, захиргааны албадан саатуулах байр, хорихын эмнэлэг болон сэтгэцийн эмнэлэг, шоронгууд гэх мэт бүх албадан саатуулах байранд бие даасан төрийн болон төрийн бус байгууллагуудад нэвтрэх эрхийг олгох”-ыг уриалав. НҮБ-ын Б.Б. САТ/С/BLR/CO/4, 2011 оны 12-р сарын 7, заалт №14. Дээрх олон нийтийн ажилд оролцох эрх гэсэн хэсгийг мөн үз.

339 НҮ-ий Хүний Эрхийн Хороо, “Узбекстанд хийсэн нэгдсэн дүгнэлт”, НҮБ-ын Б.Б. ССРР/С/УЗВ/СО/3, 2010 оны 4 дүгээр сарын 7, заалт №24.

оролцогч улсууд визийн хүсэлт шийдвэрлэхэд оролцож буй албан тушаалтнуудад хүний эрхийг хамгаалагчдад тулгардаг тодорхой сорилт бэрхшээл, хэрэгцээ, тэдний хууль ёсны байдал, ач холбогдлыг ойлгуулж, тэр дундаа хил дамнанас тохиолдолд зохих ёсоор бэлтгэж, бүрэн мэдлэг олгох ёстой. Цаашилбал, оролцогч улсууд визийн мэдүүлгийг аль болох шуурхай боловсруулж, виз олгох эсэхээ шийдэхдээ пропорциональ, үл ялгаварлан гадуурхах зарчмыг баримтлах ёстой.³⁴⁰ Визийн өргөдөл гаргахад баримтлах эдгээр зарчмуудын ач холбогдлыг Европын парламент ба зөвлөлөөс баталсан Визийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд “консулын ажилтнууд хүмүүсийг хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэстний болон нийгмийн гарал үүсэл, өмч хөрөнгө, төрсөн байдал, нас болон бусад байдал зэргээр ялгаварлан гадуурхахгүй” ба “аливаа арга хэмжээ нь тухайн арга хэмжээний зорилгод пропорциональ байна.”³⁴¹ гэж тодотгон тусгасан байдаг.

234. Визийн тухай журмууд ерөнхийдөө хүний эрхийг хамгаалагчдын ажлын онцлогт нийцдэггүй, хүний эрхийг хамгаалагчид бие даан эсвэл бусадтай хамтран, бүртгэлтэй болон бүртгэлгүй ТББ-уудаас хандан виз хүсэх тохиолдол байдаг. Бие даан эсвэл бүртгэлгүй холбоонд ажилладаг хүний эрхийг хамгаалагчид өөрсдийн албан ёсны ажлын байр, хөдөлмөрийн гэрээний хугацаа, орлогын түвшин болон бусад холбогдох баримтат нотолгоо, санхүүгийн тогтвортой байдал, эх оронтойгоо хамааралтай байдлыг нотлох баримт гарагж өгөх боломжгүй байх магадлалтай юм. Түүгээр ч үл барам, бүртгэлгүй ТББ болон хүний эрхийн чиглэлээр бие даан ажилладаг хүний эрхийг хамгаалагчийн бусад оролцогч улсын хүний эрхийг хамгаалагч нарт хүний эрхийн үйл ажиллагааны зорилгоор явуулсан урилгыг виз олгох эрх бүхий байгууллага албан ёсны бөгөөд хүчинтэй гэж үзэхгүй байж болзошгүй юм. Иймд оролцогч улсууд хүний эрхийн үйл ажиллагаатай холбоотойгоор дур зоргоор баривчилсан, ял шийтгэсэн, гэмт хэрэгт буруутгасан гэх мэт өмнөх хэргүүд зэрэг хүний эрхийг хамгаалагчдын хувийн онцлог нөхцөл байдал нь виз олгохоос татгалзах эсвэл үндэслэлгүй хойшлуулахад хүргэхээс сэргийлэх практик арга замыг анхаарч үзэх хэрэгтэй. Үүний адилаар, холбогдох байгууллагууд дүрвэгчийн статустай эсвэл бусад хэлбэрийн хамгаалалт авсан, хүний эрхийн уулзалт, чуулганд оролцохоор нэг оролцогч улсаас нөгөө рүү

340 Үл ялгаварлан гадуурхах зарчмын тухайд, Вена 1989 (Хүмүүнлэгийн болон бусад салбар дахь хамтын ажиллагаа)-д оролцогч улсууд “угсаа гарал, арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэстний эсвэл нийгмийн гарал, өмч, төрсөн байдал гэх мэт аливаа бусад байдлаар ялгаварлалгүйгээр хилийн чанадад зорчих өргөдөлд нааштай хандах хэрэгтэйг” сануулсан (заалт №20).

341 Европын Парламент ба Зөвлөлийн визийн дүрэм тогтоох журам (ЕС) No. 810/2009, 2009 оны 7 дугаар сарын 13, Зүйл №39.

нэвтрэх гэж байгаа харьяалалгүй иргэн зэрэг хүний эрхийг хамгаалагчдад тулгардаг онцлог асуудалд анхааралтай хандах ёстой.

235. Виз олгохоос татгалзсан тохиолдолд хүсэлт гаргагчдад шийдвэрийн шалтгааныг мэдэгдэж, шийдвэрт гомдол гаргах боломжоор хангах ёстой. Хүний эрхийг хамгаалагчдыг нэг эсвэл хэд хэдэн оролцогч улсад нэвтрэн орох эрхийг түдгэлзүүлэн, нэвтрүүлэхээс хориглосон жагсаалтад оруулсан тохиолдолд тэдэнд хоригийн талаар мэдэгдэж, гомдол гаргах эрхтэй байх ёстой. Шийдвэрийн талаар гомдол гаргах, шүүхэд нэхэмжлэл гаргах зохицуулалтыг холбогдох ЕАБХАБ-ын оролцогч улс орнууд тогтооно.
236. **Ноцтой эрсдэлт буй хүний эрхийг хамгаалагчид:** Оролцогч улсууд амь нас, эрүүл мэндэд нь ноцтой эрсдэл тулгардаг хүний эрхийг хамгаалагчдыг түр хугацаагаар байлгах, хамгаалах шаардлагатай байгаа тохиолдолд аюулгүй орчинд түр шилжихэд нь туслах ёстой. Тухайлбал, тэд халдлагад өртвөл улс орноо хурдан хугацаанд орхих уян хатан байдлыг хангах үүднээс эрсдэлд буй хүний эрхийг хамгаалагчдад олон удаагийн орж, гарах виз олгохыг анхаарч үзэх нь зүйтэй. Мөн шаардлагатай тохиолдолд, тэд энэ зорилгоор түргэн шуурхай журмаар (яаралтай виз) виз олгодог үр дүнтэй журам баталж, хэрэгжүүлэх талаар анхаарч үзэх хэрэгтэй (энэ талаарх сайн туршлагын жишээг доор дурдсан “Хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”-ний хэсгээс харна үү). Ийм арга хэмжээ нь “хүмүүнлэгийн шалтгаантай яаралтай зорчих визний хүсэлтийг нэн даруй хүлээн авч, нааштайгаар шийдвэрлэх” амлалт үүрэгтэй нийцэж байгаа юм.³⁴²
237. Оролцогч улсууд “визийн мэдүүлгийг шийдвэрлэхдээ, ялангуяа нэн яаралтай хүмүүнлэгийн шалтгаантай тохиолдолд, өөр бусад шаардлагатай зүйлээс гадна гэр бүлийн, хувийн эсвэл мэргэжлийн чухал, тулгамдсан нөхцөл байдлыг авч үзэн эдгээрийг аль болох хурдан, шуурхай шийдвэрлэж өгөх болно” гэснээрээ энэ үүрэг амлалтаа дахин бататгасан.”³⁴³ ЕЗПА энэ хамгааллын арга хэмжээний ач холбогдлыг онцолж, улс орнуудыг “хүмүүнлэгийн визийн тогтолцоог бий болгох эсвэл гуравдагч оронд байнга мөшгөн, хавчлагад өртсөний улмаас түр орогнох шаардлагатай эсвэл ноцтой аюул заналхийлэлд өртсөн хүний эрхийг хамгаалагчдад аливаа зохих бусад арга хэмжээ авах эсвэл ийм нөхцөл байдалд яаралтай виз олгох асуудлыг зохицуулах”-ыг³⁴⁴ уриаллаа. Энэ үүднээс хүний эрхийг хамгаалагчдын ойрын гэр бүлийн гишүүдийн хамгааллын хэрэгцээг зохих ёсоор анхаарч, нааштайгаар авч үзэж, аль болох хурдан шийдвэрлэх ёстой.

342 Вена 1989, “Хүмүүнлэгийн болон бусад салбар дахь хамтын ажиллагаа”, заалт №12.

343 Копенхаген 1990, заалт №10 (4).

344 “Европын Зөвлөлийн гишүүн орнууд дахь хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдал”-ын тухай ЕЗПА-н Тогтоол 1660 (2009), заалт №12.2.

238. Цаашилбал, олон улсын өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу оролцогч улсууд хүний эрхийн ажил эрхэлснийхээ улмаас хавчлага, мөшгүүлэхээс айн улсаа орхих шаардлагатай болсон тохиолдолд хүний эрхийг хамгаалагчдыг олон улсын урт хугацааны хамгаалалтад авах ёстой. Олон улсын хуулийн дагуу буцаан шилжүүлэхгүй байх үүргийг аливаа нөхцөлд бүрэн дагаж мөрдөх ёстой. Оршин сууж байсан буюу төрсөн улсдаа амьд явах эрхэд нь халдах, эрүүдэн шүүх болон бусад байдлаар зүй бус харьцах, хүний эрхийн бусад ноцтой зөрчилд өртөх эрсдэлтэй тулгарсан хүний эрхийг хамгаалагчдыг тэдгээр улс орнууд руу буцаан шилжүүлэх ёсгүй.
239. **Хил нэвтрэх:** Өөр оролцогч улс руу зорчихдоо хүний эрхийг хамгаалагч нар зүй бус, нэр төрийг үл хүндэтгэсэн хилийн шалгалтад өртөх ёсгүй. Гэсэн хэдий ч, зарим оролцогч улс орнуудад хилийн боомт дээр зарим тохиолдолд хүний эрхийг хамгаалагчдыг онцлон айлган сүрдүүлэх, дарамтлах үзэгдэл хэвшсэн хэвээр байгаа гэсэн мэдээлэл бий. Иймэрхүү үйл ажиллагаанд бие махбодын зүй бус нэгжлэг, хувцас тайлах шаардлага тавих эсвэл тээшийг хэт нэг бүрчлэн шалгах зэрэг багтана. Хил нэвтрэхэд хүний эрхийг хамгаалагчдыг хүний эрхийн үйл ажиллагааг явуулахад шаардагддаг зурагт хуудас, товхимол, хэвлэл болон бусад тараах материалыг тайлбаргүйгээр хураах зэргээр дарамталсан тохиолдол бүртгэгдсэн. Цаашилбал хил нэвтрэх үед хүний эрхийг хамгаалагчдын тоног төхөөрөмж, түүний дотор хувийн мэдээлэл бүхий мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийг дур мэдэн хурааж авдаг. Иймэрхүү практик нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, түгээх эрх, хувийн амьдралыг хүндэтгэх эрхэд хууль бусаар хөндлөнгөөс нөлөөлж болзошгүй тул үүнийг халах хэрэгтэй.
240. Хилийн шалгалтыг хүний нэр төрийг бүрэн хүндэтгэсэн, пропорциональ, үл ялгаварлан гадуурхах зарчмын үүднээс гүйцэтгэх ёстой. Үүнтэй холбогдуулан оролцогч улсууд холбогдох хууль эрх зүйн орчин, олон улсын хууль тогтоомж, тухайлбал хүний эрх, дүрвэгсэд, хүмүүнлэгийн тухай хууль болон ЕАБХАБ-ын холбогдох үүргүүдийн дагуу “хилээр гарахыг хүсэж буй бүх хүмүүст зохих ёсоор хандах”-ыг дэмжих тал дээр “улсынхаа хилийн алба, гаалийн байгууллага, зорчих бичиг баримт, виз олгодог төлөөллийн газрууд, хууль сахиулах болон иргэн, харьяатын асуудал эрхэлсэн газрууд, түүнчлэн бусад эрх бүхий төрийн байгууллагатай

хамтын ажиллагаагаа өргөжүүлэх”-ийг амласан.³⁴⁵ Энэхүү амлалтын дагуу, эмэгтэй хүний эрхийг хамгаалагч, үндэсний, угсаатны, шашин шүтлэг, хэл, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг эмзэг буюу цөөнхийн бүлэгт хамаарах хүмүүс төдийгүй хүн нэг бүрийн биед нэгжлэг хийх зэргээр хилээр шалган нэвтрүүлэх үедээ тэдэнтэй гарал үүсэл, гадаад төрх байдал эсвэл бусад байдлаар нь доромжлон, гутаасан байдлаар харьцах ёсгүй.

3. Хувийн амьдралыг хүндэтгэх эрх

241. ИУТЭОУП-ын 17 дугаар зүйлд зааснаар “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааны нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй.” ба “тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч хуулиар хамгаалуулах эрхтэй.” Хувийн болон гэр бүлийн амьдралыг хүндэтгэх эрхийг ХЭҮЭЧК-ын 8(1)³⁴⁶, ХЭАК-ын 11 дүгээр зүйлд мөн баталгаажуулсан болно.
242. ХЭҮЭЧК-ын 8(2) дугаар зүйлд төрийн байгууллага хувийн амьдралд хөндлөнгөөс оролцох аливаа нөхцөлийг хуульд заасан ба уг конвенцод дурдсан аль нэг үндэслэлийг хангах нь ардчилсан нийгэмд зайлшгүй гэж заасан байдаг. НҮБ-ын Хүний эрхийн хорооноос хууль бус хөндлөнгийн оролцооноос хамгаалах хамгаалал нь “зөвхөн Конвенцын заалт, зорилго, зорилтуудад нийцсэн хуулийн үндсэн дээр л төрөөс зөвшөөрөгдсөн хөндлөнгийн оролцоог зөвшөөрнө” гэсэн шаардлага тавьдгийг цохон тэмдэглэсэн. Дур зоргын гэдэг ойлголтын тухайд, тус хорооноос энэ нь “хуульд заасан хөндлөнгийн оролцоо хүртэл Конвенцын заалт, зорилго,

345 Любляна 2005, “Хилийн аюулгүй байдал ба зохицуулалтын үзэл баримтлал: ЕАБХАБ-ын оролцогч орнуудын хамтын ажиллагааны төлөвлөгөө”, заалт №4 ба 4.5. Энэ амлалттай холбогдуулан Шенгений хилийн тухай журмын 6-р зүйлд: “хилийн хамгаалалтын ажилтнууд нь үүргээ гүйцэтгэх үедээ ялангуяа эмзэг байдалтай бүлгийн хүмүүстэй харьцахдаа хүний нэр төрд бүрэн хүндэтгэлтэй, зөвхөн пропорциональ ба үл ялгаварлан гадуурхах зарчмаар хандах ёстой” гэж заажээ. Европын парламент ба Зөвлөлийн 2006 оны 3-р сарын 15-ны өдрийн хил орчмын хүмүүсийн зорчих хөдөлгөөнийг зохицуулах журам (Шенгений хилийн дүрэм) -ийн тухай 562/2006 дугаар журмыг үзнэ үү.

346 ХЭҮЭЧК-ын 8-р зүйлд ИУТЭОУП тусгасантай адил нэр хүнд, алдар хүндийн тухай тусгайлан тусгаагүй боловч, өөрийн эрх зүйн практиктаа Европын Хүний Эрхийн Шүүх тодорхой нөхцөл байдалд хүний нэр хүндийг хамгаалах эрхийг Конвенцын 8-р зүйлд хувийн амьдралыг хүндэтгэх эрхийн нэг хэсэг болгон тусгажээ. Чави болон Бусад нэхэмжлэгчийн Францын эсрэг гаргасан нэхэмжлэлийг үз. Баримт №64915/01, 2004 оны 6-р сарын 29, заалт №70. Унгар улсын эсрэг Каракогийн гаргасан нэхэмжлэлийн шүүхийн дүгнэлтэд (2009 оны 4-р сарын 28-ны өдрийн 39311/05 дугаартай өргөдөл) Шүүх нь “маш ноцтой доромжилсон шинжтэй хэвлэмэл мэдээлэл зэрэг баримттай хэргийн мэдэгдэл нь нэхэмжлэгчийн хувийн амьдралд гарцаагүй шууд нөлөө үзүүлсэн тохиолдолд л ихэвчлэн ба зөвхөн хувийн нэр хүндийг бие даасан эрх гэж авч үздэг[...].” гэж мэдэгдсэн байна. (заалт №23) Гутаан доромжлох, гадуурхахтай тэмцэх болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх тухай хэсэгт дурдсанчлан хүний нэр хүнд, алдар хүндийг хамгаалах аливаа арга хэмжээ нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлахаас сэргийлэхийн тулд олон улсын стандартад нийцсэн байх ёстой.

зорилттой нийцэж байх ёстой бөгөөд ямар ч тохиолдолд, ялангуяа тухайн тохиолдолд тохиромжтой байх ёстой”³⁴⁷ гэсэн утгатай гэдгийг онцолсон. Үүнээс гадна, тус хороо нь өөрийн эрх зүйн практиктаа тохиромжтой байдал гэдэгт тавих шалгуур нь аливаа хөндлөнгийн оролцоо хүссэн эцсийн үр дүндээ пропорциональ бөгөөд тухайн тохиолдолдоо зайлшгүй байх ёстой гэсэн үг юм гэж тухайлан заажээ.³⁴⁸ Иймээс тодорхой явцуу нөхцөлд хязгаарлагдаж болох бусад эрхийн тухайд оролцогч улсууд хувийн амьдрал дахь аливаа хөндлөнгийн оролцоо хууль ёсны, зайлшгүй, пропорциональ байх зарчмыг хатуу хангаж буй эсэхийг нягтлах ёстой.

243. Оролцогч улс орнууд “хувийн болон гэр бүлийн амьдрал, оршин суугаа газар, захидал харилцаа, цахим харилцаа холбоог хамгаалах эрх”-ийг дахин цохон дурдсан. Түүнчлэн тэд “аливаа ардчилсан нийгэмд хор хөнөөлтэй зүйл болох зүй бусаар болон дур зоргоор хувь хүнд халдах явдлаас зайлсхийхийн тулд энэхүү эрхэд зөвхөн хуульд заасан, хүний эрхийн олон улсын стандартад нийцсэн хязгаарлалтыг төр тогтооно”³⁴⁹ хэмээн мэдэгдсэн.
244. Хүний хувийн нууцад хууль бус, дур зоргоор хөндлөнгөөс оролцохоос үр дүнтэй хамгаалахын ач холбогдол нь ажлынхаа явцад ихэвчлэн ийм хөндлөнгийн оролцоонд өртөх эрсдэлтэй байдагт дан ганц хүний эрхийг хамгаалагчдын хувьд бус, хувийн нууцыг хамгаалах эрхийг хүндэтгэх нь хүний эрхийг хамгаалахад олон талаар чухал үүрэг гүйцэтгэдэг билээ. Тухайлбал, НҮБЕА нь хувийн нууцыг хамгаалах эрхийг хүндэтгэх нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ хэрэгжүүлэх, хөндлөнгийн нөлөөгүйгээр өөрийн итгэл үнэмшилтэй байхад чухал ач холбогдолтой. Иймээс ардчилсан нийгмийн суурь хүчин зүйлсийн нэг гэдгийг хүлээн зөвшөөрсөн.³⁵⁰ НҮБ-ын Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй

347 Хүний Эрхийн Хороо, ерөнхий тайлбар №16, Зүйл №17, заалт №3 ба 4.

348 Жишээлбэл: Антониус Корнелис Ван Халстын Нидерландын эсрэг Нэхэмжлэл №903/1999, НҮБ-ын Б.Б. ССРР/С/82/D/903/1999, 2004 оны 11-р сарын 15, заалт №7.6. Түүнэнийн Австралийн эсрэг Нэхэмжлэл №488/1992, НҮБ-ын Б.Б. ССРР/С/50/D/488/1992, 1994 оны 3-р сарын 31, заалт №8.3-ыг үз. Цаашилбал, тус Хороо Ерөнхий тайлбартаа Пактад нийцсэн хөндлөнгийн оролцоотой байсан ч, холбогдох хууль тогтоомж нь хөндлөнгөөс оролцох боломжтой нөхцөл байдлыг нарийвчлан зааж өгөх ёстой гэж цохон тэмдэглэв. Ийм эрх бүхий хөндлөнгийн оролцоог ашиглах шийдвэрийг зөвхөн хуульд заасан эрх бүхий байгууллага, хэрэгт тус бүрд үндэслэн гаргах ёстой. Үүнд: Ерөнхий тайлбар №16, заалт №7 ба 8-ыг үз. Хүний эрхийн Европын шүүх Конвенцоор баталгаажсан эрхээс бусад тохиолдолд тусгайлан заасан 8 (2) дугаар заалтыг нарийвчлан тайлбарлах хэрэгтэй бөгөөд тухайн хэрэгт хөндлөнгөөс оролцох шаардлага нь баттай үндэслэлтэй байх ёстой. (Классын Германы эсрэг нэхэмжлэл, 1978, 42-р зүйл ба Францын эсрэг Функегийн нэхэмжлэл. 1993, заалт №55). Цаашилбал, тандалтын систем ямар ч байсан түүнийг урвуулж ашиглахын эсрэг хангалттай, үр дүнтэй байдлын баталгааг хангах ёстой гэж тус Шүүх мэдэгдсэн (Классын Германы эсрэг нэхэмжлэл, 50-р зүйл)

349 Москва 1991, заалт №24.

350 НҮБЕА-н Тогтоол №68/167, “Тоон технологийн эрин дэх хувийн нууцын эрх”, НҮБ-ын Б.Б. А/RES/68/167, 2013 оны 12 дугаар сарын 18- ы өдөр батлагдсан, оршил.

илэрхийлэх эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч нь хүний хувийн нууцад хууль бусаар хөндлөнгөөс оролцох нь санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх явдлыг шууд болон шууд бусаар хязгаарладаг гэж мэдэгджээ.³⁵¹

245. ЕАБХАБ-ын бүс нутаг дахь хүний эрхийг хамгаалагч нар тэдний хувийн нууцад хууль бусаар, дур зоргоор хөндлөнгөөс оролцох явдалд өртөх эрсдэлтэй хэвээр байна. Тэдний гаргасан гомдол нь ихэвчлэн аюулгүй байдлын салбарын зүгээс зарим тохиолдолд бүр ажил, хувийн амьдралыг нь гутаан доромжлоход ашигладаг утсан болон цахим харилцаа холбоо зэрэг арга хэрэгслээр хувийн амьдрал, ажлыг нь зүй бусаар хянах, тандах гэсэн тохиолдлуудын тухай байдаг.³⁵² Мөн орон байр, ажлын өрөө, зорчиж явах үед хувийн эд зүйлд хууль бусаар, дур зоргоороо нэгжлэг хийх, биед дур зоргоор эсвэл дотуур үзлэг хийх, хувийн орон зайдаа байхад дуу, дүрс бичлэг хийх, түүнчлэн хууль бус, зохисгүй буюу бусад хэлбэрээр дур зоргоор тандах гэх мэт хөндлөнгийн оролцооны үйлдлүүд багтана.
246. Хүний орон байранд нэгжлэг хийх тухайд Хүний эрхийн хорооноос аливаа нэгжлэгийг “зөвхөн шаардлагатай нотлох баримт хайх зорилгоор л хийх ба дарамт шахалт үзүүлэх хэрэгсэл болгож ашиглах ёсгүй” гэж мэдэгджээ.³⁵³ Үүнээс гадна, гэрээний улсаас ямар нэг тайлбар хийгээгүй тохиолдолд баривчлах тогтоолгүйгээр орон байранд нэгжлэг хийх нь ИУТЭОУП-д зааснаар хувийн амьдралыг хүндэтгэх эрхэд халдсан зөрчилд тооцогдоно.³⁵⁴ Хувийн буюу бие махбодын нэгжлэгийн талаар тус хорооноос мэдэгдэхдээ “энэ төрлийн нэгжлэг явуулахдаа нэгжүүлж буй хүний нэр

351 Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хамгаалал, дэмжлэгийн асуудал эрхэлсэн тусгай илтгэгчийн тайлан, НҮБ-ын Б.Б. А/НRC/23/40, 2013 оны 4 дүгээр сарын 17, заалт №24-ийг үз.

352 “Хүний эрх ба аюулгүй байдлын салбар. Европын Зөвлөл Хүний эрхийн комиссарын зохион байгуулсан хүний эрхийг хамгаалагчидтай хийсэн дугуй ширээний ярилцлага”, Киев 2013 оны 5 дугаар сарын 30-31, CommDH (2013)17, 2013 оны 9 дүгээр сарын 17, заалт №14 ба 49-ийг үз.

353 Ерөнхий тайлбар №16, заалт №8-ыг үз.

354 Дармон Султановагийн Узбекистаны эсрэг нэхэмжлэл, Баримт №915/2000, 2006 оны 3-р сарын 30-ны өдөр батлагдсан, заалт №7.9. Европын Хүний Эрхийн шүүх өөрийн хууль тогтоомждоо биет нотлох баримт олохын тулд орон байранд нэгжлэг хийх, хураан авах тухай хууль тогтоомж, практикийг урвуулан ашиглахаас зохих ёсоор, сайтар сэргийлэх арга хэмжээ авах ёстойг онцолсон (Францын эсрэг Меэгийн нэхэмжлэл. Нэхэмжлэлийн дугаар: №12661/87, 1993 оны 2-р сарын 25, 37-39-р зүйл). “Хувийн амьдрал” ба “орон байр” гэсэн үгнүүдийн тайлбарын тухайд, тус Шүүх нь хувь хүний ажлын байрыг нэгжсэнийг конвенцын 8-р зүйлд заасан эрхэд хөндлөнгөөс оролцсон гэж үзэж болно гэжээ. (Германы эсрэг Ниemiцийн нэхэмжлэл, Нэхэмжлэл №13710/88, 1992 оны 12-р сарын 16, 27-33-р зүйл). Өөр нэг тохиолдолд, энэ нь компанийн бүртгэлтэй оффис, салбар эсвэл бусад бизнесийн байранд нэгжлэг хийх гэх мэт хуулийн этгээдэд хамаатай байж болно гэж үзэв (Сошайт Солас ба бусад Францын эсрэг. Нэхэмжлэлийн дугаар: №91971/97, 4-р сарын 16-ны өдөр, 2002 он).

төрийг хүндэтгэсэн байдлаар зохион байгуулах ёстой”³⁵⁵ гэжээ. Цагдаагийн байгууллагаас хориг тавих, нэгжих эрхийн тухайд, ЕХЭШ нь “тухайн хүн, түүний хувцас, эд зүйлд иж бүрэн нэгжлэг хийхдээ албадлагын арга ашиглах нь хувийн амьдралыг хүндэтгэх эрхэд хөндлөнгөөс халдаж буй илэрхий хэлбэр ба олон нийтийн газар хийж байгаа нь “хүнийг ичээх, доромжлох хоёр элемент давхар агуулснаараа уг халдлагыг ноцтой болгож байна” гэж үзжээ.”³⁵⁶ Ийм хөндлөнгийн оролцоог зөвхөн “хуульд заасны дагуу”, хууль ёсны зорилгын хүрээнд, “ардчилсан нийгэмд зайлшгүй” тохиолдолд л зөвтгөж болно.³⁵⁷

247. Европын зөвлөлийн Хүний эрхийн комиссар нь “дарангуйлагч засгийн газрууд интернэт, нийгмийн сүлжээний цахим хуудаснууд дахь мэдээллийг ашиглан хүний эрхийг хамгаалагчдыг болон бусад идэвхтнүүдийг олж илрүүлж, мөрдөж хавчдаг өнөөгийн байдал”-д хүний эрхийг хамгаалагчдад интернэтийн учруулж болох аюул заналхийллийг сөхөж хөндсөн байна.³⁵⁸ Үнэн хэрэгтээ, тоон мэдээлэл, харилцаа холбооны технологиос үүдэлтэй бэрхшээлүүд нь олон улсын санааг улам их зовоож буй асуудал юм. НҮБЕА нь тоон технологийн эринд хувийн нууцын эрхийг хамгаалах тухай 2013 оны тогтоолдоо “Технологийн хурдацтай хөгжил нь шинэ мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглах боломжийг дэлхийн бүх улс орны хүмүүст олгодог бөгөөд үүний зэрэгцээ засгийн газар, компаниуд, хувь хүмүүсийн хүний эрхийг зөрчиж болзошгүй эсвэл урвуулан ашиглаж болзошгүй тандах, хориг тавих,

355 Хилээр зорчих үед биед нэгжлэг хийх тухай Ерөнхий тайлбар №16, заалт №8, мөн, *Чөлөөтэй зорчих эрх ба хилийн дотор болон хил дамнансан хүний эрхийн ажлын тухай хэсгийг* үз.

356 “Цүнх, түрийвч, тэмдэглэлийн дэвтэр, өдрийн тэмдэглэл гэх мэт зүйл нь таньж мэдэх хүмүүс болон олон нийтэд дэлгэгдэхэд эзэмшигчид таагүй санагдаж болзошгүй хувийн мэдээлэл агуулж байж болно.” гэснийг үз. Жиллан, Кьюнтоны Нэгдсэн вант улсын эсрэг нэхэмжлэл, Нэхэмжлэл №4158/05, 2010 оны 1 дүгээр сарын 12, заалт №63.

357 Эх. сурв. заалт №65. Шалгаж буй уг хэргийн тухайд, холбогдох хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөл олгох болон баталгаажуулах, зогсоох, нэгжих эрх мэдлийг хангалттай нарийн зааглаагүй, гуйвуулан ашиглахаас сэргийлсэн зохих хуулийн хамгаалалт хэрэглээгүй тул тус Шүүхээс 8-р зүйлийг зөрчсөн гэж үзсэн. Цагдаагийн алба хаагчдад замбараагүй олгосон шийдвэр гаргах эрхээс үүдэлтэйгээр дур зоргоор ашиглах, цаашлаад, “ийм өргөн цар хүрээгээр олгосон эрх мэдэл нь Конвенцын 10,11-р зүйл (заалт №85)-ыг зөрчиж жагсагч, эсэргүүцэгчдийн эсрэг зүй бусаар ашиглах эрсдэлтэй” гэж шүүх үзсэн.

358 “Европын Зөвлөлийн Хүний эрхийн комиссар Нилс Муижниексийн бэлдсэн 2013 оны 4-р улирлын үйл ажиллагааны тайлан, 2013 оны 10-р сарын 1-ээс 12-р сарын 31, CommDH (2014) 3, 2014 оны 2-р сарын 12, хуу. №20. Тодруулбал, Комиссар, жишээлбэл: Азербайжан улсад айлчлах үеэрээ “янз бүрийн ярилцагчаас Азербайжан дахь харуул хамгаалалтын газрууд цахим үйл ажиллагаа, эсвэл хэрэглэгчийн мэдээллийг танддаг гэсэн мэдээлэл авсан” гэж мэдээлсэн. Ялангуяа, комиссарын зарим ярилцлагад эрх баригчид фэйсбүүк дэх үйлдлийг нь хэрэгт холбогдуулж авч үзсэн, эсвэл байцаалтын явцад хувийн шуудангийн хайрцгийг нь харуулсан гэж мэдээлж байсан. “Европын Зөвлөлийн Хүний эрхийн асуудал эрхэлсэн комиссар Нилс Муижниексийн 2013 оны 5-р сарын 22-ээс 24-ний хооронд Азербайжанд хийсэн томилолтоосоо бэлдсэн тайланг үз. “, CommDH (2013)14, 2013 оны 8-р сарын 6, №40 ба 41-р заалт.

мэдээлэл цуглуулах чадавхыг дээшлүүлдэг”³⁵⁹ гэдгийг анхаарлын төвд оруулсан юм. Үүний нэгэн адил, Европын зөвлөлийн сайд нарын хороо “шаардлагатай хамгаалалтын арга хэмжээ, аюулгүй байдлыг хангахгүйгээр явуулж буй мэдээллийн нийгэм дэх өгөгдөл боловсруулалт нь эцэстээ хүний эрхийн холбогдолтой томоохон асуудлуудыг үүсгэж болзошгүй юм” гэж цохон тэмдэглэжээ. Иргэдийг хавтгайруулан хянах боломжийг олгодог хууль тогтоомж нь хувийн амьдралыг хүндэтгэх эрхэд харшилж болзошгүй. Эдгээр чадвар, практик нь иргэдийн нийгэм, соёл, улс төрийн амьдралд оролцох үйл ажиллагаанд таагүй нөлөөлөл бий болгох бөгөөд урт хугацаандаа ардчилалд хортойгоор нөлөөлөх магадлалтай.”³⁶⁰ Ийм арга хэрэгслийг, “жишээ нь, сөрөг хүчний улс төрчид, хүний эрхийн идэвхтнүүд эсвэл сэтгүүлчдийг нэр төрийг унагаахад ашиглаж болзошгүй” учраас, тэдний итгэл үнэмшил, нэр хүндэд халдах үүднээс сул талыг олж мэдэх зорилготой тандалтын шинэ арга, компьютерын сүлжээнд нэвтрэх ажиллагаа зэрэг нь цаашдын олон аюулыг учруулж байна.³⁶¹

248. НҮБ-ын Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч нь олон улс оронд, тэр дундаа ЕАБХАБ-ын гишүүн орнуудад хууль, шүүхийн байгууллагаас үндэсний тагнуулын байгууллагуудад тусгай эрх олгох шаардлагыг хавтгайруулан олгосонд санаа зовниж буйгаа мэдэгдсэн

359 A/RES/68/167, 2013 оны 12 дугаар сарын 18 -ны өдөр батлагдсан, оршил-г үз.

360 “Тоон технологийн тандалт болон бусад тандалтын технологиос Үндсэн эрхүүдэд учирч болзошгүй эрсдэлүүдийн тухай Сайд нарын Хорооны тунхаглал”, 2013 оны 6 дугаар сарын 11-ны өдөр батлагдсан, заалт №2-г үз.

361 Европын Холбооны Парламентын Ассамблей (ЕЗПА), Хууль Эрх зүйн Асуудал Ба Хүний Эрхийн Хороо, Хоморголон чагнах ажиллагаа' ба 'Шүгэл үлээгчдийн тухай 'ХЭҮЭЧК-ын Нэмэлт Протокол, Тусгай илтгэгч Питер Омтзигтын Танилцуулах Санамж бичиг”, Голланд, AS/JUR (2014) 02, 2014 оны 1 дүгээр сарын 23, заалт №21-ийг үз.

байна.³⁶² Харилцаа холбооны нууцлал, аюулгүй байдал, нэрээ нууцлах нөхцөлийг хангах хангалттай хууль тогтоомж, хууль эрх зүйн стандарт байхгүй бол сэтгүүлчид, хүний эрхийг хамгаалагчид, шүгэл үлээгчдийн, харилцаа холбоо төрийн хяналтад өртөөгүй эсэхэд итгэх аргагүй гэдгийг онцлон анхааруулсан. Найдвартай хамгаалалтгүй цагт тэддур мэдэн тандах ажиллагаанд өртөх эрсдэлтэй.³⁶³ Хууль тогтоомжоор нууц тандалтаар олж авсан мэдээллийг цуглуулах, ашиглах өргөн боломж олгосон гэх гомдол гарсан тохиолдолд энэ аргыг урвуулан ашиглахаас сэргийлэн “нууцаар тандах тушаал гаргах шаардлагатай гэмт хэргийн шинж чанар; харилцаа холбоог нь хянах шаардлагатай хүмүүсийн тодорхойлолт; ийм хяналтын үргэлжлэх хугацаа; олж авсан өгөгдлийг шалгах, ашиглах, хадгалах журам; мэдээллийг бусад талуудад дамжуулахдаа анхаарах зүйлс; олж авсан өгөгдлийг арилгах, эсвэл устгах нөхцөл байдал” гэх мэт хамгийн наад

362 А/HRC/23/40, 59-р зүйлийг үз. Тэрээр энэ тухайд, АНУ-ын Гадаад тагнуулын тандалтын актыг Үндэсний Аюулгүй Байдлын Газарт шүүхийн зөвшөөрөлгүйгээр харилцаа холбоог дундаас нь тандах эрх олгосон, түүнчлэн Герман, Шведийн хууль нь тушаалгүйгээр утасны яриаг хөндлөнгөөс чатнахыг зөвшөөрснийг тус тус дурдсан болно. Хүний Эрхийн Хороо Шведэд хийсэн 2009 оны нэгдсэн дүгнэлтдээ “Батлан хамгаалах ажиллагааны харилцаа холбооны тагнуулын тухай хууль” нь цахим харилцааны талаар гүйцэтгэх засаглалын өргөн хүрээний тандалт хийх боломжийг олгосон бөгөөд “гэрээний улс нь Хувийн мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглахдаа аливаа зүй бус аргаар ашиглахгүй байх, уг Пактад харшлах зорилгоор хэрэглэхгүй, Пактын 17-р зүйлд заасан үүрэг амлалттай нийцүүлэхэд шаардлагатай холбогдох бүх арга хэмжээг авах нь зүйтэй” гэж зөвлөжээ. Үүний тулд гэрээний улс нь мэдээллийг боловсруулах, цуглуулах явцад шударга, үр дүнтэй үйл ажиллагаа явуулах зохих баталгаа бүхий хараат бус байгууллага хяналт тавих нөхцөлийг баталгаатай бүрдүүлэх ёстой.” CCPR/C/SWE/CO/6, 2009 оны 5-р сарын 7, заалт №18-ыг үз. НҮБ-ын Хүний Эрхийн Хороо нь 2014 оны 3-р сарын 26-ны өдөр батлагдсан АНУ-ын 2014 оны нэгдсэн дүгнэлтдээ Үндэсний Аюулгүй Байдлын Газар (ҮАБГ) -ын явуулдаг харилцаа холбооны тандалтын ажиллагаанд санаа зовж буйгаа илэрхийлж, өртсөн хүмүүсийн эрх ашгийг хамгаалах ҮАБГ-ын үйл ажиллагааг хянах тогтолцоо бүтэлгүйтсэн бөгөөд ямар нэг байдлаар урвуулж ашиглалаа гэхэд тэдгээр хүмүүст хохирлыг барагдуулах арга хэмжээ байхгүй болохыг тэмдэглэв. Тус Хороо “гэрээний улсуудыг тандалтын үйл ажиллагаагаа ИУТЭОУП-аар хүлээсэн үүрэг амлалтууд, түүний дотор 17-р хэсэгт бүрэн нийцүүлэхэд, тодруулбал, аливаа хөндлөнгийн оролцоог “(i) нийтэд нээлттэй; (ii) харилцаа холбооны мэдээллийг цуглуулах, нэвтрэх, ашиглахдаа тодорхой хууль ёсны зорилгод нийцэж буй эсэхийг нягтлах заалт агуулсан; (iii) аливаа хөндлөнгийн оролцоог зөвшөөрч болох нөхцөл байдалд зөвшөөрөл олгох журам; тандалтад хамрагдаж болох хүмүүсийн ангилал; тандалтын хугацааг хязгаарлах; цуглуулсан өгөгдлийг ашиглах, хадгалах журам гэх зэргээр нарийвчлан тодорхойлсон; мөн (iv) урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээтэй” байлгахад анхаарахыг уриалсан. НҮБ-ын Б.б-г. CCPR/C/USA/CO/4, заалт №22 (урьдчилан боловсруулсан хянаагүй хувилбар)-ыг үз. Тус Хороо өмнө нь 2006 онд АНУ-ын ҮАБГ зэрэг газруудын явуулсан харилцаа холбооны тандалтад хийсэн нэгдсэн дүгнэлтдээ шүүх болон бусад бие даасан хяналтгүйгээр тандалт хийж байгаад санаа зовж буйгаа илэрхийлж байсан. CCPR/C/USA/CO/3, 2006 оны 9-р сарын 15, заалт №21-г үз.

363 А/HRC/23/40, заалт №79, 51. Ерөнхийдөө Хүний Эрхийн Хорооноос дурдсанчлан, “электрон уяу, утас, телеграф болон бусад харилцаа холбооны хэлбэр, утас чагнах, харилцан яриаг хураахыг хориглох хэрэгтэй.” Ерөнхий тайлбар №16, заалт №8. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах асуудал эрхэлсэн тусгай илтгэгч “харилцаа холбооны төрийн тандалтыг зөвхөн онцгой нөхцөл байдалд, зөвхөн бие даасан шүүхийн хяналт дор хийх ёстой гэж хууль тогтоомжид заах ёстой.” гэдгийг цохон тэмдэглэсэн. А/HRC/23/40, заалт №81.

захын хамгаалалтуудыг хуульд тусгасан байх ёстойг ХЭҮЭЧК сануулсан.³⁶⁴ Цаашлаад, шүүх нууц тандалтын арга хэмжээний хүрээнд “боломжит арга хэмжээний мөн чанар, хамрах хүрээ, хугацаа, тэдгээрийг зайлшгүй хэрэглэх үндэслэл, зөвшөөрөх, хэрэгжүүлэх, хяналт тавих эрх бүхий байгууллага, үндэсний хууль тогтоомжид заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээ” гэх мэт урвуулан ашиглахын эсрэг зохих, үр дүнтэй баталгаа” бий болгох ёстойг дахин дурдсан.³⁶⁵

249. “Тандалтын мэдээллийн сан”-д бүртгэгдсэн хүний эрхийн байгууллагын гишүүнтэй холбоотой нэг хэрэг дээр ЕХЭШ нь ХЭҮЭЧК-ын дагуу хувийн нууцтай байх эрхийг зөрчсөнийг тогтоожээ.³⁶⁶ Тухайн мэдээллийн сан нь түүний орон нутагтаа зорчсон хөдөлгөөний талаарх мэдээлэл цуглуулсан байсан бөгөөд үүнийг шүүх түүний хувийн амьдралд хөндлөнгөөс оролцсон гэдгийг дурдсан байна. Мэдээллийн сан бүрдүүлэх, эрхлэх ажлыг олон нийтэд мэдээлээгүй, олон нийтэд нээлттэй бус сайдын тоот тушаалаар гүйцэтгэсэнээрээ уг хөндлөнгийн оролцоо нь ХЭҮЭЧК-д нийцэхгүй байна

364 *Европын нэгдлийн төлөв холбоо ба Хүний эрх холбоо* болон Экимдзиев нарын Болгарын эсрэг нэхэмжлэл. Нэхэмжлэл №62540/00, 2007 оны 6 дугаар сарын 28, заалт №76-г үз.

365 Эх. сурв. заалт №77. Мөн, тус Шүүхээс ХЭҮЭЧК-ын 8-р зүйлийг зөрчсөн улс нь “гадаад харилцаа холбоог тандах, шалгах хэт хавтгайруулан олгосон төрийн эрхийн цар хүрээ, эсвэл хэрэгжүүлэх байдал, эрх мэдлийг урвуулан ашиглахаас зохих ёсоор хамгаалахын тулд тухайн үеийн дотоодын хууль тогтоомжид нарийн тодорхой зааж өгөх ёстой.” гэдгийг авч үзээгүй гэж үзсэн тухай Либертигийн, Их Британийн эсрэг нэхэмжлэл. Нэхэмжлэл №58243/00, 2008 оны 7-р сарын 1-ыг үз. Ялангуяа, тус Шүүхийн жишгийн эрх зүйд шаарддагаар, тандаж цуглуулсан материалыг сонгох, шалгах, дамжуулах, хадгалах, устгахад мөрдөх журмын талаар тодорхой заагаагүй.” (заалт №69). Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах асуудал эрхэлсэн тусгай илтгэгчийн үзсэнээр аливаа хүн харилцаа холбооны тандалтад өртсөн, эсхүл түүний харилцаа холбооны мэдээлэлд төр нэвтэрсэн тохиолдолд энэ талаар мэдэгдэл авах хууль ёсны эрхтэй байх ёстой. Тусгай илтгэгч, үүний хажуугаар, урьдчилсан, эсвэл тухайн үед нь мэдэгдэх нь тандалтын үр дүнд нөлөөлж болзошгүйг хүлээн зөвшөөрсөн. Гэсэн хэдий ч, харилцаа холбооны тандалтын мэдээллээс үүсэх үр дагавраас сэргийлэх арга хэмжээ авах боломж олгохын тулд тандалтын ажиллагаа явуулсны дараа хувь хүмүүст мэдэгдэх шаардлагатай гэжээ. (A/HRC/23/40 заалт №82-ыг үз). Болгар улсад утасны яриа чагнах арга түгээмэл хэрэглэдэг практикийн болох талаар Хүний Эрхийн Хороо хэлэхдээ: алдаа гарсны улмаас тандалтад өртсөн хүмүүст энэ талаар системтэйгээр мэдээлж, зохих байдлаар алдааг засуулах боломжоор хангахыг тус гэрээний улсад зөвлөсөн байна. НҮБ-ын Б.Б. “Болгарын талаар хийсэн нэгдсэн дүгнэлт” -г үз. ССРР/С/ВGR/CO/3, заалт №22-ыг үз.

366 Шимоволосын Оросын эсрэг нэхэмжлэл, Нэхэмжлэл №30194/09, 2011 оны 6 дугаар сарын 21-ийг үз.

гэж шүүх шийдвэрлэжээ.³⁶⁷ Ерөнхийдөө хувийн мэдээллийг цуглуулах, хадгалахтай холбоотойгоор “хүн бүр автомат өгөгдлийн санд хувийн ямар мэдээлэл, ямар зорилгоор хадгалагдаж буйг ойлгомжтой тайлбарлуулах эрхтэй байх ёстой. Хүн бүр ямар төрийн байгууллага, хувь хүн, эсвэл албан байгууллага тэдний мэдээллийг хянадаг, хянах боломжтойг баталгаатай мэдэх боломжтой байх ёстой” гэдгийг Хүний эрхийн хороо онцлон тэмдэглэсэн.³⁶⁸

250. Оролцогч улсууд төрийн эрх барих байгууллага болон албан тушаалтнууд хүний хувийн амьдралд хууль бус болон дур зоргоороо хөндлөнгөөс оролцохгүй байхад анхаарах, түүнчлэн хүний эрхийг хамгаалагчдыг, жишээ нь, хуийн хэвшлийн хамгаалалтын алба гэх мэт гуравдагч этгээдийн зүгээс хийх ижил төстэй үйлдлээс хамгаалах үүрэгтэй.³⁶⁹ НҮБ-ын Хүний эрхийн хорооноос хувийн амьдралыг хүндэтгэх эрх нь “төрийн эрх бүхий байгууллагаас эсвэл хувь хүн, эс бөгөөс хуулийн этгээд үйлдсэн эсэхээс үл хамааран эдгээр бүх хөндлөнгийн оролцоо, дайралтаас хамгаалахыг шаардана” гэж мэдэгджээ.³⁷⁰

251. Үүний дагуу НҮБ-ын Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч нь улс орнууд төрийн болон төрийн бус талуудын хууль бус тандалтыг гэмт хэрэгт тооцох ёстой гэж тэмдэглэжээ.³⁷¹ НҮБЕА-аас

367 ОХУ-ын эсрэг Шимоволосын гаргасан нэхэмжлэлийн дагуу шалгахад, мэдээллийн санд бүртгэгдсэн хүмүүсийн нэрийн жагсаалтаас авсан хэсгээс харахад уг нэхэмжлэгчийн нэрийг “Хүний эрхийн идэвхтнүүд” гэсэн хэсэгт оруулсан байсан ба уг тандалтын мэдээллийн санд” мулзан толгойт (тэрс үзэлтэн), хүний эрхийн идэвхтнүүд болон хэт даврагч үйл ажиллагаанд холбогдсон гэгдэх бусад хүмүүсийн талаар мэдээлэл байдаг. Мэдээллийн баазад дурдсан хүн галт тэрэг, эсвэл онгоцны тийз худалдаж авах болгонд Тээврийн газрын Дотоод хэлтэст автоматаар мэдэгддэг.” Хууль эрх зүйн үндэслэл нь олон нийтэд нийтлэгдээгүй, танилцах боломжгүй тул, түүнчлэн “хүний нэрийг мэдээллийн санд бүртгэх үндэслэл, ийм бүртгэлийг явуулах тушаал гаргах эрх бүхий байгууллагууд, арга хэмжээ авах хугацаа, цуглуулсан мэдээллийн нарийвчлал, цуглуулсан мэдээллийг хадгалах, ашиглах журам, буруугаар ашиглахаас сэргийлсэн одоо байгаа хяналт, баталгаа зэрэг нь ч олон нийт хянах, олж мэдэхэд хаалттай.” (заалт №69).

368 Ерөнхий тайлбар №16, заалт №10-ыг үз.

369 Жишээлбэл: Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн тусгай илтгэгч хатагтай Ирланд улс дахь томилолтынхоо үеэр хийсэн тайландаа байгаль орчны эрхийн талаарх эсэргүүцлийн хүрээнд бизнесийн томоохон корпорацууд хувийн харуул хамгаалалтын газруудыг хөлсөлж, нийтийн эзэмшлийн зам, хувийн байшин, орон нутгийн оршин суугчдын зорчих хөдөлгөөнийг тандуулсан гэсэн мэдээлэл авсан гэж тэмдэглэжээ. Тэрээр иймэрхүү практик нь хувийн орон зайн эрхэд нөлөөлж болзошгүй тул санаа зовниж буйгаа илэрхийлж, тандалтын аргыг зөвхөн хууль ёсны, пропорциональ байдлаар ашиглаж, тандалтын зорилгоо нутгийн иргэдэд мэдээлэхийг зөвлөсөн. Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн тусгай илтгэгч Маргарет Секагягийн тайлан, Нэмэлт. Ирланд дахь томиллол (2012 оны 11-р сарын 19-23)”-ыг үз. НҮБ-ын Б.Б. А/HRC/22/47/Add.3, 26 Хоёрдугаар сарын 2013, заалт №78.

370 Ерөнхий тайлбар №16, заалт №1.

371 HRC/C/23/40, заалт №84.372-ыг үз.

улс орнуудад тоон технологийн харилцаа холбоо гэх мэтчилэн хувийн нууцтай байх эрхийг хамгаалах; зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарч буй зөрчлүүдийг таслан зогсоох арга хэмжээ авах; “харилцаа холбооны тандалт холбоотой журам, практик, хууль тогтоомж, хавтгайруулан хянах, зогсоох, цуглуулах гэх мэт хувийн мэдээллийг цуглуулахтай холбоотой цахим ажиллагаануудыг нягтлах”, мөн “ил тод зарчмыг хангах, төрийн цахим тандалтын хариуцлагыг зохих байдлаар хянах чадвартай бие даасан, үр дүнтэй ерөнхий хяналтын механизм шинээр бий болгох эсвэл одоо ашиглаж байгаагаа үргэлжлүүлэн сайн ажиллуулах [...]” ажлуудыг хийж гүйцэтгэхийг уриалсан.³⁷²

252. Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах асуудал эрхэлсэн Тусгай илтгэгчийн хэлсэнчлэн хувийн хэвшлийнхэн заримдаа эрх баригчдын шахалтаас болж, заримдаа сайн дураараа төрийн тандалтад гол үүрэг гүйцэтгэдэг.³⁷³ Тусгай илтгэгчийн тэмдэглэсэнээр, зарим тохиолдолд хувийн хэвшлийнхэн хууль эрх зүйн стандартыг зөрчиж, хэт нарийвчилсан тандалт хийх боломж олгодог технологийг боловсруулахад хууль бусаар оролцдог байна.³⁷⁴ Үүний дагуу тэрээр хувийн хэвшлийнхнийг харилцаа холбооны үйлчилгээний нууцлал, аюулгүй байдал, нэрийн нууцлалыг эрсдэлд оруулах арга хэмжээг хэрэгжүүлэхийг албадахаас татгалзах, “хүний эрхийг системтэй зөрчих чадварыг нь харгалзан эдгээр технологийг судлах, боловсруулах, худалдаалах, экспортлох, ашиглахад онцгой анхаарал хандуулан хяналтын технологийг арилжаалахаас урьдчилан сэргийлэх” арга хэмжээ авахыг уриалав.³⁷⁵ НҮБ-ын Бизнес, хүний эрхийн чиглүүлэх зарчмын дагуу оролцогч улсууд өөрсдийн нутаг дэвсгэрт болон/ эсвэл хууль тогтоомжид харьяалагддаг бизнесийн бүх аж ахуйн нэгж үйл ажиллагааныхаа бүхий л шатанд хүний эрхийг хүндэтгэх ёстой гэсэн

372 A/RES/68/167, заалт №4-ийг үз.

373 HRC/C/23/40, заалт №73 ба 74-ийг тус тус үз. Мөн ЕЗПА-н Илтгэгчийн санамж бичиг, “Хоморголон чагнах” болон “Шүгэл үлээгчдийг хамгаалах тухай ХЭҮЭЧК-ын нэмэлт протокол”, Тусгай илтгэгч Питер Омтзигтын Танилцуулах Санамж бичиг”, Голланд, AS/JUR (2014)02, 2014 оны 1-р сарын 23, 27-р зүйлийг үз. Хувийн оролцогч талуудыг хянах асуудлын нарийн төвөгтэй байдалд санаа зовох явдал харилцаа холбооны тандалтын ажлыг гэрээт байгууллагаар гүйцэтгүүлдэг тохиолдолд улам ч хамааралтай болж байгаа юм. Эх. сурв. заалт №52.

374 HRC/C/23/40, заалт №75-ыг үз. Үүний нэгэн адил Европын Зөвлөлийн комиссар Шведийн харилцаа холбооны компани Азербайжан улсын хууль сахиулах байгууллагын ажилтнуудад текст мессеж, интернэтийн үйл ажиллагаа, утасны дуудлага зэрэг гар утасны бүх харилцаа холбоог ямар ч шүүхийн шийдвэргүйгээр хянах боломжийг олгох технологийг суурилуулсан тухай мэдээллийг дурджээ. “Европын Зөвлөлийн Хүний эрхийн асуудал эрхэлсэн комиссар Нилс Муижниексийн 2013 оны 5-р сарын 22-24-ний өдрүүдэд Азербайжанд хийсэн томилолтынхоо дараа хийсэн тайлан”-г үзнэ үү, CommDH (2013) 2013 оны 8-р сарын 14, заалт №42.

375 A/HRC/C/23/40, заалт №96 ба 97-г үз.

хүлээлтийг тодорхой зааж өгөх ёстой.³⁷⁶ Европын зөвлөлийн сайд нарын хороо улс орнуудыг гуравдагч улстай хийсэн хоёр талын хэлэлцээнд тоон технологийн тандалтын болон бусад тандалтын технологийн эрсдэлийг бодолцож, хүний эрхийн стандартыг зөрчих зорилгоор технологийг буруугаар ашиглахаас сэргийлэх экспортын зохистой хяналтыг шаардлагатай үед нэвтрүүлэх талаар анхаарч үзэхийг зөвлөсөн.³⁷⁷ Энэ салбарын эрсдэл нэмэгдэж байгаатай холбогдуулан оролцогч улсууд мөн цахим харилцаа холбооны аюулгүй байдлыг сайжруулах мэдлэг, чадавхыг бэхжүүлэх зорилготой хүний эрхийг хамгаалагчдын санаачилгыг дэмжиж ажиллах ёстой.

253. Хүний эрхийг хамгаалагчдын хувийн орон зайд хийсэн тандалт хяналт, нэгжлэг, хураан авсан, хууль бус эсвэл дур мэдэн хөндлөнгийн оролцоотойгоор олж авсан мэдээлэл, өгөгдлийг, ерөнхийдөө, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тэдний эсрэг нотлох баримт болгож ашиглахгүй. Европын хүний эрхийн шүүх зарим тохиолдолд нотлох баримтыг хууль бус аргаар олж авах замаар хувийн нууцыг хамгаалах эрхийг зөрчсөн хэргийн шүүн таслах ажиллагааг бүхэлд нь шударга бус гэж үзэхгүйгээр тусад нь салгаж тогтоож болно гэсэн аргыг ашигласныг дурдаад, алан хядах ажиллагаатай тэмцэх үеийн хүний эрхийн асуудал эрхэлсэн НҮБ-ын Тусгай илтгэгч “Улс орнууд, ялангуяа тэдний шүүх эрх мэдлийн байгууллагууд нь хүний эрх, дотоодын хууль тогтоомж зөрчиж олж авсан нотлох баримтыг ашиглах нь шүүх хурлыг шударга бус болгоно гэсэн ойлголтыг баримталж, сонор сэрэмжтэй байх хэрэгтэй” гэсэн байр суурийг илэрхийлжээ.³⁷⁸

376 Энэ асуудлын хувьд оролцогч улсууд хүний эрхийг хамгаалагч нар нийгэмд чухал үүрэг гүйцэтгэдгийг тодорхой, олон нийтэд нээлттэй тодорхойлж, улмаар тэдний статус, үйл ажиллагааных нь хууль ёсны байдлыг хүлээн зөвшөөрөх ёстой. Олон нийт хүлээн зөвшөөрөхийн ач холбогдол, түүнчлэн төрийн бус талуудын үүрэг, НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн чиглүүлэх зарчмуудын талаар дээрх Ерөнхий зарчмуудын хэсгээс үз. Үүнээс гадна, Европын Хороо нь НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн чиглүүлэх зарчмуудад заасан хүний эрхийг хүндэтгэх корпорацийн хариуцлагын талаарх нарийвчилсан удирдамжийг багтаасан МХХТ-ын компаниудад зориулсан гарын авлагыг нийтэлсэн. Европын Хороо, “НҮБ-ын Бизнес, хүний эрхийн зарчмуудыг хэрэгжүүлэх талаар МХХТ-ийн салбарын гарын авлага” -г үз. <http://ec.europa.eu/enterprise/policies/sustainable-business/files/csr-sme/csr-ict-hr-business_en.pdf>.

377 “Үндсэн эрхүүдэд тоон технологийн тандалт болон бусад тандалтын технологиос учирч болзошгүй эрсдэлүүдийн тухай Сайд нарын Хорооны тунхаглал”, 2013 оны 6 дугаар сарын 11-ны өдөр батлагдсан, заалт №8-ыг үз.

378 “Алан хядах ажиллагаатай тэмцэх үед хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах асуудал эрхэлсэн тусгай илтгэгчийн тайлан”, НҮБ-ын Б.Б. 2008 оны 8-р сарын 6-ны А/63/223, заалт №34. Түүнчлэн, эрүүгийн хэргүүдийн тухайд, Прокурорын үүргийн талаарх НҮБ-ын удирдамжид, жишээ нь: прокурорууд гэрт орж ирсэн сэжигтнүүдийн эсрэг нотлох баримт нь хууль бус аргаар олдсоныг мэдсэн, эсвэл тэгж бодож байгаа бол хүний эрхийг ноцтой зөрчсөнд тооцох тул ийм нотлох баримтыг ашиглахаас татгалзана гэж заасан. 1990 оны 8-р сарын 27-ээс 9-р сарын 7-ны хооронд Куба, Хавана, Куба улсын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргэнтүүдтэй харьцах тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Наймдугаар их хурлаар батлагдсан Прокурорын үүргийн талаарх удирдамж”, заалт №16-г үз.

254. Ерөнхийдөө, компьютер, мэдээллийн сан эсвэл бусад төхөөрөмж дээр цуглуулж, хадгалж байгаа хувийн мэдээллийг төрийн байгууллагууд болон хувь хүмүүс ашиглахтай холбоотойгоор НҮБ-ын Хүний эрхийн хорооноос улс орнууд эдгээр мэдээллийг хүлээн авах, боловсруулах, ашиглахыг хуулиар зөвшөөрөөгүй хүмүүст олгох, Пактад үл нийцэх зорилгоор ашиглах боломж олгохгүйн тулд үр дүнтэй арга хэмжээ авах шаардлагатай байгааг цохон тэмдэглэв.³⁷⁹ Хүний эрхийг хамгаалагчдын хувийн мэдээлэл, ялангуяа тухайн хувь хүнийг гутаан доромжлох, тэдний нэр төр, алдар хүндэд халдахад ашиглаж болох нууц, хувийн байдалтай холбоотой байвал мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд дэлгэхээс хамгаалах ёстой. Тухайлбал, ЕХЭШ нь CCTV тандалтын дуранд бичигдсэн эмзэг материалыг тухайн хувь хүний зөвшөөрөлгүйгээр мөн тэдний нүүрийг халхлахгүйгээр олон нийтийн мэдээллийн хэрэгслийн өргөн нэвтрүүлэгт ил болгосон нь хувийн амьдралыг хүндэтгэх эрхэд хөндлөнгөөс ноцтой халдсан явдал гэж үзнэ.³⁸⁰ Түүнчлэн, өвчний түүх болон бусад хувийн мэдээллийг хамгаалах нь нэн чухал ач холбогдолтой бөгөөд үүнийг олон нийтэд ил болгох нь ХЭҮЭЧК-ын 8 дугаар зүйлийг зөрчин хувь хүний болон гэр бүлийн амьдралд ноцтой нөлөөлдөг гэж шүүх үзсэн байна.³⁸¹
255. Цаашилбал, хувийн өгөгдөл, мэдээллийг зөвхөн үндэслэлтэй, шаардлагатай тохиолдолд хадгалах ёстой. Тухайлбал, хувийн мэдээллийг автоматаар боловсруулахтай холбоотойгоор хувь хүнийг хамгаалах тухай Европын зөвлөлийн конвенцод, “автоматаар боловсруулагдаж буй өгөгдлийг [...] мэдээллийн эзнийг хайхад тухайн өгөгдлийг хадгалсан зорилгоос өөр хайлтад илрэхгүй байх боломжтой хэлбэрээр хадгална” гэж заасан байдаг.³⁸² Европын хүний эрхийн шүүхийн эрх зүйн хүрээнд эрх баригчид хувь хүмүүст зохих хугацаанд төрийн байгууллагуудын мэдэлд байгаа хувийн мэдээлэлд үр дүнтэй, хүртээмжтэй нэвтрэх журмаар хангах эерэг үүрэг хүлээдэг.³⁸³
256. Европын зөвлөлийн сайд нарын хорооноос өгөгдөл боловсруулах, хавтгайруулан хянах нь сэтгүүлчдийн эх сурвалжийг хамгаалах зэрэг тодорхой мэргэжилтэй холбоотой нууцлалын эрхийг алдагдуулж,

379 Ерөнхий тайлбар №16, заалт №10-г үз.

380 Пекийн Нэгдсэн Вант улсын эсрэг нэхэмжлэл, Нэхэмжлэл №44647/98, 2003 оны 1 дүгээр сарын 28. Яригдаж буй хэргийн тухайд уг бичлэгийг олон нийтийн газар бичсэн ч гэсэн ингэж үзжээ.

381 3-ийн Финландын эсрэг нэхэмжлэл, Нэхэмжлэл №22009/93, 1997 оны Хоёрдугаар сарын 25-ыг үз.

382 Европын Зөвлөл, “Хувийн мэдээллийг автоматаар боловсруулахтай холбоотойгоор хувь хүнийг хамгаалах тухай Конвенц”, Зүйл №5-ыг үз.

383 Жишээлбэл: Хараламбигийн Румын улсын эсрэг нэхэмжлэл, Нэхэмжлэл №21737/03, Шүүхийн жишгийн эрх зүйн тухай мэдээллийн тэмдэглэл №123, 2009 оны 10 дугаар сар.

холбогдох хүмүүсийн аюулгүй байдалд заналхийлж болзошгүйг хүлээн зөвшөөрсөн байна.³⁸⁴ НҮБ-ын Хуульчдын үүргийн үндсэн зарчмуудын 22 дугаар зарчимд “засгийн газрууд, хуульчид ба тэдний үйлчлүүлэгчдийн мэргэжлийн харилцааны хүрээнд хоорондын харилцаа холбоо, зөвлөгөө нь нууц гэдгийг хүлээн зөвшөөнө.”³⁸⁵ гэж заасан байдаг. Түүнчлэн ЕАБХАБ-ын оролцогч орнууд “өмгөөлөгч, үйлчлүүлэгчийн хоорондын харилцааны нууцыг чандлан сахиулах үүднээс зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн.”³⁸⁶ Мөн тэд “сэтгүүлч, түүний дотор бусад оролцогч улсуудын хэвлэл мэдээллийн байгууллагыг төлөөлж буй хүмүүс олон нийтийн болон хувийн мэдээллийн эх сурвалжид нэвтрэх, холбоо тогтоох, мэргэжлийн нууцлалаа хангуулах хэрэгцээг нь хангах”³⁸⁷ үүрэг амлалт авсан. Интернет нь олон нийтийн харилцаа, холбооны хэрэгсэл болж нэмэгдэж байгааг харгалзан сэтгүүлчдийн эх сурвалжийн хамгаалалтыг бусад талууда ч олгох шаардлага гарч ирсэн.³⁸⁸

257. Сэтгүүлч эсвэл хуульч ажилтай хүний эрхийг хамгаалагчдын адил оролцогч улсууд бусад хүний эрхийг хамгаалагчдын мэргэжлийн онцгой хэрэгцээг хүлээн зөвшөөрч, хувийн нууцыг хамгаалах, тэдний харилцаа холбооны нууцлалыг хамгаалахтай холбоотой тодорхой

384 Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооноос, “Тоон технологийн тандалт, бусад тандалтын технологийн тухай тунхаглал”, заалт №2-ыг үз. Үүнтэй нэгэн адилаар, сэтгүүлчдийн хувийн нууц, аюулгүй байдал, харилцаа холбоонд нэр нууцлахтай холбоотойгоор итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах асуудал эрхэлсэн тусгай илтгэгчийн тэмдэглэн хэлснээр “тандалтын ажиллагаа өргөн хэрэглэдэг, зохих ёсны, эсвэл шүүхийн хяналтгүйгээр хязгааргүй ажилладаг орчин эх сурвалжийг хамгаалалтыг зүй ёсоор хэрэгжүүлж чадахгүй. Явцуу хүрээний, ил тод бус, баримтжуулаагүй, өндөр албан тушаалтны явуулж буй тандалт ч маш нарийн хянаж, ашиглалтыг нь төрөөс баримтжуулахгүй, буруугаар ашиглахаас сэргийлсэн зохистой арга хэрэглэхгүйгээр явуулбал ихээхэн хортой нөлөө үзүүлж болзошгүй. А/HRC/23/40, заалт №52. Үүнээс гадна, Европын Хүний эрхийн шүүх нь “ардчилсан нийгэмд хэвлэлийн эрх чөлөөг хангахад сэтгүүл зүйн эх сурвалжийг хамгаалахын ач холбогдлын тухайд болон эх сурвалжийг ил болгох нь энэхүү эрх чөлөөг эдлэх явдалд хортойгоор нөлөөлж болзошгүй байдлыг авч үзвэл, олон нийтийн ашиг сонирхлын үүднээс зайлшгүй зөрчих үндэслэлгүй бол ийм арга хэмжээ нь конвенцын 10-р зүйлд нийцэхгүй.” Их Британийн эсрэг Гудвины нэхэмжлэл, Нэхэмжлэл №17488/90, 1996 оны 3-р сарын 27, заалт №39. Хуульчдын хувьд, НҮБ-ын Хүний Эрхийн Хорооноос, жишээ нь: Голландад нууцаар тандахаас ангид байх нууцлалын давуу эрхээр хамгаалагдсан харилцаа холбооны онцгой эрхүүдийг хангахыг зөвлөж байна. Нууцлалыг хадгалах үүрэгтэй мэргэжилтнүүд, ялангуяа өмгөөлөгчдийн оролцоотойгоор бичиж авсан утасны яриаг хуульч, үйлчлүүлэгч хоорондын нууцын зарчмаар хамгаалж чадахгүй байгаад Хорооны зүгээс санаа зовж байна. ССРР/С/NLD/CO/4, 2009 оны 8-р сарын 25-ны өдөр, заалт №14-ийг үз.

385 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтнүүдтэй харьцах тухай Наймдугаар Чуулганаар баталсан “Хуульчдын үүргийн талаарх нийтлэг зарчмууд” -ыг үз. Хавана, Куб, 1990 оны 8 дугаар сарын 27-ны өдрөөс 9 дүгээр сарын 7.

386 Брюссель, 2006, “Эрүүгийн хэргийн шүүхийн тогтолцооны тухай Брюсселийн тунхаглал” -ыг үз.

387 Вена 1989, “Хүмүүнлэгийн болон бусад салбар дахь хамтын ажиллагаа”, заалт №40-ийг үз.

388 “Хэвлэлийн эрх чөлөөг дараагийн шатанд гаргах төлөвшилтийн бодлогууд”, Интернет 2013 Бага хурлаас гаргасан ЕАБХАБ-ын Хэвлэлийн эрх чөлөөний асуудал эрхэлсэн Төлөөлөгчийн Зөвлөмжүүд, Зөвлөмж №3, <https://www.Osce.org/fom/100112> -ыг үз.

шаардлагыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Энэ нь гэрч, шүгэл үлээгч гэх мэт тэдэнд мэдээлэл өгөхөд тодорхой эрсдэлтэй тулгардаг эх сурвалжууд, ялангуяа, хүний наймааны золиос эсвэл хүчирхийлэгч, хэт даврагч бүлэглэлээс гарч байгаа хүмүүстэй хамтран ажилладаг хүмүүс, хүний эрхийг хамгаалагчдаас тусламж хүссэнээсээ болж халдлагад өртөх эрсдэл өндөртэй хүмүүст онцгой ач холбогдолтой юм.

258. Хүний эрхийг хамгаалагчдын зарим тодорхой бүлэг нь байнга тулгардаг зөрчил, хүчирхийллийн шинж чанараас шалтгаалан хувийн амьдралыг хамгаалахтай холбоотой тодорхой хэрэгцээтэй байдаг. Тухайлбал, НҮБЕА нь мэдээллийн технологитой холбоотой эмэгтэйчүүдийн, тэр дундаа хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудал улам санаа зовоосон асуудал болж байгаа тул үр дүнтэй хариу арга хэмжээ авах шаардлагатайг хүлээн зөвшөөрсөн. Ийм зөрчил, зүй бус үйлдэлд хохирогчийг гутаан доромжлох эсхүл бусад зүй бус үйлдэл, доромжлолыг өдөөх зорилгоор цахим дарамт, кибер мөшгөлт, хувийн нууцад халдах, цензур тавих, цахим шуудан, гар утас болон бусад цахим төхөөрөмжийг хакердах зэрэг орно.³⁸⁹

И. Олон улсын байгууллагатай холбоо тогтоох, харилцах эрх

259. Хүний эрх нь зөвхөн дотоод асуудал төдийгүй бүх оролцогч улсын шууд болон хууль ёсны анхаарал хандуулах ёстой асуудал³⁹⁰ тул хүний эрхийн талаарх мэдээллийг олон улсын байгууллагад, түүний дотор олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн механизмын анхааралд хүргэх нь өөрөө хамгаалуулах шаардлагатай эрх бөгөөд хууль ёсны хүний эрхийн үйл ажиллагаа юм.
260. ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтууд энэ эрхийг олон дахин хүлээн зөвшөөрч тусгасан байдаг.³⁹¹ НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглал энэ эрхийг 5 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 4-т тусгаснаар түүнийг хүний эрхийг хамгаалах эрхийн чухал хэсэг, түүнчлэн бие даасан

389 A/RES/68/181, 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан, ерөнхий заалт №12-г үз.

390 Москва 1991, Оршил.

391 Копенхаген 1990, заалт №10.4 ба 11.3. -г үз. Түүнчлэн, "ЕАБХАБ-ын заалтуудын хэрэгжилтийг мөрдөх, сурталчлах, энэ зорилгоор бусадтай хамтран ажиллах хувь хүний эрх"- ийг баталгаажуулж, оролцогч улсуудын "оролцогч улс хооронд болон дотоодод эдгээр хүн, байгууллага, институтууд хоорондоо шууд харилцах, харилцаа холбоо тогтоох боломж бий болгох" амлалт үүргийг тусгасан Вена 1989, 26 дугаар зүйлийг үз.

эрх хэмээн онцолсон байдаг.³⁹² НҮБ-ын Ерөнхий ассамблей болон Хүний эрхийн зөвлөл нар хувь хүн бие даан болон бусадтай хамтран, хүний эрхийн асуудлаар олон улсын байгууллагуудад, тэр дундаа Нэгдсэн Үндэстний байгууллага ба түүний системийн байгууллагууд, механизмуудтай чөлөөтэй холбоо тогтоох, харилцах эрхийг дахин баталгаажуулсан.³⁹³

261. Олон улсын байгууллагатай холбогдох, тэдэнтэй харилцах эрх нь НҮБ, АУДБ, ЕХ, Европын зөвлөл, ЕАБХАБ-ын хүний эрхийн механизм зэрэг олон улсын бүх байгууллагын суурь эрх юм. Цаашилбал хүний эрхийн эдгээр олон улсын механизм нь улс орнуудын хүний эрхийн олон улсын стандартын биелэлтэд дэмжлэг үзүүлэхдээ хувь хүмүүс болон бүлгүүдийн ирүүлсэн мэдээлэлд ихээхэн тулгуурладаг.³⁹⁴ Иймээс, хүний эрхийг хамгаалагчийг эдгээр олон улсын байгууллагуудад мэдээлэл дамжуулсны төлөө хариуцлага хүлээлгэх эсвэл эдгээр байгууллагатай харилцахад саад болж байгаа байдлууд нь хүний эрхийг зөрчиж байгаа хэрэг бөгөөд ингэснээрээ шударгаар хамтран ажиллах үүрэг хүлээсэн улс орнуудтай бий болгосон механизмын үйл ажиллагааг алдагдуулж байна. НҮБ-ын Ерөнхий ассамблей болон Хүний эрхийн зөвлөл нар улс орнуудыг хүний эрхийг хамгаалагч, түүнчлэн тэдний гэр бүлийн гишүүд, хамааралтай хүмүүсийг энэ мэт аливаа айлган сүрдүүлэх, хариуцлага хүлээлгэх явдлаас татгалзаж, хамгаалахыг уриалсан.³⁹⁵
262. ЭШЭК ба ЭШЭНП, ЭЯГБХУК-ын Нэмэлт протокол, ЭЗНСЭОУХ-ийн Нэмэлт протокол зэрэг олон улсын гэрээнд улс орнууд хүмүүсийг гомдол гаргаснаас эсвэл бусад хэлбэрийн харилцааны арга хэрэгслээс нь шалтгаалан зүй бус харьцах, айлган сүрдүүлэхээс хамгаалах үүрэг хүлээдэг тусгай заалтуудыг

392 НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалын 5-р зүйлд “хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилгоор хүн бүр бие даан болон бусадтай хамтран, үндэстний болон олон улсын түвшинд [...] (с) төр болон засгийн газар хоорондын байгууллагатай холбоо тогтоох” эрхтэй гэж заасан байдаг. Тунхаглалын Зүйл №9 (4)-т хүн бүр “бие даан болон бусадтай хамтран хүний эрх, үндсэн эрх чөлөөний асуудлаар олон улсын байгууллагуудтай харилцаа холбоо тогтоох санал хүлээж авах, авч үзэх ерөнхий болон тусгай эрх хэмжээг саадгүй эдлэн, холбоо харилцаа явуулах” эрхтэй гэж заасан.

393 НҮБЕА-н Тогтоол №A/RES/68/181, заалт №18, ба НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн Тогтоол №A/HRC/RES/22/6, заалт №13. -г үз. Мөн, “НҮБ, түүний төлөөлөгч, механизмуудтай явуулах хүний эрхийн салбар дахь хамтын ажиллагаа”, Тогтоол A/HRC/RES/24/24, 2013 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр батлагдсан, заалт №1-ийг үз.

394 Н.У-ий Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн тусгай илтгэгч, “Бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах ‘Хувь хүн, Бүлгэм, Нийгмийн байгууллагын эрх, үүргийн тунхаглалын тайлбар’”, 2011 оны 7 дугаар сар, хуу. №51.

395 НҮБЕА-н Тогтоол №A/RES/68/181, заалт №17, ба Хүний Эрхийн Зөвлөлийн Тогтоол №A/HRC/RES/22/6, заалт №14-ийг үз.

агуулдаг.³⁹⁶ Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь ЭШЭК-ын холбогдох заалтын дагуу нэхэмжлэгч болон гэрчийн гаргасан нотлох баримт, гомдлын улмаас хууль бус харьцаа, айлган сүрдүүлэлтэд өртөхөөс хамгаалах зохицуулалтыг зөрчлийг хөөн шалгах, хариуцан мэдээлэх үүрэгтэй Тусгай илтгэгчдийг томилсон. НҮБ-ын бусад олон улсын гэрээний байгууллагууд мөн хүний эрхийг хамгаалагчид, хүний эрхийн ТББ-уудтай харилцах өөрсдийн албан харилцааны асуудалд онцгой анхаарал хандуулдаг. Тухайлбал, НҮБ-ын Хүний эрхийн хороо нь хүний эрхийн чиглэлээр ажилладаг ТББ-уудтай харилцах, хамтын ажиллагааны чухлыг³⁹⁷ онцолж, тус хороотой харилцаж байгаа хүмүүст аливаа шийтгэл оногдуулахыг үл хүлээн зөвшөөрнө гэдгийг тэмдэглэжээ.³⁹⁸ Хүнийг хүчээр сураггүй алга болгох асуудлыг хариуцсан хороо энэ төрлийн шийтгэл, түүнийг хэрхэн шийдвэрлэх тухай журамдаа тодорхой зохицуулалтыг оруулсан байдаг.³⁹⁹

263. ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг, олон улсын үүрэг хариуцлага байгаа хэдий ч, ЕАБХАБ-ын хэд хэдэн гишүүн оронд хувь хүмүүс болон бусад бүлгүүд шийтгүүлсэн тухай мэдэгдэл, тайлан, хяналт-шинжилгээ, судалгааны материал, гомдол болон бусад мэдээллийг олон улсын холбогдох байгууллагад чөлөөтэй, айдасгүйгээр гаргаж чадахгүй байна. Үүний сацуу, тэдэнтэй холбогдсоных нь төлөө ирэх заналхийлэл, анхааруулга, зорчих хориг эсвэл харлуулах кампанит ажил зэргээс болоод эх орондоо эсвэл гадаадад байгаа ч гэсэн, мэтгэлцээнд чөлөөтэй оролцох, эдгээр байгууллагатай уулзах, бусад байгууллагатай хамтран ажиллах бололцоо нь заримдаа нилээд хязгаарлагддаг. ТББ-уудыг хууль сахиулах байгууллагууд “хянадаг”, эсвэл тэдний ажлын өрөө, ажилтнуудын хувийн орон байранд нэгжлэг хийсэн, хулгайгаар орсон гэсэн мэдээллийг ТББ-ууд олон улсын байгууллагуудад мэдээлсээр байна. Олон улсын уулзалтад оролцохоор явахад нь онгоцонд суулгахгүй паспортыг нь хурааж авсан эсвэл эргэж ирснийхээ дараа хариу арга хэмжээ авагдсан тохиолдол гарчээ. Зарим оронд эрх баригчид тухайн улсын нэр хүндэд халдсан, “хуурамч

396 “Эрүүдэн Шүүлт болон бусад хэлбэрийн хэрцгий, хүнлэг бус буюу доромжилсон харьцаа ба шийтгэлийн эсрэг конвенц”, Зүйл №13; “Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын нэмэлт протокол”, Зүйл №15; “Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах конвенцын нэмэлт протокол”, Зүйл №11; “Эдийн Засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Олон Улсын Хэлцлийн нэмэлт протокол”, Зүйл №13.

397 НҮ-ий Хүний Эрхийн Хорооны, “Хүний Эрхийн Хороо ба төрийн бус байгууллагуудтай харилцаа”, ССРР/С/104/3, 2012 оны 6 дугаар сарын 4.

398 “Иргэний ба Улс төрийн эрхийн олон улсын пактын нэмэлт протоколын улсуудын үүрэг хариуцлага”-ын талаарх 33 дугаар ерөнхий тайлбартаа Хүний Эрхийн Хороо “гэрээний улсууд нь тус Хороотой харилцаа холбоо тогтоосон аливаа хувь хүнд хариу арга хэмжээ авахаас сэргийлэх, тус Хороотой харилцахад саад учруулахгүй байх үүрэгтэй” гэж заасан. (UN Doc. ССРР/С/СР/33, 2009 оны 6 дугаар сарын 25, заалт №4).

399 “Хүнийг хүчээр сураггүй алга болгохоос хамгаалах НҮБ-ын Хорооны үйл ажиллагааны дүрэм”, НҮБ-ын Б.6. CED/C/1, 2012 оны 6 дугаар сарын 22, дүрэм №63 (2), 95 (4) ба 99-г тус тус үз.

мэдээлэл” тараахыг хориглосон хууль тогтоомж, үүнтэй ижил төстэй хууль тогтоомжуудыг ашиглан хүний эрхийн хяналт-шинжилгээ, түүний үр дүнг олон улсын байгууллагад мэдээлэх зорилготой үйл ажиллагааных нь төлөө хүний эрхийг хамгаалагчдад эрүүгийн хэрэг үүсгэдэг. Тухайлбал, НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь хэт өргөн утгатай хэрэглэгдэж болохуйц эрүүгийн зүйл заалтууд байгаад санаа зовниж буйгаа илэрхийлсэн, энэхүү заалт нь хүний эрхийн асуудлын талаарх мэдээллийг тус хороо болон бусад хүний эрхийн байгууллагатай хуваалцахыг мөн хориглосон байна.⁴⁰⁰ Хариу арга хэмжээг зорчих эрх чөлөөг хууль бусаар хязгаарлах, эрх чөлөө ба аюулгүй байдлаа хангуулах эрхийг зөрчих, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон бусад эрхүүдийг зөрчих зэрэг хүний эрхийн зөрчлийн олон хэлбэрээр авдаг.

264. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын НҮБ ба түүний системийн байгууллагууд, механизмтай хүний эрхийн чиглэлээр хамтран ажиллаж буй байдалд хийсэн жилийн тайлангаас харахад НҮБ-тай хамтран ажиллаж байгаа хүмүүсийн эсрэг хариу арга хэмжээ, хариуцлага ногдуулж байгаа нь анхаарлаа хандуулах асуудал болж байгаа бөгөөд ЕАБХАБ-ын хэд хэдэн оролцогч оронд тулгараад байна. НҮБ-ын хариу арга хэмжээ авдаг байдалд хяналт тавих ажлын хүрээнд бүс нутгийн байгууллагуудтай нь хамтран ажилласныхаа төлөө айлган сүрдүүлэлт, хариу арга хэмжээнд

400 “Нэгдсэн дүгнэлт: ОХУ.”, НҮБ-ын Б.Б. САТ/С/RUS/CO/5, 2012 оны 12-р сарын 11, заалт №12-ыг үз. Иймээс тус Хороо нь гэрээний улсыг “Эрүүдэн шүүхийн эсрэг хороо, Эрүүдэн Шүүхээс Урьдчилан сэргийлэх дэд хороо, эсвэл Эрүү шүүлтийн хохирогчдод зориулсан НҮБ-ын Сайн Дурын Сан болон тус тусын төлөөлөх эрхийг хэрэгжүүлж буй НҮБ-ын хүний эрхийн чиглэлээрх бусад байгууллагатай холбоо тогтоосон, мэдээлэл өгснийхөө төлөө аливаа хувь хүн, бүлэг шүүхээр шийтгүүлдэггүй нөхцөлийг бүрдүүлэхийг уриалсан. Эх. сурв. заалт №12 (b)-г үз. Цаашилбал, гадаад эх сурвалжаас санхүүгийн дэмжлэг авдаг байгууллагыг бүртгүүлэхийг, улмаар, өөрсдийгөө “гадаадын төлөөлөгчийн газар” гэдгээ олон нийтэд нээлттэй хүлээн зөвшөөрөхийг шаардсан хууль тогтоомжийн тухайд онцгойлон санаа зовниж буйгаа илэрхийлэв. Эх. сурв. заалт №12-ыг үз. Улмаар, тус Хороонд энэ хоёр байгууллагын ирүүлсэн мэдээлэлтэй холбогдуулан дээрх хоёр заалтад заасны дагуу тухайн хоёр байгууллага болон тэдний удирдлагыг буруутгаж байна гэсэн мэдэгдлийг хүлээн авсан. “2013 оны 5-р сарын 17, 28-ны өдрүүдэд уг хариу арга хэмжээний талаар Хорооны дарга, Тусгай илтгэгч нарын ОХУ-д илгээсэн захидал”, http://tbinternet.ohchr.org/_layouts/TreatyBodyExternal/TBSearch.aspx?Lang=en&TreatyID=1&DocTypeID=130-ыг үз. Тажикстанд хийсэн нэгдсэн дүгнэлтдээ Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь Тажикистан улсад томиллоор 2012 оны 5-р сард ажилласан Эрүүдэн шүүлт болон бусад хэлбэрийн хэрэгцгий, хүнлэг бус буюу хүний нэр төрийг доромжилсон харьцаа ба шийтгэлийн эсрэг Тусгай илтгэгчтэй уулзсаныхаа дараа хүний эрхийг хамгаалагчдыг дарамтлах, айлган сүрдүүлсэн гэх мэдээлэл, мөн, тус томилолтын үеэр Тусгай илтгэгчтэй хамтарч ажилласан хүний эрхийн нэг байгууллагыг захиргааны үндэслэлээр татан буулгасан тухайд ноцтой санаа зовж байгаагаа илэрхийлсэн. Эрүүдэн шүүхийн эсрэг хороо, “Тажикстанд хийсэн нэгдсэн дүгнэлт”, НҮБ-ын Б.Б. САТ/С/TJK/CO/2, 2012 оны 11 дүгээр сарын 20, заалт №15-ыг үз.

өртсөн гэсэн мэдэгдлүүд НҮБ-д ирсэн байна.⁴⁰¹ Хүний эрхийн зөвлөл нь НҮБ ба түүний системийн байгууллагууд, механизмтай хүний эрхийн чиглэлээр хамтран ажиллахыг эрмэлзэж буй хувь хүмүүс, бүлгүүдийн эсрэг “айлган сүрдүүлэлт, хариу арга хэмжээ авсан тухай мэдээллүүд тасрахгүй байгаа тухай, хохирогчийн амьд явах эрх, эрх чөлөөг зөрчсөн, хувь хүний аюулгүй байдлыг алдагдуулсан, эрүүдэн шүүх, харгис хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцахыг хориглосон олон улсын хууль тогтоомжийн дагуу хүлээсэн үүргээ зөрчсөн”⁴⁰² тухай асуудалд санаа зовж буйгаа илэрхийлсэн. Үүнтэй холбогдуулан НҮБ-ын Ерөнхий ассамблей ба Хүний эрхийн зөвлөлөөс улс орнуудад айлган сүрдүүлэх, хариу арга хэмжээ авах явдлаас татгалзаж, зохих ёсоор хамгаалахыг уриалав. Цаашилбал, аливаа гэмт хэрэг үйлдэгчдийг шүүхээр хэргийг нь хянан шийдвэрлүүлж хариуцлага хүлээлгэх, хохирогчдод хохирлыг нь үр дүнтэй арга хэрэгслээр барагдуулж өгөх замаар ял шийтгэлээс зугтах явдлыг таслан зогсоох, олон улсын байгууллагуудтай чөлөөтэй, аливаа саадгүйгээр холбоо тогтоох эрхийг сулруулах үр дагавар бүхий хууль тогтоомж батлахаас зайлсхийх үүргээ биелүүлэхийг улс орнуудад мөн уриалсан байна.⁴⁰³ ЕХЭШ-ийн хэрэг өмгөөлж буй хуульчдад хууль бусаар дарамт шахалт үзүүлэх болон бусад айлган сүрдүүлэх үйлдлүүдийн талаар ноцтой санаа зовж буйгаа ЕЗПА болон Евродын зөвлөлийн сайд нарын хороо илэрхийлсэн байдаг. Тус сайд нарын хороо улс орнуудыг шүүхэд нэхэмжлэл гаргахаас сэргийлэх зорилгоор нэхэмжлэлч, тэдгээрийн өмгөөлөгч, гэр бүлийн гишүүдэд дарамт үзүүлэхээс зайлсхийхийн хамт тэднийг энэ мэт дарамт шахалтаас найдвартай хамгаалах, хувь хүний шүүхэд нэхэмжлэл гаргах эрхэд

401 А/НRC/24/29, 2013 оны 7 дугаар сарын 31, заалт №49 ба заалт №14 (бүсийн байгууллагатай харилцсан хэрэгт буруутгаж, хариу арга хэмжээ авсан тухай мэдэгдлийн тухай) -г үз. Мөн, НҮБ-ын Ерөнхий Нарийн бичгийн НҮБ, түүний төлөөлөгч, механизмуудтай явуулах хүний эрхийн салбар дахь хамтын ажиллагааны талаарх өмнөх тайлан, НҮБ-ын Б.Б. А/НRC/21/18, 2010 оны 8 дугаар сарын 13; НҮБ-ын Б.Б. А/НRC/18/19, 21 2011 оны 7 дугаар сар; ба НҮБ-ын Б.Б. А/НRC/14/19, 2010 оны 5 дугаар сарын 7-ыг үз.

402 А/НRC/RES/24/24, Оршил.

403 НҮБЕА-н Тогтоол №A/RES/68/181, заалт №17; ба Хүний Эрхийн Зөвлөлийн Тогтоол №A/НRC/RES/22/6 заалт №14. -ийг тус тус үз. Мөн, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төлөөлөгч, механизмуудтай энэ чиглэлээр харилцаа холбоо тогтоосон хувь хүн, бүлгүүдийн эсрэг айлган сүрдүүлэх, хариу арга хэмжээ авсан үйлдлүүдийг авч хэлэлцэх үндэсний байгууллагатай болохыг уриалсан А/НRC/RES/24/24, заалт №8-ыг үз.

хөндлөнгөөс оролцсон байж болзошгүй бүх тохиолдлыг тодорхойлж, зохих ёсоор мөхдөн шалгах уриалга хүргүүлсэн.⁴⁰⁴

265. Хүний эрхийг хамгаалах үндэсний арга барил үр дүнтэй ажиллаж чадахгүй байгаа үед олон улсын тогтолцоо нь хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах эсвэл хууль ёсоор засаж залруулах цорын ганц буюу эцсийн арга хэрэгсэл байж болох юм. Олон улсын байгууллагад, ялангуяа хүний эрхийн механизмд ирүүлсэн мэдээлэл нь гадны этгээд тухайн улсын хүний эрхийн байдлын талаар олж мэдэх цорын ганц арга зам билээ. Ийм нөхцөл байдалд улс орнууд энэ мэт мэдээлэл дамжуулах явдлыг улс орноо, засгийн газраа муугаар харагдуулж, улмаар эрх баригчдын хийсэн хүний эрхийн зөрчил, авлигыг илчилнэ гэж үздэг. Гэсэн хэдий ч, ЕАБХАБ-ын гишүүн орнууд хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах эрхийг хүндэтгэх үүрэг хүлээсэн байдаг.⁴⁰⁵ Мөн оролцогч улсууд ЕАБХАБ-ын Хүний эрхийн талаарх үүрэг амлалтыг дагаж мөрдөхөд хувь хүмүүс, бүлгүүд, холбоод дэмжлэг болдог чухал хувь нэмэртэйг бататган зөвшөөрсөн.⁴⁰⁶ Тиймээс, тэд хүний эрхийг хамгаалагчдын олон улсын байгууллагатай мэдээлэл хуваалцах эрхийг хүндэтгэж, хамгаалах ёстой.
266. Улс орнуудын хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааг бэхжүүлэхийн тулд олон улсын байгууллагуудтай, тэр тусмаа, хүний эрхийн механизмтай явуулах харилцаа холбоог байнгын үйл ажиллагаа гэж үзэн хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Тиймээс оролцогч улсууд хүний эрхийг хамгаалагчдыг ийм байгууллагатай харилцах эрхээ эдлэхэд нь туслах үүднээс идэвхтэй алхмуудыг хэрэгжүүлэх хэрэгтэй. НҮБ-ын Олон улсын гэрээний байгууллагуудаас зөвлөдгийн дагуу улс орнууд холбогдох олон улсын гэрээ, үндэсний тайлан, эрх зүйн болон бусад холбогдох баримт бичигт хийсэн нэгдсэн дүгнэлт, зөвлөмж зэргийг өөрийн улсын хэл рүү хөрвүүлж, олон улсын хүний эрхийн механизмын талаарх мэдлэгийг

404 Европын Зөвлөлийн Сайд нарын Хороо, “Хүний эрхийн Европын шүүхэд хувь хүний нэхэмжлэл гаргах эрхийг хүндэтгэх, хамгаалах гишүүн орнуудын үүргийн тухай” СМ/Res (2010) 25 тогтоолыг үз. Заалт №1-2 ба 4. Европын Зөвлөлийн Парламентын Ассамблей (ЕЗПА) 2007 оны тогтоолдоо бараг ижил зөвлөмж гаргасан. (ЕЗПА 1571 (2007) тогтоолыг үзнэ үү. “Европын Зөвлөлийн гишүүн орнуудын Хүний Эрхийн Европын шүүхтэй хамтран ажиллах үүрэг”, заалт №17.1.-17.3-г тус тус үз Уг тогтоолд тус Ассамблей нь “Шүүхэд хэрэг мэдүүлсэн нэхэмжлэгчийг хороосон, сураггүй алга болгосон, зодсон, заналхийлсэн зэрэг олон тооны хэргийг эрх бүхий байгууллагууд бүрэн, үр дүнтэй шалгаж чадаагүй” тухай энэ нөхцөлд асуудалд санаа зовниж байгаагаа илэрхийлсний сацуу, нэхэмжлэгчдийг тус Шүүхэд өмгөөлсөн өмгөөлөгчдөд “хуурамч эрүүгийн хэрэг, татварын ялгаварлан гадуурхсан шалгалт, ‘албан тушаалаа урвуулан ашигласан’ хэргээр прокурорт өгөхөөр заналхийлсэн зэрэг” дарамт үзүүлэх хууль бус аргууд хэрэглэсэн. Нэхэмжлэгчдэд нэхэмжлэлийн материалаа бэлдэхэд нь тусалдаг ТББ-уудад ижил дарамт шахалт үзүүлэх болсон.” гэж дурджээ. Иймэрхүү айлган сүрдүүлэх үйлдэл нь зөрчлийн улмаас хохирсон хохирогчдод шүүхэд нэхэмжлэл гаргахаас татгалзах, эсвэл нэхэмжлэлээ буцааж авахад хүргэсэн (заалт №5-7-г үз.).

405 Вена 1989, заалт №13.5; НҮБ-ын хүний эрхийг хамгаалагчдын тунхаглал, Зүйл №1.

406 Жишээлбэл: Москва 1991.

дээшлүүлэх болон тэдгээрийг авч хэрэгжүүлэхийг ухуулах зорилгоор өргөнөөр түгээх, хэрэгтэй.⁴⁰⁷ Үүний нэгэн адилаар, улс орнууд хүний эрхийн бусад механизмын гаргасан зөвлөмж, түүнчлэн хүний эрхийн бүс нутгийн механизм ба бусад институтүүдээс гаргасан стандарт, эрх зүйн практикийг түгээх ёстой. Тэд мөн олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн механизм, институтэд, тэр дундаа хүний эрхийн шүүхэд гомдол хэрхэн ирүүлэх тухай мэдээллийг олон нийтэд сурталчлах, шаардлагатай тохиолдолд, эдгээр механизмыг ашиглах боломжийг зохион байгуулж өгөх хэрэгтэй.

267. НҮБ-ын Олон улсын гэрээт байгууллагууд нь хүний эрхийн холбогдох гэрээний хэрэгжилтийн талаар хугацаат тайлан бэлтгэхдээ иргэний нийгэмтэй идэвхтэй зөвлөлдөж байхыг байнга зөвлөдөг.⁴⁰⁸ Үүний нэгэн адил, улс орнуудад холбогдох оролцогч талуудыг үндэсний түвшинд өргөнөөр хамруулан зөвлөлдөж бэлдсэн үндэсний тайлан болон бусад мэдээллийг Хүний эрхийн зөвлөлийн дэлхийн хэмжээний тогтмол нэгдсэн дүгнэлт (ДХТНД)-д илгээхийг зөвлөж байна.⁴⁰⁹ Ийм зөвлөлдөх уулзалтууд нээлттэй, олон талт оролцоог хангасан, үр дүнтэй байх ёстой. Ийм зөвлөгөөнүүдийг явуулахдаа оролцогч улсууд хүний эрхийг хамгаалагчдын өөрсдийн тайлан, илтгэлээ үндэсний тайлангийн хувилбар болгон явуулах, төлөөлөх эрхийг хүндэтгэх ёстой. Иргэний нийгмийн оруулсан хувь нэмрийг үнэлж буйгаа харуулах үүднээс оролцогч улсууд улс орондоо өрнөж буй хүний эрхийн байдлыг авч үзсэн үйл явдлын тоймын бэлтгэл явцын талаарх мэдээллийг хэвлэх, түүнчлэн тоймыг бэлтгэж буй холбогдох механизм,

407 Жишээлбэл: Хүний Эрхийн Хорооны дараах зөвлөмжийг үз. Үүнтэй ижил төстэй зөвлөмжүүдийг улсуудын тайланг хянасны дараа хийсэн бүх нэгдсэн дүгнэлтүүдээс харж болно. Үүнд: "Нэгдэж орсон улс нь энэхүү Пакт болон пактын 2 нэмэлт протокол, хоёр дахь хугацаат тайлан, хоёр дахь үе шатны тайлангийн эх, Хорооноос дэвшүүлсэн асуудлын жагсаалт болон түүнд авсан арга хэмжээний бичгэн жагсаалтыг шүүх, хуулийн болон захиргааны эрх бүхий байгууллага, иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагууд, түүнчлэн олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор өргөнөөр түгээж, нэгдсэн дүгнэлтүүдийг танилцуулах хэрэгтэй. Тус Хорооноос тайлан болон нэгдсэн дүгнэлтийг гэрээний улсын бусад албан ёсны хэл дээр орчуулахыг санал болгож байна. "Хүний Эрхийн Хороо," Нэгдсэн дүгнэлт: Босни-Херцеговин, НҮБ-ын Б.б. ССРР/С/ВИН/СО/2, 2012 оны 11-р сарын 13, заалт №22. Үүнтэй адилаар, Хүүхдийн эрхийн хорооноос "Уг Хороо нь цаашид гэрээний улсын гаргасан 2-4-р нэгтгэсэн хугацаат тайлан, гэрээний улсуудын бичгээр гаргасан хариултауд болон холбогдох зөвлөмжүүд (нэгдсэн дүгнэлт)-ийг Конвенц болон Нэмэлт протоколуудын тухай мэтгэлцээн, мэдлэгийг бий болгох зорилгоор тухайн улсын хэл дээр интернэтээр(дан ганц биш), олон нийтийн газраар, иргэний нийгмийн байгууллагаар, хэвлэл мэдээлэл, залуучуудын бүлгэм, мэргэжлийн бүлгэмүүд, хүүхдүүдэд өргөнөөр түгээхийг зөвлөж байна. Хүүхдийн эрхийн хорооны "Нэгдсэн дүгнэлт: Босни-Херцеговин, НҮБ-ын Б.б." CRC/C/ВИН/СО/2-4, 2012 оны 11-р сарын 29, заалт №81-ийг үз.

408 Жишээлбэл: Хүний Эрхийн Хороо "Нэгдсэн дүгнэлт: Босни-Херцеговин," НҮБ-ын Б.б. ССРР/С/ВИН/СО/2, 2012 оны 11 дүгээр сарын 13, "Тус Хорооноос гэрээний улсыг хугацаат гурав дахь тайлангаа бэлдэх явцдаа нийгмийн ба Төрийн бус байгууллагуудтай өргөнөөр зөвлөлдөхийг шаардсан." заалт №22-ыг үз.

409 НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөл, "Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Зөвлөлийн институт байгуулах тухай", Тогтоол А/НRC/RES/5/1, Хавсралт, заалт №15-ыг үз.

байгууллагад мэдээлэл өгөх хугацаа, горимтой холбоотой мэдээллийг дамжуулах гэх мэт байдлаар иргэний нийгэмд өөрсдөө түрүүлж хандан, олон улсын хүний эрхийн механизм, институттэй идэвхтэй харилцах хэрэгтэй.

268. НҮБ-ын Тусгай журам, ЕАБХАБ, Европын зөвлөл, АДХЭХ-ны гэх мэт байгууллагуудын хүний эрхийн механизм, институт зэрэг олон улсын байгууллагууд зочлох үеэр хүний эрхийг хамгаалагч нар төлөөлөгчидтэй чөлөөтэй, аюулгүй, нууцлалтайгаар харилцаж чадаж байгаа эсэхийг улс орнууд нягтлах ёстой.⁴¹⁰

IV. УДИРДАМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үндэсний хэрэгжилт

269. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалын 2 дугаар зүйлд заасны дагуу улс орнууд тунхаг бичигт дурдсан эрх, эрх чөлөөг бодитоор баталгаажуулахын тулд шаардлагатай байж болох хууль эрх зүйн орчинг бий болгож, захиргааны болон бусад арга хэмжээг хэрэгжүүлнэ. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл нь “хүний эрхийг хамгаалагчдын ажилд шууд болон шууд бусаар нөлөөлдөг хууль тогтоомжийг хянан үзэх, нэмэлт, өөрчлөлт оруулах явцдаа тусламж хүсэхийг [...]” уриалсан.⁴¹¹ Улс орнууд хууль тогтоомжоосоо гадна хүний эрхийг хамгаалагчдыг үйл ажиллагаагаа явуулахад нь эрсдэлд оруулахгүй, эсвэл ажилд нь саад учруулахгүй, харин ч үйл ажиллагаагаа явуулахад нь чадавхжуулж буй эсэхийг нягтлах

410 НҮБ-ын Тусгай илтгэгчид/төлөөлөгчдийн баталсан гэрээний улсад томилолтоор ажиллах журмын нөхцөлийн дагуу урьж буй засгийн газар, өөр бусад шаардлагатай зүйлээс гадна, дараах баталгаа, боломжоор хангах ёстой. Үүнд: “

- а) Тухайн улсын нийт нутаг дэвсгэрээр зорчих эрх, тэр дундаа, тээврийн хэрэгсэл, ялангуяа, хаалттай газар нутагт зорчих;
- б) Асууж лавлах эрх, ялангуяа, дараах чиглэлээр:
 - (i) Бүх шорон, албадан саатуулах газрууд, байцаалт авах байранд нэвтрэх;
 - (ii) Засгийн газрын бүх салбар байгууллагын төв ба орон нутгийн удирдлагатай холбоо тогтоох;
 - (iii) Төрийн бус байгууллагууд, хувийн байгууллагууд ба хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй харилцах;
 - (iv) Гэрчүүд ба бусад Тусгай илтгэгчийн төлөөлөх эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзсэн болон эрх чөлөөгөө хасуулсан хүн зэрэг хувь хүнтэй нууцаар болон хяналтгүйгээр холбоо барих;
 - (v) Төлөөлөх эрхийнхээ хүрээндээ хамаарах бүх баримт бичигтэй бүрэн танилцах;
- с) Тусгай илтгэгч/төлөөлөгчтэй түүний төлөөлөх эрхтэй холбоотойгоор харилцсан аливаа хүн, албан тушаалтан болон хувь хүн энэ шалтгаанаар заналхийлэл, дарамт, шийтгэл хүлээхгүй, шүүхээр шийтгүүлэхгүй гэсэн Засгийн газрын баталгаа; [...]”. E / CN.4 / 1998/45, Хавсралт V-ыг үз.

411 A/HRC/RES/22/6, заалт №22.

үүднээс дотоодын бодлого, практикаа эргэн харж шинжлэх хэрэгтэй. Тэд ийм шинжилгээг иргэний нийгэмтэй зөвшилцөн хийж, шаардлагатай бол олон улсын байгууллагууд, тэр дундаа АИХЭГ-аас техникийн туслалцааг авах хэрэгтэй.⁴¹²

270. Оролцогч улсууд хүний эрхийг хамгаалагчдад нөлөөлж буй хууль тогтоомж, практик үйл ажиллагаандаа суурь шинжилгээ хийх нь энэхүү удирдамж болон бусад холбогдох стандарт, үүрэг амлалтын хэрэгжилтийг хангахад чухал алхам болно. Дараагийн шатны явцын хяналт-шинжилгээ нь ахиц дэвшлийг ажиглах, бусад бэрхшээлийг тодорхойлоход тусална. Түүнчлэн, хүний эрхийг хамгаалагчдын статус, ажлыг хөхиүлэн дэмжих, аюулгүй, таатай орчныг бий болгох, бэхжүүлэх зорилгоор улс орнууд нь хууль тогтоомжийн болон бусад өөрчлөлтийг нэвтрүүлэх, олон жилийн үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах нь зөв. Мөн хүний эрхийг хамгаалагч нар болон ҮХЭИ-үүд гэх мэт холбогдох талуудтай хамтарсан үйл ажиллагааг зохиох замаар хууль эрхзүйд хийсэн дүн шинжилгээ, хяналт-шинжилгээний үр дүнд суурилсан ажлуудыг идэвхтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай зохих арга хэмжээнүүдийг авах нь зүйтэй.
271. Парисын зарчмуудыг баримталж буй бие даасан ҮХЭИ-үүдийн гишүүд, ажилтнуудыг хүний эрхийг хамгаалагч гэж тооцож болно. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч ХЭҮК-ууд нь хүний эрхийг хамгаалагчдын гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хүний эрхийг хамгаалагчдын ажиллах таатай орчныг бүрдүүлэх зорилгоор ухуулан таниулах үйл ажиллагаа явуулах, олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн механизмтай харилцах, эдгээр механизмуудыг улс оронд нь өрнөж буй хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын талаарх мэдээллээр хангах үүрэг хүлээдэг. Мөн хүний эрхийг хамгаалагчдын эсрэг хүний эрхийг зөрчсөн тохиолдолд олон нийтийн дэмжлэгтэйгээр үйл ажиллагаа явуулах, хорих анги, албадан саатуулах байран дахь хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдалд хяналт-шинжилгээ хийх, хүний эрхийг хамгаалагч нар ба эрх баригчид эсвэл нийгмийн бусад талуудын хооронд маргаан гарсан тохиолдолд хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх, эсвэл зуучлагч хийх зэргээр хүний эрхийг хамгаалахад оролцож чадах

412 Ялангуяа, Хүний Эрхийн Зөвлөл “хууль тогтоомжийг олон улсын хүний эрхийн эрх зүйн шаардлагад нийцүүлэхийн тулд улс орнуудад хууль тогтоомжийн төслөө үр нөлөөтэй болгоход үндэсний хүний эрхийн байгууллага, иргэний нийгэм болон бусад оролцогч талын оруулдаг үнэтэй хувь нэмэр”-т өндөр ач холбогдол өгсөн. A/HRC/RES/22/6, заалт №17-г үз.

чухал үүргийг нь онцоллоо.⁴¹³ ХЭҮК нь энэхүү удирдамжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, дээр дурдсан суурь шинжилгээг хийхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

272. Оролцогч улсууд нь ҮХЭИ-үүдийг Парисын зарчмуудад заасанчлан хүчтэй төлөөлөх эрхтэй, бөгөөд энэ эрх хэмжээгээ үр дүнтэй, бие даан хэрэгжүүлэх эх үүсвэртэй байх тал дээр анхаарах ёстой. Оролцогч улсууд хүний эрх, эрхзүйт ёсыг дээдлэх чиглэлээр бие даасан үндэсний институтийг бий болгох, бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.⁴¹⁴ Энэхүү чиглэлээр ЕАБХАБ-ын Парламентын ассамблей нь оролцогч улс орнуудад “Парисын зарчмуудын дагуу хүний эрхийн үндэсний институтүүдийг байгуулах, тэдний бие даасан байдлыг хангах, иргэний нийгмийн бусад төлөөлөгчидтэй хамтран, эсвэл зөвлөх байгууллагаар ажиллах нөхцөлийг хангахад шаардлагатай бүх зохих арга хэмжээ, алхмуудыг авч хэрэгжүүлэхийг” уриалсан.⁴¹⁵ Европын зөвлөлийн сайд нарын хороо гишүүн орнуудаа “хараат бус комисс, омбудсмэн, эсвэл хүний эрхийн үндэсний байгууллагуудад хүний эрхийг хамгаалагчдын гаргасан зөрчлийн талаарх гомдлыг хүлээн авах, авч үзэх, зөвлөмж өгөх эрх, чадавхыг бэхжүүлэх, шаардлагатай бол, шинээр олгох талаар бодолцох” зэргийг зөвлөжээ.⁴¹⁶
273. ЕАБХАБ-ын Парламентын ассамблейгаас ЕАБХАБ-д суугаа парламентын төлөөлөгчдийг өөрсдийн улс орны хүний эрхийг хамгаалагч нар болон

413 НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн Тусгай илтгэгчийн тайланг үз. 2013 оны 1-р сарын 16, НҮБ-ын Б.6./HRC/22/47. Нэгдсэн дүгнэлтдээ Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын Олон улсын зохицуулах хорооны (ОУЗХ) магадлан итгэмжлэлийн дэд хороо (МИДХ)-ноос үндэсний институтүүдийг хүний эрхийг үндэсний хэмжээнд шинэ шатанд гаргах, хамгаалах тусгайлсан зорилгоор улс орнууд байгуулдаг.” гэдгийг дахин сануулсан. Түүнчлэн, Парисын зарчмуудын үндсэн шаардлагын дагуу ҮХЭИ-үүд нь хүний эрхийн хүрээний байгууллагууд, түүний дотор иргэний нийгэм, төрийн бус байгууллагатай харилцаа үүсгэн тогтоож, албажуулж, хадгалах ёстой гэж цохон тэмдэглэв. “олон нийтийн харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах зэргээр хүний эрхийн бусад байгууллага, иргэний нийгмийн байгууллагатай тогтоосон харилцаагаа ойлгомжтой болгож, албажуулахын ач холбогдол нь эдгээр байгууллагатай харьдаг ҮХЭИ-үүдийн ил тод байдлыг нэмэгдүүлэх гол түлхүүр юм.” Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын олон улсын зохицуулах хороо, “МИДХ ОУЗХ-ны 2013 оны 5-р сард Женев хотод баталсан Нэгдсэн дүгнэлт”, 6, 21-22-р хуудсыг тус тус үз.

414 Копенхаген 1990, заалт №27.

415 ЕАБХАБ Парламентын Ассамблей, “Хүний эрхийг хамгаалагч нар болон үндэсний хүний эрхийн институтүүдтэй тогтоосон ЕАБХАБ-ын харилцааг бэхжүүлэх тухай тогтоол”, заалт №15, Киевийн тунхаглал ба арван зургаадугаар чуулганаар баталсан тогтоолууд, 2007 оны 7-р сарын 5-аас 9-ний хооронд, Киев, хууд. №28-30, <<http://www.EABXABpa.org/publications/declarations/2007-kyiv-declaration/250-kyiv-declaration-english/file>>.

416 Өм. дурд. “Европын Зөвлөлийн хүний эрхийг хамгаалагчдын хамгааллыг сайжруулах, үйл ажиллагааг нь хөхиүлэн дэмжих арга хэмжээний талаарх Сайд нарын Хорооны Тунхаглал”, заалт №2 (v).

ҮХЭИ-үүдтэй харилцан уялдаа холбоогоо сайжруулахыг зөвлөж байна.⁴¹⁷ Үүний нэгэн адил, ЕЗПА парламентын гишүүд улс төрийн нөхцөл байдал, хүний эрхийг хамгаалагчдын ажиллах орчны хандлагыг бүрдүүлэхэд томоохон үүрэг хариуцлага хүлээдгийг онцолсон.⁴¹⁸ Тодруулбал, ЕЗПА нь чиг үүргийнхээ хүрээнд Европын зөвлөлийн гишүүн орнуудын үндэсний парламентуудыг хүний эрхийг хамгаалагч нар болон тэдний үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж олон улсын стандартуудад нийцэж буй эсэхийг нягтлах, хүний эрхийг хамгаалагчдын эрх ашгийг хамгаалах талаар бодлого, үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө, стратеги зэрэг хууль эрх зүйн бус баримт бичгүүдийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх, хүний эрхийг хамгаалагчидтай тогтмол харилцаж, хөгжүүлэх, хүний эрхийг хамгаалагчдын ажлыг олон нийтэд нээлттэй (сонсгол, парламентын хэлэлцүүлэг зохион байгуулах, хүний эрхийг хамгаалагчдад зориулсан шагнал бий болгох гэх мэт) хүлээн зөвшөөрөх үүрэг хүлээдэг. Мөн эрсдэлд буй хүний эрхийг хамгаалагчдад тусламж үзүүлэх, тэднийг хамгаалах арга хэмжээ авах болон хамгаалах механизмууд болон НҮБ, Европын зөвлөлийн хүний эрхийг хамгаалагчдын талаарх тунхаглалыг олон нийтэд ухуулан таниулахыг уриалсан.⁴¹⁹ ЕАБХАБ-ын оролцогч орнуудын парламентын гишүүдэд ч энэхүү удирдамжийг ухуулан таниулах, хэрэгжилтийг үр дүнтэй нэхэн шалгаж нягтлах зорилгоор эдгээр болон бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

274. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл 2010 онд “өөр бусад зорилгоос гадна, хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүдийн гэх мэт хамгаалалтын онцгой хэрэгцээнүүдийг тодорхойлох, зорилтот хамгааллын арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэхэд хүний эрхийг хамгаалагчдын оролцоог хангах зорилгоор хүний эрхийг хамгаалагчдад дуу хоолойгоо илэрхийлэх боломжтой орчин бий болгож өгөх зэрэг аргаар хүний эрхийг хамгаалагчидтай зөвлөлдөх, харилцан ярилцах механизмыг бий болгох,

417 ЕАБХАБ Парламентын Ассамблей, “Хүний эрхийг хамгаалагч нар болон үндэсний хүний эрхийн институтуудтай тогтоосон ЕАБХАБ-ын харилцааг бэхжүүлэх тухай тогтоол”, заалт №20.

418 ЕЗПА-н Тогтоол 1660 (2009), заалт №3.

419 Эх. сурв. заалт №13. Европын Зөвлөлийн гишүүн орнууд дахь хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын талаар 2012 онд гаргасан тогтоолдоо Ассамблей “хүний эрхийг хамгаалагчидтай холбоотой хууль тогтоомж, тэдгээрийн ажил олон улсын стандартад нийцсэн байх, хүний эрхийг хамгаалагчдад зохисгүй хязгаарлалт тавих, захиргааны дарамт үзүүлэх хууль тогтоомж гаргахаас зайлсхийх, эсвэл шаардлагатай бол ийм хуулийг хүчингүй болгоход”, мөн, “хүний эрхийн ТББ, хамгаалагчдыг тэдэнтэй холбоотой хууль тогтоомж боловсруулахад олон нийтийн хэлэлцүүлгээр дамжуулан оролцуулахад” анхаарах хэрэгтэй гэдгийг үндэсний парламентууд болон тэдний гишүүдэд дахин сануулсан. Тогтоолыг №1891 (2012), заалт №6 үз.

бэхжүүлэх”⁴²⁰-ийг улс орнуудад зөвлөсөн. Хүний эрхийг хамгаалагчдын нэр төр, бие махбодын болон сэтгэл зүйн халдашгүй байдалд томоохон аюул заналхийлж байгаа тохиолдолд оролцогч улсууд хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах үндэсний бодлого, хөтөлбөр, механизм боловсруулж хэрэгжүүлэх ёстой. Шаардлагатай тохиолдолд оролцогч улсууд ийм хамгаалалтын хөтөлбөр, бодлогын хэрэгжилтийг зохицуулах зөвлөлдөх, зохицуулах этгээдийг байгуулах, томилох асуудлыг авч үзэх хэрэгтэй. Ийм байгууллагууд байгаа эсвэл бий болсон тохиолдолд эрх зүйн суурь шинжилгээг удирдан явуулах, энэхүү удирдамж болон бусад холбогдох стандарт, үүрэг амлалтуудын хэрэгжилтэд явцын хяналт хийх үүрэг хариуцлагыг тодорхой болгох хэрэгтэй. Тэдний төлөөлөх эрх, тухайн улс орны онцлог нөхцөл байдлаас хамааран ийм этгээдэд холбогдох яам, хууль сахиулах болон шүүх засаглал, үндэсний, бүс нутгийн болон орон нутгийн засаг захиргаа, парламент, хүний эрхийн үндэсний институтүүд (ХЭҮИ)-ийг ойлгоно. Мөн олон төрөл, цар хүрээг хамарсан эрхийг хамгаалах үйл ажиллагаануудыг төлөөлөн тус улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг бие даасан хүний эрхийг хамгаалагч нарыг тооцож болно. Шаардлагатай тохиолдолд засгийн газар хоорондын байгууллагууд, тэдгээрийн бие төлөөлөгчдийг дээрх төлөөлөх эрхийг хэрэгжүүлэгчээр авч үзэж болно.

275. НҮБЕА нь улс орнуудыг НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалыг орчуулж, үндэсний болон орон нутгийн түвшинд, тэр дундаа төрийн албан хаагчид болон төрийн бус талуудад аль болох өргөнөөр түгээхэд шаардлагатай бүх арга хэмжээг авахыг зөвлөсөн. Шүүгчид эрх бүхий албан тушаалтнуудаар тунхаглалын заалтыг дагаж мөрдүүлэх, ингэснээр хүний эрхийг хамгаалагчид, тэдний ажлын талаар илүү сайн ойлголт, хүндэтгэл бий болгох зорилгоор тэдний дунд тунхаглалын талаар мэдлэг олгох,

420 НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн тогтоол A/HRC/RES/13/13 заалт №5. Европын Зөвлөлийн Парламентын Ассамблей нь байгууллагын гишүүн орнуудыг “эрсдэлд буй хүний эрхийг хамгаалагчдад зохих дэд бүтэц, тусламжийн хөтөлбөрүүдийг бий болгохыг” уриалав.” ЕЗПА-н Тогтоол 1660 (2009), заалт №12.1-г үз.

сургалт явуулахыг улс орнуудад зөвлөсөн.⁴²¹ ЕАБХАБ-ын оролцогч орнуудыг энэхүү удирдамжтай холбогдуулан ижил төстэй алхам хийхийг зөвлөж байна. Тэд энэхүү удирдамжийг холбогдох мэргэжлийн бүлгүүд болон төрийн бус талуудад өргөнөөр түгээж, холбогдох төрийн албан хаагчид, сурган хүмүүжүүлэгчид болон бусад хүмүүст хүний эрхийн боловсрол олгох сургалтад ашиглах хэрэгтэй. Мөн эдгээр улс орнууд энэ удирдамжийг сурталчлах, холбогдох сургалт, боловсролын үйл ажиллагааны талаар АИХЭГ-тай хамтарч ажиллах, мөн энэ чиглэлд бие даасан ҮХЭИ-үүд болон иргэний нийгмийн санаачилгыг дэмжин ажиллах ёстой.

ЕАБХАБ-ын бусад оролцогч болон гуравдагч орон дахь хүний эрхийг хамгаалагчдыг дэмжих, хамгаалах

276. Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах нь зөвхөн улс орны дотоод хэрэг биш гэдгийг хүлээн зөвшөөрч, оролцогч улсууд ЕАБХАБ-ын бусад оролцогч орнууд, түүнчлэн ЕАБХАБ-ын бүсээс гаднах гуравдагч оронд хүний эрхийг хамгаалагчдыг дэмжих, хамгаалах арга хэмжээний талаар холбогдох төрийн албан тушаалтнуудад зориулсан үйл ажиллагааны удирдамж боловсруулах талаар анхаарч үзэх хэрэгтэй. Европын зөвлөлийн сайд нарын хороо нь “шүүх хуралдаанд ажиглагчаар оролцуулах, боломжтой бол яаралтай виз олгох зэрэг арга хэмжээг хурдан шуурхай үзүүлэх, хамгаалах арга хэмжээ авах зэргээр гуравдагч оронд байгаа аюулд учирсан хүний эрхийг хамгаалагчдад шаардлагатай тусламж үзүүлэх”-ийг зөвлөж байна.⁴²²

277. Хүний эрхийг хамгаалагчдын хамгааллын Европын холбооны удирдамж нь ЕХ-ны гадаадад суугаа төлөөлөгчийн газруудад (ЕХ-ны гишүүн орнуудын дипломат төлөөлөгчийн газрууд болон Европын зөвлөлийн төлөөлөгчдөд) гуравдагч оронд хүний эрхийг хамгаалагчдыг дэмжих арга хэмжээний чиглэл болдог. ЕХ-ны төлөөлөгчдийг ерөнхийдөө хүний эрхийг хамгаалагчдад чиглэсэн санаачилгатай бодлого хэрэгжүүлэх

421 А/RES/66/164, заалт №11 ба 12-ыг үз. Мөн, 2013 оны 12-р сарын 18, А/RES/68/181, заалт №1-ийг үз. Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн НҮБ-ын Тусгай илтгэгчийн өгсөн зөвлөмжийн талаар, жишээ нь: Тунхаглалыг өргөн дэлгэр түгээх, ялангуяа, хууль сахиулах байгууллага, төрийн албан тушаалтнуудад чиглэсэн боловсролын хөтөлбөрүүдэд хүний эрхийг хамгаалагчдын нийгэмд гүйцэтгэж буй үүргийг хүлээн зөвшөөрсөн сургалтын модулиудыг оруулах, хүний эрхийг хамгаалагчдын эрх, үүргийн талаар шаардлагатай сургалтыг төрийн албан хаагчдын дунд явуулахыг зөвлөсөн түүний А/HRC/25/55 дугаартай тайлан, заалт 131(с) ба (g)-ыг үз. Хууль, шүүх болон захиргааны байгууллагууд, иргэний нийгэм, ТББ-уудын мэдлэгийг дээшлүүлэхийн тулд НҮБ-ын олон улсын гэрээний байгууллагууд хүний эрхийн холбогдох бичиг баримтууд, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх тайлангууд, түүнчлэн тус Хороодын хийсэн нэгдсэн дүгнэлт, зөвлөмжийг орчуулж, түгээхийг улс орнуудад тогтмол уриалдаг. НҮБ-ын Хүний Эрхийн Хороо нь гэрээний улсын тайланг хэлэлцэний дараа хийсэн нэгдсэн дүгнэлтдээ оруулсан стандарт зөвлөмжийг, жишээлбэл: CCPR/C/DEU/CO/6, 12 11 дүгээр сарын 2012, заалт №19-ээс үз.

422 Европын Зөвлөл Сайд нарын Хорооны тунхаглал, заалт №2 (xi).

ёстой гэж зөвлөдөг.⁴²³ 2009 онд ЕЗПА нь Европын зөвлөлийн гишүүн болох Европын холбооны гишүүн орнуудыг ЕХ-ны удирдамжийг бүрэн ашиглаж, үүнд заасан зарчмуудыг өөрсдийн хил хязгаарын дотор хэрэгжүүлэхийг уриалсан.⁴²⁴

278. ЕХ-ны удирдамжийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор Европын парламентаас явуулсан судалгааны үр дүнд сайн туршлагуудыг илрүүлж байгаагаас гадна дипломат ажилтнуудын төдийгүй, хүний эрхийг хамгаалагчдын дунд удирдамжийн агуулгын талаарх мэдлэг хязгаарлагдмал, ЕХ-ны удирдамжийн дагуу хүний эрхийн асуудалд хэрхэн оролцох талаар ойлголт дутмаг байсан зэрэг удирдамжийн хэрэгжилтийн зөрүүг тодорхойлсон.⁴²⁵ Иймээс ЕХ-ны гишүүн орнууд болох ЕАБХАБ-ын гишүүн орнууд удирдамжийг өөрсдийн дипломат ажилтнууд, төрийн бусад холбогдох албан тушаалтнуудад өргөнөөр түгээх нь зөв., Мөн дипломат төлөөлөгчийн газрын гишүүд болон бусад албан тушаалтнуудад Удирдамжийн хэрэгжилтийн талаар зохих сургалт явуулж, энд дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэхдээ нэн тэргүүнд мөрдлөг болгож буй эсэхийг анхаарч ажиллах хэрэгтэй. Бусад оролцогч улсууд өөрсдийн үндэсний, болон нэмэлт удирдамжийн үндсэн дээр ижил төстэй алхмуудыг авч хэрэгжүүлэх ёстой.⁴²⁶

423 “Хамгаалалтыг хангах нь - Европын холбооны Хүний эрхийг хамгаалагчдын хамгааллын удирдамж”, <<http://www.consilium.europa.eu/uedocs/cmsUpload/GuidelinesDefenders.pdf>>, заалт №10. Удирдамжийг анх 2004 онд баталж, 2008 онд хянасан.

424 ЕЗПА-н Тогтоол 1660 (2009), заалт №12.3.

425 Хатагтай Карен Беннетт, “Хүний эрхийг хамгаалагчдын Европын холбооны удирдамжийн хэрэгжилтийг үнэлэх - Киргизстан, Тайланд, Тунисийн хэрэг”, Европын парламент, Холбооны гадаад бодлогын Ерөнхий захирал, 2013 оны 6-р сар, <[http://www.europarl.europa.eu/RegData/etudes/etudes/join/2013/410221/EXPO-DROI_ET\(2013\)_410221_EN.pdf](http://www.europarl.europa.eu/RegData/etudes/etudes/join/2013/410221/EXPO-DROI_ET(2013)_410221_EN.pdf)>-г үз. Гурван өөр газарзүйн байршилд гарсан тохиолдлуудыг судалсны үндсэн дээр энэхүү тайланд уг удирдамжийн хэрэгжилтийг сайжруулах талаар хэд хэдэн зөвлөмж гаргасан болно. Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн тусгай илтгэгч Европын Холбооны Хүний эрхийг хамгаалагчдын удирдамжийн хэрэгжилт, үнэлгээ сайжруулах үүднээс энгийн бүтцийн болон үр дүнгийн үзүүлэлтүүдийг боловсруулж өгөхийг зөвлөсөн. Ирланд улсад ажилласан томилолын тайлан, НҮБ-ын Б.Б. А/HRC/22/47/ Add.3, 26 Хоёрдугаар сарын 2013 заалт №111 (g)-г үз.

426 Швейцарын удирдамж нь жишээлбэл, хүний эрхийн хамгаалагчидтай нягт холбоотой ажилладаг Элчин сайдын яамны ажилтнуудад зориулсан тодорхой сургалтын ач холбогдлыг хүлээн зөвшөөрдөг. “Эдгээр тусгайлан бэлтгэгдсэн ажилтнууд энэ асуудлаар ярилцах гол газар болох төдийгүй, тэд мэдээллийг цааш түгээгчид болдог бөгөөд өөрсдийн мэдлэгээ хамт ажиллагсадтайгаа хуваалцдаг.” (хуу. №17)-г үз.

279. Энэ талын сайн туршлагын жишээ бол Норвеги⁴²⁷ ба Швейцарь⁴²⁸ улсын Засгийн газруудаас гадаад дахь үйлчилгээ, төлөөлөгчдөдөө зориулж гаргасан Хүний эрхийг хамгаалагчдын хамгааллын удирдамжууд юм. Эдгээр удирдамж нь тухайн улсад суугаа дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан хүний эрхийг хамгаалагчдыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж болох үйл ажиллагааг тодорхойлсон. Тухайлбал, мэдээлэл солилцох, тэдний ажлыг хууль ёсны болгох үүднээс хүний эрхийг хамгаалагчидтай шууд холбоо тогтоох, шүүх ажиллагааг ажиглах, хорих анги, гэрийн хорионд байгаа хүмүүстэй уулзах, хариуцагч орны эрх бүхий байгууллагуудад (албан ёсны болон албан бус сувгууд, дипломат мэдэгдэл, хөндлөнгөөс оролцох замаар) хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэлийн мэдээ, ярилцлага, олон нийтийн мэдэгдэл, хүний эрхийг хамгаалагчдын тухайлсан нөхцөл байдалд олны анхаарал татах зэрэг аргаар хүний эрхийн ажлын харагдах байдлыг нэмэгдүүлэх, мэдээлэл солилцох, хүний эрхийг хамгаалагчидтай холбоо тогтоох зорилгоор тухайн улс дахь олон улсын талууд, бусад дипломат төлөөлөгчийн газрууд болон тухайн улсын ҮХЭИ-үүдтэй хамтран ажиллах гэх мэт хэд хэдэн боломжит практик арга хэмжээг бодож олсон. Норвеги болон Швейцарь улсын удирдамжийн аль аль нь тодорхой тохиолдолд хүний эрхийг хамгаалагчдыг өөр хот, эсвэл ойролцоох улс руу түр нүүлгэн шилжүүлэхийн тулд санхүүгийн дэмжлэг, практик тусламж шаардагддаг гэдгийг хүлээн зөвшөөрдөг.⁴²⁹ ЕАБХАБ-ын бүх оролцогч орнууд шаардлагатай бол хүний эрхийг хамгаалагчдыг дэмжих, тэдний хамгаалалтыг сайжруулахад дипломат үйл ажиллагаагаараа дэмжин оролцох ёстой. Ялангуяа тэд ийм арга хэмжээ авахдаа нийслэлээс гадна, хөдөө орон нутаг, алслагдсан бүс нутагт байрладаг хүний эрхийг хамгаалагчдад хүрч үйлчлэх ёстойг анхаарах хэрэгтэй.⁴³⁰
280. Гадаадад суугаа дипломат төлөөлөгчийн газруудаараа дамжуулан үйл ажиллагаагаа явуулахаас гадна, улс төрийн уулзалтууд болон албан

427 “Хүний эрхийг хамгаалагчдыг дэмжих Норвегийн хүчин чармайлт, гадаад хэргийн албаны гарын авлага”, Норвегийн Гадаад Хэргийн Яам, оны 12 дугаар сар, <http://www.regjeringen.no/en/dep/ud/documents/handbooks_brochures/2010/hr_defenders_guide.html?id=633052>.

428 “Швейцарын Хүний Эрхийг хамгаалагчдын Хамгааллыг Хэрэгжүүлэх Удирдамж”, Гадаад Хэргийн Холбооны Хэлтэс (ГХХХ), 2013 оны 12 дугаар сар, <<http://www.admin.ch/aktuell/00089/index.html?lang=en&msg-id=51322>>.

429 Норвегийн удирдамж, хуу. №14, ба Швейцарын удирдамж, хуу. №15-ыг тус тус үз.

430 ЕХ-ны удирдамжийг хэрэгжүүлэх талаар дээр дурдсан судалгаагаар, жишээлбэл: судалгаа хийсэн орнуудад нийслэлээс өөр газруудад дипломат төлөөлөгчид шүүх хурлын ажиглалт хийсэн, биечлэн очсон тохиолдол нэн ховор (Европын парламент, Холбооны гадаад бодлогын ерөнхий захирал, “Европын Холбооны Хүний эрхийг хамгаалагчдын удирдамжийн хэрэгжилтийн үнэлгээ - Киргизстан, Тайланд, Тунисийн хэрэг”, 2013 оны 6-р сар) байна. Швейцарын удирдамжид, жишээлбэл: ёс суртахууны дэмжлэг үзүүлэх, тэдний хамгааллыг сайжруулах зорилгоор хөдөө орон нутаг дахь хүний эрхийн хамгаалагчидтай газар дээр нь уулзах хэрэгцээ шаардлага бийг онцолсон (Швейцарын удирдамж, хуу. №12-ыг үз).

ёсны айлчлалын үеэр хүний эрхийг хамгаалагчдын ерөнхий байдал, тодорхой тохиолдлын хувь хүний хэргийн талаар асуудал хөндөж тавих нь чухал болохыг Норвегийн удирдамжид тэмдэглэжээ. Тухайлбал, энэхүү удирдамжид хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын талаарх мэдээллийг албан ёсны айлчлалын өмнө улс төрийн удирдлагад бэлтгэсэн суурь материалд оруулахыг зөвлөсөн байна. Мөн ийм айлчлалын үеэр албан тушаалтнууд тухайн орны иргэний нийгмийн төлөөлөл, хүний эрхийн төлөөлөгчидтэй уулзах талаар бодож үзэхийг зөвлөсөн байна. Уг асуудалд тус улсын хамгаалагчдыг оролцуулж байгаа.⁴³¹ Бусад оролцогч улсууд мөн ийм арга хэмжээ авах нь зүйтэй юм.

281. Үүний нэгэн адил, Голландын Засгийн газар хүний эрхийн гадаад бодлогынхоо хүрээнд, Голландын Гадаад хэргийн яам нь “Голландад түр хугацаагаар оршин суухыг хүсэж буй эрсдэлд орсон хүний эрхийг хамгаалагчдад Шенгенийн богино хугацааны визийг түргэн шуурхай олгоход туслалцаа үзүүлнэ” гэж заасан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулжээ.⁴³² Үүнтэй адилаар, швейцарын удирдамжид “Хэрвээ тухайн хэргийг нарийвчлан судалж үзээд, тухайн улсаас гарах нь хамгийн тохиромжтой сонголт гэдэг нь нотлогдвол Швейцарын гадаад хэргийн яам швейцарын виз олгох явцыг түргэвчлэх зөвшөөрөл өгөх замаар хөндлөнгөөс оролцоно.”⁴³³ гэж заажээ. Дээр дурдсан Европын зөвлөлийн сайд нарын хорооны зөвлөмжөөс гадна ЕЗПА нь улс орнуудад хүмүүнлэгийн визний тогтолцоог бий болгох эсвэл бусад зохих арга хэмжээ авах⁴³⁴-ыг, ялангуяа, үндэсний парламентыг “эрсдэлд орсон хүний эрхийг хамгаалагчдыг яаралтай виз авах гэх мэт асуудал дээр тусламж үзүүлж, хамгааллын арга хэмжээг авч дэмжих”⁴³⁵ -ийг уриалсан байна. Иргэний нийгмийн байгууллагууд, хүний эрхийг хамгаалагчдын сүлжээнүүдтэй хамтран Парламентын гишүүд нь нүүлгэн шилжүүлсний дараа тухайн иргэнийг хүлээн авах, санхүүжүүлэхэд үндэсний болон орон нутгийн засаг захиргаа, төрийн болон хувийн байгууллагуудын дэмжлэгийг авахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

431 Норвегийн удирдамж, хуу. №20-ийг үз.

432 “Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө”, <<http://www.government.nl/issues/human-erxs/supporting-human-rights-defenders> (Голландын үйл ажиллагааны төлөвлөгөө)>, хуу. №5.

433 Швейцарын удирдамж, хууд. №16. Хүний эрхийн хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн тусгай илтгэгч Ирланд улс 2006 онд түр зуурын аюулгүй байдлын асуудалтай тулгарч буй хүний эрхийн хамгаалагчдад Ирландад түр орогнох боломжийг олгодог түргэвчилсэн журмаар олгох хүмүүнлэгийн визийн тогтолцоог бий болгосны дараа Ирландын сайн туршлагын жишээ болгон дурджээ. HRC/22/47/Add.3, 26 Хоёрдугаар сарын 2013, заалт №56-г үз.

434 Европын Зөвлөл Сайд нарын Хорооны тунхаглал, заалт №2 (xi) ба ЕЗПА Тогтоол 1660 (2009), заалт №12.2-ыг тус тус үз.

435 ЕЗПА-н Тогтоол 1660 (2009), заалт №13.5.

282. Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгчийн хэлсэнчлэн хөгжлийн тусламж нь гуравдагч орны хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг төдийгүй тэдний ажилд аюулгүй, таатай орчныг бүрдүүлж өгдөг. Түүнчлэн хөгжлийн тусламжийн нэг хэсэг болох хүний эрхийн зөрчлийн тохиолдлууд, хүний эрхийг хамгаалагчдын чадавх, аюулгүй байдлыг хангахад шаардлагатай санхүүжилтийн хэрэгцээний асуудал дахь хандивлагчдын уялдаа холбоотой, тогтвортой арга хэмжээний чухал ач холбогдлыг, Тусгай илтгэгч эмэгтэй онцлон дурдсан.⁴³⁶

Олон улсын хамтын ажиллагаа ба хүний эрхийн механизм

283. Ардчилал, эрх зүйт ёс, хүний эрхийг хүндэтгэх явдлыг тусгайлан анхаарахын зэрэгцээ, ЕАБХАБ-ын зарчмуудыг баримтлах хамтын үүрэг хариуцлагаа онцлон тэмдэглэхдээ ЕАБХАБ-ын оролцогч орнууд ЕАБХАБ болон түүний байгууллагууд, төлөөлөгчидтэй хамтран ажиллах эрмэлзэлтэйгээ дахин баталгаажуулсан.⁴³⁷ ЕАБХАБ-ын оролцогч орнууд ЕАБХАБ болон бусад гишүүнээр элссэн байгууллагуудаараа дамжуулан ЕАБХАБ-ын зарчим, үүрэг амлалтын биелэлтийг сайжруулах талаар тусламж санал болгох, одоо байгаа хамтын ажиллагааны хэрэгслийг бэхжүүлэх, оролцогч орнуудын тусламж авах хүсэлтэд үр дүнтэй хариу өгөх үүднээс шинэ арга хэрэгсэл бий болгох чиглэлээр хамтын ажиллагааны хамтарсан арга хэмжээнүүдэд нэгдэн ажиллахаа амласан.⁴³⁸ Түүнчлэн, “Ардчилсан институт, хүний эрхийн газар (АИХЭГ), Үндэсний цөөнхийн асуудал эрхэлсэн дээд комиссар, Хэвлэлийн эрх чөлөөний асуудал эрхэлсэн төлөөлөгч (ХЭЧАЭТ) ба түүний төлөөллийн үйл ажиллагаа, түүний нарийн бичгийн даргын газар зэрэг өөрийн байгууллагуудаа бүрэн ашиглан ЕАБХАБ нь тэдний бүс нутаг дахь идэвхтэй тоглогч хэвээр байх болно.” гэдгийг дахин баталгаажуулсан. Эдгээр нь бүх оролцогч улс орнуудын хувьд хүний эрх, ардчилал, эрх зүйт ёсыг хүндэтгэх үүргээ хэрэгжүүлэхэд туслах чухал хэрэгсэл юм.”⁴³⁹ Хүний эрхийг хамгаалагч нар чөлөөтэй ажиллах орчныг бүрдүүлэхийн тулд Европын холбооны удирдамж нь АИХЭГ, Европын зөвлөлийн хүний эрхийн комиссар гэх мэт хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах бүс нутгийн одоогийн механизмыг бэхжүүлэх, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Тусгай журам, түүний дотор

436 Жишээлбэл: A/HRC/22/47/Add.3, 2013 оны Хоёрдугаар сарын 26, заалт №65.

437 Станбул 1999, “Европын Аюулгүй Байдлын Дүрэм: III. Бидний Хамтын Арга хэмжээ”, заалт №14.

438 Эх. сурв.

439 Маастрихт 2003, “Хорин нэгдүгээр зууны аюулгүй байдал, тогтвортой байдалд тулгарч буй аюул заналыг арилгах ЕАБХАБ-ын стратеги” -г үз. Заалт №20.

Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн тусгай илтгэгчийг дэмжих зорилт тавьсан.⁴⁴⁰

284. Оролцогч улсууд бусад улсуудтай шударгаар бие биедээ харилцан дүн шинжилгээ хийж, хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах, тэдний ажилд аюулгүй, таатай орчныг бүрдүүлэх, бэхжүүлэх зорилгоор олон улсын хүний эрхийн байгууллагуудтай хамтран ажиллах ёстой. Тухайлбал, Европын зөвлөлийн сайд нарын хороо гишүүн орнуудаа улс орондоо томилолт зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын талаар комиссартай яриа хэлэлцээ хийх, зохих арга хэмжээг авах замаар Европын зөвлөлийн хүний эрхийн механизм, ялангуяа ЕХЭШ, Хүний эрхийн комиссартай хамтран ажиллахыг уриалж байна.⁴⁴¹ Үүнтэй адил, оролцогч улсууд НҮБ-ын Тусгай удирдлага, түүний дотор Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгчтэй хамтран ажиллаж, тухайн улсад томилолтоор ажиллах хүсэлтийг хүндэтгэн авч үзэх ёстой.⁴⁴² Тэд мөн хяналт-шинжилгээний эрх бүхий дээд байгууллагуудад өөрсдийн соёрхон баталсан олон улсын хүний эрхийн баримт бичгийн хэрэгжилтийн талаар тогтмол тайлагнах үүргээ бүрэн биелүүлж, тэдгээр байгууллагуудыг хүний эрхийг хамгаалагчдын хамгааллыг хангахад шаардлагатай арга хэмжээг авсан талаараа нарийвчилсан мэдээллээр хангах шаардлагатай. Ялангуяа улс орнууд олон улсын гэрээний хяналт-шинжилгээний байгууллага, хүний эрхийн бусад механизмаас гаргасан зөвлөмжүүд дээр үр дүнтэй, зохих ёсны явцын мэдээлэл өгөх ёстой. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл нь улс орнуудыг “үндэсний тайлан, гэрээний байгууллагууддаа явуулах мэдээлэлдээ хүний эрхийг хамгаалагчдад аюулгүй, таатай орчныг бүрдүүлэхэд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнийхээ талаар тусгахыг” уриалсан.⁴⁴³

285. Хүний эрхийг хамгаалагчдын эрх ашгийг хамгаалахтай холбоотой олон улсын стандартууд, ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтуудаа төгс биелүүлэхийн тулд Оролцогч улс орнууд хууль тогтоомжиндоо дүн шинжилгээ хийх, хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулахдаа АИХЭГ-аас тусламж авах нь бүрэн нээлттэй. Энэхүү удирдамжийг хэрэгжүүлэх талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнийхээ талаар АИХЭГ-т мэдээлэл өгөх ёстой. Энэ нь АИХЭГ хяналт-шинжилгээ явуулах үүргээ гүйцэтгэх,

440 Европын холбооны удирдамж, заалт №12, хууд. №7-9, ба заалт №13, хууд. №9-10-ыг тус тус үз.

441 Европын Зөвлөл Сайд нарын Хорооны тунхаглал, заалт №2 (viii).

442 НҮБЕА нь “Тусгай илтгэгчийн улс орнуудад томилолтоор ажиллах хүсэлтэд нааштай хариу өгөхийг нухацтай авч үзэж, Тусгай илтгэгч төлөөлөх эрхийнхээ хүрээнд ажил үүргээ илүү үр дүнтэй гүйцэтгэх боломж олгох үүднээс түүний зөвлөмжийг дагаж мөрдөх, хэрэгжүүлэхтэй холбогдуулан Тусгай илтгэгчтэй бүтээлч яриа хэлэлцээ хийхийг” улс орнуудад уриалж байна. А/RES/66/164, заалт №10-г үз.

443 А/HRC/RES/22/6, заалт №19-ийг үз.

оролцогч улсуудад мэдээлэл түгээх, шилдэг туршлагаа хуваалцах гэх мэтээр холбогдох хүний аюулгүй байдлын хэмжүүрийг хангах үүрэг амлалтаа хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлэх чадвартай байлгахад чухал ач холбогдолтой юм.⁴⁴⁴ Хүний аюулгүй байдлын хэмжүүрийн асуудлаар ажилладаг гол институтийн хувьд, АИХЭГ нь ЕАБХАБ-ын Байнгын зөвлөлд “үйл ажиллагааныхаа талаар тогтмол давтамжтайгаар мэдээлэх, хэрэгжилтийн асуудлаар мэдээлэл өгөх” ба “хэрэгжилтийн жилийн дүн-шинжилгээнд материал бэлтгэж өгөх, шаардлагатай бол хүлээн авсан мэдээллийг тодруулах эсвэл нэмэлт мэдээлэл өгөх” үүрэгтэй.⁴⁴⁵ ЕАБХАБ болон түүний байгууллагуудтай хамтран ажиллах үүрэг амлалтынхаа хүрээнд ЕАБХАБ-ын гишүүн орнууд “хэрэгжилтэд тасралтгүй дүн шинжилгээ хийхэд эв санаа нэгтэй, түншлэлийн чиг баримжаатайгаар хамтран ажиллах” эрмэлзлээ илэрхийлсэн.⁴⁴⁶

286. Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалахтай холбоотой Хүний аюулгүй байдлын хэмжүүрийн талаарх амлалтдаа бүрэн нийцүүлэхийн тулд оролцогч улсууд АИХЭГ-ын бусад үйл ажиллагаанд нээлттэй хандах, дэмжих ёстой. Тухайлбал, хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалахтай холбоотой Хүний аюулгүй байдлын хэмжүүрийн үүрэг амлалтуудынхаа хэрэгжилтэд дэмжлэг болгож, АИХЭГ-аас улс орондоо төлөөлөгч урих боломжтой. Мөн, “Оролцогч улсуудын төрийн бус байгууллагын төлөөлөгчид болон бусад сонирхсон хүмүүсийг шүүх хуралдаанд ажиглагчаар оролцуулахыг итгэлцлийг бий болгох хэмжүүр болгон хүлээн авна.”⁴⁴⁷ гэсэн ЕАБХАБ-ын амлалтынхаа дагуу холбогдох оролцогч улсууд хүний эрхийн хамгаалагчдын шүүх хуралд ЕАБХАБ/АИХЭГ-ын хяналт-шинжилгээ хийлгэх ажлыг дэмжиж зохион байгуулах хэрэгтэй.

444 1992 оны Хельсинкийн баримт бичгийн дагуу АИХЭГ-ын төлөөлөх эрх нь ЕАБХАБ-ын гишүүн орнуудад “хүний эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн хэмжээгээр хүндэтгэж, эрх зүйт ёсыг дээдлэх зарчмыг баримтлах, ардчиллын зарчмуудыг хөхиүлэн дэмжих, [...] ардчилсан институтийг байгуулах, бэхжүүлэх, хамгаалах, мөн нийгэм даяар хүлээцтэй байдлыг хөхиүлэн дэмжихэд туслах зорилготой юм.” (Хельсинки, 1992, “Шийдвэр: VI. Хүний аюулгүй байдлын хэмжүүр”, 2-р зүйл). Цаашилбал, АИХЭГ нь ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтынхаа дагуу оролцогч улсуудаас ирэх мэдээллийг хүлээж авах газрын үүрэг гүйцэтгэх, хүний аюулгүй байдлын хэмжүүрийн талаарх мэдээллийг түгээх зэрэг үүрэгтэй (Ром 1993, “Шийдвэр: IV. Хүний аюулгүй байдлын хэмжүүр”, заалт №4).

445 Будапешт 1994, “Шийдвэрүүд: VIII. Хүний аюулгүй байдлын хэмжүүр”, заалт №8.

446 Станбул 1999, “Европын Аюулгүй Байдлын Дүрэм: III. Бидний Хамтын Арга хэмжээ”, заалт №14.

447 Копенхаген 1990, заалт №12.

ЕАБХАБ

287. 2003 онд ЕАБХАБ-ын оролцогч улсууд “Ардчилсан институт, хүний эрхийн газар (АИХЭГ), Үндэсний цөөнхийн асуудал эрхэлсэн дээд комиссар, Хэвлэлийн эрх чөлөөний асуудал эрхэлсэн төлөөлөгч (ХЭЧАЭТ) ба түүний төлөөллийн үйл ажиллагаа, түүний нарийн бичгийн даргын газар зэрэг өөрийн байгууллагуудаа бүрэн ашиглан тэдний бүс нутаг дахь идэвхтэй тоглогч байх” нь ЕАБХАБ-ын чухал үүргийг гэж онцлон тэмдэглэсэн. Мөн “хүний эрх ба ардчилал, эрх зүйт ёсыг хүндэтгэх зэрэг бүхий л хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь оролцогч улсуудад туслах чухал хэрэгсэл болох⁴⁴⁸ тус институтгийн үүргийг онцлон, чухалчлан тэмдэглэсэн. 2007 онд ЕАБХАБ-ын Парламентын ассамблей нь хүний эрхийг хамгаалагч нарт ЕАБХАБ, түүний байгууллагууд болон бие төлөөлөгчдийн онцгой анхаарал, дэмжлэг, хамгаалал шаардлагатайг дахин мэдэгдсэн.⁴⁴⁹ Хүний аюулгүй байдлын хэмжүүрийн талаарх амлалтыг хэрэгжүүлэхэд хүний эрхийг хамгаалагчидтай хийж буй ЕАБХАБ-ын хүний аюулгүй байдлын хэмжүүрийн талаарх үйл ажиллагаанд оролцох зэрэг ажиллагааг тасалдуулахгүйн тулд ЕАБХАБ-ын гүйцэтгэх удирдлага, байгууллага, тэдгээрийн бие төлөөлөгчид өөрсдийн төлөөлөх эрхийн хүрээнд уг Удирдамжийг хэрэгжүүлэх ёстой. Энэ нь хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах үйл ажиллагааг өргөжүүлэх, ЕАБХАБ-ын үйл ажиллагаануудаар дамжуулан хүний эрхийн үйл ажиллагаа эрхлэх аюулгүй, таатай орчныг бүрдүүлэх, бэхжүүлэх чадамжийг олгодог.

448 Маастрихт 2003, “Хорин нэгдүгээр зууны аюулгүй байдал, тогтвортой байдалд тулгарч буй аюул заналыг арилгах ЕАБХАБ-ын стратеги”-г үз. Заалт №20.

449 ЕАБХАБ Парламентын Ассамблей, “Хүний эрхийг хамгаалагч нар болон үндэсний хүний эрхийн институтүүдтэй тогтоосон ЕАБХАБ-ын харилцааг бэхжүүлэх тухай тогтоол”, заалт №8 ба 23.

ХАВСРАЛТ

Сонгосон лавлах материал,
эх сурвалжууд

ХАВСРАЛТ

Сонгосон лавлах материал, эх сурвалжууд

1. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧДЫГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙ ТУСГАЙ БАРИМТ БИЧИГ, СТАНДАРТУУД

- НҮБ: Бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах хувь хүн, бүлэг, иргэний нийгмийн байгууллагуудын эрх, үүргийн тунхаглал, 1998 оны 12 дугаар сарын 9-ний өдөр НҮБ-ын Ерөнхий ассамблейн А/RES/53/144 тоот тогтоолоор санал нэгтгэйгээр батлагдсан, <<http://www.ohchr.org/Documents/Issues/Defenders/Declaration/declaration.pdf>>.
- Европын зөвлөл: Хүний эрхийг хамгаалагчдын хамгааллыг сайжруулах, тэдний үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих тухай Европын зөвлөлийн сайд нарын хорооны Тунхаглал, 2008 оны 2 дугаар сарын 6-ны өдөр батлагдсан, <<https://wcd.coe.int/ViewDoc.jsp?id=1245887&Site=CM>>

Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалахтай холбоотой гол тогтоол, зөвлөмжүүд

Нэгдсэн Үндэстний Байгууллага:

- Эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах тухай Ерөнхий ассамблейн тогтоол, НҮБ-ын Б.б. А/RES/68/181, 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан, <http://www.un.org/ga/search/view_doc.asp?symbol=A/RES/68/181>.
- НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалыг сурталчлах тухай Ерөнхий ассамблейн тогтоол, НҮБ-ын Б.б. А/RES/66/164, 2011 оны 12 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан, <http://www.un.org/ga/search/view_doc.asp?symbol=A/RES/66/164>.
- Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах тухай тогтоол, НҮБ-ын Б.б. А/HRC/RES/22/6, 2013 оны 3 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан, <http://www.un.org/ga/search/view_doc.asp?symbol=A/HRC/RES/22/6>.
- Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах тухай НҮБ-ын Б.б. А/HRC/RES/13/13 дугаар тогтоол, 2010 оны 3 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан, <http://www.un.org/ga/search/view_doc.asp?symbol=A/HRC/RES/13/13>.

(Ерөнхий ассамблей, Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах тухай өмнөх бүх тогтоолыг дараах холбоосоор авах боломжтой. Үүнд: <http://ap.ohchr.org/documents/dpage_e.aspx?m=70&m=166>).

Европын зөвлөл:

- Европын зөвлөлийн гишүүн орнууд дахь хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын талаар Европын зөвлөлийн парламентын ассамблей (ЕЗПА)-н 1891 (2012) дүгээр тогтоол, 2012 оны 6 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан, <<http://assembly.coe.int/ASP/XRef/X2H-DW-XSL.asp?fileid=18948&lang=EN>>.
- Европын зөвлөлийн гишүүн орнуудын хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын талаарх ЕЗПА-н 1891 (2009) дүгээр тогтоол <<http://assembly.coe.int/ASP/XRef/X2H-DW-XSL.asp?fileid=17727&lang=en>> ба Зөвлөмж №1866 (2009), <<http://assembly.coe.int/ASP/XRef/X2H-DW-XSL.asp?fileid=17728&lang=en>> Хоёулаа 2009 оны 4-р сарын 28-нд батлагдсан.

ЕАБХАБ:

- ЕАБХАБ-ын Парламентын ассамблейн ЕАБХАБ-ын хүний эрхийг хамгаалагч нар болон хүний эрхийн үндэсний байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх тухай тогтоол, заалт №17, “Арван зургаадугаар чуулганаар батлагдсан Киевийн тунхаглал ба тогтоол” гэсэн хэсэг, Киев, 2007 оны 7 дугаар сарын 5-аас 9-ний өдөр, 28-30 дугаар хуудас <<http://www.EABXAB.org/publications/declarations/2007-kyiv-declaration/250-2007-kyiv-declaration-eng/file>>.

Европын холбооны удирдамж

- “Хамгааллыг хангах - Хүний эрхийг хамгаалагчдын хамгааллын Европын холбооны удирдамж”, 2008 он, <<http://www.consilium.europa.eu/uedocs/cmsUpload/GuidelinesDefenders.pdf>>.

Үндэсний удирдамжууд

- Швейцар: “Хүний эрхийг хамгаалагчдын хамгааллын Швейцарын удирдамж”, Гадаад хэргийн яам холбооны газар (ГХЯХГ), 2013 оны 12 дугаар сар, <<http://www.admin.ch/aktuell/00089/index.html?lang=en&msg-id=51322>>.
- Норвеги: “Норвегийн хүний эрхийг хамгаалагчдыг дэмжихэд чиглэсэн хүчин чармайлт, гадаад хэргийн албаны гарын авлага”, Норвегийн гадаад хэргийн яам, 2010 оны 12 дугаар сар, <http://www.regjeringen.no/en/dep/ud/documents/handbooks_brochures/2010/hr_defenders_guide.html?id=633052>.

2. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧДЫГ ХАМГААЛАХ АСУУДЛЫГ ТУСГАСАН ЕРӨНХИЙ ХҮНИЙ ЭРХИЙН СТАНДАРТУУД

ЕАБХАБ-ын Хүний аюулгүй байдлын хэмжүүрийг хангах үүрэг амлалтууд

ЕАБХАБ-ын гишүүн орнууд Хүний аюулгүй байдлын хэмжүүр гэх ЕАБХАБ-ын хүний аюулгүй байдлын цогц ойлголттой холбоотой заавал биелүүлэх улс төрийн томоохон үүрэг амлалтуудыг авсан билээ. Хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагаатай холбоотой Хүний аюулгүй байдлын хэмжүүрийн үүрэг амлалтад төрийн бус байгууллага, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэл, мэдээллийн эрх чөлөө, зорчих эрх чөлөө, эрх зүйт ёс, шүүхийн хараат бус байдал, эрүүдэн шүүх болон бусад харгис хэрцгийлэл, хүнлэг бус, доромжлох, зүй бусаар харьцах, шийтгэхийг хориглох, дур зоргоор баривчлах, албадан саатуулагдахаас ангид байх, шударга шүүх ажиллагаа, хохирлоо бүрэн барагдуулж авах болон өөр бусад эрхтэй холбоотой амлалтууд багтдаг.

НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалын төслийг боловсруулах ажлын хүрээнд оролцогч улсууд 1994 оны Будапештын баримт бичигт хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах хэрэгцээ шаардлага байгааг онцлон тэмдэглэжээ (Будапештын баримт бичиг: Шинэ эрин дэх бодит түншлэлийн төлөө (Төрийн ба засгийн газрын тэргүүн нарын дээд хэмжээний уулзалт), 1994 он, Шийдвэр: VIII. Хүний аюулгүй байдлын хэмжүүр).

ЕАБХАБ-ын бүх Хүний аюулгүй байдлын хэмжүүрийн үүрэг амлалтын сэдэвчилсэн ба он дарааллын эмхэтгэлийг <<http://www.Osce.org/odihr/76894>> болон <<http://www.Osce.org/odihr/elections/76895>> холбоосоор үзнэ үү.

Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалахтай холбоотой хүний эрхийн түгээмэл ба бүс нутгийн олон улсын гэрээнүүд

Хүний эрхийг хамгаалагчдын эрх ашгийг хамгаалах, хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаатай холбоотой хүний эрхийн нийтлэг ба бүс нутгийн олон улсын гэрээний эхүүдийг дараах холбооснуудаар үзнэ үү.

Нэгдсэн үндэстний байгууллага:

- Өөр бусад олон улсын гэрээнүүд болон Иргэний ба Улс төрийн эрхийн олон улсын пакт (ИУТЭОУП), Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын хэлцэл (ЭЗНСЭОУХ) зэрэг хүний эрхийн тухай үндсэн олон улсын гэрээнүүд: <http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CoreБаримт_bичгүүд.aspx>.
- Хүний эрхийн олон улсын үндсэн гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийдэг НҮБ-ын олон улсын гэрээний байгууллагуудын эрх зүйн практик, хяналт-шинжилгээний дүгнэлтүүдийг эндээс хайж олох

боломжтой. Үүнд: <http://tbinternet.ohchr.org/_layouts/treatybodyexternal/TBSearch.aspx?Lang=en>.

(Олон улсын гэрээний бус стандарт зэрэг хүний эрхийн баримт бичгийн сэдэвчилсэн бүрэн жагсаалтыг дараах холбоосоор үзнэ үү. Үүнд: <http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/UniversalHumanRightsBarimт_bичгүүд.aspx>).

Европын зөвлөл:

- Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай конвенц (Хүний эрхийн тухай Европын конвенц) ба энэхүү конвенцын протоколууд: <<http://www.conventions.coe.int/Treaty/Commun/ListeTraites.asp?MA=3&CM=7&CL=ENG>>.
- Европын хүний эрхийн шүүхийн эрх зүйн практикийн талаарх мэдээллийг дараах холбоосоор хайж олох боломжтой. Үүнд: <<http://hudoc.XEYЭЧК.coe.int/sites/eng/Pages/search.aspx>>.

Америкийн улсууд дундын байгууллага:

- Хүний эрхийн америкийн конвенц (ХЭАК), Америкийн хүний эрх, үүргийн тухай тунхаглал ба Америкийн улсууд дундын (Интер-америкийн) хүний эрхийн бусад баримт бичгүүдийг дараах холбоосоор авна уу. Үүнд: <http://www.oas.org/en/iachr/mandate/basic_documents.asp>.

3. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧДЫГ ХАМГААЛАХ ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БҮС НУТГИЙН МЕХАНИЗМУУД

Нэгдсэн үндэстний байгууллага:

- Хүний эрхийн асуудал эрхэлсэн тусгай илтгэгч: <<http://www.ohchr.org/EN/Issues/SRHRDefenders/Pages/SRHRDefendersIndex.aspx>>.

(Хүний эрхийг хамгаалагчдад хамааралтай болон бусад Хүний эрхийн зөвлөлийн тусгай удирдлагын төлөөлөх эрхүүдийн сэдэвчилсэн жагсаалтыг дараах холбоосоор орж үзнэ үү. Үүнд: <<http://www.ohchr.org/EN/HRBodies/SP/Pages/Themes.aspx>>)

Европын зөвлөл:

- Хүний эрхийн комисс,
<<http://www.coe.int/en/web/commissioner/human-erxs-defenders>>.

Америкийн улсууд дундын байгууллага:

- Америкийн улсууд дундын хорооны Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч, <<http://www.oas.org/en/iXЭАК/defenders/default.asp>>.